



# Нийгмийн хамгааллын үнэлгээнд суурилсан үндэсний хэлэлцүүлэг: Монгол Улсын нийгмийн хамгааллын суурь түвшний тодорхойлолт, зардал




ЭРҮҮЛ МЭНД БОЛОВСРОЛ УНДНЫ УС НИЙГМИЙН ТУСЛАМЖ ДЭМЖЛЭГ  
НИЙГМИЙН ДААТГАЛ ХҮҮХЭД ГЭР БҮЛ ХАМГААЛАЛ  
ХООЛ ТЭЖЭЭЛ ТЭТГЭВЭР ХАМТЫН АЖИЛЛАГАА  
МЭДЭЭЛЭЛ ХӨДӨЛМӨРИЙН НАС



Нийгмийн хамгааллын үнэлгээнд суурилсан  
үндэсний хэлэлцүүлэг:

Монгол Улсын нийгмийн хамгааллын  
суурь түвшний тодорхойлолт, зардал



ОУХБ Япон улсын  
олон/хоёр талт хамтын  
ажиллагааны хөтөлбөр



**Нийгмийн хамгааллын үнэлгээнд суурилсан  
үндэсний хэлэлцүүлэг:**

**Монгол Улсын нийгмийн хамгааллын  
суурь түвшний тодорхойлолт, зардал**

Copyright © Нэгдсэн үндэстний байгууллага, Олон улсын хөдөлмөрийн байгууллага,  
Монгол Улсын Засгийн газар 2015  
2015 онд анх удаа хэвлэгдэв.

Энэхүү тайланг зохих ёсоор мэдэгдсэний дагуу ашгийн бүс зорилгоор хэвлэн олшруулж, тарааж болно.

---

Нийгмийн хамгааллын үнэлгээнд суурилсан үндэсний хэлэлцүүлэг: Нийгмийн хамгааллын суурь түвшний тодорхойлолт, зардал / Нэгдсэн үндэстний байгууллага; ОУХБ-ын Ази, Номхон далайн бүсийн товчоо; Монгол Улсын Засгийн газар. Улаанбаатар: НҮБ/ОУХБ/Монгол Улсын Засгийн газар, 2015

ISBN: 9789228298352; 9789228298369 (web pdf)

Нэгдсэн үндэстний байгууллага; ОУХБ-ын Ази, Номхон далайн бүсийн товчоо; Монгол Улсын Засгийн газар

social protection / social security / social security policy / social security financing / rapid assessment / Mongolia

02.03.1

Англи хэл дээрх хувилбарыг дараах хаягаар орж үзнэ үү: Social protection assessment based national dialogue: Definition and cost of a social protection floor in Mongolia (ISBN 9789221298359; 9789221298366 (web pdf)), Улаанбаатар, 2015.

*ОУХБ-ын хэвлэлийн каталоги*

---

Нэгдсэн үндэстний байгууллагын практикт нийцүүлэн гаргадаг Нэгдсэн үндэстний байгууллага, Олон улсын хөдөлмөрийн байгууллага, Монгол Улсын Засгийн газрын хамтарсан хэвлэл нийтлэлд Нэгдсэн үндэстний байгууллага, Олон улсын хөдөлмөрийн байгууллага, Монгол Улсын Засгийн газрын зүгээс аливаа улс орон, бүс, газар нутгийн болон эрх барих байгууллагын эрх зүйн байдал, эсвэл тэдгээрийн хил хязгаарыг тогтоохтой холбоотой ямарваа нэг үзэл бодол илэрхийлдэггүй болно.

Зохиогчтой өгүүлэл, судалгаа болон бусад нийтлэлд илэрхийлэгдсэн үзэл бодлын талаарх хариуцлагыг гагцхүү тэдгээрийг зохиогч хүлээх бөгөөд Нэгдсэн үндэстний байгууллага, Олон улсын хөдөлмөрийн байгууллага, Монгол Улсын Засгийн газар хамтран хэвлэн нийтэлсэн нь тэдгээрт илэрхийлсэн үзэл бодлыг зөвшөөрсөн хэрэг биш юм.

Фирмийн нэр болон арилжааны зориулалттай бүтээгдэхүүн, технологийн үйл явцын талаар дурдсан нь Нэгдсэн үндэстний байгууллага, Олон улсын хөдөлмөрийн байгууллага, Монгол Улсын Засгийн газрын зүгээс тэдгээрийг сайшааж байгааг илэрхийлэхгүй бөгөөд тодорхой фирм, арилжааны зориулалттай бүтээгдэхүүн, технологийн үйл явцыг дурдалгүй орхигдуулсан бол энэ нь тэдгээрийг үгүйсгэсэн явдал биш болно.

ОУХБ-ын хэвлэл нийтлэл болон цахим бүтээгдэхүүнүүдийг томоохон номын худалдаа, эсвэл цахим мэдээллийн сангаас авах буюу [ilo@turpin-distribution.com](mailto:ilo@turpin-distribution.com) гэсэн и-мэйлээр шүүд захиалан авч болно. Илүү дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл [www.ilo.org/publns](http://www.ilo.org/publns), [www.un.org/publications](http://www.un.org/publications) вэб сайт, [ilopubs@ilo.org](mailto:ilopubs@ilo.org), [order@un.org](mailto:order@un.org) и-мэйл хаягуудаар холбогдоно уу.

---

Гэрэл зургийг © ILO/N. Munkhbaatar 2014, В. Byamba-Ochir 2012  
Монгол Улсад хэвлэв.

## Нийгмийн хамгааллын үнэлгээнд суурилсан үндэсний хэлэлцүүлэг:

## Монгол Улсын нийгмийн хамгааллын суурь түвшний тодорхойлолт, зардал

*Нийгмийн хамгааллын суурь түвшнийг бүрдүүлж буй дөрвөн баталгааны хүрээнд хамаарах нийгмийн даатгал, нийгмийн хамгааллын хөтөлбөрүүдийн тойм, бодлогын болон хэрэгжилтийн түвшинд тулгарч буй асуудлууд, бодлогын зөвлөмж, нийгмийн хамгааллын суурь түвшнийг хангахад шаардагдах зардлын тооцоолол*

Нэгдсэн үндэстний байгууллага болон Монгол Улсын Засгийн газрын хамтарсан Нийгмийн хамгааллын ажлын хэсгийг төлөөлж Селин Пейрон Биста (ОУХБ), Амгалангийн Лхагвадэмбэрэл (ОУХБ), Санжжавын Байгалмаа, Төмөртүлгын Батсүх нар энэхүү тайланг бэлтгэв.

Монгол Улсын нийгмийн хамгааллын суурь түвшний зардлыг тооцоход Ченг Онг Буун дэмжлэг үзүүлэв.

## Өмнөх үг

Монгол Улсын эдийн засаг хурдацтай өсч, сүүлийн арван жилийн хугацаанд дотоодын нийт бүтээгдэхүүний жилийн дундаж өсөлт 9 хувьтай байна. Энэ өсөлт уул уурхайн салбарын өсөлттэй шууд холбоотой. Энэхүү эдийн засгийн өсөлтийн үр дүнд ядуурал тодорхой хэмжээгээр буурсан боловч үр ашгийн хуваарилалт тэгш бус, хүн амынх нь 30 шахам хувь ядуурлын түвшнээс доогуур амьдарч байна. Тиймээс эдийн засгийн хурдацтай өсөлтийг хүртээмжтэй болгох, нийт ард түмний, ялангуяа ядуу, эмзэг бүлгийн иргэдийн амьжиргааны түвшинг дээшлүүлэхийн тулд нийгмийн хамгааллыг сайжруулах асуудал нэн чухал байна.

Монгол Улсын Засгийн газар, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын болон Хөдөлмөрийн яамдууд нь нийгмийн хамгааллын суурь түвшний үзэл баримтлалыг ядуурлыг бууруулж, эдийн засгийн өсөлтийг хүртээмжтэй болгох арга замын нэг гэж үзэж байна.

Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамнаас 2013 оны есдүгээр сард эхлүүлсэн нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих Үнэлгээнд суурилсан үндэсний хэлэлцүүлэг нь НҮБ-ын дэмжлэгтэйгээр бүтэн жилийн хугацаанд амжилттай зохион байгуулагдаж 2014 оны есдүгээр сард дүнгээ гаргалаа. Үнэлгээнд суурилсан үндэсний хэлэлцүүлгээр Монгол Улсын нийгмийн хамгааллын суурь түвшнийг тодорхойлж, шаардагдах зардлыг тооцоход тус болох асуудлуудыг хамтран тодорхойлохыг зорьсон билээ. Уг хэлэлцүүлэг нь нийгмийн хамгааллын цогц хөгжлийн үндэс суурь, хүн бүрийг нийгмийн хамгааллын тогтолцоонд хамруулах чиглэлд гарч буй ахиц дэвшлийг үнэлж дүгнэхэд тус болно. Үнэлгээнд суурилсан үндэсний хэлэлцүүлэг нь ядуурлыг бууруулах болон нийгмийн хамгааллын талаархи стратегийн хэрэгжилтэнд гарсан ахиц дэвшлийг хэмжих шинжилгээний болон хяналт үнэлгээний хүрээг тодорхойлоход тус болох ач холбогдолтой.

НҮБ нийгмийн хамгааллыг сайжруулах нь аливаа улс орны ядуурлыг бууруулах, нийгэм, эдийн засгийн хөгжлийг дэмжих, эдийн засгийн өсөлтийн үндэс суурийг илүү тогтвортой болгох үр дүнтэй арга гэж үздэг. Сүүлийн үед, ялангуяа 2008-2009 оны дэлхий нийтийг хамарсан санхүү, эдийн засгийн хямралаас хойш эдийн засгийн цочролын сөрөг нөлөөллийг бууруулах, эдийн засаг, нийгмийн хөгжлийг хурдасгах нэг арга зам гэж үзэж нийгмийн хамгаалалд ихээхэн анхаарал хандуулж байна.

2009 оны дөрөвдүгээр сард НҮБ-ын Удирдах зөвлөлөөс дэлхийн санхүүгийн хямралын хариу арга хэмжээний нэг болгож нийгмийн хамгааллын суурь түвшний талаарх санаачилгыг баталсан билээ. Энэ шийдвэр нь нийгмийн хамгааллын суурь түвшинг хангах, нийгмийн үйлчилгээг бүх хүнд хүртээмжтэй болгох талаарх дэлхий нийтийн үүрэг амлалтын илэрхийлэл болсон юм. Түүнээс хойш энэ санаачилгыг дэлхийн нийтээр дэмжиж байна. Тухайлбал, 2011 онд Францад, 2012 онд Мексикт болсон Их 20-ын уулзалтаас, 2012 онд Нийгмийн хамгааллын суурь түвшний тухай зөвлөмжийг баталсан Олон улсын хөдөлмөрийн бага хурал энэхүү санаачлагыг дэмжих шийдвэр гаргасан байна. Нийгмийн хамгааллын суурь түвшинг бүрдүүлэх асуудал нь 2015 оноос хойшхи хөгжлийн бодлого болох Тогтвортой хөгжлийн зорилтуудын нэг байх болно.

Нийгмийн хамгааллын суурь түвшин нь тухайн орны нийт иргэдийг нэн шаардлагатай эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хамруулах, хүүхдэд боловсрол, асрамж халамжийн болон хоол тэжээлийн дэмжлэг үзүүлэх, хөдөлмөрийн насныхан, ахмадууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн орлогын баталгааг хангах замаар хамгийн наад захын нийгмийн тусламж, үйлчилгээг хүртэх боломжийг нь баталгаажуулах зорилготой юм. Түүнчлэн нийгмийн хамгааллын суурь түвшний үзэл баримтлал нь НҮБ-ын төрөлжсөн байгууллагууд, хөгжлийн түншүүд, олон улсын санхүүгийн байгууллагуудад нийгмийн хамгааллыг өргөжүүлэх, нийгмийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг сайжруулахын төлөө хамтран ажиллах боломж олгож байна.

Афганистан, Камбож, Энэтхэг, Индонези, Мьянмар, Балба, Пакистан, Филиппин, Соломоны арлууд, Тайланд, Вануату, Вьетнам зэрэг Ази, Номхон далайн бүс нутгийн олон улс нийгмийн хамгааллын суурь түвшний үзэл баримтлалыг хүлээн зөвшөөрч, нийгмийн хамгааллын бодлого, стратегия боловсруулж, тэргүүлэх чиглэлээ тодорхойлохдоо үнэлгээнд суурилсан үндэсний хэлэлцүүлгийн аргыг ашигласан байна.


Бид энэхүү хэлэлцүүлгийн үр дүн, ялангуяа энэ тайланд тусгасан зөвлөмжүүд нь Монгол Улсад нийгмийн хамгааллын суурь түвшинг бүрдүүлж, хэрэгжүүлэхэд тус дөхөм болохын зэрэгцээ бодит ажил хэрэг болж хэрэгжинэ гэж найдаж байна. Энэ хэлэлцүүлэгт хэрэглэсэн оролцооны арга нь салбарын яамд, ажилчдын болон ажил олгогчдын төлөөлөгчид, иргэний нийгмийн байгууллагууд, НҮБ-ын төрөлжсөн байгууллагуудын дунд нийгмийн хамгааллын суурь түвшний үзэл баримтлал, ач холбогдлыг таниулж, нийгмийн хамгааллын харилцан уялдаатай цогц хөгжлийн хандлага чухал болохыг ойлгуулахад хувь нэмрээ оруулсан гэдэгт итгэлтэй байна.

Сезин Синаноглу



НҮБ-ын Суурин зохицуулагч  
НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн  
Суурин төлөөлөгч

Тим Дэ Мэйэр



ОУХБ-ын БНХАУ, Монгол Улсыг хариуцсан  
товчооны захирал

## Гарчиг

|                                                                                                                                                              |      |
|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------|
| Өмнөх үг .....                                                                                                                                               | vi   |
| Гарчиг .....                                                                                                                                                 | viii |
| Зургийн жагсаалт .....                                                                                                                                       | ix   |
| Хүснэгтийн жагсаалт .....                                                                                                                                    | x    |
| Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамны талархал .....                                                                                                    | xi   |
| Хөдөлмөрийн яамны талархал .....                                                                                                                             | xii  |
| Зохиогчдын талархал .....                                                                                                                                    | xiii |
| Товч хураангуй .....                                                                                                                                         | xiv  |
| Товчилсон үгсийн жагсаалт .....                                                                                                                              | xxi  |
| 1. Танилцуулга .....                                                                                                                                         | 1    |
| 2. Агуулга ба үйл явц .....                                                                                                                                  | 3    |
| 3. Үнэлгээнд суурилсан үндэсний хэлэлцүүлэг: Зорилго, арга зүй, үйл явц .....                                                                                | 5    |
| 3.1. Зорилго .....                                                                                                                                           | 5    |
| 3.2. Ерөнхий арга зүй, үйл явцын өрнөл .....                                                                                                                 | 5    |
| 3.3. Монгол Улсын нийгмийн хамгааллын тогтолцооны тойм .....                                                                                                 | 10   |
| 4. Нэгдүгээр үе шат. Монгол Улсад явагдсан нийгмийн хамгаалал болон хөдөлмөр эрхлэлтийг дэмжих асуудлаарх ҮСҮХ-ийн матрицийн боловсруулалт, үр дүн .....     | 15   |
| 4.1. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ .....                                                                                                                  | 16   |
| 4.2. Хүүхэд .....                                                                                                                                            | 27   |
| 4.3. Хөдөлмөрийн насны хүн ам .....                                                                                                                          | 38   |
| 4.4. Ахмад настан .....                                                                                                                                      | 59   |
| 5. Хоёрдугаар үе шат: Зардал тооцох аргачлал, нийгмийн хамгааллын суурь түвшинг хангах бодлогын саналууд (“хувилбарууд”)-ын тайлбар, зардлын тооцоолол ..... | 69   |
| 5.1. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ .....                                                                                                                  | 74   |
| 5.2. Хүүхэд .....                                                                                                                                            | 78   |
| 5.3. Хөдөлмөрийн насны хүн ам .....                                                                                                                          | 84   |
| 5.4. Ахмад настан .....                                                                                                                                      | 94   |
| 6. Монгол Улсын нийгмийн хамгааллын суурь түвшин .....                                                                                                       | 99   |
| 6.1. Монгол Улсын НХСТ-г хангахад тулгамдаж буй бодлогын асуудлуудыг шийдвэрлэхэд чиглэсэн нэгдсэн зөвлөмж .....                                             | 99   |
| 6.2. Монгол Улсад нийгмийн хамгааллын суурь түвшин тогтоох хувилбаруудын зардлын харьцуулалт .....                                                           | 101  |
| 6.3. Монгол Улсын нийгмийн хамгааллын суурь түвшний тодорхойлолт, зардал .....                                                                               | 103  |

|                                                                                              |     |
|----------------------------------------------------------------------------------------------|-----|
| 6.4. Монгол Улсын нийгмийн хамгааллын суурь түвшинг санхүүжүүлэх төсвийн багтаамж .....      | 107 |
| 6.5. Салбар дундын зохицуулалт, тусламж үйлчилгээг үр дүнтэй хүргэх хэрэгцээ шаардлага ..... | 111 |
| Ашигласан материал .....                                                                     | 112 |
| Хавсралт.....                                                                                | 115 |

## Зургийн жагсаалт

|                                                                                                                                                                                    |       |
|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------|
| Зураг 1. Монгол Улсын нийгмийн хамгааллын суурь түвшинг хангахад шаардагдах нэмэлт зардлын тооцоо, баталгаа тус бүрээр .....                                                       | xviii |
| Зураг 2. Нийгмийн хамгааллын зардлын ДНБ-д эзлэх хувийг НХСТ-ий зардлын төсөөлөлтэй харьцуулсан байдал (2014-2020) .....                                                           | xviii |
| Зураг 3. РАП загварын бүтэц .....                                                                                                                                                  | 6     |
| Зураг 4. ҮСҮХ-ийн үйл явц .....                                                                                                                                                    | 10    |
| Зураг 5. Монгол Улсын нийгмийн хамгааллын тогтолцооны ерөнхий бүтэц .....                                                                                                          | 11    |
| Зураг 6. Монгол Улсын нийгмийн даатгалын тогтолцоо .....                                                                                                                           | 12    |
| Зураг 7. Үнэлгээний матрицийн бүтэц .....                                                                                                                                          | 13    |
| Зураг 8. Монгол Улсын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хамралтыг олон хэмжээст үзүүлэлтээр бусад орнуудтай харьцуулсан байдал (2011) .....                                      | 25    |
| Зураг 9. Хүүхдэд зориулсан одоогийн нийгмийн хамгааллын хөтөлбөрүүд .....                                                                                                          | 28    |
| Зураг 10. Монгол Улсын хөдөлмөрийн насны хүн амд зориулсан нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих одоогийн хөтөлбөрүүд .....                                               | 38    |
| Зураг 11. 15-аас дээш насны нийт хүн амын тоо, засварласан тооцоо (2012), (а) эрэгтэй (б) эрэгтэй .....                                                                            | 70    |
| Зураг 12. Зардлын хувьд их, бага хувилбараар тооцсон НХСТ-ийг хангахад нэмж шаардагдах зардлыг хөтөлбөр тус бүрээр харьцуулан тооцсон үр дүн, ДНБ-д эзлэх хувиар (2014-2020) ..... | 101   |
| Зураг 13. Зардлын хувьд их, бага хувилбараар тооцсон НХСТ-ийг хангахад нэмж шаардагдах зардлыг баталгаа тус бүрээр харьцуулан тооцсон үр дүн, ДНБ-д эзлэх хувиар (2014-2020) ..... | 102   |
| Зураг 14. Нийгмийн зардлыг ДНБ-д эзлэх хувиар тооцож, НХСТ-ий зардал бага, их хувилбаруудтай харьцуулсан байдал .....                                                              | 102   |
| Зураг 15. Нийгмийн зардлын ДНБ-д эзлэх хувь, одоогийн нийгмийн хамгааллын зардлыг НХСТ-ий зардалтай харьцуулсан байдал (2014-2020) .....                                           | 105   |
| Зураг 16. Монгол Улсын нэгдсэн төсөв, нийгмийн зардлын эзлэх хувь, орлого, зарлагын өсөлтийн хувийг өмнөх жилтэй харьцуулсан байдал (тэрбум төгрөг) .....                          | 107   |
| Зураг 17. Нийгмийн хамгааллын нийт зарлага, эх үүсвэрээр (тэрбум төгрөг) .....                                                                                                     | 108   |
| Зураг 18. Нийгмийн зардлын ДНБ-нд болон улсын төсвийн орлого, тусламжийн дүнд эзлэх хувь, 2005-2020 .....                                                                          | 108   |
| Зураг 19. Нийгмийн хамгааллын зарлага болон НХСТ-ий зардлын улсын төсвийн орлого, тусламжийн дүнд эзлэх хувь (гүйцэтгэл ба төсөөлөл) .....                                         | 109   |
| Зураг 20. Төсвийн алдагдлын ДНБ-д эзлэх хувь (оны үнээр), одоогийн нийгмийн хамгааллын зардлыг НХСТ-ий зардалтай харьцуулсан байдал .....                                          | 110   |
| Зураг 21. НХСТ-ий зардлыг улсын төсвийн нийт зарлага, нийт орлого, тусламжийн дүнд харьцуулсан байдал .....                                                                        | 110   |

## Хүснэгтийн жагсаалт

|                                                                                                                                                                         |     |
|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----|
| Хүснэгт 1. Монгол Улсын нийгмийн хамгааллын суурь түвшний тодорхойлолт .....                                                                                            | xvi |
| Хүснэгт 2. Үнэлгээнд суурилсан үндэсний хэлэлцүүлгийн хамрах хүрээ .....                                                                                                | 6   |
| Хүснэгт 3. Нийгмийн даатгалд даатгуулагчдын тоо (мянган хүн) .....                                                                                                      | 13  |
| Хүснэгт 4. Нийгмийн даатгалд даатгуулагчдын ЭЗИХА-д эзлэх хувь .....                                                                                                    | 13  |
| Хүснэгт 5. Эрүүл мэндийн даатгалын хөгжлийн урт хугацааны стратегийн зорилтууд (2013-2022) ...                                                                          | 18  |
| Хүснэгт 6. Эрүүл мэндийн даатгалд даатгуулагчдын тоо (мянган хүн) .....                                                                                                 | 22  |
| Хүснэгт 7. ҮСҮХ-ээс эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг<br>сайжруулах чиглэлээр гаргасан зөвлөмжүүд .....                                                   | 26  |
| Хүснэгт 8. Эмзэг бүлгийн хүүхдүүдийн боловсролыг дэмжихэд чиглэсэн хөтөлбөрүүд .....                                                                                    | 32  |
| Хүснэгт 9. Хүүхдэд зориулсан нийгмийн хамгааллын хөтөлбөрүүдийн хураангуй .....                                                                                         | 34  |
| Хүснэгт 10. ҮСҮХ-ээс хүүхдийн нийгмийн хамгааллын чанарыг сайжруулах<br>чиглэлээр гаргасан зөвлөмжүүд .....                                                             | 37  |
| Хүснэгт 11. 1994 ба 1999 онд батлагдсан хуулиудын тахир дутуугийн болон тэжээгчээ алдсаны<br>тэтгэвэртэй холбоотой зохицуулалтыг харьцуулсан байдал .....               | 44  |
| Хүснэгт 12. Нийгмийн халамжийн бусад мөнгөн тусламж (2013) .....                                                                                                        | 46  |
| Хүснэгт 13. Хөдөлмөрийн насны хүн амд зориулсан нийгмийн хамгааллын<br>хөтөлбөрүүдийн хураангуй .....                                                                   | 53  |
| Хүснэгт 14. ҮСҮХ-ээс хөдөлмөрийн насны хүн амын орлогын баталгааг хангах<br>чиглэлд гаргасан зөвлөмжүүд .....                                                           | 58  |
| Хүснэгт 15. Монгол Улсын тэтгэврийн зэрэгцээ хоёр хөтөлбөр .....                                                                                                        | 63  |
| Хүснэгт 16. Нийгмийн халамжийн бусад мөнгөн тусламж, дэмжлэг .....                                                                                                      | 65  |
| Хүснэгт 17. Ахмад настанд зориулсан нийгмийн хамгааллын хөтөлбөрүүдийн хураангуй .....                                                                                  | 66  |
| Хүснэгт 18. ҮСҮХ-ээс ахмад настны нийгмийн хамгааллыг баталгаажуулах<br>чиглэлд гаргасан зөвлөмжүүд .....                                                               | 68  |
| Хүснэгт 19. Монгол Улсын хүн амын дундаж наслалт 2007-2013 .....                                                                                                        | 70  |
| Хүснэгт 20. Өрхийн сарын дундаж орлогын эх үүсвэрүүд<br>(2012 оны 4-р улирлын байдлаар, төгрөгөөр) .....                                                                | 72  |
| Хүснэгт 21. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хамралттай холбоотой хувилбарууд .....                                                                                  | 74  |
| Хүснэгт 22. ЭМД-тай холбоотой хувилбаруудын зардлын тооцооллын үр дүн .....                                                                                             | 77  |
| Хүснэгт 23. Хүүхдийн нийгмийн хамгаалалтай холбоотой хувилбарууд .....                                                                                                  | 78  |
| Хүснэгт 24. Хүүхдийн орлогын баталгаа, хоол тэжээлийг сайжруулахтай<br>холбоотой зардлын тооцооллын дүн .....                                                           | 82  |
| Хүснэгт 25. Хөдөлмөрийн насны хүн амын нийгмийн даатгалтай холбоотой хувилбарууд .....                                                                                  | 84  |
| Хүснэгт 26. Хөдөлмөрийн насны хүн амын ХЗЗИБ-той холбоотой хувилбарууд .....                                                                                            | 85  |
| Хүснэгт 27. Хөдөлмөрийн насны хүн амын нийгмийн даатгалд хамрагдалтыг нэмэгдүүлж,<br>хөдөлмөр эрхлэлтийг дэмжихтэй холбоотой хувилбаруудын зардлын тооцооллын дүн ..... | 90  |
| Хүснэгт 28. Ахмад настны нийгмийн хамгаалалтай холбоотой хувилбарууд .....                                                                                              | 94  |
| Хүснэгт 29. Малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн өндөр насны тэтгэврийн<br>даатгалын хамрагдалтыг өргөжүүлэхтэй холбоотой зардлын тооцооллын дүн .....                 | 96  |
| Хүснэгт 30. Санал болгож буй зардал их, бага хувилбаруудын нэгтгэл .....                                                                                                | 99  |
| Хүснэгт 31. Нийгмийн хамгааллын зардлын ДНБ-д эзлэх бүсийн дундаж хувь<br>(нийт хүн амын жигнэсэн дундажаар), баталгаа тус бүрээр .....                                 | 103 |
| Хүснэгт 32. Монгол Улсын нийгмийн хамгааллын суурь түвшний тодорхойлолт .....                                                                                           | 104 |

## Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамны талархал

Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага(ОУХБ)-аас Япон Улсын Засгийн газрын санхүүгийн дэмжлэгтэйгээр АСЕАН-ны гишүүн орнуудад үзүүлж байгаа техникийн туслалцааны хүрээг өргөтгөн Монгол Улсад нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих асуудлаар төсөл хэрэгжүүлж байгаа билээ.

НҮБ болон ОУХБ-ын нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих түс төслийн дэмжлэгтэйгээр явуулсан үнэлгээнд суурилсан үндэсний хэлэлцүүлгүүдээр Монгол Улсын нийгмийн хамгааллын одоогийн тогтолцоо нь ОУХБ-ын 2012 оны 202 дугаар зөвлөмжид заасан нийгмийн хамгааллын суурь түвшний үндсэн дөрвөн баталгааг хангаж байгаа эсэхийг тодорхойлсон юм.

Монгол Улс гурван сая иргэнтэй болсон түүхэн чухал цаг үед хүн бүр үндэснийхээ хэмжээнд тодорхойлсон 1) зайлшгүй шаардлагатай эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг боломжийн үнэ өртгөөр хүртэх, 2) хүүхэд бүрт хоол тэжээл, боловсрол, асаргаа авах шаардлагыг хангахуйц мөнгөн болон түүнтэй адилтгах тусламж, дэмжлэг үзүүлэх замаар орлогын баталгааг хангах, 3) орлого багатай хөдөлмөрийн насны иргэдийг орлогын наад захын баталгаагаар хангах, 4) ахмад настнуудыг тэтгэвэр, тэтгэмж, тусламж үйлчилгээгээр дамжуулан амьжиргааны баталгаажих доод түвшний орлогоор хангахаар нийгмийн хамгааллын суурь түвшнийг тогтоох үнэлгээ хийж, нийт хүн амд баталгаажуулан оролцогч бүх талууд нэгдсэн зөвшилцөлд хүрч чадсан нь том ололт гэж дүгнэж байна.

Дунд болон урт хугацаанд хүн амын нийгмийн хамгааллын баталгааг хангах, ажилгүйдэл, ядуурлыг бууруулахад хэдий хэмжээний хөрөнгө шаардлагатай болох талаар тооцоолсон нь цаашдын нийгмийн хамгааллын нотолгоонд суурилсан бодлого боловсруулахад чухал дэмжлэг болно гэдгийг тэмдэглэх нь зүйтэй.

Нийгмийн хамгааллын одоогийн нөхцөл байдлыг дүгнэн, Монгол Улсын нийгмийн хамгааллын суурь түвшнийг тодорхойлж ажилласан НҮБ болон Засгийн газрын хамтарсан Нийгмийн хамгааллын ажлын хэсгийн гишүүд, түүнчлэн Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам, Хөдөлмөрийн яам, Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо, Монголын үйлдвэрчний эвлэлийн холбооны төлөөллөөс бүрдсэн Төслийн удирдах хорооны хамт олон болон бусад оролцогчдод талархлаа илэрхийлье.

Хүндэтгэсэн,



Содномзүндүйн Эрдэнэ  
УИХ-ын гишүүн, Засгийн газрын гишүүн,  
Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд

## Хөдөлмөрийн яамны талархал

Монгол Улсын Засгийн газар НҮБ-ын туслалцаатайгаар нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих асуудлаар 2013 оны 9 дүгээр сараас хойшхи хугацаанд үнэлгээнд суурилсан үндэсний хэлэлцүүлгүүдийг зохион байгуулаад байна. Эдгээр хэлэлцүүлгийг зохион байгуулж, Монгол улсад нийгмийн хамгааллыг өргөжүүлж, наад захын хэм хэмжээг тогтооход үнэтэй зөвлөмж өгч, хамтран ажилласан ажлын хэсгийн хамт олонд талархал илэрхийлье.

Засгийн газар, Хөдөлмөрийн яам хөдөлмөрийн насны иргэд, хөдөлмөрийн зах зээл дэх эмзэг бүлгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, арга хэмжээ, үйлчилгээнд хамруулах болон ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тэтгэвэр, тэтгэмжийн үйлчилгээ үзүүлэх замаар орлогын түвшинг нэмэгдүүлж, нийгмийн хамгааллын доод хэм хэмжээг хангах, улмаар орлогын баталгаат түвшинг дээшлүүлэх зорилт тавин ажиллаж байна.

Хөдөлмөрийн салбарт сүүлийн 10 гаруй жилийн хугацаанд зохистой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, хүн амын зорилтот бүлгүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр шат дараалсан бодлогын шинэчлэлүүд хийгдэж, тодорхой нааштай үр дүн гарч байна. Тухайлбал, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, нөхөрлөл, хоршоо байгуулах иргэн, малчид, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, залуусын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ахмад зөвлөхүүдэд орлогын дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээнүүдийг дурдаж болно.

Цаашид үнэлгээнд суурилсан үндэсний хэлэлцүүлгээр тодорхойлсон Монгол Улсын нийгмийн хамгааллын суурь түвшнийг хангах зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх, ялангуяа залуу малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, залуучуудыг мэргэжил эзэмшин байнгын орлоготой, ажлын байртай болох, нийгмийн даатгалд хамрагдах зэрэг арга хэмжээнд түлхүү анхаарал хандуулж ажиллах шаардлагатай юм.

Нийгмийн хамгааллын арга хэмжээг хөдөлмөрийн зах зээлийн идэвхтэй бодлого, арга хэмжээнүүдтэй үр дүнтэй, системтэй уялдуулахад идэвх санаачлагатай хамтын ажиллагаа илүү үр дүнг авчирна гэдэгт итгэж байна.

Хүндэтгэсэн,



Содномын Чинзориг  
Засгийн газрын гишүүн,  
Хөдөлмөрийн сайд

## Зохиогчдын талархал

Зохиогчид 2013 онд хэвлэгдэн гарсан ОУХБ-ын Үнэлгээнд суурилсан үндэсний хэлэлцүүлэг (ҮСҮХ)-ийн талаарх сайн туршлагын гарын авлагыг Монгол Улсад явагдсан ҮСҮХ-ийн удирдамж болгон ашигласан болно.

Зохиогчдын зүгээс үндэсний хэлэлцүүлгийн туршид дэмжлэг үзүүлсэн нийт оролцогчид, тухайлбал, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам (ХАХНХЯ), Хөдөлмөрийн яам, Нийгмийн даатгалын ерөнхий газар (НДЕГ), Эрүүл мэнд, спортын яам (ЭМСЯ), Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам (БСШУЯ), Сангийн яам, Хөдөлмөрийн судалгааны институт (ХСИ), Үндэсний статистикийн хороо (ҮСХ), Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо (МАОЭНХ), Монголын үйлдвэрчний эвлэлийн холбоо (МҮЭХ), иргэний нийгмийн байгууллагууд болон нийгмийн хамгааллын суурь түвшний санаачилгад оролцсон НҮБ-ын төрөлжсөн байгууллагуудын төлөөлөгчдөд гүн талархал илэрхийлж байна.

Мөн ХАХНХЯ, ялангуяа тус яамны Нийгмийн хамгааллын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, Хөдөлмөрийн яамны Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт ҮСҮХ-ийг зохион байгуулахад манлайлах үүрэг гүйцэтгэж, энэ тайланд үнэтэй санал, зөвлөмж өгсөнд талархал илэрхийлэхийг хүсч байна.

Хэлэлцүүлгийн туршид байнга дэмжлэг үзүүлж ажилласан ХАХНХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Б.Отгонжаргал, НҮБ-ын Суурин зохицуулагч, НҮБХХ-ийн Монгол Улс дахь суурин төлөөлөгч Сезин Синаноглу болон ОУХБ-ын БНХАУ, Монгол Улсыг хариуцсан товчооны захирал Тим Дэ Мэйэр нарт гүнээ талархаж байна.

Түүнчлэн мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж, бодлогын удирдамжаар ханган санал шүүмжээ харамгүй хуваалцсан:

- ХАХНХЯ-ны Нийгмийн хамгааллын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Л.Мөнхзүл;
- МҮЭХ-ны Ерөнхий нарийн бичгийн дарга Г.Адьяа;
- МАОЭНХ-ны Дэд ерөнхийлөгч, Гүйцэтгэх захирал Х.Ганбаатар;
- МАОЭНХ-ны Ерөнхийлөгчийн Зөвлөх Д.Нармандах;
- Хөдөлмөрийн яамны Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах мэргэжилтэн Ч.Эрдэнэчимэг;
- Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Ц.Уртнасан нарт талархал илэрхийлье.

Зохиогчид НҮБ/Засгийн газрын хамтарсан Нийгмийн хамгааллын ажлын хэсгийн гишүүд:

- Саураб Синха – НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр (НҮБХХ);
- Др.Су Ньюнт-У болон Б.Цогзолмаа – Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (ДЭМБ);
- Н. Энхнасан болон Викториа Коламарко – НҮБ-ын Хүүхдийн сан (НҮБХС),
- П. Болормаа –(ОУХБ) нарт энэ ажилд идэвхтэй оролцож, хамтран ажиллаж, техникийн дэмжлэг туслалцаа үзүүлж ирсэн явдалд талархлаа илэрхийлэхийг хүсч байна.

Эцэст нь, Япон Улсын Эрүүл мэнд, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд ОУХБ/Япон Улсын хамтарсан олон талт хөтөлбөрийн хүрээнд энэхүү ҮСҮХ-ийг, ялангуяа ОУХБ-ын Техникийн хамтын ажиллагааны “Монгол Улсад эмзэг бүлгийн нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг дэмжих, АСЕАН-ны туршлагаас суралцах нь” (2014-2015) төслийг санхүүжүүлж байгаа явдалд онцгойлон талархал илэрхийлж байна.

## Товч хураангуй

### Монгол Улс нийгмийн хамгааллын суурь түвшинг хангаж чадсан уу?

Нийгмийн хамгааллыг өргөжүүлж, наад зах нь нийгмийн хамгааллын суурь түвшинг тогтоох нь Монгол Улсын нэн тэргүүний зорилт болоод байна.

Нийгмийн хамгааллын суурь түвшин (НХСТ) гэдэг нь нийгмийн гишүүн бүрийг ямар ч үед хамгийн наад захын хэрэгцээт бараа, үйлчилгээг хүртэх боломж бололцоогоор хангаж буй хүний эрх, тэтгэмж, тусламжийн үндсэн багц юм. Энэ нь: (i) тухайн улсад оршин суугаа хүн бүрт үндэснийхээ хэмжээнд тодорхойлсон нэн шаардлагатай эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багцыг боломжийн үнэ өртгөөр хүргэх; (ii) хүүхэд бүрт хоол тэжээл, боловсрол, асаргаа авах боломжийг хангахуйц мөнгөн буюу түүнтэй адилтгах тусламж дэмжлэг үзүүлэх замаар орлогын баталгааг нь хангах; (iii) хангалттай орлого олох боломжгүй байгаа хөдөлмөрийн идэвхтэй насны хүмүүст мөнгөн буюу түүнтэй адилтгах тусламж дэмжлэг үзүүлэх болон хөдөлмөр эрхлэлтийн хөтөлбөрт хамруулах замаар орлогын наад захын баталгаагаар хангах; (iv) өндөр насны тэтгэвэр, бусад тусламж үйлчилгээгээр дамжуулан тухайн улсад оршин суугаа ахмад настан бүрийг наад зах нь үндэснийхээ хэмжээнд тодорхойлсон доод түвшинг хангахуйц орлогын баталгаагаар хангахад чиглэдэг.

НХСТ тогтоох санаачилга нь НҮБ-ын бүх төрөлжсөн байгууллагуудыг олон улсын санхүүгийн институциуд болон төрийн бус байгууллага(ТББ)-уудтай хамтран засгийн газар, нийгмийн түншүүд, бусад оролцогч талуудад нийгмийн хамгааллыг өргөжүүлэхэд гаргаж буй хүчин чармайлтад нь зохион байгуулалттайгаар дэмжлэг үзүүлэхийг уриалж байгаа юм. Нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үнэлгээнд суурилсан үндэсний хэлэлцүүлэг (ҮСҮХ) нь нийт хүн амд нийгмийн хамгааллын суурь түвшинг хангаж баталгаажуулахын тулд бүх талыг нийгмийн хамгааллын асуудлаар нөхцөл байдлаа дүгнэх, бодлогын хийдэл болон хэрэгжүүлэлтийн түвшинд тулгарч буй асуудлуудаа тодорхойлох, улмаар нийгмийн хамгааллын хамрах хүрээг өргөжүүлэх талаар бодлогын зөвлөмжүүд дээр нэгдсэн зөвшилцөлд хүрэх үндэс суурь болно.

НХСТ-г хангах чиглэлд гаргасан санал зөвлөмжийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын төсөөллийг ОУХБ-ын Түргэвчилсэн үнэлгээний протокол буюу РАП загварыг ашиглан таван жилийн хугацаагаар тооцоолсон юм. Зардлын тооцоолол нь төсвийн багтаамж, төсвийн зардлыг дахин хуваарилах асуудлыг авч үзэх үндэс суурь болохоос гадна эргээд нийгмийн хамгааллын бодлогын янз бүрийн хувилбаруудыг ач холбогдлоор нь эрэмбэлэхэд тус болно.

2013 оны 7 дугаар сараас 2014 оны 12 дугаар сар хүртэлх хугацаанд Засгийн газар, тухайлбал Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам (ХАХНХЯ) болон НҮБ-ын Монгол Улс дахь Удирдлагын баг хамтран нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих асуудлаар ҮСҮХ-ийг зохион байгуулсан юм.

Үндэсний хэлэлцүүлгээс Монгол Улсад НХСТ бүрэн бүрэлдэж чадаагүй, өөрөөр хэлбэл хүн бүрийн орлогын аюулгүй байдал, нэн шаардлагатай нийгмийн үйлчилгээнд хамрагдах боломжийг баталгаажуулсан цогц бодлого, арга хэмжээ хараахан бий болоогүй байна гэж дүгнэсэн. Хэлэлцүүлэгт оролцогчид үндэсний хэмжээнд тодорхойлсон НХСТ-г хангахын тулд зарим баталгаа (эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, жирэмсний болон амаржсаны тэтгэмж, хүүхэд хамгаалал зэрэг)-ны хувьд одоо хэрэглэж байгаа бүх нийтийг хамарсан зарчмыг хэвээр үлдээх, нийгмийн хамгааллын зардлыг хязгаарлах зорилгоор нийгмийн тусламж, дэмжлэгийг тодорхой бүлгүүдэд хамааруулах үзэл бодлын хариу болгож бусад тэтгэвэр, тэтгэмж (тухайлбал, өндөр насны тэтгэвэр)-ийг бүх хүнд хүргэх чиглэлд хүчин чармайлт гаргах нь чухал болохыг онцолсон юм. Нийгмийн хамгааллын зарим тодорхой тусламж дэмжлэгт орлогоос хамааралтай шалгуур тавих нь нийгмийн хамгааллын хүрсэн түвшинг дордуулж, ядуурлыг бууруулахад гарсан ахиц дэвшлийг ухраах хор үршигтай гэсэн дүгнэлтийг хэлэлцүүлэгт оролцогчид хийсэн болно.

Монгол Улсын НХСТ-ийг тодорхойлоход чиглэсэн дараах гол зөвлөмжүүд дээр ҮСҮХ-ийн оролцогчид санал нэгдсэн юм. Үүнд:

**Баталгаа 1. Эрүүл мэнд:** Эрүүл мэндийн даатгал албан журмынх бөгөөд бараг бүх нийтийн хамралтад хүрсэн боловч хөдөө орон нутагт амьдарч буй олон хүн эрүүл мэндийн чанартай тусламж, үйлчилгээ авахад хүндрэл бэрхшээлтэй хэвээр байна. Сүүлийн үед (төрөөс шимтгэлийг нь санхүүжүүлэх замаар хүн амыг эрүүл мэндийн даатгалд бүрэн хамруулсан 2011 онтой харьцуулахад) хамрагдалт 6 хувиар буурсан нь үйлчлүүлэгчид тусламж, үйлчилгээнд сэтгэл дундуур байгаагийн илрэл байж болзошгүй бөгөөд энэ нь иргэдийн шимтгэл төлөх эрмэлзлийг бууруулахад нөлөөлсөн байх магадлалтай. Хүмүүсийн хувиасаа төлж буй төлбөр өндөр, улсын эмнэлгүүдийн үйлчилгээ үр ашиг муутай байгаа нь эрүүл мэндийн даатгалд сайн дураар хамрагдах эрмэлзлийг бууруулж, улмаар эрүүл мэндийн зохих тусламж, үйлчилгээ хүртэхэд нь саад учруулж байна. Энэ хүрээнд гол нь эрүүл мэндийн үйлчилгээний чанар, олдоц, хүртээмжийг сайжруулах шаардлагатай гэсэн зөвлөмжийг гаргасан юм.

**Баталгаа 2. Хүүхэд:** Ерөнхий боловсрол (бүрэн дунд буюу 12 жилийн боловсрол), эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг бүх хүүхдэд үнэ төлбөргүй олгож байна. Сургуулийн дотуур байр хүрэлцээтэй, үнэ төлбөргүй хангаж байгаа нь боловсролын үйлчилгээнд үр дүнтэй хамрагдах боломжийг баталгаажуулж байна. 2012 оноос хойш бүх хүүхдэд олгосон хүүхдийн мөнгө нь 0 – 18 насны хүүхэд бүрийг хамгийн наад захын орлогын баталгаагаар хангаж байна. Энэ хүрээнд гол нь бүх хүүхдийн эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг төрөөс бүрэн хариуцаж байгааг хэвээр үлдээж, хүүхдийн мөнгийг орлогын шалгуураар бус одоогийн байдлаар нь бүх хүүхдэд үргэлжлүүлэн олгох зэрэг зөвлөмжүүд гарсан юм. Мөн бүх хүүхэд хүүхдийн мөнгөнд хамрагдаж байгааг хуулиар баталгаажуулах, амьжиргааны өртгийн өсөлттэй уялдуулан индексжүүлэх, цэцэрлэгийн хүүхдийн хоолны чанарыг сайжруулах, нийгмийн ажилтны үйлчилгээг чанартай хүртээмжтэй болгох, ялангуяа тусгай хэрэгцээ бүхий хүүхдүүд уг үйлчилгээг авах боломжийг нэмэгдүүлэх асуудал зөвлөмжид багтсан болно.

**Баталгаа 3. Хөдөлмөрийн насны иргэд:** Нийгмийн даатгалд сайн дураар хамрагдалт бага, орлогын дэмжлэг үзүүлэх хөтөлбөрүүд (нийгмийн халамжийн хөтөлбөрүүд болон ажилгүйдлийн тэтгэмж зэрэг) болон хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээ хоорондын уялдаа холбоо сул байна. Хөдөлмөрийн насны хүн амын тухайд нийгмийн хамгааллын суурь түвшин тогтоох талаар гаргасан гол зөвлөмж нь малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн нийгмийн даатгалд хамрагдалтыг нэмэгдүүлэх урамшууллын механизмыг нэвтрүүлэх (тухайлбал, шимтгэлд татаас олгох); нийгмийн даатгалд сайн дураар хамрагдсан эмэгтэйчүүдийн жирэмсний болон амаржсаны тэтгэмж бодох хувь хэмжээг нэмэгдүүлэх; нийгмийн даатгалыг хөдөлмөрийн зах зээлийн идэвхтэй арга хэмжээний хөтөлбөрүүдтэй үр дүнтэй, системтэй уялдуулах зэрэг болно.

**Баталгаа 4. Ахмад настан:** Хувийн хэвшилд ажиллагчид болон төрийн албан хаагчдын өндөр насны тэтгэврийн даатгалд хамрагдалт өндөр байна. Харин малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, албан бус эдийн засагт ажиллагчдын уг даатгалд хамрагдалтыг нэмэгдүүлэх зорилгоор удаа дараа хүчин чармайлт гаргаж байгаа боловч тэдний дөнгөж 23.4 хувь нь нийгмийн даатгалд сайн дураар шимтгэл төлж байна. Тиймээс ҮСҮХ-ээс малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, албан бус эдийн засагт ажиллагчдыг тэтгэврийн даатгалд албан журмаар хамруулах, төрөөс шимтгэлийн татаас (50 хувийг нь хариуцахыг санал болгосон) олгохыг зөвлөмж болгосон юм. Ийнхүү бүхэлдээ албан журмын тогтолцоонд шилжихэд хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах механизмыг сайжруулах шаардлагатай болно. Мөн урт хугацааны асрамжийн үйлчилгээг цогц байдлаар үзүүлэх арга замыг боловсруулах талаар анхаарах нь зүйтэй гэж үзсэн.

#### **Монгол Улсын нийгмийн хамгааллын суурь түвшний тодорхойлолт**

НҮБ/ЗГ-ын хамтарсан Нийгмийн хамгааллын ажлын хэсгээс Монгол улсын НХСТ-ий зардлыг хэд хэдэн хувилбараар тооцоолсон юм. Үүнд нийгмийн даатгалын санд улсын төсвөөс олгох татаас,

татвараар буюу улсын төсвөөс санхүүждэг нийгмийн хамгааллын хөтөлбөрүүд (тухайлбал, нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, тусламж, үйлчилгээ, хүүхдийн мөнгө)-ийн мөнгөн тэтгэмж, зарим тодорхой үйлчилгээний зардал, тэтгэмж, тусламжийн хэмжээг индексжүүлэн өсгөхөд шаардагдах зардал зэргийг оруулж тооцлоо. Эдгээр нь Монгол Улсын төсвийн нийгмийн хамгааллын зардлыг бүрдүүлдэг юм. Түүнчлэн үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчинд өртөгсөд, ажилгүйдлийн тэтгэмж авагчид, залуу малчдад зориулсан хөдөлмөрийн зах зээлийн идэвхтэй бодлогыг шинээр нэвтрүүлэхэд шаардагдах зардлыг мөн нэмж тооцсон болно.

2014 оны 9 дүгээр сард зохион байгуулсан үндэсний хэлэлцүүлгээр нийгмийн хамгааллын Монгол Улсад хэрэгжүүлж болохуйц суурь түвшнийг тодорхойлж санал болгоход зардлын тооцооллын олон янзын хувилбаруудыг авч үзсэн болно.

#### Хүснэгт 1. Монгол Улсын нийгмийн хамгааллын суурь түвшний тодорхойлолт

| Баталгаа                 | Нийгмийн хамгааллын суурь түвшний бүрэлдэхүүн хэсгүүд                                                                                                                                                                                                                     | Одоо байгаа, сайжруулах шаардлагатай | Шинээр бий болгох |
|--------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------|-------------------|
| Эрүүл мэнд               | Эмзэг бүлгийн иргэд болон малчдын төлөх шимтгэлийг төрөөс бүрэн хариуцах замаар бүх нийтийг эрүүл мэндийн даатгалд хамруулах                                                                                                                                              | ✓                                    |                   |
|                          | Бүх хүнд чанартай, олдоцтой, боломжийн үнэ өртөг бүхий эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг улс орон даяар хүргэх, хөдөө орон нутагт тусламж үйлчилгээ, нийлүүлэлтийг сайжруулах                                                                                             | ✓                                    |                   |
| Хүүхэд                   | Ерөнхий боловсролыг бүх хүүхдэд үнэ төлбөргүй эзэмшүүлэх, сургуулийн дотуур байраар үнэ төлбөргүй хангах                                                                                                                                                                  | ✓                                    |                   |
|                          | Бүх хүүхэд хүүхдийн мөнгөнд хамрагдаж байгааг хуулиар баталгаажуулж, амьжиргааны өртөгийн өсөлттэй уялдуулан автоматаар индексжүүлж байх                                                                                                                                  | ✓                                    |                   |
|                          | Цэцэрлэгт хамрагдаж буй (2-5 насны) бүх хүүхдийн хоолны зардлыг амьжиргааны өртгийн өсөлттэй уялдуулж индексжүүлэн нэмэгдүүлэх замаар бага насны хүүхдийн хоол тэжээлийн чанарыг сайжруулах                                                                               | ✓                                    |                   |
|                          | Малчин өрхийн хүүхдийн үндсэн эрх, хөгжлийг хангахуйцаар орчин нөхцөлийг сайжруулах                                                                                                                                                                                       |                                      | ✓                 |
| Хөдөлмөрийн насны хүн ам | Малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, албан бус эдийн засагт ажиллагчдын төлөх шимтгэлд (улсын төсвөөс 50 хувийн) татаас өгөх замаар хөдөлмөрийн чадвар түр алдсаны, жирэмсний болон амаржсаны, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалд бүрэн хамруулах |                                      | ✓                 |
|                          | Хөдөлмөр эрхэлж буй бүх хүнд, түүний дотор малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, албан бус эдийн засагт ажиллагчдад жирэмсний болон амаржсаны тэтгэмжийг өмнөх орлогыг нь 100 хувь нөхөх хэмжээнд олгох                                                                    | ✓                                    |                   |
|                          | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүд (ХЭДХ)-ийг бэхжүүлж, залуу малчдад зориулсан тусгай хөтөлбөрийг нэвтрүүлэх                                                                                                                                                         | ✓                                    |                   |
|                          | Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хохирсон иргэд болон ажилгүйдлийн даатгалын сангаас тэтгэмж авч буй иргэдийг ажил хөдөлмөр эрхлэх, давтан сургах хөтөлбөрүүдэд хамруулах                                                                         |                                      | ✓                 |

|              |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                       |  |   |
|--------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--|---|
| Ахмад настан | Тэтгэврийн гурван давхаргат тогтолцоо нь дараах бүтэцтэй байна:<br>- Бүх нийтийг хамарсан суурь тэтгэвэр: тэтгэврийн хэмжээг амьжиргааны өртгийн өсөлттэй уялдуулан индексжүүлж байх<br>- Өндөр насны тэтгэврийн албан журмын даатгал: Малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, албан бүсэдийн засагт ажиллагчдын төлөх шимтгэлд (улсын төсвөөс 50 хувийн) татаас олгох замаар заавал даатгуулдаг болох<br>-Тэтгэврийн нэмэлт хөтөлбөрүүд |  | ✓ |
|              | Ядуу амьдралтай ахмад настнуудад мөнгөн ба түүнтэй адилтгах тусламж үзүүлж буй одоогийн нийгмийн халамжийн хөтөлбөрүүд дээр үндэслэн ахмадуудад зориулсан тусламж, үйлчилгээний нэгдсэн багц бий болгох. Үүнд урт хугацааны асрамжийн тогтолцоог хамруулах.                                                                                                                                                                           |  | ✓ |

Эх сурвалж: НҮБ/ЗГ-ын хамтарсан Нийгмийн хамгааллын ажлын хэсэг, 2014.

### Монгол Улсад нийгмийн хамгааллын суурь түвшинг хангахад шаардагдах зардал


**Монгол Улсын ийнхүү тодорхойлсон НХСТ-г хангахын тулд** нийгмийн хамгаалалд зарцуулахаар төсөвлөсөн зардал дээр **2015 онд ДНБ-ий 0.94, 2020 онд 1.68 хувьтай тэнцэх** хэмжээний хөрөнгө нэмж шаардагдана(Зураг 1). Эрүүл мэндийн даатгалд бараг бүх нийтээр хамрагдсан тул нэмэгдэл хөрөнгө нь хүүхдийн нийгмийн хамгаалал, хоол тэжээлийг сайжруулах, хөдөлмөрийн насны хүн амын орлогын аюулгүй байдал, хөдөлмөр эрхлэх чадамжийг сайжруулах, өндөр настны хамгааллыг хангахад голчлон зарцуулагдах юм. 2020 он гэхэд НХСТ-г бүрэн хангахад шаардагдах нэмэлт хөрөнгийн 0.60 хувь нь хүүхдийн, 0.60 хувь нь хөдөлмөрийн насны иргэдийн, 0.48 хувь нь ахмад настны нийгмийн баталгааг хангахад тус тус зарцуулагдах болно.

Монгол Улсын НХСТ-ий зардал нэмэгдэж байгаа нь үндсэндээ ирэх 5 жилд хүн амын томоохон бүлэг төрөөс шимтгэлийн татаас авснаар нийгмийн даатгалд бүх нийтээр буюу ажиллах хүч 100 хувь хамрагдана гэсэн таамаглал дэвшүүлсэнтэй холбоотой. Бүх нийтээр хамрагдсаны дараа зардлын түвшин тогтворжих хандлагатай байна. НХСТ-ий зардлын өсөлт нь ерөнхийдөө цалингийн өсөлтийг тооцсон инфляцийн таамаглалаас үүдэлтэй.

Монгол Улсад НХСТ-г хангахад шаардагдах зардал **2020 онд ДНБ-ий 4.7 хувиас хэтрэхгүй бөгөөд энэ нь** улс орнуудын нийгмийн хамгааллын зардлын дэлхийн дундаж <sup>1</sup> хувиас доогуур байна.


<sup>1</sup> ОУХБ, 2014: *Дэлхийн нийгмийн хамгааллын илтгэл 2014-2015* (Женев, 2014) Хүснэгт Б.13

**Зураг 1. Монгол Улсын нийгмийн хамгааллын суурь түвшинг хангахад шаардагдах нэмэлт зардлын тооцоо, баталгаа тус бүрээр**



Эх үүсвэр: ОУХБ-ын РАП загвараар хийсэн тооцооллын дүн, 2015

**Зураг 2. Нийгмийн хамгааллын зардлын ДНБ-д эзлэх хувийг НХСТ-ий зардлын төсөөлөлтэй харьцуулсан байдал (2014-2020)**



Эх үүсвэр: ОУХБ-ын РАП загвараар хийсэн тооцооллын дүн, 2015

Монгол Улсын Засгийн газраас хэд хэдэн төрлийн мөнгөн тэтгэмжийг нийт иргэддээ олгох болсноор 2007-2011 оны хооронд нийгмийн хамгааллын зардал нэмэгдэж, ДНБ-ий 6.6-аас 9.5 хувийн хооронд хэлбэлзэж байсан юм. 2020 онд НХСТ-г хангахад шаардагдах нэмэлт зардал нь ДНБ-ий 1.7 хувьтай тэнцэх (одоогийн нийгмийн хамгааллын зарлага дээр нэмэгдэнэ) болно. Өөрөөр хэлбэл, 2020 онд НХСТ-нд нийтдээ сард нэг хүнд 44,650 төгрөг буюу 22.5<sup>2</sup> ам.доллар зарцуулах бол, одоогийн нийгмийн хамгааллын зарлага дээр нэмж шаардагдах нь сард нэг хүнд 8 ам.доллар болно.

<sup>2</sup> 2015 оны 3 дугаар сарын 16-ны өдрийн валютын ханш: 1 ам.доллар=1985.6 төгрөг

Энэ зардалд нийгмийн хамгааллын өмнө тогтсон бүх зардал, нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийг амьжиргааны өртгийн өсөлттэй уялдуулан индексжүүлэх, нийгмийн даатгалын шимтгэлд олгох татаас, Монгол Улсын шинээр тодорхойлсон НХСТ-г хангахад шаардагдах зарим нэмэлт арга хэмжээний зардал орсон болно.

Нийгмийн хамгаалалд шаардагдаж буй нэмэлт зардлыг Хүний хөгжил сангийн хөрөнгөөр, эсхүл төсвийг тэлэх замаар санхүүжүүлж болох юм. Үүний зэрэгцээ малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, албан бус эдийн засагт ажиллагчдыг нийгмийн даатгалд хамруулснаар нэмэгдэх шимтгэлийн орлого нь одоо төсвийн татаасаар санхүүжиж буй нийгмийн даатгалын сангийн алдагдлыг багасгах боломжийг бүрдүүлнэ.

### **Монгол Улсад зохион байгуулагдсан ҮСҮХ-ийн дүгнэлт**

Монгол Улсад хүн бүр орлогын баталгаа, нийгмийн суурь үйлчилгээнд хамрагдах боломжийг хангахын тулд нийгмийн зардал дээр 2020 онд нэмж шаардагдах хөрөнгө нь ДНБ-ий 1.68 хувьтай тэнцэж байна. Ингэснээр ДНБ-д нийгмийн зардлын эзлэх хувь 4.72-т хүрэх юм. НХСТ нь эмзэг бүлгийн бүх иргэд болон малчдын төлөх шимтгэлийг төрөөс хариуцах замаар бүх нийтийг эрүүл мэндийн даатгалд хамруулж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах боломжоор хангах; цэцэрлэгийн хүүхдийн хоол тэжээлийг сайжруулах; одоогийн ерөнхий (бүрэн дунд буюу 12 жилийн) боловсролыг үнэ төлбөргүй олгож байгааг болон бүх хүүхдэд хүүхдийн мөнгө олгож байгааг хэвээр нь үргэлжлүүлэх, тэтгэмж, тусламжийн хэмжээг индексжүүлэх; малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, албан бус эдийн засагт ажиллагчдад шимтгэлийн татаас олгох замаар бүх нийтийг нийгмийн, тэр дундаа өндөр насны тэтгэврийн даатгалд хамруулах; зорилтот бүлэгт, ялангуяа залуу малчдад чиглэсэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үр дүнтэй хөтөлбөрүүдийг бий болгож хэрэгжүүлэх баталгаа нь болно. Гэхдээ хүн бүрийг НХСТ-д хамруулж үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд төр засгийн байгууллагуудаас нийгмийн хамгааллын тусламж дэмжлэг, нийгмийн үйлчилгээний зохицуулалт, чанар, хүргэлтийг сайжруулах чиглэлд ихээхэн хүчин чармайлт шаардах болно. Нийгмийн үйлчилгээний дэд бүтцийг сайжруулахад шаардагдах зардлын тооцоог гаргахад техник-эдийн засгийн үндэслэлийг боловсруулж, илүү нарийвчилсан актуар тооцоо хийх шаардлагатай хэдий ч эдгээр зөвлөмж нь Монгол Улсын НХСТ-ий тодорхойлолтод тусгагдсан юм.

### **Үнэлгээний арга зүйн талаарх тайлбар**

Үнэлгээнд суурилсан үндэсний хэлэлцүүлгийн үндсэн үүрэг нь нийгмийн хамгааллын асуудлаар улс орны бүх гол оролцогч талуудтай, тухайлбал Монгол Улсын Засгийн газар, нийгмийн түншүүд, иргэний нийгмийн байгууллагууд, эрдэмтэн судлаачид, НҮБ-ын төрөлжсөн байгууллагууд, хөгжлийн бусад түншүүдтэй ярилцаж хэлэлцэх явдал юм. Үүний гол зорилго нь нийгмийн хамгааллын салбарт засгийн газрын оролцооны тэргүүлэх чиглэлийг тодорхойлж, үндэсний хэмжээнд нийгмийн хамгааллын суурь түвшинг тогтоох талаар мэдээлэлд тулгуурласан үндэслэл бүхий шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэх явдал болно.

Хэлэлцүүлгийн эхний үе шат болох үнэлгээгээр одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй бүх хөтөлбөрийг нэг бүрчлэн авч үзэж, тус бүрийнх нь бүтэц тогтолцоон дахь алдаа дутагдал, хэрэгжүүлэхэд гарч буй асуудал бэрхшээлүүдийг олж тодорхойлсон. Гэхдээ энэхүү шинжилгээ нь хялбарчилсан байдлаар хийгдсэн бөгөөд дээрх тогтолцооны удирдлага, зохион байгуулалтын талаарх дэлгэрэнгүй судалгааг орлохгүй болно.

Энэхүү үнэлгээгээр бодлогын хийдлийг арилгахад чиглэсэн тоон болон чанарын зөвлөмжүүдийг боловсруулан гаргалаа. Эхний бүлэг зөвлөмж (“Монгол Улсад НХСТ тогтоох, хүний амьдралын бүхий л хугацаанд орлогын баталгааг хангахад шаардлагатай нэмэлт зохицуулалтууд бий болгох”)-ийн хувьд НҮБ/ЗГ-ын хамтарсан Нийгмийн хамгааллын ажлын хэсгийнхэн санал болгож буй эдгээр нэмэлт хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын тооцоо, төсөөллийг

боловсруулсан юм. Харин хоёр ба гурав дахь бүлэг зөвлөмж(“нийгмийн даатгалын тогтолцоог шинэчлэх”, “одоогийн хэрэгжиж буй хөтөлбөрүүдийн үйл ажиллагаа, үйлчилгээний чанарыг сайжруулах”)-ийн хувьд Засгийн газарт бодитой зөвлөмж гаргаж өгөхийн тулд нарийвчилсан нэмэлт судалгаа хийх шаардлагатай. Эдгээр судалгаа нь ОУХБ болон НҮБ-ын бусад байгууллагуудаас үзүүлэх дараагийн бодлогын болон техникийн дэмжлэг тусалцааны нэг хэсэг байх болно.

Хэлэлцүүлгийн хоёр дахь үе шат буюу зардлыг тооцох хэсэгт ОУХБ-ын РАП загварыг ашигласан. Энэ нь логик дүн шинжилгээний дарааллаар хийгдэж 1) аливаа хөтөлбөрийн үйлчилгээ, тусламж, дэмжлэгийн дизайныг уян хатан авч үзэх 2) тоо мэдээллийн олдоцоос хамаарч төсөөлөл, таамаглалыг өөрчлөх, 3) мөнгөн тэтгэмж, дэмжлэг тусламжид ирээдүйд шаардагдах зардлыг тооцоолох зэрэг боломжийг олгодог.

Гэхдээ РАП загвар нь нийгмийн даатгалд олгох татаас, төсвөөс санхүүждэг нийгмийн хамгааллын хөтөлбөрүүд (тухайлбал, нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, үйлчилгээ, хүүхдийн мөнгө), одоо олгогдож буй тэтгэвэр, тэтгэмжийг индексжүүлэх зэрэг зөвхөн мөнгөн хэлбэрийн тусламж дэмжлэг болон нийгмийн тодорхой үйлчилгээний зардлыг авч үздэг. Эдгээр нь улсын төсвийн нийгмийн хамгааллын зардлыг бүрдүүлж байна. Түүнээс гадна РАП загварт Монгол Улсын НХСТ-ий зардлыг тооцохдоо зорилтот бүлэгт, түүний дотор залуу малчид, ажилгүйдлийн даатгалын сангаас тэтгэмж авагчид, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр авч буй иргэдэд зориулсан хөдөлмөрийн зах зээлийн идэвхтэй бодлогыг шинээр хэрэгжүүлэх зардлыг оруулж тооцсон юм.

Гэсэн ч Монгол Улсын НХСТ-г бүрдүүлж буй зарим мөнгөн тусламж, дэмжлэгт хамрагдах эрх нь нийгмийн үйлчилгээний зохих дэд бүтэц, тэдгээрийг үзүүлэх хүн хүч бүрдсэн нөхцөлд л хэрэгжих боломжтой болно. Жишээлбэл, нэн шаардлагатай эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг баталгаажуулахад эрүүл мэндийн даатгалд бүх нийтийг хамруулах, түүнчлэн улс орон даяар эрүүл мэндийн чанартай, хүрэлцээтэй материаллаг бааз, боловсон хүчин шаардлагатай. Гэхдээ олон улсын стандартаар авч үзвэл ийм дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг мөнгөн тусламж, дэмжлэг, зарим тодорхой нийгмийн үйлчилгээний зардлыг багтаасан нийгмийн хамгааллын үрсгал зарлагад оруулж тооцдоггүй бөгөөд Монгол Улсын НХСТ-ий зарлагад ч мөн тусгаагүй болно.

РАП загварын тооцооллын үр дүн нь мөнгөн тусламж, дэмжлэг, нийгмийн үйлчилгээний зардлыг урт хугацаанд илүү нарийвчлалтай төсөвлөж тооцох, түүнчлэн Монгол Улсад НХСТ-г бүрдүүлж хэрэгжүүлэхэд шаардлагатай дэд бүтэц, хүн хүчийг тодорхойлоход чиглэсэн техник эдийн засгийн болон актуар тооцооллын нарийвчилсан судалгааг орлож чадахгүй юм.

## Товчилсон үгсийн жагсаалт

|        |                                                                                                            |
|--------|------------------------------------------------------------------------------------------------------------|
| БСШУЯ  | Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам                                                                        |
| ГОУХАН | Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг                                                            |
| ДНБ    | Дотоодын нийт бүтээгдэхүүн                                                                                 |
| ДЭМБ   | Дэлхийн эрүүл мэндийн байгууллага                                                                          |
| МАОЭНХ | Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо                                                                 |
| МҮЭХ   | Монголын үйлдвэрчний эвлэлийн холбоо                                                                       |
| НДЕГ   | Нийгмийн даатгалын ерөнхий газар                                                                           |
| НДС    | Нийгмийн даатгалын сан                                                                                     |
| НХҮЕГ  | Нийгмийн халамж, үйлчилгээний ерөнхий газар                                                                |
| НХСТ   | Нийгмийн хамгааллын суурь түвшин                                                                           |
| НҮБ    | Нэгдсэн үндэстний байгууллага                                                                              |
| НҮБХХ  | НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр                                                                                   |
| НҮБХС  | НҮБ-ын Хүүхдийн сан                                                                                        |
| НДТ    | Нэрийн дансны тогтолцоо                                                                                    |
| ОУВС   | Олон улсын валютын сан                                                                                     |
| ОУХБ   | Олон улсын хөдөлмөрийн байгууллага                                                                         |
| ОУХТ   | Олон улсын хөдөлмөрийн товчоо                                                                              |
| ТХДХМ  | Төсвийн хүрээний дунд хугацааны мэдэгдэл                                                                   |
| ЦСТТ   | Цалинд суурилсан тэтгэврийн тогтолцоо                                                                      |
| УИХ    | Улсын Их Хурал                                                                                             |
| ҮОМШӨ  | Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин                                                            |
| ҮСҮХ   | Үнэлгээнд суурилсан үндэсний хэлэлцүүлэг                                                                   |
| ҮСХ    | Үндэсний статистикийн хороо                                                                                |
| ХАХНХЯ | Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам                                                                   |
| ХБИ    | Хөгжлийн бэрхшээлтэй иргэн                                                                                 |
| ХЗЗИБ  | Хөдөлмөрийн зах зээлийн идэвхтэй бодлого                                                                   |
| ХМХ    | Хүүхдийн мөнгө хөтөлбөр                                                                                    |
| ХТҮГ   | Хүүхдийн төлөө үндэсний газар                                                                              |
| ХҮИ    | Хэрэглээний үнийн индекс                                                                                   |
| ХХС    | Хүний хөгжил сан                                                                                           |
| ХЧТА   | Хөдөлмөрийн чадвараа түр алдсан                                                                            |
| ХЭДС   | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан                                                                             |
| ХЭДХ   | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр                                                                        |
| ЭЗИХА  | Эдийн засгийн идэвхтэй хүн ам                                                                              |
| ЭЗХЯ   | Эдийн засгийн хөгжлийн яам                                                                                 |
| ЭМДБ   | Эрүүл мэндийн даатгалын байгууллага                                                                        |
| ЭМДС   | Эрүүл мэндийн даатгалын сан                                                                                |
| ЭМСЯ   | Эрүүл мэнд, спортын яам                                                                                    |
| Р4Н    | Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний бүх нийтийн хамралт, эрүүл мэндийн хамгааллыг дэмжих олон улсын сүлжээ |





## 1. Танилцуулга

Монгол Улс нь өмнө талаараа БНХАУ, хойд талаараа ОХУ-тай хиллэн оршдог төв Азийн далайд гарцгүй орон юм. 2013 онд тус улс 2,9 сая хүн амтай байсан бөгөөд 21 аймагтай, нийслэл нь Улаанбаатар хот. Нийт хүн амын 60 гаруй хувь нь хот суурин газарт аж төрж байна. Нийслэл хотдоо нэг сая гаруй хүн ам суурьшиж, бусад нутаг дэвсгэрт хүн амын нягтрал 2-оос бага байна.

Аймгуудын хүн амын тоо 14,500-аас 118,000-ын хооронд байна. Аймаг нь аймгийн төв болон сумдад, сум нь багт хуваагдана. Монгол Улсад нийт 330 сум, 1592 баг байна. Багийн оршин суугчид нь гол төлөв байгаль цаг уурын эрс тэс нөхцөлд мал сүргээ маллан нүүдэллэж амьдарч байна. Улаанбаатар хот нь 9 дүүрэг, 152 хороотой.<sup>3</sup>

Монгол Улсад нийгэм-эдийн засаг, улс төрийн шилжилт одоо ч үргэлжилж байна. 1990 оны хувьсгалын дараагаас социалист төрийн тогтолцоо олон намын ардчилсан хэлбэрээр солигдож, төрийн өмчит эдийн засгаас чөлөөт зах зээлийн эдийн засагт шилжих шилжилт эхэлсэн юм. Хэдийгээр хүн амынх нь 30 орчим хувь мал аж ахуй эрхэлж, хөдөө орон нутагт эдийн засгийн гол тулгуур нь мал аж ахуй болон газар тариалан хэвээр байгаа ч өнөөдөр уул уурхайн салбар нь ДНБ-ий тавны нэгийг бүрдүүлж байна. Ноолуур, ноосны худалдаа нь хөдөөгийн эдийн засаг болон аж үйлдвэр, экспортын салбаруудыг хооронд нь холбох гүүр болж байна.

Сүүлийн жилүүдэд Монгол Улсад эдийн засгийн асар их ахиц дэвшил гарчээ. ДНБ-ий өсөлт 2004-2008 онд зэсийн үнэ өссөн, алт шинээр олборлож эхэлсэн зэргээс хамаарч жилд дунджаар бараг 9 хувьд хүрч байв. Эдийн засаг нь дэлхийн санхүүгийн 2008-2009 оны хямралаас маш хурдан гарч, сүүлийн гурван жилд өсөлт хоёр оронтой тоогоор илэрхийлэгдэж байв.<sup>4</sup> Энэ гайхамшигтай өсөлт нь ядуурлыг бууруулахад хувь нэмрээ оруулж, улмаар ядуу хүмүүс (ядуурлын шугамаас доогуур амьдарч байгаа) 2010 онд хүн амын 38.7 хувийг эзэлж байсан бол 2012 онд 27.4 хувь болж багасчээ.<sup>5</sup>

Эдийн засаг нь одоо ч цөөн хэдхэн салбарт төвлөрсөн хэвээр байна. Эрдэс баялгийн бүтээгдэхүүн тус улсын нийт экспортын 80 орчим хувийг эзэлж, уул уурхайгаас улсын төсвийн нийт орлогын

<sup>3</sup> Нийслэлийн статистикийн газрын тайлан, 2013

<sup>4</sup> Монгол Улсын Үндэсний Статистикийн хороо, *Статистикийн эмхэтгэл*, 2008-2013 он (Улаанбаатар, 2013)

<sup>5</sup> Монгол Улсын Үндэсний Статистикийн хороо, *Статистикийн эмхэтгэл*, 2013 он (Улаанбаатар, 2013)

40 орчим хувийг бүрдүүлж байна. Уул уурхайн орлогоос ихээхэн хамааралтай эдийн засаг нь улс орныг гадаад орчны хэлбэлзэлд өртүүлж, эдийн засгийн өсөлтийн үр шим нийт хүн амд тэгш хуваарилагдаж чадахгүй, хоёр оронтой тоонд хүрч байсан ДНБ-ий өсөлтийн үр шимийг Улаанбаатар хотын төвийнхөн л хамгийн ихээр хүртэж байна.

Зүй зохистой нийгмийн хамгаалал нь бүтээмжийг сайжруулж, зах зээлийн эдийн засагт шилжих шилжилтийг дэмжихэд чухал билээ. Шилжилт эхлэхээс өмнө эмнэлгийн тусламж, үйлчилгээ, тэтгэвэр, тахир дутуугийн даатгал, жирэмсний ба амаржсаны тэтгэмж зэрэг нийгмийн тусламж, үйлчилгээг улсаас санхүүжүүлж хүн бүрт хүргэдэг байв. Харин шилжилтийн явцад ахмад настнууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, өнчин болон боловсрол, үр чадвар багатай хүмүүс зэрэг нийгмийн эмзэг бүлгийн иргэд шинэчлэлийн сөрөг нөлөөнд хамгийн ихээр өртжээ. Өмч хувьчлалын явцад олон ажилчид, малчид зөвхөн албан бүс эдийн засагт хөдөлмөр эрхлэх боломжтой үлдсэн байна.

1995 оноос хойш Монгол Улсад цоо шинэ нийгмийн хамгааллын тогтолцоог бий болгох үйл явц эхэлжээ. Одоогийн нийгмийн хамгааллын тогтолцоо нь нийгмийн халамжийн тусламж, үйлчилгээ, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүд болон нийгмийн даатгал гэсэн гурван гол бүрэлдэхүүнтэй байна. 2009 онд ДНБ-ий 9.5 хувьтай тэнцэж байсан нийгмийн хамгааллын зардал<sup>6</sup> 2013 онд ДНБ-ий 4.3 хувьд хүрч буурсан байна.

НҮБ-аас санаачлан дэмжиж буй НХСТ-ий үзэл баримтлал нь Монгол Улсын нийгмийн хамгаалал, нийгмийн баталгаа, ядуурлыг бууруулах хөтөлбөрүүдийг тоймлон харуулж, нийгмийн хамгааллын эрхэд суурилсан илүү цогц, системтэй тогтолцоог бий болгохын тулд төрөөс авч буй арга хэмжээнүүдийг уялдуулан зохицуулах, цаашид шаардагдах арга хэмжээг тодорхойлох үндэс суурь нь болсон юм. Нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үнэлгээнд суурилсан үндэсний хэлэлцүүлэг нь одоогийн нөхцөл байдлын зураглалыг гаргах, нийт хүн амд зориулан НХСТ тогтооходтой холбогдуулан хууль эрх зүйн зохицуулалтуудыг цаашид боловсронгуй болгоход баримтлах зөвлөмжүүдийг гаргах нэг арга хэрэгсэл юм. ҮСҮХ-ийн хүрээнд мөн нийгмийн хамгааллын эдгээр нэмэлт зохицуулалтыг нэвтрүүлэхэд шаардагдах зардлын тооцооллыг хийсэн. ҮСҮХ-т салбарын яамд, нийгмийн түншүүд, иргэний нийгмийн байгууллагууд, эрдэмтэн судлаачид, НҮБ-ын төрөлжсөн байгууллагууд, хөгжлийн бусад түншүүд болон нийгмийн хамгааллын чиглэлээр ажилладаг хоёр талын хамтын ажиллагааны холбогдох хандивлагчид оролцсон болно.

Монгол Улсын Засгийн газар НХСТ-г баталгаажуулахын ач холбогдлыг хүлээн зөвшөөрч НҮБ-ын тус улс дахь Удирдлагын багаас ҮСҮХ-ийг эхлүүлэхэд дэмжлэг тусалцаа үзүүлэхийг хүссэн юм. Хэлэлцүүлгийн үйл явцыг дэмжих зорилгоор 2013 оны 7 дугаар сард НҮБ/Засгийн газрын хамтарсан Нийгмийн хамгааллын ажлын хэсгийг ОУХБ-аар ахлуулан байгуулж, 2013 оны 9 дүгээр сард ХАХНХЯ, НҮБ хамтран уг хэлэлцүүлгийг албан ёсоор эхлүүлсэн билээ.

Энэхүү тайлангаар ҮСҮХ-ээс гарсан үр дүнг танилцуулж байна. Тайлангийн эхний хэсэгт Монголд ашигласан үзэл баримтлал, арга зүйн талаар тайлбарласан. Хоёр дахь хэсэгт Монгол Улсын нийгмийн хамгааллын тогтолцооны өнөөгийн байдлыг судалсан ерөнхий зураглалын үр дүн, мөн НХСТ-г тогтоож, хэрэгжүүлэх талаар зөвшилцөж тохиролцсон зөвлөмжүүдийг оруулсан. Төгсгөлд нь, тайлангийн гурав дахь хэсэгт Монгол Улсын НХСТ-г хангахад чиглэсэн зөвлөмжүүдийг бодитой хэрэгжүүлэхийн тулд түүнд шаардагдах зардлыг ОУХБ-ын РАП загварыг ашиглан тооцсон үр дүнг тусгалаа.

<sup>6</sup> Нийгмийн хамгааллын зардалд нийгмийн халамжийн зардал, нийгмийн даатгалын санд улсын төсвөөс олгох татаас, Хүний хөгжил сангаас олгох нийгмийн бусад тусламж дэмжлэг ордог.

## 2. Агуулга ба үйл явц

2009 оны дөрөвдүгээр сард НҮБ-ын Удирдах зөвлөлийн Хөтөлбөрийн асуудлаарх дээд комиссоос НХСТ-г санхүү, эдийн засгийн хямралыг давж, эдийн засгаа хурдан хугацаанд сэргээн босгох хамтын санаачилгуудын нэг болгож баталсан юм. Энэхүү санаачилга нь нийгмийн тэтгэмж, тусламж, нийгмийн чухал шаардлагатай үйлчилгээг багтаасан нийгмийн хамгааллын тогтвортой стратегийг төлөвлөх, хэрэгжүүлэхэд улс орнуудад дэмжлэг үзүүлэх зорилготой. Энэ зорилго нь нэг байгууллага, агентлагийн эрхлэх асуудлын хүрээнээс хальсан асуудал учир уг санаачилгад НҮБ-ын төрөлжсөн байгууллагууд (НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага, НҮБ-ын Хүний эрхийн асуудал эрхлэх Дээд комиссарын газар, НҮБ-ын ХДХВ/ДОХ-ын нэгдсэн хөтөлбөр, НҮБ-ын Эдийн засаг, нийгмийн зөвлөл, НҮБХХ, НҮБ-ын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага (ЮНЕСКО), НҮБ-ын Хүн амын сан, НҮБ-ын Нутагшил, суурьшлийн Хөтөлбөр (ХАБИТАТ), НҮБ-ын Дүрвэгсдийн асуудал эрхлэх Дээд Комиссарын газар, НҮБХС, НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх газар, НҮБ-ын бүс нутгийн комиссууд, Ойрхи Дорнодын Палестины дүрвэгсдэд туслах НҮБ-ын агентлаг, Дэлхийн Хоол хүнсний хөтөлбөр, Дэлхийн цаг уур судлалын байгууллага), Олон улсын валютын сан (ОУВС) болон Дэлхийн банк, түүнчлэн хөгжлийн түншүүд, тэргүүлэх төрийн бус байгууллагууд (ТББ) оролцон дэлхий нийтийн эвсэл болж өргөжсөн билээ. НХСТ-г бүрдүүлэх асуудал нь удахгүй батлагдан гарах Тогтвортой хөгжлийн зорилтуудын 1.3 дахь зорилт болно.

Олон Улсын Хөдөлмөрийн Бага хурал нь 2012 онд хуралдсан 101 дэх удаагийн чуулганаараа нийгмийн хамгааллын үүргийг хүний эрх, нийгэм, эдийн засгийн зайлшгүй хэрэгцээ гэдгийг дахин бататгаж, улс орнууд нийгмийн хамгааллын иж бүрэн тогтолцоог үе шаттай хөгжүүлэх хүрээнд НХСТ-ийг бүрдүүлэхэд баримтлах удирдамж болгон Нийгмийн хамгааллын суурь түвшний тухай 202 дугаар зөвлөмжийг<sup>7</sup> батлан гаргасан юм. ОУХБ-ын гишүүн улс орнууд нийгмийн хамгааллыг өргөжүүлэхээ дахин нотолж, тус зөвлөмжийг бараг санал нэгтгэйгээр (453 нь дэмжиж, нэг түдгэлзсэн) баталсан билээ. Түүнчлэн тус Бага хурлаас нийгэм, эдийн засгийн хөгжилд, ялангуяа ядуурал, эмзэг дорой байдал, нийгмийн гадуурхалттай тэмцэх, бүх хүнийг зохистой хөдөлмөр эрхлэх боломжоор хангахад нийгмийн хамгаалал шийдвэрлэх үүрэгтэйг хүлээн зөвшөөрч, “Дэлхий даяар нийгмийн хамгааллын суурь түвшинг үндэсний хэмжээнд бодит ажил хэрэг болгох тухай тогтоол<sup>8</sup>”-ыг баталж, улс орны нөхцөл байдал бүрэлдмэгц аль болох хурдан 202 дугаар зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлэхийг улс орнуудын Засгийн газар, ажил олгогчид болон ажилчдад үриалсан юм.

НХСТ нь нийгмийн бүх гишүүдэд ямар ч үед хамгийн наад захын хэрэгцээт бараа, үйлчилгээг хүртэх боломж бололцоог хангаж буй үндэсний хэмжээнд тодорхойлсон хүний эрх, нийгмийн тэтгэмж, тусламжийн үндсэн багц юм. Эдгээр нь дараахаас бүрдэж болно. Үүнд:

- Нэн шаардлагатай үйлчилгээ: Усан хангамж, ариун цэвэр, хангалттай хоол тэжээл, эрүүл мэнд, боловсрол, орон сууц зэрэг нэн шаардлагатай үйлчилгээг газар зүйн болон санхүүгийн хувьд хүртэх боломжтой байх;
- Нэн шаардлагатай тэтгэмж, тусламж: Ядуу болон эмзэг бүлгийн иргэдийн орлогын болон эрүүл мэндийн наад захын баталгааг хангахуйц мөнгөн болон бусад тусламж.

Бүх насны бүлгийнхэнд, түүний дотор орхигдсон буюу эмзэг бүлгийнхэн (үндэсний цөөнх, хөгжлийн бэрхшээлтэй иргэд зэрэг)-д бараа, үйлчилгээний баталгаат багцыг хүртээмжтэй байлгахыг шаарддагаараа НХСТ түвшин нь нэгдмэл цогц арга юм. НХСТ-г бүрдүүлж хангасан бол дараа нь улс орнууд аажмаар нийгмийн хамгааллын илүү өндөр түвшин (тухайлбал, бага боловсролыг үнэ төлбөргүй олгодог байсан бол өргөжүүлж дунд болон сургуулийн өмнөх боловсролыг хамруулах, эсвэл шимтгэлд суурилсан болон шимтгэлд суурилаагүй тогтолцоог хослуулах маягаар тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүлэх)-д дэвшихийг зорьж болох юм.

<sup>7</sup> <http://www.socialprotectionfloor-gateway.org/216.htm>

<sup>8</sup> ОУХБ: “Дэлхий даяар нийгмийн хамгааллын суурь түвшинг үндэсний хэмжээнд бодит ажил хэрэг болгох тухай тогтоол”, Хурлын тэмдэглэл No 14, Олон улсын хөдөлмөрийн бага хурал, 101 дэх удаагийн чуулган (Женев, 2012).

НХСТ нь орлогын баталгааг дор дурдсан үндсэн баталгаат багцаар дамжуулан дэмждэг. Үүнд:

- Эхэд үзүүлэх тусламж, үйлчилгээг оруулан үндэснийхээ түвшинд тодорхойлсон (олдоц, хүртээмж, хэрэгцээ, чанарын шалгуурт нийцсэн) эрүүл мэндийн нэн шаардлагатай тусламж, үйлчилгээний багц;
- Хүүхэд бүрийн хоол тэжээл, боловсрол, асаргаа, бусад шаардлагатай бараа, үйлчилгээг авах боломжийг нь баталгаажуулахын тулд наад зах нь үндэснийхээ хэмжээнд тодорхойлсон доод түвшнийг хангахуйц хэмжээний орлогын суурь баталгаагаар хангах;
- Өвчлөх, ажилгүй болох, жирэмслэх болон хүүхэд төрүүлэх, хөдөлмөрийн чадвараа алдах зэрэг шалтгаанаар хангалттай орлого олох боломжгүй байгаа хөдөлмөрийн насны хүмүүсийг наад зах нь үндэснийхээ хэмжээнд тодорхойлсон доод түвшнийг хангахуйц хэмжээний орлогын суурь баталгаагаар хангах;
- Ахмад настан бүрийг наад зах нь үндэснийхээ хэмжээнд тодорхойлсон доод түвшнийг хангахуйц хэмжээний орлогын суурь баталгаагаар хангах.

Суурь түвшний бүрэлдэхүүн хэсгүүдийг ингэж баталгаа болгож тодорхойлох нь НХСТ-г үндэсний нөхцөл байдал, одоогийн нийгмийн хамгааллын тогтолцоотой уялдуулан тогтооход уян хатан хандах боломжийг олгодог юм. Эдгээр дөрвөн баталгаа нь тухайн улсын нийгмийн хамгааллын тогтолцооны бүтцийг тухайлан зааж өгч буй хэрэг биш, харин нийгмийн хамгааллын тогтолцооны хүрээнд орлогын баталгаа болон хүртээмж, хамрах хүрээний түвшин, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний гүйцэтгэлийн болон үр дүнгийн доод стандартыг тогтоож өгч байгаа болно. Бүх улс орон нийт хүн амдаа нийгмийн хамгааллын бүх бүрэлдэхүүн хэсгүүдийг нэг дор бүхэлд нь хэрэгжүүлэх боломжгүй ч НХСТ нь нийгмийн хамгааллын иж бүрэн тогтолцооны алсын харааг баталгаажуулах, мөн бусад бүрэлдэхүүн хэсгүүдийн бие биеэ нөхөх боломж, уялдаа холбоог хангах, цаашдын ахиц дэвшлийг төлөвлөх ерөнхий хүрээг гаргаж өгнө.

НХСТ нь жендерийн тэгш байдлыг хангах нэг арга хэрэгсэл мөн. Дэлхий даяар эмэгтэйчүүдийн эзлэх хувь ядуу, эмзэг бүлгийнхний дунд харьцангуй өндөр хэвээр байна. Тэд албан ёсны эдийн засагт ажил хөдөлмөр эрхлэх, эд хөрөнгө өмчлөх, илүү өндөр цалин хөлстэй ажил хийх, эсвэл эрэгтэй ажилчидтай адил тэгш цалин хөлс авах зэрэг боломжийг нь хязгаарласан хууль эрх зүйн болон нийгмийн маш олон бэрхшээлтэй тулгардаг. Ёс юм шиг эмэгтэйчүүд тохиолдлын, аюултай, хүнд хүчир ажил хийх, хувиараа хөдөлмөр эрхлэх, ялангуяа албан бүс эдийн засагт ямар ч нийгмийн хамгаалалд орох боломж нь хязгаарлагдмал, эсвэл бүр тийм боломж байхгүй нөхцөлд ажиллах хандлага давамгайлж байдаг. НХСТ нь эдгээр ялгаварлагдаж, гадуурхагдсан хүмүүст наад захын нийгмийн хамгааллыг хүргэхийг зорьж байгаа бөгөөд ингэснээр жендерийн тэнцвэргүй байдлыг арилгах маш их боломж олгох юм. Эмэгтэйчүүд илүү асарч халамжлах үүрэгтэй гэж үздэг нийгэмд ч ялгаагүй, нийгмийн тусламж дэмжлэг чухал ач холбогдолтой болох нь тогтоогдсон билээ.

Ази, Номхон далайн орнууд сүүлийн хорин жилд эдийн засгийн хувьд ихээхэн ахиц дэвшил олж, сая сая хүнийг ядуурлаас гаргасан боловч хүн ам бүгдээрээ энэхүү үр шимийг хүртээгүй байна. Дотоодын эдийн засгийн бүтцийн өөрчлөлт, дэлхийн эдийн засгийн хямрал, уур амьсгалын өөрчлөлт зэргийн улмаас эрсдэлд өртсөөр байгаа олон сая хүн ядуу зүдүү, ажлын байр нь баталгаагүй, үндсэн эрхээ эдэлж чадахгүй хэвээр байна. Энэ нь өнгөрсөн арван жилд маш их хөдөлмөр зүтгэлээр олж авсан хүний хөгжлийн ололт амжилтаа буцаан алдах аюул дагуулж байна. Ийм нөхцөл байдалд бүх хүнийг орлогын баталгаагаар хангаж, хамгийн наад захын нийгмийн үйлчилгээ хүртэх эрхийг нь баталгаажуулахад чиглэсэн бодлогын арга хэрэгсэл болох нийгмийн хамгаалал нь тус бүс нутгийн бодлогын нэн тэргүүний асуудал болж байгаад гайхах зүйлгүй юм. НҮБ-ын Ази, Номхон далайн бүсийн Эдийн засаг, нийгмийн комисс 2011 оны 5 дугаар сард хуралдсан 67 дугаар чуулганаараа “Ази, Номхон далайн бүс нутагт нийгмийн хамгааллын тогтолцоог бэхжүүлэх тухай” тогтоолыг баталсан.

## 3. Үнэлгээнд суурилсан үндэсний хэлэлцүүлэг: Зорилго, арга зүй, үйл явц

### 3.1. Зорилго

Азид НХСТ-ий санаачилгыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор ОУХБ-аас үндэсний НХСТ-г оролцооны аргаар тодорхойлох арга зүйн удирдамжийг боловсруулан гаргасан юм. Энэхүү ҮСҮХ-ийн аргачлал нь дараах хэсгүүдээс бүрдэнэ. Үүнд:

- тухайн улсад хэрэгжиж байгаа НХСТ-ий бүрэлдэхүүнд хамаарах хөтөлбөр, арга хэмжээ, тэдгээрийн хамрах хүрээний дутагдлыг тодорхойлох
- НХСТ-г бүрдүүлэхэд хэрэгцээтэй бодлогын хувилбаруудыг гаргах, тэдгээрийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг тооцох
- тодорхойлсон бодлогын хувилбаруудыг үндэснийхээ хэмжээнд хэлэлцэж батлах.

ҮСҮХ-ийн арга зүй, үйл явц болон арга хэрэгслийг 2011-2013 онд Камбож, Индонези, Тайланд болон Вьетнам улсуудад хэрэглэж туршсан бөгөөд энэхүү туршлагад үндэслэсэн “Нийгмийн хамгааллын Үнэлгээнд суурилсан үндэсний хэлэлцүүлэг: Сайн туршлагын гарын авлага”-ыг гаргасан байна.<sup>9</sup>

Үнэлгээнд суурилсан үндэсний хэлэлцүүлэг (ҮСҮХ)-ийн үндсэн зорилго нь:

1. Монгол Улсын Засгийн газар, нийгмийн түншүүд, иргэний нийгмийн байгууллагууд, эрдэмтэн судлаачид, НҮБ-ын төрөлжсөн байгууллагууд зэрэг бүхий л гол оролцогч талууд хамтран нийгмийн хамгааллын талаарх үндэсний хэлэлцүүлэгт хувь нэмэр оруулахын зэрэгцээ нийгмийн хамгааллын суурь түвшний үзэл баримтлалын талаарх мэдлэг, мэдээллийг нь дээшлүүлэх, бодлого боловсруулах, төлөвлөх чадавхийг нэмэгдүүлэх;
2. Нийгмийн хамгааллын асуудлаар Засгийн газрын оролцох оролцооны нэн тэргүүний чиглэлүүд болон Монгол Улсад хүний эрхэд суурилсан, иж бүрэн, системтэй нийгмийн хамгааллын суурь түвшин тогтооход шаардлагатай арга хэмжээнүүдийг тодорхойлох;
3. Санал болгож буй шинэ тогтолцоо, тэтгэвэр тэтгэмжийн талаарх саналууд нь нийгмийн хамгааллын тогтолцоонд бүхэлд нь санхүүгийн тогтвортой байдлын талаасаа аюул учруулахгүй байхын зэрэгцээ цаашид нийгмийн хамгааллын суурь түвшний бодлогыг боловсронгуй болгох талаар мэдлэг, мэдээлэлд суурилсан шийдвэр гаргаж байхыг дэмжих;
4. Монгол Улсын Засгийн газар, НҮБ-ын төрөлжсөн байгууллагуудын хооронд нийгмийн хамгааллын асуудлаарх түншлэл, үйл ажиллагааны төлөвлөгөөг тодорхойлох;
5. Монгол Улсад НХСТ-ий бодлогыг үе шаттайгаар хэрэгжүүлэх хүрээнд гарч буй ахиц дэвшлийг хэмжихэд суурь мэдээлэл болгож Үндэсний эдийн засаг, нийгмийн хөгжлийн төлөвлөгөөний хүрээнд хяналт шинжилгээнд ашиглах.

### 3.2. Ерөнхий арга зүй, үйл явцын өрнөл


Үнэлгээгээр одоогийн нийгмийн хамгааллын тогтолцоо, хөтөлбөрүүдийн ерөнхий дүр зургийг гаргаж, мөн дээр дурдсан дөрвөн үндсэн баталгаа бүрт хамаарах бодлогын болон хэрэгжүүлэлтийн алдаа дутагдлуудыг тодорхойлно. Энэхүү үнэлгээ нь цаашид бүх хүн амд наад зах нь НХСТ-г хангах зохицуулалтуудыг боловсруулж хэрэгжүүлэхэд чиглэсэн зөвлөмжүүдийг гаргахад тусална. Үүний дараа нийгмийн хамгааллын хууль эрх зүйн эдгээр нэмэлт зохицуулалтыг амьдралд нэвтрүүлэхэд гарах зардлын тооцооллыг хийнэ. Нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээний талаарх ҮСҮХ нь дараах үе шатуудаас бүрдэнэ. Үүнд:

<sup>9</sup> В. Шмит ба бусад: Нийгмийн хамгааллын үнэлгээнд суурилсан үндэсний хэлэлцүүлэг: Сайн туршлагын гарын авлага (ОУХБ, 2013)

**1 ДҮГЭЭР ШАТ – Үнэлгээний матрицийг боловсруулах** - Одоогийн мөрдөгдөж буй нийгмийн хамгаалал, нийгмийн халамжийн тогтолцоонууд, хөдөлмөрийн зах зээлийн идэвхтэй бодлого, ядуурлыг бууруулах хөтөлбөрүүдийг НХСТ-ны дөрвөн баталгаа тус бүрээр авч үзэж, нийгмийн хамгаалалд хамаарах бүх оролцогч талуудаар буюу салбарын яамд, нийгмийн түншүүд, иргэний нийгмийн байгууллагууд болон хөгжлийн түншүүдээр баталгаажуулна. Энэ матриц нь бодлогын болон хэрэгжүүлэлтийн түвшинд гарч болох алдаа дутагдлуудыг тодорхойлох, мөн бүх хүн амд НХСТ-г баталгаажуулах зорилгоор нийгмийн хамгааллын цаашдын зохицуулалтуудыг боловсруулах, хэрэгжүүлэх зөвлөмжүүдийг гаргахад тус болно.

**2 ДУГААР ШАТ–Зардлыг тооцох** - ОУХБ-ын РАП загвараар Зураг 3-т үзүүлсний дагуу санал болгож буй зөвлөмжүүдийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийн тооцоог гаргаж, (үндэсний статистик мэдээллийн олдцоос хамаарч) арван жилийн хугацаагаар төсөвлөнө. Энэхүү зардлын тооцоо нь тэдгээрийг санхүүжүүлэх төсвийн багтаамж бий эсэхийг тодруулах, улсын төсвийн дахин хуваарилалт, нийгмийн хамгааллын бодлогын сонголтуудыг эрэмбэлэх асуудлыг хэлэлцэх үндэс суурь болно.

**Зураг 3. РАП загварын бүтэц**



Эх үүсвэр: Шмит болон бусад, 2013

**3 ДУГААР ШАТ – Нэгтгэн дүгнэж, баталгаажуулах** - Нийгмийн хамгааллыг өргөжүүлэх, НХСТ-ийг тогтоох чиглэлд өгч буй эцсийн зөвлөмжүүдийг зардлын тооцооллын хамт үндэсний түвшинд баталгаажуулахаар засгийн газрын дээд түвшинд танилцуулна. Засгийн газраар сайшаагдсан эцсийн тайлан нь шинэ хөтөлбөрүүдийн дизайныг боловсруулахад шаардагдах техник эдийн засгийн үндэслэлийг судлах, одоогийн тогтолцоог өргөжүүлэх, зохицуулалтын механизмуудыг бүрдүүлэх зэрэг дараа дараагийн алхмуудыг бэлтгэхэд тусална.

Хүснэгт 2-т ҮСҮХ-ээр гаргаж авах мэдээлэл, хэлэлцүүлгийн үр дүнд үндэслэн хэрэгжүүлэх боломжит алхмуудыг нэгтгэн харуулав.

**Хүснэгт 2. Үнэлгээнд суурилсан үндэсний хэлэлцүүлгийн хамрах хүрээ**

| ҮСҮХ-ийг хийснээр дараах зүйлсийг мэдэж авна: |                                                                                                                                                                                                                   |
|-----------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Нөхцөл байдал ямар байна вэ?                  | НХСТ-ий баталгаа тус бүрээр одоо хүчин төгөлдөр буй тогтолцоо, хууль эрх зүйн зохицуулалтуудын ерөнхий дүр зураглал.                                                                                              |
| НХСТ-г бүрэн хангахад бид хэр хол байна вэ?   | НХСТ-ий хүрээнд одоо байгаа тогтолцоонуудыг харьцуулах – Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмж, орлогын баталгаа нь нийт хүн амд хангагдсан байна уу? Тэтгэвэр, тэтгэмжүүд хангалттай байж чадаж байна уу? |

|                                                       |                                                                                                                                                                                                                                                                                                                                           |
|-------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| НХСТ-г тогтоохын тулд бид юу хийх хэрэгтэй вэ?        | Нийгмийн хамгааллын шинэ, эсхүл одоогийн хууль эрх зүйн зохицуулалтуудыг өргөжүүлэх санал зөвлөмжүүд.                                                                                                                                                                                                                                     |
| Үүнийг хийхэд хэр их зардал гарах вэ?                 | РАП загварыг ашиглан НХСТ-ий нэмэлт зохицуулалтуудыг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн тооцоо, ДНБ болон улсын төсвийн орлого, зарлагатай харьцуулсан зардлын тооцоо, зардлыг улсын төсөвт тусгасан төсөөлөл боловсруулж санал болгож буй нийгмийн хамгааллын зохицуулалтуудыг хэрэгжүүлэх боломжтой эсэхийг урьдчилсан байдлаар гаргах. |
| <b>ҮСҮХ-ийг дараах байдлаар гүйцэтгэж болно:</b>      |                                                                                                                                                                                                                                                                                                                                           |
| НХСТ-ий шинэ зохицуулалтуудыг хэрхэн санхүүжүүлэх вэ? | Улсыг төсвийн зарлагыг дахин хуваарилах, төсвийн багтаамжийг нэмэгдүүлэх байдлаар болон өөр бусад арга замаар шинэ зохицуулалтуудыг хэрхэн санхүүжүүлэх талаар зөвлөмжүүд гаргах.                                                                                                                                                         |
| Хөрөнгө оруулалтын өгөөж нь ямар байх вэ?             | Ядуурлыг бууруулах, тэгш бус байдал, ажил эрхлэлт, бүтээмж, эдийн засгийн өсөлт зэрэгт НХСТ-ий зохицуулалтуудын үзүүлэх үр нөлөөнд шинжилгээ хийх. Улмаар НХСТ-ий хөрөнгө оруулалтын өгөөжийн түвшинг тооцох.                                                                                                                             |
| Зөвлөмжүүдийг хэрхэн сурталчлах вэ?                   | Олон нийт, ажилчид ба ажил олгогчид, парламент, засгийн газрын байгууллагуудад зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх талаар танилцуулах нийгмийн маркетингийн болон мэдээлэл, сурталчилгааны арга тактикуудыг боловсруулах.                                                                                                                           |

Эх үүсвэр: Шмит болон бусад, 2013

### Монгол Улсад явагдсан ҮСҮХ-ийн үйл явц

2013 оны 7 дугаар сараас 2014 оны арван хоёрдугаар сар хүртэл НҮБ/ЗГ-ын хамтарсан Нийгмийн хамгааллын ажлын хэсэг нь Монгол Улсын нийгмийн хамгааллын нөхцөл байдалд үнэлгээ хийх, бодлогын хийдэл, хэрэгжүүлэлтийн шатны асуудлуудыг тодорхойлох, улмаар үндэсний НХСТ-г цогцоор нь бүрдүүлэхэд чиглэсэн бодлогын зөвлөмжүүдийг боловсруулах зорилгоор чиглэлийн яамд, засгийн газрын агентлагууд, НҮБ-ын төрөлжсөн байгууллагууд, нийгмийн түншүүд, иргэний нийгмийн байгууллагууд, эрдэмтэн судлаачид болон бусад оролцогч талуудтай хамтран ажиллалаа.

ҮСҮХ-ийн үйл явц нь дараах зүйлд үндэслэсэн болно. Үүнд:

- Судалгаа, тайлан, хууль тогтоомж болон статистикийн тайлан эмхэтгэлийн тойм судалгаа;
- Хоёр талын зөвлөлдөх уулзалтууд, техникийн сургалт семинарууд, үе шат бүрийн үр дүнг танилцуулж санал солилцох, мэдээлэл цуглуулах, түүнчлэн Засгийн газар, нийгмийн түншүүд, иргэний нийгмийн байгууллагууд, эрдэмтэн судлаачдын дунд яриа хэлэлцээг дэмжих зорилготой үндэсний хэмжээний зөвлөлдөх уулзалтууд;
- Чадавхи бэхжүүлэхэд чиглэсэн бодлогын зөвлөлгөөн, сургалт семинар;
- НҮБ/Засгийн газрын хамтарсан Нийгмийн хамгааллын ажлын хэсгийн үйл ажиллагаа;
- НҮБ, салбарын яамд, эрдэмтэн судлаачид, иргэний нийгмийн байгууллагууд хоорондын бодлогын зөвлөгөөн, уялдаа холбоо.

Энэхүү хэсэгт үнэлгээний үйл явцын гурван шат тус бүрт хэрэгжүүлсэн үйл ажиллагааг хураангуйлан оруулав.

## НЭГДҮГЭЭР ҮЕ ШАТ-Үнэлгээний матрицийг боловсруулах

**Тойм судалгаа:** 2013 оны 7 дугаар сараас 9 дүгээр сард ОУХБ-аас НХСТ-ий дөрвөн баталгаа түс бүрээр одоогийн мөрдөж буй нийгмийн даатгал, нийгмийн хамгааллын хөтөлбөрүүдийг бүртгэж, судлах ажлыг гол төлөв тойм судалгааны аргаар хийж, мэдээлэл цуглуулсан. НҮБ/ЗГ-ын Нийгмийн хамгааллын хамтарсан ажлын хэсэг ҮСҮХ-ийн эхний үндэсний хэмжээний зөвлөлдөх уулзалтын үеэр танилцуулах үнэлгээний матрицийн анхны хувилбарыг хянаж, баталсан болно.

**Үндэсний хэлэлцүүлэг 1:** Үнэлгээний матрицийн анхны хувилбарыг 2013 оны 9 дүгээр сарын 5-нд ҮСҮХ-ийг албан ёсоор эхлүүлэх уулзалт<sup>10</sup> дээр танилцуулж хэлэлцүүлсэн бөгөөд уг уулзалтад салбарын яамд, нийгмийн түншүүд, иргэний нийгмийн байгууллагууд, эрдэмтэн судлаачид, НҮБ-ын 50 гаруй төлөөлөгчид оролцсон юм. НХСТ-г бүрдүүлэх зорилгоор цаашид нийгмийн хамгааллын дутагдаж буй зохицуулалтуудыг боловсруулж хэрэгжүүлэхдээ анхаарвал зохих бодлогын болон хэрэгжүүлэлтийн түвшинд тулгамдаж буй гол алдаа дутагдлыг энэ хэлэлцүүлгээр тодорхойлсон юм.

**Хоёр талт зөвлөлдөх уулзалтууд:** 2013 оны 9 дүгээр сараас 11 дүгээр сар хүртэл ОУХБ-ын ахалсан НҮБ/ЗГ-ын хамтарсан Нийгмийн хамгааллын ажлын хэсэг өмнө дурдсан дөрвөн баталгаа түс бүрээр одоогийн мөрдөж буй нийгмийн хамгааллын хөтөлбөрүүд, холбогдох хууль тогтоомжийг бүртгэн судлах, үнэлгээний матрицийг Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам (ХАХНХЯ), Хөдөлмөрийн яам, Эрүүл мэндийн яам (ЭМЯ, тухайн үеийн хуучин нэрээр), Сангийн яам, Нийгмийн даатгалын ерөнхий газар (НДЕГ), Нийгмийн халамж, үйлчилгээний ерөнхий газар (НХҮЕГ), аймаг, сумын түвшин (Өвөрхангай, Баянхонгор аймгууд)-д ажиллаж буй төрийн болон орон нутгийн байгууллагууд, Монгол Улсын Их сургууль, Удирдлагын академи, Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо (МАОЭНХ), Монголын үйлдвэрчний эвлэлийн холбоо (МҮЭХ) зэрэг байгууллагуудын оролцоотойгоор хэлэлцэн баталгаажуулах зорилготой хоёр талын зөвлөлдөх уулзалтуудыг зохион байгууллаа.

**Үндэсний хэлэлцүүлэг 2:** Шинэчлэн хянасан үнэлгээний матрицийг бодлогын болон хэрэгжүүлэлтийн түвшинд буй алдаа дутагдлуудыг олж илрүүлсэн хэд хэдэн чухал үр дүн, түүнчлэн зөвлөмжүүдийн хамтаар 2013 оны 12 дугаар сарын 5-ны өдөр болсон *Үнэлгээний матрицийг баталгаажуулах уулзалт семинар*<sup>11</sup> дээр танилцуулж, баталгаажуулсан болно. Энэхүү хоёр дахь удаагийн үндэсний хэлэлцүүлэгт яамд, нийгмийн түншүүд, иргэний нийгмийн байгууллагууд, эрдэмтэн судлаачид, НҮБ-ын 60 гаруй төлөөлөгчид оролцсон юм. Энэ хэлэлцүүлгээс НХСТ-г бүрдүүлэх зорилгоор цаашид нийгмийн хамгааллын дутагдаж буй зохицуулалтуудыг боловсруулж хэрэгжүүлэхтэй холбогдсон бодлогын тодорхой зөвлөмжүүдийг гаргасан юм.

**Матрицийг эцэслэн боловсруулах:** Хоёр удаагийн үндэсний хэлэлцүүлгээс гарсан үр дүн дээр үндэслэн үнэлгээний матриц болон хууль эрх зүйн хүрээг эцэслэн боловсруулсан болно.

## ХОЁРДУГААР ҮЕ ШАТ – ОУХБ-ын РАП загвараар зардлыг тооцох

**Хувилбарууд:** Тэргүүлэх гол зөвлөмжүүдийг 2014 оны 3 дугаар сарын 13-ны өдөр хуралдсан НҮБ/ЗГ-ын хамтарсан Нийгмийн хамгааллын ажлын хэсгийн хурлаар хэлэлцэж “өртөг зардал тооцож болохуйц” хувилбарууд буюу цаашид шинээр нэвтрүүлэх, хүрээг нь өргөжүүлэх шаардлагатай нийгмийн хамгааллын тодорхой арга хэмжээнүүд болгон томъёолсон юм. Энэ уулзалтад ХАХНХЯ, Хөдөлмөрийн яам, НҮБ (ОУХБ, НҮБХС, НҮБХХ, ДЭМБ)-ыг төлөөлсөн 13 мэргэжилтэн оролцсон болно.

<sup>10</sup> Уулзалтын талаарх мэдээллийг эндээс үзнэ үү: <http://www.social-protection.org/gimi/gess/ShowProjectPage.do?pid=2287>

<sup>11</sup> Уулзалтын талаарх мэдээллийг эндээс үзнэ үү: <http://www.social-protection.org/gimi/gess/ShowProjectWiki.action?wiki.wikiId=2202>

**Зардлын тооцоолол:** НҮБ/ЗГ-ын хамтарсан Нийгмийн хамгааллын ажлын хэсгийг төлөөлж ОУХБ-ын зөвлөх нь хүн амын тоо, ажиллах хүчний оролцооны түвшин, эдийн засгийн үзүүлэлтүүд, улсын төсөв зэрэг санал болгож буй хувилбаруудаар зардлын тооцоо хийхэд шаардлагатай холбогдох бүх мэдээллийг цуглуулав. ОУХБ-ын МАПС төслөөс РАП загварыг ашиглан санал болгож буй хувилбаруудын зардлын тооцоо, төсөөллийг 2015-2020 онуудаар боловсрууллаа.

**Үндэсний хэлэлцүүлэг 3:** 2014 оны 5 дугаар сарын 2-ны өдөр болсон “НХСТ-ий зардлыг тооцох нь: Аргачлал ба Урьдчилсан үр дүн” сэдэвт 3 дахь удаагийн үндэсний хэлэлцүүлэгт хувилбаруудыг танилцуулж, хэлэлцүүлсэн.<sup>12</sup> Мөн оролцогч талуудад РАП загварын арга зүй, тооцооллын урьдчилсан үр дүнг танилцуулав. Зөвлөлдөх уулзалтаас гарсан санал, шүүмжийг ОУХБ-ын РАП аргачлалыг ашиглан НХСТ-ий тооцооллыг эцэслэн боловсруулахад ашигласан болно.

**РАП загварын сургалт:** ОУХБ-аас 2014 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр “Нийгмийн хамгааллын хөтөлбөрүүдийн зардлыг хэрхэн тооцоолж, санхүүжүүлэх вэ?” сэдэвт практик сургалтыг зохион байгуулав. Төрийн байгууллага, хөдөлмөрчдийн болон ажил олгогчид, иргэний нийгэм, эрдэмтэн судлаачдын төлөөлөл 25 хүн уг сургалтад хамрагдаж ОУХБ-ын РАП загварын Монгол Улсад зориулан боловсруулсан аргачлалтай танилцлаа.

#### **ГУРАВДУГААР ҮЕ ШАТ – Эцэслэн боловсруулж, баталгаажуулах**

**РАП загварын тооцооллын үр дүнгийн баталгаажуулалт:** РАП загвараар тооцсон эцсийн үр дүнг НҮБ/ЗГ-ын Нийгмийн хамгааллын ажлын хэсэг 2014 оны 9 дүгээр сарын 9-ны өдөр ОУХБ, НҮБХС ДЭМБ, НҮБХХ-ийн төлөөллийг оролцуулан хэлэлцэж нэгтгэн дүгнэв.

**Үндэсний хэлэлцүүлэг 4:** 2014 оны 9 дүгээр сарын 11-ний өдөр НҮБ/ЗГ-ын хамтарсан Нийгмийн хамгааллын ажлын хэсэг “Үнэлгээнд суурилсан үндэсний хэлэлцүүлэг: Эцсийн үр дүн ба Засгийн газарт өгөх зөвлөмжүүд”<sup>13</sup> сэдэвт 4 дэх үндэсний хэлэлцүүлгийг Засгийн газар, нийгмийн түншүүд, иргэний нийгмийн байгууллагууд, эрдэмтэн судлаачид болон НҮБ-ын төлөөлөгчдийг оролцуулан зохион байгуулж, зардлыг тооцох үнэлгээний ажлын үр дүнг танилцуулан санал солилцож, цаашид хийх дараагийн алхмуудаа ярилцав. Өөрөөр хэлбэл, нийгмийн хамгааллыг санхүүжүүлэх төсвийн багтаамжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн боломжит арга хэмжээнүүдийг тодорхойлох, НХСТ-ий хүрээнд хамрагдаж буй бодлогын уялдаа холбоо, тэдгээрийн хэрэгжилтийг сайжруулах, эцсийн тайланг НҮБ-ын Монгол Улс дахь Удирдлагын баг, Засгийн газар, нийгмийн түншүүдээр баталгаажуулахын тулд авах алхмуудаа ярилцлаа. 4 дэх удаагийн үндэсний хэлэлцүүлгээс цаашид авч хэрэгжүүлэх олон арга хэмжээ хэрэгжүүлэхээр тогтсоны дотор “Нийгмийн хамгаалал надад яагаад хэрэгтэй вэ?” гэсэн нэртэй, олон нийтэд мэдлэг мэдээлэл өгөх видео сурталчилгааг бэлтгэхээр болсны зэрэгцээ ҮСҮХ-ээс гаргасан зөвлөмжүүдийн хэрэгжилт, НХСТ-ий бодит биелэлтийг хэмжих хяналт шинжилгээний тогтолцоотой болох нь зүйтэй гэж шийдвэрлэсэн болно.

**Тайлан боловсруулалт:** НҮБ/ЗГ-ын хамтарсан Нийгмийн хамгааллын ажлын хэсгийг ахалж байгаагийн хувьд ОУХБ нь тайлангийн төслийг 2014 оны 9 дүгээр сараас 12 дугаар сарын хугацаанд боловсруулав. 2015 оны нэгдүгээр сард тус ажлын хэсгийн гишүүдийн саналыг авах зорилгоор тайлангийн төслийг хүргүүлэв.

**Сурталчлан таниулах ажил:** Тайланг албан ёсоор танилцуулсны дараа зөвлөмжүүдийн заримыг үндэсний хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөө болон нийгмийн хамгааллын бодлогод тусгуулах, үр дүнтэй хэрэгжүүлэх талаар нөлөөллийн буюу сурталчлан таниулах үйл ажиллагааг үргэлжлүүлэх учиртай.

<sup>12</sup> Уулзалтын талаарх мэдээллийг эндээс үзнэ үү: <http://www.social-protection.org/gimi/gess/ShowProjectWiki.action?wiki.wikiId=2419>

<sup>13</sup> Уулзалтын талаарх мэдээллийг эндээс үзнэ үү: <http://www.social-protection.org/gimi/gess/ShowProjectWiki.action?wiki.wikiId=1569>

Зураг 4-т Монгол Улсад өрнөсөн ҮСҮХ-ийн үйл явцыг харуулав.

Үндэсний хэлэлцүүлгүүдээр санал нэгдсэн зөвлөмжүүдийг нийгмийн хамгаалалтай холбогдох олон улсын хөдөлмөрийн хэм хэмжээний зарчим, үзүүлэлтүүдтэй харьцуулан авч үзэж, хэлэлцсэн болно. Эдгээр хэм хэмжээг дүрдвал:

- Нийгмийн хамгааллын суурь түвшний тухай зөвлөмж, 2012 (No. 202);
- Нийгмийн хамгааллын доод хэм хэмжээний тухай конвенц, 1952 (No. 102);
- Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний үеийн хамгааллын тухай конвенц, 1964 (No. 121);
- Хөдөлмөрийн чадвараа алдсаны, өндөр насны болон тэжээгчээ алдсаны тэтгэврийн тухай конвенц, 1967 (No.128);
- Эхчүүдийн хамгааллын тухай конвенц, 2000 (No.183);
- Нийгмийн хамгааллын хүрээнд адил тэгш хандах тухай конвенц, 1962 (No.118).

**Зураг 4: ҮСҮХ-ийн үйл явц**



Эх үүсвэр: НҮБ/ЗГ-ын хамтарсан Нийгмийн хамгааллын ажлын хэсэг, 2015

### 3.3 Нийгмийн хамгааллын үндэсний тогтолцооны тойм

#### Эдийн засгийн хурдацтай өсөлт

Монгол Улс сүүлийн арван жилд эдийн засгийн гайхамшигтай өсөлттэй байлаа. 2008-2009 оны дэлхийн санхүүгийн хямралын дараа ДНБ-ий өсөлт 2 оронтой тоонд хүрч, ядуурлыг бууруулахад хүргэсэн гол арга хэрэгсэл нь эдийн засгийн өсөлт гэж үзэж байсан юм. Эдийн засгийн энэхүү байдал нь ядуурал огцом буурахад хувь нэмэр оруулж, Үндэсний статистикийн хорооноос гаргасан судалгаагаар ядуурлын түвшин 2010 онд 38.7 хувь байсан бол 2012 онд 27.4 хувь болж буурсан байна.

Монгол Улсын эдийн засаг, улс төрийн хүрээний гол сорилт нь эрдэс баялгаас хамааралтай эдийн засгийн өсөлт, бууралтын мөчлөг хооронд тогтвортой өсөлтийг хангах явдал болж байна. Өнгөрсөн хэдэн жилийн хугацаанд хүрсэн эдийн засгийн хоёр оронтой тооны өсөлт, тухайлбал 2011 онд ДНБ 17.3 хувийн өсөлттэй гарсан нь ашигт малтмалын салбар дахь хөрөнгө оруулалт, үйлдвэрлэл, экспорт дээр түшиглэж байсан юм. Монгол Улс нь зэс, алт, цайр, жонш, нүүрс зэрэг эрдэс баялагийн

томоохон үйлдвэрлэгч орон юм. Тус улс асар их нөөцтэй учир үйлдвэрлэлийг мэдэгдэхүйцээр нэмэгдүүлэх боломжтой.

Гэсэн хэдий ч Монгол Улсын эдийн засгийн хөгжилд зогсонги байдал нүүрлээд байна. Үнэхээр өсөлтийн хурдац 2011 онд 17.3 хувь байснаа 2013 онд 11.7 хувь болж саарсан байна. Олон улсын валютын сан (ОУВС), Дэлхийн Банкны аль аль нь 2014 онд ДНБ-ий өсөлтийн хурд буурч 9.5 хувь болно гэж тооцоолж байсны зэрэгцээ 2015 онд Монгол Улсын бодлого шийдвэрээс хамаарч, ДНБ дээд тал нь 12 хувь, доод тал 2 хувиар өснө гэсэн таамаглал гаргажээ. Санхүү, мөнгөний зөөлөн бодлого нь эдийн засгийн сөрөг өөрчлөлтийн шалтгаан байж болохыг ОУВС тэмдэглэжээ.

Эдийн засгийн хурдацтай өсөлттэй орны хувьд ядуурлын түвшин нь хүлээн зөвшөөрөх аргагүй өндөр байна. Эрүүл мэндийн болон бусад суурь үйлчилгээний хүртээмж хангалтгүй, байгалийн гамшиг, хөдөлмөр эрхлэх боломжийн хомсдол, бүс нутгийн хөгжлийн тэнцвэргүй байдал, боловсрол ба хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хоорондын үл зохицол зэрэг нь ядуурлын шалтгаан болж байна.

### Нийгмийн хамгаалал бол Монгол Улсын бодлогын нэг тэргүүлэх чиглэл


Монгол Улс нь албан журмын нийгмийн даатгалаас гадна малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, албан бус эдийн засагт ажиллагчдыг сайн дурын үндсэн дээр хамруулдаг нийгмийн хамгааллын тогтолцоог бий болгосон байна. Мөн эрүүл мэндийн албан журмын даатгал, бүх хүүхэд хамрагддаг хүүхдийн мөнгө, нийгмийн халамжийн хэд хэдэн хөтөлбөртэйгээс гадна сүүлийн үед хөдөлмөр эрхлэлтийг дэмжих болон орон нутгийн хөгжлийг хангах хөтөлбөрүүдийг өргөжүүлэхэд чиглэсэн хууль тогтоомжуудыг хэрэгжүүлж байна. Гэсэн ч уул уурхайн салбараас хэт хамааралтай Монгол Улсын өнөөгийн хөгжил нь эдийн засгийн тогтвортой өсөлт, нийгмийн бодлогын залгамж чанарыг хадгалахад аюул дагуулж болох талтай юм. Үүнээс гадна нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж болон хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг хүн ам тархуу суурьшсан улс орон даяар зохион байгуулж, хүргэхэд хүндрэлтэй бөгөөд энэ нь малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, албан бус эдийн засагт ажиллагчдын 75 хувийг орлогын хангалттай баталгаагүй үлдэхэд хүргэж байна.

Ийм учраас Монгол Улсын Засгийн газар нийгмийн бодлогыг бэхжүүлэх, нийгмийн хамгааллын суурь түвшин тогтоох нь хот ба хөдөөгийн хөгжлийн ялгааг ойртуулахад чухал ач холбогдолтой гэж үзсэн юм.

### Монгол Улсын нийгмийн хамгааллын тогтолцооны тойм

Монгол Улсын өнөөгийн нийгмийн хамгааллын тогтолцоо нь нийгмийн халамжийн (зорилтот бүлэгт чиглэсэн болон бүх нийтийг хамарсан) хөтөлбөрүүд, нийгмийн даатгал, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ гэсэн гурван гол үндсэн хэсгээс бүрдэж байгааг Зураг 5-д үзүүлэв.


**Зураг 5. Монгол Улсын нийгмийн хамгааллын тогтолцооны ерөнхий бүтэц**



Эх үүсвэр: Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, Нийгмийн хамгааллын салбарын стратегийн баримт бичиг, 2003

Монголын нийгмийн даатгалын тогтолцоо нь даатгуулагч ажилтан, ажил олгогчийн төлсөн шимтгэл дээр суурилах бөгөөд хэд хэдэн төрлийн тэтгэвэр, тэтгэмжийг олгож байна. Нийгмийн даатгал нь доорх Зураг 6-д харуулсан таван төрөлтэй болно.

Зураг 6: Монгол Улсын нийгмийн даатгалын тогтолцоо



Эх үүсвэр: НДЕГ, Нийгмийн даатгалын багц хууль

Төрийн албан хаагчид, хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж буй Монгол Улсын болон гадаадын иргэд, харьяалалгүй хүмүүс нийгмийн даатгалд албан журмаар хамрагддаг бол малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, албан бүс эдийн засагт ажиллагчид сайн дураар даатгуулж болно. Эдийн засгийн идэвхтэй хүн ам (ЭЗИХА), нийгмийн даатгалд албан журмаар болон сайн дураар хамрагдсан иргэдийн тоо мэдээллийг Хүснэгт 3-т харуулав.

### Хүснэгт 3: Нийгмийн даатгалд даатгуулагчдын тоо (мянган хүн)

|                                                                                | 2010    |         | 2011    |         | 2012    |         | 2013    |         |
|--------------------------------------------------------------------------------|---------|---------|---------|---------|---------|---------|---------|---------|
|                                                                                | Эрэгтэй | Эмэгтэй | Эрэгтэй | Эмэгтэй | Эрэгтэй | Эмэгтэй | Эрэгтэй | Эмэгтэй |
| Эдийн засгийн идэвхтэй хүн ам                                                  | 628 870 | 531 085 | 635 034 | 567 732 | 654 144 | 597 080 | 668 590 | 608 115 |
| <i>Нийгмийн даатгалд даатгуулагчдын бүлэг</i>                                  |         |         |         |         |         |         |         |         |
| Албан журмын даатгалд даатгуулагчид                                            | 270 183 | 278 279 | 315 963 | 310 241 | 357 526 | 348 959 | 387 235 | 379 580 |
| Сайн дурын даатгалд даатгуулагчид, үүнээс:                                     | 22 777  | 39 906  | 29 096  | 52 240  | 34 800  | 66 172  | 52 115  | 94 987  |
| Малчид                                                                         | 2787    | 3954    | 4652    | 6548    | 5298    | 7201    | 10527   | 13196   |
| Хувиараа хөдөлмөр эрхлэгчид                                                    | 6853    | 12539   | 7463    | 13935   | 9630    | 19286   | 15818   | 30656   |
| Бусад (албан бус эдийн засагт ажиллагчид)                                      | 13139   | 23415   | 16995   | 31775   | 19945   | 39759   | 26398   | 51447   |
| Эх үүсвэр: НДЕГ, РАП загварын таамаглалд нийцүүлэн өөрчилж тооцсон ЭЗИХА, 2015 |         |         |         |         |         |         |         |         |

2013 оны жилийн эцсийн байдлаар нийгмийн даатгалд 766,815 хүн албан журмаар хамрагдсан бол сайн дураар 147,100 хүн даатгуулжээ. Өөрөөр хэлбэл, эдийн засгийн идэвхтэй хүн амын 71.6 хувь нь л нийгмийн даатгалд хамрагдсан байна (Хүснэгт 4). Гэхдээ сайн дурын даатгалд хамрагдагсад нь уг даатгалд хамрагдвал зохих нийт малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, албан бус эдийн засагт ажиллагчдын 23.3 хувь нь болж байна.

### Хүснэгт 4: Нийгмийн даатгалд даатгуулагчдын эдийн засгийн идэвхтэй хүн амд эзлэх хувь

| Даатгуулагчдын бүлэг                                                           | 2010        | 2011        | 2012        | 2013        |
|--------------------------------------------------------------------------------|-------------|-------------|-------------|-------------|
| Албан журмын даатгалд даатгуулагчид                                            | 47.3        | 52.1        | 56.5        | 60.1        |
| Сайн дурын даатгалд даатгуулагчид, үүнээс:                                     | 5.4         | 6.8         | 8.1         | 11.5        |
| Малчид                                                                         | 0.6         | 0.9         | 1.0         | 1.9         |
| Хувиараа хөдөлмөр эрхлэгчид                                                    | 1.7         | 1.8         | 2.3         | 3.6         |
| Бусад (албан бус эдийн засагт ажиллагчид)                                      | 3.2         | 4.1         | 4.8         | 6.1         |
| <b>Нийт</b>                                                                    | <b>52.7</b> | <b>58.9</b> | <b>64.6</b> | <b>71.6</b> |
| Эх үүсвэр: НДЕГ, РАП загварын таамаглалд нийцүүлэн өөрчилж тооцсон ЭЗИХА, 2015 |             |             |             |             |

Эрүүл мэндийн албан журмын даатгал нь бараг бүх нийтийг буюу хүн амын 90 гаруй хувийг хамарсан байна.

Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, өнчин болон нярай хүүхдүүд, жирэмсний болон амаржсаны амралттай байгаа эмэгтэйчүүд, бие даан амьдрах чадваргүй олон хүүхэдтэй ганц бие эхчүүд зэрэг эмзэг бүлгийн иргэдэд төрийн дэмжлэг үзүүлэхэд төсвөөс санхүүждэг нийгмийн халамжийн тогтолцоо чухал үүрэг гүйцэтгэж байна. ДНБ-ий 1.0 хувьтай тэнцэх зардалтай, хүн амын тодорхой бүлэгт зориулахаар хуульд заасан 29 хөтөлбөр байна<sup>14</sup>. 2010 – 2014 оны хооронд нийгмийн халамжийн зардал 99.3 тэрбум төгрөг байснаа 237.1 тэрбум төгрөг болж, хоёр илүү дахин нэмэгдэн, дөрвөн хүн тутмын нэг нь халамжийн ямар нэг тэтгэмж, түслэмж авч байсан нь ядуурлыг бууруулахад эерэгээр нөлөөлсөн байна. 2010-2012 оны хооронд ядуурлын хамралтын хүрээ 38.7 хувиас 27.4 хувь, хөдөө орон нутагт 49.0 хувиас 35.5 хувь болж буурчээ.<sup>15</sup>

<sup>14</sup> Хөтөлбөрүүдийг 2012 оны Нийгмийн халамжийн тухай хууль, 2005 оны Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хууль, 2005 оны Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хууль болон 2008 оны Монгол Улсын баатар, хөдөлмөрийн баатар, ардын болон гавьяат цолтон ахмад настанд төрөөс олгох нэмэгдлийн тухай хуулийн дагуу ХАХНХЯ-ны харьяа Нийгмийн халамж, үйлчилгээний ерөнхий газар хэрэгжүүлдэг.

<sup>15</sup> УСХ, 2014

Нийгмийн халамжийн хөтөлбөрүүдийг санхүүжүүлдэг нэг чухал эх үүсвэр нь 2009 онд УИХ-аас баталсан Хүний хөгжил сангийн тухай хуулийн дагуу байгуулагдсан Хүний хөгжил сан (ХХС) юм. ХХС нь эрдэс баялаг, уул уурхайн орлогоос бүрддэг бөгөөд Монгол Улсын бүх иргэнд баялгийг тэгш хуваарилах зорилготой. Дахин хуваарилалт нь тэтгэврийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөх, орон сууц худалдаж авсны үнэ төлөх, бэлэн мөнгө олгох, эрүүл мэнд, боловсролын үйлчилгээний төлбөр төлөх, хүүхдийн мөнгө олгох хэлбэрээр хийгдэх ёстой. Хүүхдийн мөнгө хөтөлбөр нь ХХС-аас санхүүжүүлдэг хамгийн гол хөтөлбөрүүдийн нэг юм.

Хөдөлмөр эрхлэлтийн зонхилох хэлбэр нь мал аж ахуй, хувиараа болон албан бус хөдөлмөр эрхлэлт (2013 онд эдийн засгийн идэвхтэй хүн амын 55.7 хувийг эзэлж байв) байна. 2013 онд ажилгүйдлийн түвшин 7.8 хувьтай байв (ҮСХ). Албан бус эдийн засагт бүрэн бус ажил эрхлэлт болон далд ажилгүйдэл өндөр, мал аж ахуй дахь өрхийн үйлдвэрлэлд бүтээмж, орлого бага, хөдөлмөрийн нөхцөл муу байна. Дэд бүтэц сул хөгжсөн, хүн ам цөөтэй учраас хөдөө орон нутагт мал аж ахуйгаас бусад салбарт хөдөлмөрийн зах зээл хязгаарлагдмал учир хөдөө орон нутгаас хот суурин газар руу чиглэсэн ажиллах хүчний шилжих хөдөлгөөнийг эрчимжүүлж байна.

Институцийн тухайд гэвэл Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам нь 2012 онд Хөдөлмөрийн яам ба ХАХНХЯ болж хуваагджээ. Энэхүү бүтцийн өөрчлөлт нь нийгмийн хамгааллыг өргөжүүлж, хөдөлмөрийн зах зээлийн идэвхтэй бодлого (ХЗЗИБ)-ыг шинэчлэх замаар хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, ядуурлыг бууруулах, хүний хөгжлийг дэмжих зорилготой ажээ. Хөдөлмөрийн яам нь анх 2001 онд батлаж, 2011 онд шинэчлэн найруулсан Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийг хэрэгжүүлэх, ялангуяа 2011 онд эхлүүлсэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдийг эрчимжүүлэх зорилт тавин ажиллаж байна.



#### 4. Нэгдүгээр үе шат. Монгол Улсад явагдсан нийгмийн хамгаалал болон хөдөлмөр эрхлэлтийг дэмжих асуудлаарх ҮСҮХ-ийн матрицийн боловсруулалт, үр дүн

Үнэлгээний матриц нь одоо байгаа болон шинээр төлөвлөж буй нийгмийн хамгааллын зохицуулалтууд нь НХСТ-ий дөрвөн баталгаа тус бүрийг хэрхэн хангаж байгаад дүн шинжилгээ хийх арга хэрэгсэл юм. Үндэсний оролцогч талууд нь НХСТ-ий матрицийг нийгмийн хамгааллын иж бүрэн тогтолцоог бүрдүүлэх бодлогын тэргүүлэх чиглэлүүдээ тодорхойлохдоо ашиглаж боломжтой. Баталгаа тус бүрийн хувьд матриц нь нийгмийн хамгааллын тогтолцоонууд, тэдгээрийн хууль эрх зүйн хамрах хүрээ болон үр дүнтэй хамрагдалт, бодлогын хийдэл болон хэрэгжүүлэлтийн түвшний алдаа дутагдал, мөн сайжруулах боломжуудыг тодорхойлж өгнө.

Зураг 7. Үнэлгээний матрицийн бүтэц

|                   | НХДХС-ний зорилтууд | Одоогийн НХДХС-ний заалтууд                                                                                                   | Одоогийн хамралт | Стратегид урьдчилан харж буйгаар | Бодлогын цоорхой                                              | Хэрэгжилтийн алдаа                                                                       | Зөвлөмж                                            | Хувилбарууд-ын өргийг тооцох |
|-------------------|---------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------|----------------------------------|---------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------|------------------------------|
| Эрүүл мэнд        |                     |                                                                                                                               |                  |                                  |                                                               |                                                                                          |                                                    |                              |
| Хүүхэд            |                     | Нийгмийн хамгааллын зорилтуудыг харгалзан үзэж, нийгмийн хамгааллын одоогийн болон төлөвлөж буй арга хэмжээнүүдийг тайлбарлах |                  |                                  | Бодлогын цоорхой, хэрэгжүүлэлтийн алдаа дутагдлыг тодорхойлох |                                                                                          |                                                    |                              |
| ХНХА              |                     |                                                                                                                               |                  |                                  |                                                               | Үнэлгээний үр дүнд үндсэн үндэсний хэлэлцүүлгээр шийдсэн нэн тэргүүний бодлогын саналууд | Бодлогын цоорхой болон зөвлөмж дээр үндсэн өртгийг |                              |
| Өндөр настан, ХБИ |                     | Нийгмийн хамгааллын доод хэм хэмжээний хэвзагвар: Баталгаа ба Зорилтууд                                                       |                  |                                  |                                                               |                                                                                          | урьдчилан тооцох                                   |                              |

Эх үүсвэр: Шмит болон бусад, 2013

Зураг 7-д үнэлгээний матрицийн бүтцийг харуулав. Үнэлгээний матрицийн эцсийн хувилбарыг үзэх холбоосыг энэ тайлангийн хавсралтад тусгав.

Дараах хэсгүүдэд баталгаа тус бүрээр матрицад тусгагдсан мэдээллийг дэлгэрэнгүй орууллаа.



#### 4.1. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ

*“Эхэд үзүүлэх тусламж, үйлчилгээг оруулан үндэснийхээ түвшинд тодорхойлсон (олдоц, хүртээмж, хэрэгцээ, чанарын шалгуурт нийцсэн) эрүүл мэндийн нэн шаардлагатай тусламж, үйлчилгээний багц;”*

##### Одоогийн зохицуулалтууд

Монгол Улсын Үндсэн хуульд иргэн бүрийн эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж, үйлчилгээ авах эрхийг баталгаажуулсан байна. 1990 оноос өмнө Монгол Улсын нийт хүн амд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх үүргийг төр хариуцаж, улсын төсвөөс бүрэн санхүүжүүлж тэгш үйлчилгээ хүргэдэг байв. Зах зээлийн эдийн засагт шилжих шилжилтийн явцад эдийн засаг буурч, улсын хөрөнгө нөөц багассаны улмаас Засгийн газар эрүүл мэндийн салбарын төсвийг эрс бууруулсан байна. Нийгмийн эрүүл мэндийн даатгал (ЭМД) нь эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүрсэн түвшинг хадгалах, хүн амыг эрүүл мэндийн зардалтай холбоотой санхүүгийн эрсдлээс хамгаалах, тэгш хүртээмжтэй, чанартай үйлчилгээг хүргэх зорилго тавьжээ. Бүх нийтийн нийгмийн ЭМД-ын тогтолцоо нь эв санааны нэгдлийн зарчим дээр тулгуурласан нийгмийн даатгалын таван төрлийн нэг бөгөөд Монгол Улсын бүх иргэнийг албан журмаар хамруулахаас гадна гадаадын иргэд, тус улсад амьдарч буй харьяалалгүй хүмүүсийг сайн дурын үндсэн дээр даатгуулахыг зөвшөөрдөг. Энэхүү харилцаа нь Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай 1994 оны хуулиар зохицуулагдаж байна.

Эрүүл мэндийн даатгалын тогтолцоог нэвтрүүлсэн нь эрүүл мэндийн салбарт санхүүжилтийн тогтвортой эх үүсвэрийг бий болгосон юм. Одоогийн байдлаар, эрүүл мэндийн салбарын санхүүжилт нь улсын төсөв, эрүүл мэндийн даатгалын сан, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлсний төлбөр, гадаадын зээл, тусламж зэрэг хэд хэдэн эх үүсвэрээс бүрддэг байна. Монгол Улсын эрүүл мэндийн салбарын гол зорилго нь санхүүжилтийн тогтвортой механизм бий болгох замаар эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг бүх нийтэд хүрээмжтэй болгох юм.

Эрүүл мэндийн даатгал нь бүх шатны эмнэлгүүдэд хэвтэн эмчлүүлж буй өвчтөнүүд болон амбулаторийн үйлчилгээ авч буй үйлчлүүлэгчдэд санхүүгийн дэмжлэг үзүүлдэг. Энэ нь мөн өрхийн

эмнэлгийн болон амбулаторийн тусламж, үйлчилгээтэй холбогдох зардлыг хариуцахаас гадна батлагдсан үнэ тарифын дагуу жагсаалтад орсон эмийн үнэнд хөнгөлөлт үзүүлнэ. Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ, жирэмсний болон төрөхийн тусламж, сүрьеэ, хорт хавдрын хөнгөвчлөх эмчилгээ нь шууд улсын төсвөөс санхүүжих бөгөөд ЭМД-ын сангаас төлбөр хийхгүй.

ХАХНХЯ нь эрүүл мэндийн даатгалын сангийн үйл ажиллагааг өөрийн хэрэгжүүлэгч агентлаг Нийгмийн даатгалын ерөнхий газар (НДЕГ)-аар дамжуулан удирдан, зохион байгуулдаг. Эрүүл мэнд, спортын яам (ЭМСЯ) нь эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багц, үнэ тариф, эмийн хөнгөлөлт зэрэгтэй холбоотой бодлогын гол шийдвэрүүдийг гаргадаг байна.

### Шигтгээ 1

#### Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг бүх нийтэд хүртээмжтэй болгохын төлөө

2013 онд ХАХНХЯ-наас ЭМЯ, Германы Олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг (ГОУХАН), ДЭМБ, олон улсын эрүүл мэндийн Providing for Health (P4H) сүлжээ байгууллагатай хамтран *Монгол Улсын эрүүл мэндийн даатгалын хөгжлийн урт хугацааны стратеги (2013-2022)*<sup>1</sup>-ийг боловсруулан, хэрэгжүүлж эхэлжээ. Энэхүү баримт бичигт иргэдийг эрүүл мэндийн даатгалд бүрэн хамруулахад дараах асуудлууд тулгамдаж байгааг дурдсан байна. Үүнд:

1. ЭМД-д хамрагдах боломжтой хүмүүс тус даатгалын ач холбогдлын талаар ойлголт, мэдлэг муутайгаас шимтгэл төлөх эрмэлзэл бага, сард төлөх шимтгэлийн хэмжээ нь оновчтой биш байна.
2. Хувиараа хөдөлмөр эрхлэгчид, малчид, тодорхой хөдөлмөр эрхлээгүй иргэдийн дунд эрүүл мэндийн даатгалын хамралт буурах шинжтэй байна. Шимтгэлээ өөрсдөө төлдөг эдгээр бүлгийн иргэдээс ЭМДС-ийн шимтгэл цуглуулах үйл ажиллагаа үр дүн муутай. Эрүүл мэндийн даатгалд хамрагддаггүй, шимтгэл төлдөггүй хэсгийн дийлэнх хувийг малчид, ажил хөдөлмөр эрхлээгүй иргэд, оюутан суралцагчид эзэлдэг байна. НДЕГ-ын тооцоолсноор 2012 онд эрүүл мэндийн даатгалын хамралт 90.4 хувьтай байв.
3. Хүн амын эрүүл мэндийн эрэлт хэрэгцээг бүрэн хангаагүй байхад эрүүл мэндийн даатгалын сан нь ихээхэн (2012 онд ЭМДС-ын жилийн орлогын 95.3 хувьтай тэнцүү) эерэг үлдэгдэлтэй байна. Эрүүл мэндийн даатгалын худалдан авч буй тусламж, үйлчилгээний багц нь даатгуулагчийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн тусламж, үйлчилгээг бүрэн хамардаггүй учраас багцад ороогүй тусламж, үйлчилгээний зардлыг иргэд хувиасаа төлдөг. Тусламж, үйлчилгээний багцыг тодорхойлохдоо даатгуулагчийн шууд төлөх зардлын хэмжээг тооцдоггүйн улмаас шууд төлбөрийн хэмжээ жил ирэх тусам өсч байна. Эрүүл мэндийн санхүүжилтийн стратегийн баримт бичигт хувь хүний шууд төлөх төлбөрийг эрүүл мэндийн салбарын нийт зардлын 25 хувиас хэтрүүлэхгүй байхаар заасан боловч ДЭМБ-ын статистикийн мэдээгээр энэ үзүүлэлт нь 2008 оноос хойш 26.6 хувиар өсч, 2013 онд 41.0 хувьд хүрсэн байна.
4. Эрүүл мэндийн даатгалын байгууллага (ЭМДБ)<sup>2</sup> нь даатгуулагчийн эрэлт хэрэгцээг судалж, үйлчилгээнийхээ хүрээг тодорхойлох, үйлчилгээг хүргэх эрүүл мэндийн байгууллагыг сонгох, тусламж, үйлчилгээний зардлын хэмжээг хэлэлцэн тогтоох зэргээр идэвхтэй худалдан авагчийн чиг үүргийг хэрэгжүүлэх хууль эрх зүйн орчин байхгүй. Худалдан авах үйл ажиллагаа нь ЭМДБ, эрүүл мэндийн байгууллага хоорондын гэрээгээр дамжин хэрэгждэг. Гэхдээ гэрээний хэрэгжилтийг дүгнэх талаар тодорхой зааварчилсан аргачлал байхгүй байгаа нь үйлчилгээ үзүүлэгч зарим байгууллагын зүгээс гэрээгээ биелүүлэхгүй, тусламж, үйлчилгээний чанарт муугаар нөлөөлөхөд хүргэдэг байна.
5. Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуульд ЭМД-ын оролцогч талуудын үүрэг, хариуцлагдыг олон талын дунд давхардуулсан, хуваасан байдалтайгаар тогтоосон байдаг. Төрөөс бус оролцогч талууд буюу ажил олгогчид, ажилтны төлөөллийн оролцоог шийдвэр гаргахад бүрэн хангаж чадаагүй, энэ чиглэлээр бүтээлч яриа хэлэлцээ хийх чадавх сул байна.

<sup>1</sup> Монгол Улсын Эрүүл мэндийн даатгалын хөгжлийн урт хугацааны стратеги (2013-2022), Засгийн газрын тогтоол № 143 (2013 оны 4-р сарын 13)

<sup>2</sup> Одоогийн Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуулиар ЭМДБ нь НДЕГ-ын бүрэлдэхүүнд байдаг.

Эх үүсвэр: НҮБ/ЗГ-ын хамтарсан Нийгмийн хамгааллын ажлын хэсэг, 2015

Эрүүл мэндийн даатгалын хөгжлийн урт хугацааны стратеги (2013-2022) нь Монгол Улсын иргэн бүрийг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хамруулах зорилт тавьжээ. Хүснэгт 5-д үзүүлсэнчлэн энэ баримт бичигт ЭМД-ын хамралт ба орлого, тусламж, үйлчилгээний багц, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар ба худалдан авалт, ЭМД-ын засаглал, ЭМДБ-ын чадавх, эрүүл мэндийн хувийн даатгал гэсэн гол чиглэлээр дараах зорилтуудыг дэвшүүлсэн байна. Үүнд:

**Хүснэгт 5. Эрүүл мэндийн даатгалын хөгжлийн урт хугацааны стратегийн зорилтууд (2013-2022)**

| Гол чиглэлүүд                                                         | Зорилт                                                                                                                                                                      | Стратеги                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                      |
|-----------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Эрүүл мэндийн даатгалын хамралт, орлого                               | Хүн амыг эрүүл мэндээс үүдэлтэй санхүүгийн эрсдэлээс бүрэн хамгаалахын тулд эрүүл мэндийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх, даатгалын сангийн тогтвортой байдлыг хангах      | Эрүүл мэндийн даатгалд хамрагдаагүй хүн амыг бүрэн хамруулах;<br>Төр шимтгэлийг нь хариуцах иргэд, эрүүл мэндийн даатгалын шимтгэлээ өөрөө хариуцан төлдөг иргэдийн шимтгэлийн хувь хэмжээг тус тус хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй уялдуулан тогтоодог тогтолцоог бүрдүүлэх;<br>Эрүүл мэндийн даатгалын сангийн менежмент, бодлого төлөвлөлтийг сайжруулж, орлого, зарлагын тэнцвэртэй байдлыг хангах;<br>Нийт эрүүл мэндийн зардалд хувь хүний төлөх шүүд төлбөрийн эзлэх хувийг 25 хувь хүртэл бууруулах.                                                                                                                                                                                                                                                                               |
| Эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээний багц                    | Хүн амын эрүүл мэндийн нэн шаардлагатай хэрэгцээг бүрэн хангах эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээний багцыг оновчтой тодорхойлох                                    | Улсын төсвөөс санхүүждэг тусламж, үйлчилгээний багцаас тусламж, үйлчилгээг эрүүл мэндийн даатгалын багцад үе шаттайгаар шилжүүлэх замаар даатгалын багцыг өргөжүүлэх;<br>Анхан шатны тусламж үйлчилгээг эрүүл мэндийн даатгалын багцад хамруулснаар гарах эдийн засаг, нийгмийн хамгаалал, эрүүл мэндийн үр нөлөөг судалж, оновчтой шийдвэр гарган, алслагдсан орон нутгийн иргэдэд эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээний багцыг хүртээмжтэй болгох;<br>Тусламж, үйлчилгээний багцыг үр ашигтай хэлбэрээр хүргэх зорилгоор даатгуулагчийн хамтарсан төлбөрийн хэмжээг тусламж, үйлчилгээний шатлалаар ялгавартайгаар тогтоох;<br>Эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээний багцыг тодорхойлох, хэлэлцэх, шийдвэр гаргах үйл явц, зохион байгуулалтын оновчтой бүтцийг бий болгох. |
| Эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээний чанар ба худалдан авалт | Эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээний чанарын хяналтыг сайжруулах;<br>Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний стратегийн идэвхтэй худалдан авалтын тогтолцоог бүрдүүлэх; | Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ худалдан авах үйл ажиллагааг даатгалын байгууллага болон тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагын хооронд хийх гэрээгээр зохицуулж, талуудын хүлээх үүрэг, тэдгээрт тавих хяналтын талаар гэрээнд нарийвчлан тусгах;                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                         |

|                                                                       |                                                                                                                                                                                                      |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                 |
|-----------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээний чанар ба худалдан авалт |                                                                                                                                                                                                      | <p>Даатгуулагчийн хэрэгцээнд нийцсэн тусламж, үйлчилгээ үзүүлэгчийг сонгох, тэдэнтэй гэрээ байгуулах, тусламж, үйлчилгээний багц, тарифыг оновчтой тогтоох чадавх бүхий стратегийн худалдан авалтын тогтолцоо бүрдүүлэх;</p> <p>Нотолгоонд тулгуурласан чанартай тусламж, үйлчилгээг худалдан авахад шаардагдах хяналтын тогтолцоог сайжруулахын тулд магадлан итгэмжлэл, ижил мэргэжилтний үзлэг, даатгуулагчийн сэтгэл ханамжийн судалгаа зэрэг чанарын арга хэрэгслүүдийг нэвтрүүлэх;</p>                                                                                                                    |
| Засаглал                                                              | Эрүүл мэндийн даатгалын тогтолцоонд сайн засаглалын зарчмуудыг нэвтрүүлж, олон нийт, даатгуулагчдын эрүүл мэндийн даатгалд итгэх итгэлийг нэмэгдүүлэх                                                | <p>Хариуцлагатай, ил тод, шударга, үр ашигтай байх зарчмаар ажиллаж, талуудын ашиг сонирхлыг харилцан авч үздэг сайн засаглалтай тогтолцоог бүрдүүлэх;</p> <p>Эрүүл мэндийн даатгалын тогтолцооны хамтын удирдлагын бүтцэд эрүүл мэндийн даатгалын харилцаанд оролцогч талуудын оролцоог тэгш хангах;</p> <p>Эрүүл мэндийн даатгалын сангийн төлөвлөлт, нөөцийн хуваарилалтыг аль нэг талаас хараат бус байдлаар эрүүл мэндийн даатгалын байгууллага бие даан гүйцэтгэдэг болох.</p>                                                                                                                            |
| Эрүүл мэндийн даатгалын байгууллага                                   | Эрүүл мэндийн даатгалын байгууллага (ЭМДБ)-ыг даатгуулагч төвтэй орчин үеийн менежмент бүхий стратегийн идэвхтэй худалдан авагч байгууллага болгон хөгжүүлэх                                         | <p>Эрүүл мэндийн даатгалын байгууллагад менежментийн орчин үеийн дэвшилтэт аргыг нэвтрүүлэх;</p> <p>Эрүүл мэндийн даатгалын байгууллагын үйл ажиллагаанд даатгуулагчийн мэдээллийн аюулгүй байдлыг хангасан технологийг тасралтгүй нэвтрүүлж, үр ашгийг нь нэмэгдүүлэх;</p> <p>Нийгмийн маркетинг явуулж, эрүүл мэндийн даатгалын байгууллагын “бүтээгдэхүүн-үйлчилгээ”-г сурталчлах;</p> <p>Эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээний чанарын хяналтыг хэрэгжүүлэх эрүүл мэндийн даатгалын байгууллагын чадавхийг бэхжүүлэх</p>                                                                            |
| Эрүүл мэндийн хувийн даатгал                                          | Эрүүл мэндийн даатгалын багцад ороогүй тусламж, үйлчилгээг эрүүл мэндийн хувийн даатгалаар хүн амд нөхөн хүргэх нөхцлийг бүрдүүлэх замаар эрүүл мэндийн даатгалын тогтолцооны нэгдмэл байдлыг хангах | <p>Эрүүл мэндийн хувийн даатгалыг хүн амыг санхүүгийн эрсдэлээс хамгаалах, эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээний хүрээг өргөтгөх замаар бүх нийтийн хамралтад хүрэх тогтолцооны нэг бүрэлдэхүүн хэсэг гэж үзэн хөгжүүлэх;</p> <p>Иргэд сайн дураар давхар даатгуулах замаар эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээний багцад ороогүй тусламж, үйлчилгээг нөхөн болон нэмэлтээр авахын тулд эрүүл мэндийн хувийн даатгалд хамрагдах эрх зүйн орчныг тодорхой болгох;</p> <p>Эрүүл мэндийн хувийн даатгалын болон эрүүл мэндийн даатгалын улсын байгууллага хамтран ажиллах механизмыг бий болгох</p> |

Эх үүсвэр: ХАХНХЯ, ЭМЯ, 2013

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн шинэчилсэн найруулга 2015 оны 1 дүгээр сарын 29-ний өдөр УИХ-аар батлагдаад байна. Уг хуулийг 2015 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс дагаж мөрдөх боловч зарим тодорхой хэсэг, заалт нь 2016 оны 1 дүгээр сарын 1-нээс хүчин төгөлдөр болох юм. Энэ хуулинд тусгагдсан зарим гол өөрчлөлтийг дурдвал:

- Хүүхдээс бусад төрөөс шимтгэлийг нь хариуцдаг иргэд (III ангилал: 0-18 насны хүүхэд, эмзэг бүлгийн иргэд- Ангиллыг доороос үзнэ үү.) болон МСҮТ-ийн суралцагчдаас бусад шимтгэлээ өөрөө дангаараа хариуцдаг бүлэг (II ангилал: Малчид, ажилгүй иргэд; IV ангилал: Хувиараа хөдөлмөр эрхлэгчид)-ийн төлөх шимтгэлийн хувь хэмжээг нэмэгдүүлж, сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 2 хувиас багагүйгээр (өмнө нь төр шимтгэлийг нь хариуцдаг иргэний сарын шимтгэлийн хэмжээ 670 төгрөг буюу жилд 8040 төгрөг байсан бол одоо сард 3840 төгрөг буюу жилд 46080 төгрөгөөс багагүй болно) Засгийн газар жил бүр тогтооно.
- МСҮТ-ийн суралцагчид (II ангилалд хамаарна) болон 0-18 насны хүүхэд (III ангилалд хамаарна)-ийн ЭМД-ын шимтгэлийн хэмжээг нэмэгдүүлж, сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 1 хувиас багагүйгээр (өмнө нь сарын шимтгэлийн хэмжээ 670 төгрөг буюу жилд 8040 төгрөг байсан бол одоо сард 1920 төгрөг буюу жилд 23040 төгрөгөөс багагүй болно) тогтооно.
- Өмнө нь төрөөс ЭМД-ын шимтгэлийг нь бүрэн хариуцдаг байсан их, дээд сургууль, коллежийн оюутнууд 2016 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 1 хувиас багагүйгээр (жилд 23,040 төгрөг) өөрсдөө төлнө. Харин 2015 оны шимтгэлийг нь төрөөс хариуцах юм.
- Төрөөс шимтгэлийг нь хариуцдаг иргэдээс бусад даатгуулагчийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардлын төлбөр нь тухайн жилийн дээд хязгаараас хэтэрсэн тохиолдолд гэр бүлийн өөр даатгуулагчийн зардлаас жилд нэг удаа шилжүүлэн тооцуулж болно.
- Аймаг, дүүргийн амбулаторийн төрөлжсөн мэргэжлийн эмчийн бичсэн жороор олгох эм үнийн хөнгөлөлтөнд хамаарахаар болсон (өмнө нь ийм хөнгөлөлт зөвхөн анхан шатны тусламж, үйлчилгээ үзүүлэх түвшинд хамаарч байсан юм).
- ЭМД-ын тусламж, үйлчилгээний багцыг өргөжүүлж зарим өндөр өртөгтэй тусламж, үйлчилгээ, протезийн хэрэгсэл, хорт хавдарын болон бусад хөнгөвчлөх тусламж, үйлчилгээг хамруулахаар болсон байна.

### Эрүүл мэндийн албан журмын даатгалын тогтолцоо

Дараах мэдээлэл болон ЭМД-ын бүх нийтийн хамралтад хүрэхэд чиглэсэн зөвлөмжүүд нь үндэсний хэлэлцүүлгийн үед хүчин төгөлдөр байсан хууль, тогтоомжид үндэслэсэн болно. Дээр тайлбарласан шинэ хууль нь 2015 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн мөрдөгдөнө.

**Хууль эрх зүйн орчин** Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хууль (2002 оны дөрөвдүгээр сарын 25); Эрүүл мэндийн тухай хуулийн 15.1, 23, 24-р зүйл (2011 оны тавдугаар сарын 5); 2015 оны 7-р сарын 1-нээс эхэлж мөрдөгдөх Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн шинэчилсэн найруулга (2015 оны 1-р сарын 29)<sup>16</sup>.

**Зорилтот бүлэг** Монгол Улсын бүх иргэн, гадаадын иргэд, харьяалалгүй хүмүүс.  
Монгол Улсын иргэд албан журмаар даатгуулна (6.1.1-6.1.11 дэх зүйл)  
Гадаадын иргэд сайн дурын үндсэн дээр даатгуулж болно (6.2 дэх зүйл)

**Даатгалын тусламж, үйлчилгээний багц** **Тусламж, үйлчилгээний багц:** Амбулаторийн болон хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээ (I ба II шатлалын эмнэлгүүд үзүүлдэг), өдрийн эмчилгээ үйлчилгээ (II шатлал), уламжлалт анагаах ухааны эмнэлгүүдэд хэвтүүлэн эмчлэх үйлчилгээ, рашаан сувиллын нөхөн сэргээх болон хөнгөвчлөх эмчилгээ, эмийн хөнгөлөлт; Даатгуулагчийн хүсэлтээр нэг жилийн дотор ямар ч тохиолдолд нэг удаад 56,000 төгрөгөөс үл хэтрэх үнэ төлбөргүй үзлэг шинжилгээ, оношлогоо.  
**Урамшуулал:** Даатгуулагч сүүлийн 36 сарын хугацаанд ЭМД-ын сангаас ямар нэгэн эмчилгээ, үйлчилгээний төлбөр аваагүй тохиолдолд жилд нэг удаа 80,000 төгрөгийн үнэ төлбөргүй үзлэг шинжилгээнд хамрагдах эрхтэй.  
**Тусламж, үйлчилгээний дээд хязгаар:** Нэг даатгуулагчид нэг жилд 1,380,000 төгрөг байна.

<sup>16</sup> Энэ хэсэгт оруулсан мэдээлэл нь 2002 оны Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуулинд үндэслэсэн болно.

|                                                     |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                              |
|-----------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| <b>Төлбөрийн механизм</b>                           | НДЕГ-ын ЭМД-ын газар нь тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагын ирүүлсэн нэхэмжлэлийг үндэслэн төлбөрийг хийнэ.                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                             |
| <b>Даатгалын багцад ороогүй тусламж, үйлчилгээ:</b> | Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ, жирэмсний хяналт ба төрөхийн тусламж, сүрьеэ, хорт хавдрын эмчилгээний зардлыг шууд улсын төсвөөс санхүүжүүлдэг.                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                |
| <b>Санхүүжилт</b>                                   | <p>Энэ тогтолцоо нь гурван тал (ажил олгогчид, ажиллагчид, төр)-ын санхүүжилтээс бүрддэг. Даатгуулагчдын бүлэг:</p> <p><b>I ангилал:</b> Төрийн албан хаагчид болон аж ахуйн нэгж байгууллагын ажилтнууд сарын цалин хөлсний 4 хувь (ажил олгогч 2.0 хувь, ажилтан 2.0 хувь)-ийг төлөх үүрэгтэй;</p> <p><b>II ангилал:</b> Малчид, ажилгүй иргэд, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн суралцагчид сард 670 төгрөг төлнө;</p> <p><b>III ангилал:</b> 0-18 насны хүүхдүүд, нийгмийн даатгалын болон халамжийн сангаас олгож буй өндөр насны, тахир дутуугийн болон тэжээгчээ алдсаны тэтгэвэрээс өөр орлогогүй иргэд, их дээд сургууль, коллежийн оюутнууд, хүүхдээ 2 нас хүртэл нь асарч буй эхчүүд, цэргийн албан хаагчид (батлан хамгаалах, хил хамгаалах, цагдаа, онцгой байдал) болон шимтгэлийг нь төрөөс бүрэн хариуцдаг, олон нийтэд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд хамрагдаж буй иргэд зэрэг болно. Бусад зорилтот бүлгийн иргэдэд ахмад настнууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, архаг өвчтэй хүүхдүүд, гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүмүүс, засан хүмүүжүүлэх төвөөс суллагдсан иргэд, согтууруулах ундаа, мансууруулах бодист донтогсод, орон гэргүй хүмүүс, өрх толгойлсон эх ба эцэг, эдгэшгүй өвчин туссан хүмүүс, ядуу иргэд, орон нутгаас шилжин ирэгсэд, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг эхчүүд орох бөгөөд эдгээр хүмүүс мөн 670 төгрөг төлөх ёстой ч одоогоор төрөөс бүрэн татаас өгч, шимтгэлийг нь ХХС-аас санхүүжүүлж байна;</p> <p><b>IV ангилал:</b> Татварын албанд гаргасан татварын тайлангийн үндсэн дээр өөрийн жишиг орлогоосоо 1.0 хувийг төлж буй хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн;</p> <p><b>V ангилал:</b> Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 6.0 хувийг төлөх үүрэгтэй гадаадын иргэн, харьяалалгүй хүмүүс (сард 8,424 төгрөг);</p> |
| <b>Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хүргэх</b>     | <p><b>Анхан шат</b> – улсын төсвөөс санхүүждэг: а) 1,588 <i>багийн бага эмч</i> (хөдөө орон нутаг); б) 271 <i>сумын эмнэлэг</i> болон 39 <i>сум дундын эмнэлэг</i> (нэг суманд 15-30 ор); в) 221 өрхийн эрүүл мэндийн төв (хот суурин газар, хувийн); <b>Хоёр дахь шатлал</b> - төлбөрийн 10 хувийг хувиасаа (хамтын) төлөх системтэй: дүүргийн 12 эмнэлэг (200-300 ортой), аймгийн 17 эмнэлэг (100-500 ортой), 3 төрөх эмнэлэг;</p> <p><b>Гурав дахь шатлал</b> - төлбөрийн 15 хувийг нь хувиасаа (хамтын) төлөх системтэй: бүсийн оношлогоо, эмчилгээний 4 төв (аймгийн төвүүд дээр), 3 төв эмнэлэг, нарийн мэргэжлийн 11 эмнэлэг;</p>                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                     |
| <b>Хамрагдсан хүн ам</b>                            | 2013 онд нийт 2,761.7 <sup>17</sup> мянган хүн (байнга оршин сууж буй хүн амын 97.8 хувь) хамрагдсан байна; Төрөөс шимтгэлийг нь хариуцдаг иргэд нийт хүн амын 57.9 хувь нь (1,658.2 мянга) байна. Эдгээр нь давхардуулан тоолсон дүн бөгөөд НДЕГ-ын тооцоолсноор 2012 онд хамралт 90.4 хувь байсан байна.                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                   |

<sup>17</sup> Статистик давхардсан тоогоор гарсан байж магадгүй. Системд даатгалд бүтэн жилийн турш хамрагдсан даатгуулагч бүрийг тоолж, энэ мэдээллээ тухайн жилийн эцэст нэгтгэн тооцдог тул ангилал хооронд шилжсэн хүмүүс буюу албан салбараас хувиараа эрхлэгч болсон, эсвэл ажил хийж байгаад тэтгэвэрт гарсан зэрэг хүмүүсийг тухайн жилд хоёр удаа тоолсон байж болох юм.

## Хүснэгт 6. Эрүүл мэндийн даатгалд даатгуулагчдын тоо (мянган хүн)

|                                                 | 2006           | 2007           | 2008           | 2009           | 2010           | 2011           | 2012           | 2013           |
|-------------------------------------------------|----------------|----------------|----------------|----------------|----------------|----------------|----------------|----------------|
| Оршин суугаа хүн ам                             | 2,583.3        | 2,620.4        | 2,666.0        | 2,716.3        | 2,653.9        | 2,704.5        | 2,760.4        | 2,823.0        |
| <b>Нийт даатгуулагчдын тоо:</b>                 | <b>1,905.7</b> | <b>2,101.7</b> | <b>2,233.7</b> | <b>2,123.0</b> | <b>2,267.6</b> | <b>2,704.5</b> | <b>2,593.6</b> | <b>2,761.7</b> |
| <i>Албан журмын</i>                             |                |                |                |                |                |                |                |                |
| I ангилал:                                      | 456.7          | 484.8          | 539.7          | 546.0          | 580.8          | 659.3          | 742.0          |                |
| Албан салбар                                    |                |                |                |                |                |                |                |                |
| II ангилал:                                     | 102.4          | 98.1           | 90.8           | 94.2           | 101.5          | 250.1          | 100.6          |                |
| Малчид                                          |                |                |                |                |                |                |                |                |
| III ангилал: МСҮТ-ийн                           | 44.9           | 48             | 51.5           | 75.2           | 81.9           | 81.1           | 87.0           |                |
| суралцагчид                                     |                |                |                |                |                |                |                |                |
| IV ангилал:                                     | 149.3          | 175.3          | 198.3          | 172.4          | 196.7          | 370.4          | 194.0          |                |
| Хувиараа хөдөлмөр эрхлэгчид                     |                |                |                |                |                |                |                |                |
| <i>Сайн дурын</i>                               |                |                |                |                |                |                |                |                |
| V ангилал: Гадаадын иргэд                       | 0.1            | 0.1            | 0.2            | 0.2            | 0.2            | 0.2            | 0.3            |                |
| <i>Төрөөс шимтгэлийг нь хариуцдаг хүн ам</i>    |                |                |                |                |                |                |                |                |
| III ангилал:                                    | 1,152.5        | 1,295.5        | 1,353.2        | 1,235.0        | 1,306.5        | 1,354.0        | 1,469.7        | 1,658.2        |
| Хүүхэд, өндөр настан, эмзэг бүлгийн бусад иргэд |                |                |                |                |                |                |                |                |
| <b>Оршин суугаа хүн амд эзлэх хувь</b>          | <b>73.7</b>    | <b>80.4</b>    | <b>83.8</b>    | <b>76.9</b>    | <b>85.4</b>    | <b>100.0</b>   | <b>93.9</b>    | <b>97.8</b>    |

Эх үүсвэр: НДЕГ, Монгол Улсын статистикийн эмхэтгэл 2012

## Бодлогын болон хэрэгжүүлэлтийн түвшинд тулгарч буй асуудлууд

### Бодлогын хийдэл

|                                   |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                   |
|-----------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| <b>Тусламж, үйлчилгээний багц</b> | Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ нь дараах хоёр багцад хуваагддаг: 1/ ЭМД-ын сан (2013 онд эрүүл мэндийн нийт зардлын дөнгөж 25.1 хувийг эзэлж байсан) <sup>18</sup> -ийн багц; 2/ Татварын санхүүжилт(улсын төсөв)-ийн багц. Эрүүл мэндийн даатгалын багц нь даатгуулагчид шаардлагатай тусламж, үйлчилгээг бүрэн хамарч чаддаггүй учраас даатгуулагч багцад ороогүй үйлчилгээг авахын тулд зардлыг хувиасаа төлөх ёстой болдог. |
| <b>Нэмэлт төлбөр</b>              | Даатгуулагч одоо ч эрүүл мэндийн зардлын багагүй хэсэг (эрүүл мэндийн нийт зардлын 41 хувь) <sup>19</sup> -ийг хувиасаа төлж байгаа бөгөөд хувиасаа төлж буй төлбөрийн ихэнхи хувийг эмийн зардал (хоёр, гурав дахь шатлалын эмнэлгүүд, нарийн мэргэжлийн эмчийн бичиж өгсөн эмийн зардлыг нөхөн төлдөггүй) эзэлдэг.                                                                                                              |
| <b>Зорилтот бүлэг</b>             | Төрөөс шимтгэлийг хариуцах иргэдийн хүрээг оновчтой тогтоогоогүй. ХХС-аас санхүүжүүлдэг бүлгийнхэн, малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, ажилгүйчүүд болон албан бус эдийн засагт ажиллагчдын шимтгэлийн хувь хэмжээг эрсдлийг тооцож зохистой тогтоогоогүй.                                                                                                                                                                      |
| <b>Засаглал</b>                   | Эрүүл мэндийн даатгалын оролцогч талуудын чиг үүрэг болон хариуцлагыг салгаж, давхардуулж хуваарилсан.                                                                                                                                                                                                                                                                                                                            |
| <b>Институцийн чадавхи</b>        | Даатгуулагчдын хэрэгцээ шаардлагыг судлах, эрүүл мэндийн тусламж үйлчилгээг тодорхойлох, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгчдийг сонгох, үйлчилгээний үнэ, тарифыг тогтоох зэрэг эрүүл мэндийн даатгалын байгууллагын идэвхтэй худалдан авагчийн үүрэг хариуцлагаа хэрэгжүүлэх хууль эрх зүйн орчин байхгүй.                                                                                                                |

<sup>18</sup> НДЕГ, 2014.

<sup>19</sup> ДЭМБ, 2014.

**Тэгш байдал** Монгол Улсын иргэд (670 төгрөг) болон гадаадын иргэд (8,424 төгрөг)-ийн сар бүр төлдөг шимтгэлийн хувь хэмжээ ихээхэн ялгаатай. 2015 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхлэх Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн шинэчилсэн найруулгаар энэ гажуудал засагдаж болох юм. Тус хуулийн дагуу гадаадын иргэн сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 2 хувиас доошгүй хэмжээгээр шимтгэл төлнө.

### Хэрэгжүүлэлтийн түвшинд гарч буй асуудлууд

**Хамралт** Эрүүл мэндийн даатгалын хамралт 2011-ээс 2012 оны хооронд 100.0-аас 94.0 хувь болж буурчээ. НДЕГ-аас тооцоолсон хамралт давхардуулан тоолсныг харгалзан үзвэл үүнээс ч доогуур байхаар байна. Харин 2011 онд ЭМД-ын хамралт сайн байсан гол шалтгаан нь төрөөс Хүний хөгжил сангаар дамжуулан малчид, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд суралцагчид, ажилгүй иргэдийн даатгалын шимтгэлийг төлсөнтэй холбоотой байв.

**Шимтгэл цуглуулах** Нийгмийн даатгалын институцийн одоогийн тогтолцоо нь шимтгэлээ өөрсдөө төлдөг малчид, албан бус эдийн засагт ажиллагчдаас эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг цуглуулахад төдийлөн үр дүнтэй байж чадахгүй байна.

**Институцийн чадавхи** Эрүүл мэндийн даатгалын үйл ажиллагаа нь ХАХНХЯ болон НДЕГ-аас хараат бус бие даасан хэлбэрт орж институцлэгдээгүй.

**Тусламж, үйлчилгээний багц** Үнэ төлбөргүй оношлогоо, үзлэг шинжилгээний багц (нэг удаад 56,000 төгрөг, дээр нь нэмээд жилд нэг удаа 80,000 төгрөгийн урамшуулал) нь хэдийгээр боломжийн боловч тусламж, улсын эмнэлгүүдийн үйлчилгээний хүртээмж, үйлчилгээг хүргэх чадавх хангалтгүй байгаагаас үр шимийг хүртэгчдийн тоо маш бага байна. Хувийн хэвшлийн эмнэлгийн оношлогооны төвүүд нь ЭМД-ын сантай гэрээ байгуулахгүй байна.

**Чанар** Улсын эмнэлгүүдэд хийж буй хөрөнгө оруулалт хангалтгүй байгаа нь эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар доголдож, сайн тоноглогдсон дэд бүтэц дутагдахад хүргэж байна.

**Үйлчилгээний чанарын хяналт** Эрүүл мэндийн үйлчилгээтэй холбоотой өргөдөл гомдлын систем зохих ёсоор ажилладаггүй, гомдлыг хэрэглэгчийн сэтгэл ханамжид нийцүүлэх байдлаар шийдвэрлэдэггүй.

### Төрөөс санхүүждэг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ

Улсын төсвөөс бүрэн болон хэсэгчлэн санхүүждэг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээтэй холбоотой нэлээд олон бэрхшээл байна. Улсын төсвийг эрүүл мэндийн хөтөлбөрөөр бус харин зардлын зүйлүүдээр нь хуваарилдаг. Үүний үр дүнд төсвийн хуваарилалт нь үйлчилгээг биш, эрүүл мэндийн байгууллагын хөрөнгө болон үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэх хандлагатай болж хувирч байна. Энэ нөхцөл байдал нь тусламж, үйлчилгээ, түүний дотор эх, хүүхдийн эрүүл мэндийн өртөг багатай, өндөр үр дүнтэй тусламж, үйлчилгээний багцын тоо хэмжээ, чанарт нөлөөлж байна. Улсын төсвөөс санхүүждэг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний өртөг зардлыг бодитой тооцож төлөвлөх аргачлал байхгүй байна. Өртөг зардлыг тооцох болон үүнтэй холбогдох санхүүжилтийн зохистой аргачлал байхгүй нь улсын эмнэлэг, эрүүл мэндийн төвүүдийн үйлчилгээний чанар доголдоход гол нөлөө үзүүлж байна. Түүнээс гадна улсын эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагуудад улсын төсвөөс хөрөнгө хуваарилж буй томъёонд алслагдмал байдал, ядуурлын түвшин, байгаль орчны хүчин зүйлс зэргийг тооцож үздэггүй. Суурь үнэ тарифыг инфляцийн нөлөөг бодитой тусгалгүй маш доогуур түвшинд тогтоодог. Энэ нь хөдөө орон нутаг болон хот суурин газар, чинээлэг болон ядуу бүлгийн хооронд тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн зөрүү багасахгүй байгаагийн гол шалтгаан юм.


## Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд бүх нийтийг хамруулахад шаардагдаж буй хангамж, чанар, зардал

ОУХБ-аас НХСТ-ий нэг баталгаа болох бүх хүн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хамрагдах боломжийг бүрдүүлэх хүрээнд тулгарч буй саад(хомсдол)-ыг илэрхийлдэг 5 үзүүлэлтийг тодорхойлсон байна. Тухайлбал, хамгийн наад зах нь нэн шаардлагатай эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хамрагдах боломжийг хуулиар баталгаажуулаагүй үед эрхийн хомсдол үүсдэг. Монгол Улсын хувьд 2002 оны Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хууль болон 2015 оны 1 сард батлагдсан тус хуулийн шинэчилсэн найруулгаар хүн бүр эрүүл мэндийн даатгалд хамрагдах баталгааг хангасан байна. Монгол Улсын хувьд эрүүл мэндийн даатгалд бараг бүх нийтээрээ хамрагдсан боловч тусламж, үйлчилгээний багц, эрүүл мэндийн санхүүжилт, хүчин чадал болон дэд бүтэц, түүнчлэн эрүүл мэндийн үйлчилгээ, эмийн чанар зэрэгт дутагдал, хомсдол байгаа нь иргэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах эрхээ хэрэгжүүлэхэд нь саад учруулж болох юм.

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний олдцын хомсдолыг 10,000 хүн ам тутамд ногдож буй эрүүл мэндийн мэргэжилтнүүд (эмч, сувилагч, эх баригч)-ийн тоогоор шууд бусаар хэмжиж болдог. Үүний зэрэгцээ үйлчилгээний чанарыг нэг хүнд ногдох эрүүл мэндийн зардал (хувиасаа төлөх төлбөрийг оруулахгүйгээр), 10,000 амьд төрөлтөд ногдох эхийн эндэгдэл гэх зэрэг орлуулах үзүүлэлтүүдээр хэмжиж болно. Эхний үзүүлэлт нь эрүүл мэндийн зардал ба үйлчилгээний чанарын хооронд өндөр хамаарал байгаа гэж таамагладаг. Үүний нэгэн адил, ерөнхийдөө эрүүл мэндийн үйлчилгээний чанар нь эх барих үйлчилгээний чанар, ялангуяа 10,000 амьд төрөлт тутамд жирэмслэлттэй холбоотой шалтгааны улмаас эндэх эмэгтэйчүүдийн эндэгдлийн бууралтаар харагдана гэж үздэг. 10,000 хүн амд ногдох эрүүл мэндийн мэргэжилтний тоо болон нэг хүнд ногдох эрүүл мэндийн зардал (хувиасаа төлөх төлбөрийг оруулахгүйгээр)-ыг “эрсдэл бага” гэсэн ангилалд хамаардаг хөгжингүй орнуудын харгалзах медиан (голч) утгуудтай харьцуулж болно. (Энэхүү арга зүйн талаар дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл Шейл-Адлун, Боннэт нарын 2011 оны илтгэл (ОУХБ, 2014, 296-р хуудас)-ийг үзнэ үү.)

Үүнийг тайлбарлахын тулд Зураг 8-д Монгол Улсын хувьд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжийн хомсдолыг таван хэмжээсээр гаргаж, бусад улс орны бүлгүүдтэй харьцуулан үзүүлэв. Зургаас харахад эрүүл мэндийн даатгалын хамралтыг өргөжүүлэх хүрээнд, түүнчлэн эрүүл мэндийн мэргэжилтний тоо, эхийн эндэгдлийн түвшин зэрэг үзүүлэлтээр хэмжигдэж буй эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарт харьцангуй ахиц дэвшил гарсан боловч эрүүл мэндийн зарлагын хомсдол анхаарал татаж байна.

## Зураг 8. Монгол Улсын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хамралтыг олон хэмжээст үзүүлэлтээр бусад орнуудтай харьцуулсан байдал (2011)



Эх үүсвэр: ОУХБ, Дэлхийн нийгмийн хамгааллын илтгэл 2014-2015, 2015

### Дүгнэлт, зөвлөмж

Эрүүл мэндийн даатгал албан журмынх бөгөөд бараг л бүх нийтийг хамарч байгаа боловч хөдөө орон нутагт амьдарч буй олон хүний хувьд эрүүл мэндийн чанартай тусламж, үйлчилгээ авахад хүндрэл бэрхшээлтэй хэвээр байна. Төрөөс шимтгэлийг нь санхүүжүүлэх замаар хүн амыг эрүүл мэндийн даатгалд бүрэн хамруулсан 2011 оноос хойш хамрагдалт 6 хувиар буурсан нь үйлчлүүлэгчид тусламж, үйлчилгээнд сэтгэл дундуур байгаагийн илрэл байж болзошгүй бөгөөд энэ нь иргэдийн шимтгэл төлөх эрмэлзлэлийг бууруулахад нөлөөлсөн байх магадлалтай. Хүмүүсийн хувиасаа төлж буй төлбөр өндөр, улсын эмнэлгүүдийн үйлчилгээ үр ашиг муутай байгаа нь эрүүл мэндийн даатгалд сайн дураар хамрагдах эрмэлзлийг бууруулж, улмаар эрүүл мэндийн зохих тусламж, үйлчилгээ хүртэхэд нь саад учруулж байна. Энэ хүрээнд эрүүл мэндийн үйлчилгээний чанар, хүртээмж, олдоцыг сайжруулах шаардлагатай гэсэн гол зөвлөмжийг гаргасан юм.

Хүснэгт 7-д үнэлгээнд суурилсан үндэсний хэлэлцүүлгийн явцад гарсан зөвлөмжүүдийг нэгтгэн харуулав. Нийгмийн хамгааллын шинэ зохицуулалт бий болгох, эсвэл одоогийн зохицуулалтынх нь хамрах хүрээг өргөжүүлэх шаардлагатайг илэрхийлсэн зөвлөмжийг (\*)-оор тэмдэглэв. Эдгээр нэмэлт зохицуулалтыг нэвтрүүлэх, хамрах хүрээг өргөжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог ОУХБ-ын РАП загвараар тооцоолсон болно. Зарим зөвлөмжийг хэрэгжүүлэхэд хэрэгцээтэй хөрөнгийн хэмжээг тооцохын тулд техник эдийн засгийн илүү нарийвчилсан үнэлгээ, актуар судалгаа хийх шаардлагатай юм. Эдгээр зөвлөмжийг хүснэгтэд (Δ)-аар тэмдэглэсэн болно.

**Хүснэгт 7. ҮСҮХ-ээс эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг сайжруулах чиглэлээр гаргасан зөвлөмжүүд**

|   | Гол зөвлөмжүүд                                                                                                                                                                                                                                      |
|---|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| * | ЭМ1: Малчид, ажилгүйчүүд, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн суралцагчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн төлөх ЭМД-ын шимтгэлийг төрөөс бүрэн хариуцах замаар ЭМД-ын тогтолцоонд бүрэн хамрагдаж чадахгүй байгаа хүн амын бүлгүүдийг хамруулах. |
|   | ЭМ2: Малчдын бэлэн мөнгөний орлого олдог цаг улиралтай нь нийцүүлэн ЭМД-ын шимтгэлийг жилд хоёр удаа төлөх боломжтой болгох.                                                                                                                        |
|   | ЭМ3: Эрэлт хэрэгцээ өндөртэй эмийг нэн шаардлагатай эмийн жагсаалт (үнийн 80 хувийг нь нөхөн олгодог)-д оруулж, нөхөн олговрын хэмжээг нэмэгдүүлэх.                                                                                                 |
|   | ЭМ4: Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарыг аймаг, сумын түвшинд баталгаажуулахад, тухайлбал эрүүл мэндийн үйлчилгээний талаарх өргөдөл гомдлыг хариуцсан бие даасан товчоог байгуулах замаар ЭМДБ-ын хяналт, мониторингийн үүргийг бэхжүүлэх. |
|   | ЭМ5: Монгол Улсын иргэд, гадаадын иргэдийн төлж буй ЭМД-ын шимтгэлийн хувь хэмжээнд тэгш байдлыг хангах. ОУХБ-ын 118 дугаар конвенцийн зарчимд нийцүүлж, гадаадын иргэдийг тусгай бүлэг болгож үзэхгүй байх.                                        |
| Δ | ЭМ6: ЭМД-аас санхүүжүүлэх тусламж, үйлчилгээний багцыг аажмаар өргөжүүлж, хувь хүний хувиасаа төлдөг зардлуудыг бүүруулах.                                                                                                                          |
|   | ЭМ7: ЭМД-ын тусламж, үйлчилгээний багцад ордог аль ч төрлийн үйлчилгээг авахад бүх шатны эмнэлгүүдэд хэрэглэгдэх ухаалаг үнэмлэхний бүртгэлийн системийг нэвтрүүлэх                                                                                 |
|   | Нэмэлт зөвлөмжүүд                                                                                                                                                                                                                                   |
| Δ | ЭМ8: ЭМД-ын байгууллагын захиргаа, менежментэд сайн засаглал, бүтцийн өөрчлөлтийг нэвтрүүлэх.                                                                                                                                                       |
|   | ЭМ9: Эмийн нөхөн олговрын хэмжээг нэмэгдүүлэх, одоогийн хөнгөлөлттэй эмийн жагсаалтыг хянан үзэж, үнийн 80.0 хувиар хөнгөлөлт олгодог эмүүдийг нэмэгдүүлэх                                                                                          |
|   | ЭМ10: Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хүргэхэд төр, хувийн хэвшлийн түншлэлийг дэмжих.                                                                                                                                                            |
| Δ | ЭМ11: Нийгмийн халамжийн сангаас хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад настнуудад олгож буй протезийн хэрэгслийн хөнгөлөлтийг ЭМДС-аас санхүүжүүлэх нь зүйтэй.                                                                                          |

Эх үүсвэр: НҮБ/ЗГ-ын Нийгмийн хамгааллын ажлын хэсэг, 2015




#### 4.2. Хүүхэд

*“Хүүхэд бүрийн хоол тэжээл, боловсрол, асаргаа, бусад шаардлагатай бараа, үйлчилгээг авах боломжийг нь баталгаажуулахын тулд наад зах нь үндэснийхээ хэмжээнд тодорхойлсон доод түвшнийг хангахуйц хэмжээний орлогын суурь баталгаагаар хангах”*

Монгол Улс 1990 онд НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенцид нэгдэн орсон бөгөөд 1996 онд Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийг баталжээ. Дараагийн арван жилд нь Монгол Улс хүүхдийн хамгааллыг сайжруулах зорилгоор НҮБ-ын бусад конвенциудад нэгдэн орсон байна. Үүнээс гадна Монгол Улс бүх нийтийн ерөнхий боловсролыг үнэ төлбөргүй олгож, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хүүхдүүд үнэ төлбөргүй хамраагдах боломжийг бүрдүүлэхийн зэрэгцээ 0-18 насны бүх хүүхдэд сар бүр мөнгөн тэтгэмж олгодог. Хүүхдийн мөнгө хөтөлбөр (ХМХ) нь хүүхдэд зориулсан нийгмийн хамгааллын үндсэн арга хэмжээ юм. Мөн эмзэг бүлгийн хүүхдүүдэд чиглэсэн нийгмийн халамжийн хэд хэдэн тэтгэмж, тусламж байдаг. 1994 оны Нийгмийн даатгалын тухай хууль, мөн 1994 оны Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд тэжээгчээ алдсан хүүхдийн орлогын баталгааг хангах талаарх зохицуулалтууд, 2012 оны Нийгмийн халамжийн тухай хуульд эмзэг бүлгийн хүүхдүүдэд зориулсан үндсэн баталгааны талаар тусгагдсан байна.

**Зураг 9. Хүүхдэд зориулсан одоогийн нийгмийн хамгааллын хөтөлбөрүүд**



Эх үүсвэр: ХАХНХЯ, 2014

## Бүх нийтийг хамарсан зохицуулалт

### Хүүхдийн мөнгө хөтөлбөр

Энэ хөтөлбөрийг 2012 оны 10 дугаар сард эхлүүлсэн ба эрдэс баялагийн орлогоос бүрддэг Хүний хөгжил сангаас санхүүжүүлж байна. 0-18 насны бүх хүүхэд, түүн дотроо засан хүмүүжүүлэх газар хүмүүжиж байгаа болон гадаадад амьдарч буй хүүхдүүд ч бүгд сар бүр 20,000 төгрөгийн тэтгэмж авах эрхтэй.

ХМХ-ийн амжилтыг хоёр үзүүлэлтээр тайлбарлаж болно. Нэгдүгээрт, бүх хүүхэд Улсын бүртгэлийн ерөнхий газрын иргэний бүртгэлийн хэлтэст төрсний бүртгэлд бүртгэгдсэн даруйд автоматаар тэтгэмж авах эрх үүсдэг (өөр нэмэлт журам шаардлагагүй). Хоёрдугаарт, сар бүрийн мөнгөн тэтгэмж нь банкны шилжүүлгээр автоматаар эрх үүссэн хүүхдийн дансанд шилжин орно. Үүний үр дүнд 2013 оны жилийн эцэст нийт 960.3 мянга хүүхэд буюу 0-18 насны бүх хүүхэд бараг 100 хувь тэтгэмжээ авчээ.

НҮБ/ЗГ-ын хамтарсан Нийгмийн хамгааллын ажлын хэсгээс ҮСҮХ-ийг зохион байгуулж байх үед буюу 2014 оны 9 дүгээр сард улсын төсвийн алдагдал болон хүүхдийн мөнгөнд зарцуулж буй санхүүжилтийн хэмжээ зэргээс шалтгаалан хүүхдийн мөнгийг цаашид бүх хүүхдэд олгох эсэх асуудлыг УИХ-аар авч хэлэлцэн өөр өөр байр суурь илэрхийлэгдэж байв. Үндэсний хэлэлцүүлгээс хүүхдийн мөнгөнд орлогын шалгуур тавих нь уг тэтгэмжээс хасагдах олон хүүхдийн боловсрол, эрүүл мэнд, хоол тэжээлийн хангамж, хөгжилд төдийгүй сүүлийн үед хүүхдийн ядуурлыг бууруулах чиглэлд гарсан ахиц дэвшилд сөргөөр нөлөөлж болзошгүй гэж үзсэн болно.<sup>20</sup> Тиймээс ҮСҮХ-т оролцогчид хүүхдийн мөнгийг бүх хүүхдэд олгож байгааг хэвээр үлдээх, цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардал, үнэгүй дотуур байртай сургууль, 0-18 насны бүх хүүхдийн ЭМД-ын шимтгэлийг төрөөс хариуцах зэрэг нийгмийн хамгааллын хөтөлбөрүүдийг үргэлжлүүлэх зөвлөмжийг гаргасан болно.

<sup>20</sup> НҮБХС, 2014: Монгол Улс дахь Хүүхдийн аж байдлын үнэлгээ 2014, [http://www.unicef.org/mongolia/unicef\\_sitan\\_mongol\\_final.pdf](http://www.unicef.org/mongolia/unicef_sitan_mongol_final.pdf)

|                             |                                                                                                                                                                        |
|-----------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| <b>Хууль эрх зүйн орчин</b> | Хүний хөгжил сангийн тухай хууль (2012 оны 12-р сарын 13)-ийн 17.1.5 дахь заалт; Засгийн газрын 2012 оны 49 дүгээр тогтоол, Засгийн газрын 2012 оны 70 дугаар тогтоол. |
| <b>Зорилтот бүлэг</b>       | 0 – 18 насны бүх хүүхэд (засан хүмүүжүүлэх төвд хүмүүжиж буй хүүхдүүд, гадаадад амьдарч байгаа хүүхдүүд мөн хамрагдана).                                               |
| <b>Тэтгэмж</b>              | Сар бүр 20,000 төгрөг                                                                                                                                                  |
| <b>Хүргэх арга зам</b>      | Хүүхдийн мөнгийг банкны карт, онлайн банкны системийг ашиглан хялбар дөхөм байдлаар хүргэдэг.                                                                          |
| <b>Санхүүжилт</b>           | Хүний хөгжил сан (ХХС)-д хуримтлагдсан эрдэс баялагийн татварын орлого. Хөтөлбөрт 2013 онд 232.0 тэрбум төгрөг зарцуулсан байна.                                       |
| <b>Хамралт</b>              | 960.3 мянган хүүхэд (2013, зорилтот хүн ам бараг 100 хувь хамрагдсан)                                                                                                  |

## Одоогийн зохицуулалт: Шимтгэлд суурилсан нийгмийн хамгааллын хөтөлбөр

### Нийгмийн даатгалын сангаас хүүхдэд олгох тэжээгчээ алдсаны тэтгэвэр

|                             |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                   |
|-----------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| <b>Хууль эрх зүйн орчин</b> | Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль(1994 оны зургадугаар сарын 17)-ийн 12.1.1, 12.1.2, 12.1.3 болон 12.2.3 дахь заалтууд.                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                           |
| <b>Зорилтот бүлэг</b>       | <p>1) хууль ёсоор тэжээн тэтгэх өөр хүн байгаа эсэхийг үл харгалзан төрүүлсэн буюу үрчлэн авсан 16 нас (оюутан бол 19 нас) хүрээгүй хүүхэд (үүнд эцгээ нас барснаас хойш мэндэлсэн, төрсөн хүүхэд нь хамаарна);</p> <p>2) хууль ёсоор тэжээх өөр хүнгүй 16 нас хүрээгүй ач, зээ, төрсөн дүү;</p> <p>3) тэжээгчийн асрамжид байсан төрөлхийн тахир дутуу буюу 16 нас (2015 оны 7-р сарын 1-нээс 19 нас болсон) хүрээгүй байхдаа тахир дутуу болсон хүүхэд, ач, зээ, төрсөн ах,эгч, дүү;</p> <p>4) төрсөн эцэг, эхээс шүүхийн шийдвэрээр тэтгэлэг авдаггүй хүүхэд хойт эцэг буюу эхийгээ нас барахад төрсөн хүүхдийн адил.</p>                                                      |
| <b>Даатгуулах хэлбэр</b>    | Албан журмын ба сайн дурын                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                        |
| <b>Санхүүжилт</b>           | <p>Нийгмийн даатгалын тэтгэврийн санд ажил олгогч ба ажилтны төлөх шимтгэл:</p> <p><u>Албан журмын даатгал:</u> хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос 14.0 хувийн шимтгэлийг ажил олгогч, ажилтан адил хуваан төлж, тэтгэврийн сангаас олгох гурван төрлийн тэтгэврийг санхүүжүүлнэ.</p> <p><u>Сайн дурын даатгал:</u> даатгуулагч хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогынхоо 10 хувиар Тэтгэврийн даатгалын санд шимтгэл төлнө. Хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогыг даатгуулагч өөрөө сайн дураар тодорхойлох ба шимтгэл төлөх орлогын дээд, доод хязгаар нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ ба уг хэмжээг 10 дахин нэмэгдүүлсэн дүнтэй тэнцүү байна.</p> |
| <b>Тэтгэврийн хэмжээ</b>    | <p>Гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүдийн тоог харгалзан нас барсан даатгуулагчид тогтоогдвол зохих өндөр насны тэтгэврийн хэмжээнээс дараах байдлаар тогтооно.</p> <ul style="list-style-type: none"> <li>• Нэг тэжээлгэгч бол 50 хувиар,</li> <li>• Хоёр тэжээлгэгч бол 75 хувиар,</li> <li>• Гүрав ба түүнээс дээш тэжээлгэгч бол 100 хувь</li> </ul> <p>Тэтгэврийн доод хэмжээ нь гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүдийн тооноос хамааран хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ (2013 онд 192,000 төгрөгөөр тогтоогдсон)-ний 50 – 100 хувьтай тэнцүү байна.</p>                                                                                                             |
| <b>Хамралт</b>              | 2013 онд 22.5 мянган хүн уг тэтгэврийг авсан (тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагчдыг насаар ангилаагүй)                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                              |

## Нийгмийн халамжийн хөтөлбөрүүд

2012 онд батлагдсан Нийгмийн халамжийн тухай хуулийн дагуу хүүхдүүд доор дурдсан тохиолдолд нийгмийн халамжийн тэтгэмж авах эрхтэй:

- Байнгын асаргаа шаардлагатай 16 хүртэлх насны хүүхэд нийгмийн халамжийн сангаас сар бүр 126,500<sup>21</sup> төгрөгийн тэтгэмж авах эрхтэй.
- Хоёр ба түүнээс дээш ихэр (гурав ба дөрвөн ихэр) хүүхэд төрүүлж, өсгөж буй иргэн, гэр бүлд: хоёр ихэр бол 1,000,000 төгрөг, гурав ба түүнээс дээш ихэр бол 3,000,000 төгрөг хүүхэд түс бүрт нэг удаа олгоно. Тус хөтөлбөрт 2013 онд 4,032 ихэр хүүхэд хамрагдсан байна.
- 1999 онд батлагдсан Гэр бүлийн тухай хуулийн 25.5-д зааснаар сэтгэл санааны болон бие махбодийн хүчирхийллийн хохирогч болсон хүүхдийг Гэр бүлийн тухай хуулийн 74-т заасны дагуу гэр бүлдээ авч асрамжилж байгаа иргэнд хүүхэд бүрээр тооцож 58,000 төгрөгийг сар бүр олгоно. Асаргаа сувилгааны үр чадварын сургалтад мөн үнэ төлбөргүй хамруулна.
- Эмнэлгийн хяналт дор, байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч буй иргэн сар бүр 58,000 төгрөгийн мөнгөн тэтгэмж авч, асаргаа сувилгааны үр чадварын сургалтад мөн үнэ төлбөргүй хамрагдана.
- 18 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, түүнчлэн үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас протез хийлгэх, сэргээн засалттай холбогдсон хөнгөлөлт авах эрх үүсээгүй, хөгжлийн бэрхшээлтэй иргэний дотоодод хийлгэсэн болон худалдан авсан ортопед, тэргэнцэр зэрэг тусгай хэрэгслийн үнийг 3 жил тутам нэг удаа 100 хувь нөхөн олгоно.

## Нийгмийн халамжийн сангаас хүүхдэд олгох тэжээгчээ алдсаны тэтгэвэр

**Хууль эрх зүйн орчин** 2012 оны Нийгмийн халамжийн тухай хуулийн 12.1.4 дэх заалт

**Зорилтот бүлэг** Нийгмийн даатгалын сангаас тэжээгчээ (хэн нэгнийг нь, эсвэл хоёуланг нь) алдсаны тэтгэвэр авах эрх үүсээгүй 18 хүртэлх насны хүүхдүүд

**Тэтгэврийн хэмжээ** 2015 оны 2-р сарын 1-нээс эхлэн сар бүр 126,500 төгрөг

**Санхүүжилт** Улсын төсвөөс санхүүждэг Нийгмийн халамжийн сан

**Хамралт** 14, 072 хүүхэд<sup>22</sup> (2013)

## Ганц бие эцэг, өрх толгойлсон эхэд олгох нийгмийн халамжийн тэтгэвэр

**Хууль эрх зүйн орчин** 2012 оны Нийгмийн халамжийн тухай хуулийн 12.1.5 дахь заалт. Засгийн газрын тогтоол 2012 оны 81 дүгээр тогтоол

**Зорилтот бүлэг** өрх толгойлсон 45 насанд хүрсэн эх (50 насанд хүрсэн эцэг)-ийн 18 хүртэлх насны 4 ба түүнээс дээш хүүхэд

**Тэтгэмжийн хэмжээ** 2015 оны 2-р сарын 1-нээс эхлэн сар бүр 126,500 төгрөг

**Санхүүжилт** Улсын төсвөөс санхүүждэг Нийгмийн халамжийн сан

**Хамралт** 52 эцэг эх (2013)

<sup>21</sup> 2012 оны Нийгмийн халамжийн тухай хуульд 2013 оны 2 дугаар сарын 7-ны өдөр оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр энэхүү сарын тэтгэмж нь 2014 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн нийгмийн халамжийн тэтгэвэртэй тэнцүү байна гэж заасан. Тиймээс энэ тэтгэмжийн хэмжээ сард 60,000 төгрөг байсан бол 2014 онд 115,000 төгрөг, 2015 оны 2 дугаар сард 126,500 төгрөг болж нэмэгдсэн.

<sup>22</sup> ХАХНХЯ, 2013 оны тайлан сэтгүүл, 42 дугаар хуудас

## Эмзэг бүлгийн хүүхдүүдэд зориулсан нийгмийн халамжийн тэтгэмж, тусламжийн багц

|                                   |                                                                                                                                                                                                                                                                                                                    |
|-----------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| <b>Хууль эрх зүйн орчин</b>       | Нийгмийн халамжийн тухай хууль(2012)-ийн 12.1.5, 13, 17.1.1, 17.1.2 ба 18.2.3 дахь заалтууд; Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хууль(2005 оны 12-р сарын 08)-ийн 5.1.2 ба 5.1.4 дэх заалт; Засгийн газрын 2012 оны 153 дугаар тогтоол                                                         |
| <b>Зорилтот бүлэг</b>             | Бүтэн өнчин хүүхдийг өргөж авсан болон хууль ёсны асран халамжлагч болсон иргэн; тусгай хэрэгцээ бүхий хүүхдүүд; хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд; архаг өвчтэй хүүхдүүд, 14-өөс доош насны 3 ба түүнээс дээш хүүхэдтэй ганц бие эх/эцэг; ихэр хүүхдүүд                                                               |
| <b>Тэтгэмж, тусламжийн хэмжээ</b> | Долоон төрлийн тэтгэмж: сар бүр олгох 58,000-126,500 төгрөгийн тэтгэмж, амьжиргааг дэмжих нэг удаагийн 1.2 сая төгрөгийн дэмжлэг, олон хүүхэдтэй ганц бие эцэг, эхэд жилд нэг удаа олгох 120,000 төгрөгийн тусламж; хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд протез хийлгэх, сэргээн засалттай холбогдсон хөнгөлөлт (100 хувь) |
| <b>Санхүүжилт</b>                 | Улсын төсвөөс санхүүждэг Нийгмийн халамжийн сан                                                                                                                                                                                                                                                                    |
| <b>Хамралт</b>                    | 18,376 хүүхэд болон тэднийг асарч буй иргэд сар бүр олгох тэтгэмжид, ба 4032 хүүхэд ихэр хүүхдийн тэтгэмжид хамрагджээ (2013)                                                                                                                                                                                      |

## Амьдралын нөхцөлийг сайжруулах мөнгөн тэтгэмж

|                             |                                                                                                                                                                                                                                                                           |
|-----------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| <b>Хууль эрх зүйн орчин</b> | Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2013 оны 3 дугаар сарын 29-ний өдрийн 42 дугаар зарлиг; Засгийн газрын 2013 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн 168 дугаар тогтоол                                                                                                               |
| <b>Зорилтот бүлэг</b>       | Тайгад амьдардаг цаатан өрхийн гишүүд (үндэсний цөөнх)                                                                                                                                                                                                                    |
| <b>Тэтгэмжийн хэмжээ</b>    | Хүүхдэд амьжиргааны доод түвшин(АДТ)-ий 50 хувь, насанд хүрсэн хүнд 100 хувиар тооцож (2013 оны зургадугаар сарын 1-нээс эхлэн) сар бүр тэтгэмж олгож байна. АДТ-г ҮСХ-ноос 2013 онд бүсийн ялгаатайгаар сард 130,500 -149,900 төгрөгийн хооронд тогтоосон. <sup>23</sup> |
| <b>Санхүүжилт</b>           | Улсын төсөв                                                                                                                                                                                                                                                               |
| <b>Хамралт</b>              | 2013 онд 94 өрхийн 339 хүн (хүүхэд, насанд хүрсэн иргэд)                                                                                                                                                                                                                  |

## Хүнсний талон хөтөлбөр

|                             |                                                                                                                                                |
|-----------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| <b>Хууль эрх зүйн орчин</b> | Нийгмийн халамжийн тухай хууль(2012 оны 1-р сарын 19)-ийн 22 дугаар зүйл, Сангийн болон ХАХНХ-ийн сайдын хамтарсан 2012 оны А/95 дугаар тушаал |
| <b>Зорилтот бүлэг</b>       | (Орлогыг орлуулан тооцох аргаар тодорхойлсон) <sup>24</sup> ядуу, нэн ядуу өрхийн 18-аас доош насны хүүхдүүд                                   |
| <b>Тусламжийн хэмжээ</b>    | 2014 онд сарын 5,000 төгрөг байсан бол 2015 оны 1 дүгээр сарын 1-нээс 6,500 төгрөг болсон.                                                     |
| <b>Санхүүжилт</b>           | Улсын төсвөөс санхүүждэг Нийгмийн халамжийн сан                                                                                                |
| <b>Хамралт</b>              | 2013 онд 50,371 хүүхэд <sup>25</sup>                                                                                                           |

<sup>23</sup> 2015 оны хүн амын амьжиргааны доод түвшин: Сард бүсээр 160,800-185,400 төгрөг байна. Хамгийн өндөр нь Улаанбаатар хотын бүс.

<sup>24</sup> ХАХНХЯ 2015 онд өрхийн мэдээллийн сангаас хамгийн бага хэрэглээтэй 10.0 хувь энэ хөтөлбөрт хамрагдана гэж тооцсон.

<sup>25</sup> ХАХНХЯ-ны мэдээлэл

## Боловсролыг дэмжих хөтөлбөрүүд

Монгол Улсад хэрэгжиж буй боловсролыг дэмжих хөтөлбөрүүдийн тоймыг Хүснэгт 8-д харуулав.

### Хүснэгт 8. Эмзэг бүлгийн хүүхдүүдийн боловсролыг дэмжихэд чиглэсэн хөтөлбөрүүд

| Хөтөлбөр                    | Цэцэрлэгийн хүүхдийг үнэ төлбөргүй хооллох                                                                                                                                                                                                                                     |
|-----------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Хууль эрх зүйн орчин        | Боловсролын тухай хууль (2002 оны 6 дугаар сарын 6); Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль (2008 оны 5 дугаар сарын 23)                                                                                                                                                     |
| Зорилтот бүлэг              | 2-5 насны хүүхдүүд                                                                                                                                                                                                                                                             |
| Тэтгэмж, тусламж, үйлчилгээ | Улсын цэцэрлэгүүд үнэ төлбөргүй хоолоор хангана.                                                                                                                                                                                                                               |
| Хамралт (2013)              | 174,600 хүүхэд <sup>1</sup> (2-5 хүртэлх насны хүүхдүүдийн 71.9 хувь)                                                                                                                                                                                                          |
| Хөтөлбөр                    | Бага, дунд боловсролыг үнэ төлбөргүй олгох                                                                                                                                                                                                                                     |
| Хууль эрх зүйн орчин        | Монгол Улсын Үндсэн хууль(1992 оны 1 дүгээр сарын 13)-ийн 16.7 дэх заалт, Боловсролын тухай хууль(2002 оны 6 дугаар сарын 6)-ийн 6.2 дахь заалт                                                                                                                                |
| Зорилтот бүлэг              | 6-18 насны бүх хүүхэд                                                                                                                                                                                                                                                          |
| Тэтгэмж, тусламж, үйлчилгээ | Бага боловсрол - 5 жил, дунд боловсрол - 9 жил, бүрэн дунд боловсрол -12 жил                                                                                                                                                                                                   |
| Хамралт (2013)              | 481,000 хүүхэд <sup>1</sup> (үүн дээр хувийн сургуулиудад суралцаж буй 28,700 хүүхэд)                                                                                                                                                                                          |
| Хөтөлбөр                    | Дүйцүүлэх боловсролын хөтөлбөр                                                                                                                                                                                                                                                 |
| Хууль эрх зүйн орчин        | Боловсролын тухай хууль (2002 оны 6 дугаар сарын 6)-ийн 3.1.7 дахь заалт; Албан бус боловсролын үндэсний хөтөлбөр (Засгийн газрын 1997 оны 116 дугаар тогтоол); БСШУ-ны Сайдын 2007 оны 10 дугаар сарын 9-ний 362 дугаар тушаал                                                |
| Зорилтот бүлэг              | 10-аас дээш насны сургуулиас завсардсан хүүхдүүд, сургуульд огт суралцаж байгаагүй, эсвэл сургуулиас завсардсан насанд хүрэгсэд                                                                                                                                                |
| Тэтгэмж, тусламж, үйлчилгээ | Зорилтот бүлгийн хэрэгцээнд тохируулсан сургалтын хөтөлбөрөөр бага ба дунд боловсролыг үнэ төлбөргүй олгох                                                                                                                                                                     |
| Хамралт (2013)              | 2013/2014 оны хичээлийн жилд 1,800 мянган хүүхэд сургуулиас завсардсан байна (сургууль завсардалтын хувь 0.4) <sup>2</sup> . Энэ хөтөлбөрийн хүрээнд (3,600 хүүхэд бага , 4,200 хүүхэд дунд, 2,300 хүүхэд бүрэн дунд боловсрол) нийтдээ 10,020 хүүхэд хамрагджээ. <sup>3</sup> |
| Хөтөлбөр                    | Цахим-боловсрол: “Хүүхэд бүрт компьютер” хөтөлбөр 2008-2015                                                                                                                                                                                                                    |
| Хууль эрх зүйн орчин        | Засгийн газрын 2008 оны 92 дугаар тогтоол                                                                                                                                                                                                                                      |
| Зорилтот бүлэг              | ЕБС-ийн 2-5 дугаар ангийн сурагчид                                                                                                                                                                                                                                             |
| Тэтгэмж, тусламж, үйлчилгээ | Үнэ төлбөргүй зөөврийн компьютер                                                                                                                                                                                                                                               |
| Хамралт (2013)              | 15,000 хүүхэд                                                                                                                                                                                                                                                                  |
| Хөтөлбөр                    | Сургуулийн дотуур байр                                                                                                                                                                                                                                                         |
| Хууль эрх зүйн орчин        | Боловсролын тухай хууль (2002 оны 6-р сарын 6)-ийн 43.2.1 дэх заалт                                                                                                                                                                                                            |
| Зорилтот бүлэг              | Оршин суудаг газраасаа сургуульд тогтмол явах боломжгүй, өнчин буюу амьжиргааны түвшин доогуур хүүхдүүд                                                                                                                                                                        |
| Тэтгэмж, тусламж, үйлчилгээ | Үнэ төлбөргүй дотуур байр, хоолоор хангах                                                                                                                                                                                                                                      |
| Хамралт (2013)              | Дотуур байранд хамрагдалтын индекс: гаргасан хүсэлтийн 94.8 хувь                                                                                                                                                                                                               |
| Хөтөлбөр                    | Сургуулийн үдийн цай                                                                                                                                                                                                                                                           |
| Хууль эрх зүйн орчин        | Засгийн газрын 2006 оны 194 дүгээр тогтоол                                                                                                                                                                                                                                     |
| Зорилтот бүлэг              | Ерөнхий боловсролын сургуулийн 1-5 дугаар ангийн сурагчид                                                                                                                                                                                                                      |

|                             |                                                                                                                                                                                                                          |
|-----------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Тэтгэмж, тусламж, үйлчилгээ | Үнэ төлбөргүй үдийн цай                                                                                                                                                                                                  |
| Хамралт (2013)              | 239,300 хүүхэд                                                                                                                                                                                                           |
| Хөтөлбөр                    | Сургуулийн сурах бичиг                                                                                                                                                                                                   |
| Хууль эрх зүйн орчин        | Засгийн газрын 2006 оны 192 дугаар тогтоолоор батлагдсан Боловсролын салбарыг хөгжүүлэх мастер төлөвлөгөө (2006-2015); БСШУ-ны сайдын 2009 оны 131 дүгээр тушаал, Засгийн газрын хуралдааны 2009 оны 28 дугаар тэмдэглэл |
| Зорилтот бүлэг              | Ерөнхий боловсролын сургуульд суралцаж буй эмзэг бүлгийн хүүхдүүд                                                                                                                                                        |
| Тэтгэмж, тусламж, үйлчилгээ | Бага ангийн бүх сурагчид, дунд болон ахлах ангид суралцаж буй эмзэг бүлгийн хүүхдүүд                                                                                                                                     |
| Хамралт (2013)              | 343,700 хүүхэд                                                                                                                                                                                                           |
| Хөтөлбөр                    | Мэргэжлийн боловсрол                                                                                                                                                                                                     |
| Хууль эрх зүйн орчин        | Боловсролын тухай хууль(2002 оны 6 дугаар сарын 6)-ийн 43.2.2, 43.2.10 дахь заалтууд; Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль (2009 оны 2 дугаар сарын 13)                                                           |
| Зорилтот бүлэг              | Сүүрх боловсрол эзэмшсэн хүүхэд, залуучууд                                                                                                                                                                               |
| Тэтгэмж, тусламж, үйлчилгээ | Мэргэжлийн боловсрол үнэ төлбөргүй олгох, өмчийн бүх хэвшлийн мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвд суралцагчдад сар бүр 70,000 төгрөгийн тэтгэлэг, шаардлагатай суралцагчдыг дотуур байраар үнэ төлбөргүй хангах       |
| Хамралт (2013)              |                                                                                                                                                                                                                          |
| Хөтөлбөр                    | Нийтийн тээврээр үнэ төлбөргүй зорчих                                                                                                                                                                                    |
| Хууль эрх зүйн орчин        | Боловсролын тухай хууль (2002 оны 6-р сарын 6)-ийн 43.2.3 дахь заалт                                                                                                                                                     |
| Зорилтот бүлэг              | Их, дээд сургуулийн оюутнууд                                                                                                                                                                                             |
| Тэтгэмж, тусламж, үйлчилгээ | Оюутны виза картаар нийтийн тээврээр үнэгүй зорчих                                                                                                                                                                       |
| Хамралт (2013)              | 103,000 оюутан                                                                                                                                                                                                           |
| Хөтөлбөр                    | Суралцагчийн үндэсний тэтгэлэг                                                                                                                                                                                           |
| Хууль эрх зүйн орчин        | Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хууль (2011 оны 7-р сарын 9)-ийн 8.1 дэх заалт; Засгийн газрын 2014 оны 3 дугаар сарын 7-ны 71 дүгээр тогтоол                                        |
| Зорилтот бүлэг              | Өмчийн бүх хэлбэрийн их, дээд сургуулийн өдрийн ангийн оюутнууд, тэтгэлэгт хамрагдах их, дээд сургууль болон оюутнуудын аль аль нь тодорхой шаардлагыг хангасан байх ёстой. <sup>4</sup>                                 |
| Тэтгэмж, тусламж, үйлчилгээ | 10 сарын хугацаанд сар бүр 70.000 төгрөгийн тэтгэлэг                                                                                                                                                                     |
| Хамралт (2013)              | 122,000 оюутан                                                                                                                                                                                                           |

<sup>1</sup> Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны төсвийн төслийн мэдэгдэл (2015)

<sup>2</sup> Монгол Улсын статистикийн эмхэтгэл 2013, ҮСХ

<sup>3</sup> БСШУЯ-ны харьяа Насан туршийн боловсролын үндэсний төвийн 2014 оны үйл ажиллагааны нэгдсэн тайлан

<sup>4</sup> 2014 оны эхний хагас жилийг дуустал хугацаанд энэ тэтгэлэгийг нийт оюутнуудад олгож байсныг 2013 оны 11 дүгээр сард Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт, Засгийн газрын 2014 оны 3 дугаар сарын 7-ны өдрийн 71 дүгээр тогтоолоор үндэсний тэтгэлэг авах суралцагчдад дараах шаардлагыг тавьсан: төрийн болон хувийн хэвшлийн магадлан итгэмжлэгдсэн их, дээд сургуульд элссэн өдрийн ангийн суралцагч байх, хичээлийн жилийн нэг улиралд 12-оос доошгүй багц цагийн хичээл судалж, дүгнүүлсэн байх, өмнөх улирлын голч дүн нь 2.0-аас доошгүй үнэлэгдсэн байх. Түүнээс хойш Засгийн газрын 2014 оны 7 дугаар сарын 4-ний өдрийн 214 дүгээр тогтоол, Засгийн газрын 2015 оны 1 дүгээр сарын 26-ны өдрийн 26 дугаар тогтоолоор уг шаардлагыг улам өндөржүүлж, өмнөх улирлын голч дүн нь 3.0-аас дээш гарсан суралцагчид тэтгэлэг олгохоор шийдвэрлэсэн байна.

Эх үүсвэр: НДЕГ, НХҮЕГ, БСШУЯ, ХТҮГ

## Хүүхдийн нийгмийн хамгааллын хүрээнд хийхээр яригдаж буй шинэчлэл

Хүүхдийн нийгмийн хамгааллын хүрээнд дараах өөрчлөлт оруулахаар яригдаж байна. ҮСҮХ-ийн үед эхлээгүй байсан тул эдгээр асуудлыг нийгмийн хамгааллын суурь түвшний хүүхдийн баталгааг хангахтай холбогдсон зөвлөмжид тусгаагүй болно. Үүнд:

1. ХАХНХЯ-наас Эхэд тэтгэмж, дэмжлэг, хөнгөлөлт олгох тухай шинэ хуулийн төслийг боловсруулсан байна. Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэж дэмжсэн энэ хуулийн төсөлд а) жирэмсэн эхэд жирэмсний 5 дахь сараас эхлэн хүүхэд төрүүлэх хүртэл сар бүр мөнгөн тэтгэмж, хүнсний дэмжлэг үзүүлэх; б) эх хүүхдээ 2 нас хүртэл, ихэр хүүхдийг 3 нас хүртэл асарч байгаа бол сар бүр мөнгөн тэтгэмж олгох, 3 дахь хүүхдээ асарч байгаа бол тэтгэмжийн хэмжээг 50 хувиар нэмэгдүүлэх; в) 4 хүртэлх насны ихэр хүүхэдтэй эхэд нэг удаагийн мөнгөн тэтгэмж олгох; г) хүүхэд асарч байгаа эх/эцэг нь төрүүлсэн болон үрчлэн авсан хүүхдээ 2 нас хүртэл, ихэр хүүхдийг 3 нас хүртэл асарч байх хугацаандаа тэтгэврийн даатгалын шимтгэлээ сайн дураар төлөх бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс тооцсон шимтгэлийн 50 хувийг төрөөс хариуцаж төлөх; д) 2-оос 18 хүртэлх насны дөрөв ба түүнээс дээш хүүхэдтэй эх хувь хүний орлогын албан татварт төлсөн татварынхаа 50-иас доошгүй хувийг дараа ондоо эргүүлэн авахаар тусгажээ. Тэтгэмж, дэмжлэгийн хэмжээг Засгийн газар тогтооно.
2. УИХ-аар Хүүхэд харах үйлчилгээний тухай хуулийн төслийг хэлэлцэж байна. Энэ хуулийн зорилтот бүлэг нь цэцэрлэгт хамрагдаж чадаагүй 2- 5 насны хүүхдүүд юм. Хуулиар тогтоосон стандарт шаардлагыг хангаж, 20 хүртэлх хүүхэд элсүүлж авсан хүүхэд харах үйлчилгээний төв асарч буй хүүхэд бүрийн тоогоор улсын төсвөөс төрийн өмчийн цэцэрлэгт олгож буй зардлын хэмжээтэй ижил түвшинд санхүүжилт авна. Үйл ажиллагааны болон чанарын стандартыг харьцангуй хөнгөлөлттэй тогтоох учраас 6000 гаруй ийм төв байгуулагдаж, цэцэрлэгийн хомсдолын асуудлыг шийдвэрлэнэ гэж үзэж байгаа ажээ.
3. УИХ-ын 2015 оны 1 дүгээр сарын 29-ний өдрийн 12 дугаар тогтоолоор батлагдсан “Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого (2014-2024)”-ын 6.7-д цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлыг эцэг эх, асран хамгаалагч нь хуваалцах зарчим баримтлахаар тусгагдсан байна.
4. ХХС-ийн санхүүжилтээр 2015 онд Улаанбаатар хотын Баянгол, Баянзүрх дүүрэг болон Архангай аймгийн Хайрхан суманд хүүхэд, гэр бүлийн хөгжлийн төв баригдана.

Хүүхдийн нийгмийн хамгааллын хөтөлбөрүүд, тэдгээрийн 2013 оны хамралтын талаарх мэдээллийг Хүснэгт 9-д харуулав.

### Хүснэгт 9. Хүүхдэд зориулсан нийгмийн хамгааллын хөтөлбөрүүдийн хураангуй

| Хөтөлбөрүүд                                                 | Хамралт (2013)                                                                                                        |
|-------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Бүх хүүхдэд зориулсан Хүүхдийн мөнгө хөтөлбөр               | 960,300 хүүхэд буюу 0-18 хүртэлх насны бүх хүүхэд бараг 100 хувь хамрагдсан                                           |
| НДС-аас олгох тэжээгчээ алдсаны тэтгэвэр                    | 22,500 хүүхэд                                                                                                         |
| Нийгмийн халамжийн сангаас олгох тэжээгчээ алдсаны тэтгэвэр | 14,072 хүүхэд                                                                                                         |
| Өрх толгойлсон эх, ганц бие эцэгт олгох халамжийн тэтгэвэр  | 52 гэр бүл                                                                                                            |
| Нийгмийн халамжийн тэтгэмж, тусламжийн багц                 | 18,376 хүүхэд болон тэдний асран хамгаалагчид сарын тэтгэмж авсан ба 4,032 хүүхэд ихэр хүүхдийн тэтгэмж авчээ (2013). |
| Цэцэрлэгийн хүүхдийг үнэ төлбөргүй хооллох                  | 193,672 хүүхэд буюу 2-5 насны хүүхдүүдийн 79.9 хувь                                                                   |

|                                                            |                                         |
|------------------------------------------------------------|-----------------------------------------|
| Бага, дунд боловсролыг үнэ төлбөргүй олгох                 | 498,600 хүүхэд                          |
| Дүйцүүлэх боловсролын хөтөлбөр                             | 10,020 хүүхэд                           |
| Цахим боловсрол “Хүүхэд бүрт компьютер хөтөлбөр 2008-2015” | 15,000 хүүхэд                           |
| Сургуулийн дотуур байр                                     | Дотуур байранд хамрагдалтын индекс 94.8 |
| Сургуулийн үдийн цай                                       | 239,300 хүүхэд                          |
| Сургуулийн сурах бичиг                                     | 343,700 хүүхэд                          |
| Мэргэжлийн боловсрол                                       | 42,798 суралцагч                        |
| Нийтийн тээврээр үнэ төлбөргүй зорчих                      | Их, дээд сургуулийн 103,000 оюутан      |
| Суралцагчийн үндэсний тэтгэлэг                             | Их, дээд сургуулийн 122,000 оюутан      |
| Хүнсний талон хөтөлбөр                                     | 50,371 хүүхэд                           |

Эх үүсвэр: НДЕГ, НХҮЕГ, БСШУЯ, ҮСХ, ХТҮГ

## Бодлогын болон хэрэгжүүлэлтийн түвшинд тулгарч буй асуудлууд

### Бодлогын хийдэл

#### ХМХ

Хүүхдийн мөнгө нь 2012 онд Хүний хөгжлийн сангийн тухай хуулинд тусгагдсан. Гэсэн ч энэ хөтөлбөрийн зарим зохицуулалт, ялангуяа НХСТ-ий үндсэн зарчмын нэг болох бүх нийтийг хамарсан шинж нь хуулиар баталгаажуулах тул хамралтын хувьд улс төрийн шийдвэрээс ихээхэн хамаардаг. Мөнгөн тэтгэмжийн хэмжээ нь сурагчийн дүрэмт хувцас, сурах бичиг зэрэг сургуульд суралцахтай холбогдон гарах бүх зардалд хүрэлцэхээргүй, хэтэрхий бага. Хүүхдийн мөнгөний хэмжээг амьжиргааны өртөгийн өсөлттэй уялдуулан автоматаар индексжүүлдэггүй.

#### Тэжээгчээ

##### алдсаны тэтгэвэр

НДС-аас олгох тэжээгчээ алдсаны тэтгэврийн хэмжээг амьжиргааны өртөгтэй уялдуулан автоматаар индексжүүлдэггүй тухай бүр шийдвэр гаргаж нэмэгдүүлдэг.

#### Цэцэрлэгийн хүртээмж

Цэцэрлэгт хамрагдалт ерөнхийдөө нэмэгдсэн боловч сургуулийн өмнөх боловсрол, цэцэрлэгийн үнэ төлбөргүй хоолноос хамгийн ихээр хүртэх ёстой бага орлоготой өрхийн хүүхдүүдийн хамрагдалт нэмэгдэхгүй байна.

#### Хоол тэжээлийн чанар

Цэцэрлэгийн хүүхдийн хоолны чанар муу

#### Нийгмийн үйлчилгээний хүртээмж

Нийгмийн халамжийн олон хөтөлбөр байгаа боловч хүүхдүүд эрүүл мэнд, боловсрол зэрэг нийгмийн үндсэн үйлчилгээг хүртэхэд ихэнхдээ зайнаас хамаарсан саад бэрхшээлтэй тулгарсаар байна. Эдгээр үйлчилгээний чанарыг хөдөө орон нутагт, ялангуяа тусгай хэрэгцээ бүхий хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд зориулсан үйлчилгээний чанарыг сайжруулах шаардлага өнөөдөр хэвээр байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тухай тодорхойлолт нь тусгай хэрэгцээ бүхий бүх хүүхдэд таарахгүй байна. Тиймээс тэдний ихэнх нь одоо ч гэсэн нийгмийн хамгааллын үйлчилгээ, тэтгэмж, тусламж хүртэж чадахгүй гадна нь орхигдож байна.

Сүм хийдэд шавилан сууж буй хүүхдүүд албан боловсролын сургалтын хөтөлбөрт хамрагдахгүй байна.

Хүүхдүүдэд зориулсан үндны усны ариун цэвэр, эрүүл ахуй, ариун цэврийн байгууламжийн хүртээмж асуудалтай хэвээр байна.

Хөдөлмөр эрхлэлтийн бодлогод гэр бүлийн үүрэг хариуцлага бүхий ажилчдын хэрэгцээг илүү анхаарах шаардлагатай байна.

## Хэрэгжүүлэлтийн түвшинд гарч буй асуудлууд

|                                     |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                     |
|-------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| <b>Үйлчилгээний хүртээмж</b>        | Бүрдүүлэх бичиг баримт (төрсний гэрчилгээ, эцэг, эхийн иргэний үнэмлэх)-д тавигдах шаардлага нь хөдөө орон нутагт нийгмийн үйлчилгээ авахад гол хүндрэл бэрхшээл болдог.                                                                                                                                                                                                                                                                            |
| <b>Үйлчилгээний чанар</b>           | <p>Нийгмийн үйлчилгээний чанарын стандартууд болон хүргэх дэд бүтэц сайн тодорхойлогдсон боловч стандартын хэрэгжилт, мөрдүүлэх ажил хангалтгүй байна.</p> <p>Сургуулийн дотуур байрны үйлчилгээ муу байна.</p> <p>Нийгмийн ажилтан, асаргаа сувилгаа үзүүлэх хүмүүсийн тоо, ялангуяа сэтгэл зүйн зөвлөгөө өгөх үйлчилгээ хангалтгүй байна.</p> <p>Сургуулийн амралтын үеэр хүүхдүүдэд зориулсан, чөлөөт цагийг өнгөрүүлэх газар байхгүй байна.</p> |
| <b>Зорилтот бүлгийг тодорхойлох</b> | Нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдах нэн шаардлагатай, тэндээс дэмжлэг туслалцаа авах ёстой өрх, иргэдийг тодорхойлох талаар зарим алдаа гарсаар байна.                                                                                                                                                                                                                                                                                         |
| <b>Мэдээлэл</b>                     | Нийгмийн хамгааллын үйлчилгээг хүргэж буй байдал, үр шимийг хүртэгчдийг хянах мэдээллийн найдвартай тогтолцоо байхгүй байна.                                                                                                                                                                                                                                                                                                                        |

## Дүгнэлт, зөвлөмж

Ерөнхий боловсрол (бүрэн дунд буюу 12 жилийн боловсрол), эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг бүх хүүхдэд үнэ төлбөргүй олгож байна. Сургуулийн дотуур байр хүрэлцээтэй, үнэ төлбөргүй хангагдаж байгаа нь боловсролын үйлчилгээнд үр дүнтэй хамрагдах боломжийг баталгаажуулж байна. 2012 оноос эхлэн 0-18 насны бүх хүүхдэд олгож байгаа ХМХ нь хүүхэд бүрийг хамгийн наад захын орлогын баталгаагаар хангаж байна. Энэ хүрээнд бүх хүүхдийн эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг төрөөс бүрэн хариуцаж байгааг хэвээр хадгалж, хүүхдийн мөнгийг орлогын шалгуураар бус одоогийн байдлаар нь бүх хүүхдэд үргэлжлүүлэн олгох зэрэг гол зөвлөмжүүд гарсан юм. Мөн бүх хүүхэд хүүхдийн мөнгөнд хамрагдах боломжийг хуулиар баталгаажуулах, амьжиргааны өртгийн өсөлттэй уялдуулан индексжүүлэх, цэцэрлэгийн хүүхдийн хоол тэжээлийн чанарыг сайжруулах, нийгмийн ажилтны үйлчилгээ, ялангуяа тусгай хэрэгцээ бүхий хүүхдүүдэд зориулсан үйлчилгээг дэмжих замаар нийгмийн чанартай үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зэрэг нэмэлт зөвлөмжүүд гарсан болно.

Хүснэгт 10-т үнэлгээнд суурилсан үндэсний хэлэлцүүлгийн явцад гарсан зөвлөмжүүдийг нэгтгэн харуулав. Нийгмийн хамгааллын шинэ зохицуулалт бий болгох, эсвэл одоогийн зохицуулалтынх нь хамрах хүрээг өргөжүүлэх шаардлагатайг илэрхийлсэн зөвлөмжийг (\*)-оор тэмдэглэв. Эдгээр нэмэлт зохицуулалтыг нэвтрүүлэх, хамрах хүрээг өргөжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог ОУХБ-ын РАП загвараар тооцоолсон болно. Зарим зөвлөмжийг хэрэгжүүлэхэд хэрэгцээтэй хөрөнгийн хэмжээг тооцохын тулд техник эдийн засгийн илүү нарийвчилсан үнэлгээ, актуар судалгаа хийх шаардлагатай юм. Эдгээр зөвлөмжийг хүснэгтэд (Δ)-аар тэмдэглэсэн болно.

**Хүснэгт 10. ҮСҮХ-ээс хүүхдийн нийгмийн хамгааллын чанарыг сайжруулах чиглэлээр гаргасан зөвлөмжүүд**

| Гол зөвлөмжүүд    |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                         |
|-------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| *                 | X1. ХМХ-ийг хэвээр нь үргэлжлүүлэх, хэрэглээний үнийн индекстэй уялдуулан индексжүүлж байх. Бүх хүүхэд ХМХ-т хамрагдах боломжийг хуулиар баталгаажуулах.                                                                                                                                                                                                                |
| △                 | X2. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд зориулсан хөтөлбөрүүдийн нийгэмшүүлэх зорилтуудыг сайжруулах, тухайлбал нийгмийн үйлчилгээ хүртэх, ялангуяа цэцэрлэг, сургуульд хамрагдах боломж бүрдүүлэхийн тулд барилга байгууламжийг шинэчлэн тохируулж засварлах, тусгай хэрэгцээ бүхий хүүхдүүдэд зориулсан сургуулийн өмнөх боловсролын өөр бусад хөтөлбөрүүдийг өргөжүүлэх. |
|                   | X3. Цэцэрлэг, сургуулийн хүүхдүүдийн хоол хүнсний аюулгүй байдал, чанарыг улам сайжруулах хяналтын механизмыг нэвтрүүлэх.                                                                                                                                                                                                                                               |
| *                 | X4. Өдрийн болон 24 цагийн ажиллагаатай цэцэрлэгийн хүүхдийн хоолны чанарыг сайжруулах. Засгийн газрын шинэ бодлого нь төрөөс хоолны мөнгөний 50 хувийг л хариуцахыг санал болгож байгаа.                                                                                                                                                                               |
|                   | X5. Цэцэрлэгт хамрагдаагүй үлдсэн хүүхдүүд(гол төлөв эмзэг бүлгийн хүүхдүүд)-д боловсролын эдгээр үйлчилгээг авах боломжийг олгох зорилгоор цэцэрлэгийн тоог нэмэгдүүлэх.                                                                                                                                                                                               |
| Нэмэлт зөвлөмжүүд |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                         |
| *                 | X6: Бага насны хүүхдүүдэд олгох хүүхдийн мөнгөний хэмжээг нэмэгдүүлэх (гэхдээ, НҮБ/ЗГ-ын Нийгмийн хамгааллын ажлын хэсэг энэ зөвлөмжийг зардал тооцох хувилбарт оруулахгүй байхаар санал нэгдсэн, учир нь одоо ХМХ-ийг бүх хүүхдэд адилхан олгох явдлыг хадгалж үлдэх нь илүү чухал байна).                                                                             |
|                   | X7: Олон хүүхэдтэй ганц бие эх, эцэгт зориулсан нийгмийн халамжийн тэтгэвэрт тавигдах шаардлагыг зөөлрүүлэх.                                                                                                                                                                                                                                                            |
| △                 | X8: Архаг өвчтэй хүүхдүүдэд зориулсан үйлчилгээг өргөжүүлэх.                                                                                                                                                                                                                                                                                                            |
| △                 | X9: Хөдөлмөрийн насны залуучууд (16-аас дээш насны)-ын хувьд сургуулиас ажилд шилжих шилжилтийг хөнгөвчлөх хөтөлбөрүүдийг бий болгох. (Баталгаа 3-ийн хүрээнд гарсан зөвлөмжүүдийг үзнэ үү.)                                                                                                                                                                            |
|                   | X10: Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрт хамаарах хөдөлмөр эрхэлж буй хүүхдүүдийн эцэг эхийг зохистой ажлын байраар хангах.                                                                                                                                                                                                                                          |
|                   | X11: Малчин өрхийн хүүхдүүдийн хөгжих, боловсрол эзэмших эрхийг нь баталгаажуулах орчин нөхцлийг сайжруулах.                                                                                                                                                                                                                                                            |

Эх үүсвэр: НҮБ/ЗГ-ын хамтарсан Нийгмийн хамгааллын ажлын хэсэг, 2014




### 4.3. Хөдөлмөрийн насны хүн ам

*“Өвчлөх, ажилгүй болох, жирэмслэх болон хүүхэд төрүүлэх, хөдөлмөрийн чадвараа алдах зэрэг шалтгаанаар хангалттай орлого олох боломжгүй байгаа хөдөлмөрийн насны хүмүүсийг наад зах нь үндэснийхээ хэмжээнд тодорхойлсон доод түвшнийг хангахуйц хэмжээний орлогын суурь баталгаагаар хангах;”*

Хөдөлмөрийн насны хүн амын нийгмийн хамгаалал нь нийгмийн даатгалын болон нийгмийн халамжийн тэтгэвэр тэтгэмж, тусламжийн хөтөлбөрүүд, хөдөлмөрийн зах зээлийн идэвхтэй бодлогын хүрээн дэх хөдөлмөр эрхлэлтийн хөтөлбөрүүдээс бүрдэнэ.

**Зураг 10. Монгол Улсын хөдөлмөрийн насны хүн амд зориулсан нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих одоогийн хөтөлбөрүүд**



Эх үүсвэр: ХАХНХЯ, Хөдөлмөрийн яам

## Одоогийн тогтолцоо: Хөдөлмөрийн насны хүн амд зориулсан нийгмийн даатгалын хөтөлбөрүүд

### Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгал

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин(ҮОМШӨ)-ий даатгал нь нийгмийн даатгалын таван төрлийн нэг бөгөөд даатгалын үйл ажиллагааг НДЕГ эрхэлдэг.

**Хууль эрх зүйн орчин** 1994 оны Нийгмийн даатгалын тухай хууль, 1994 оны Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль

**Зорилтот бүлэг** Монгол Улсын аж ахуйн нэгж, байгууллага, ТББ-үүд болон бусад байгууллагад хөдөлмөрийн болон иргэний гэрээгээр ажиллаж ажиллагчид (Монгол Улсын иргэд, гадаадын иргэд, харьяалалгүй хүмүүс) (4.2.1 дэх заалт); Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа гадаадын аж ахуйн нэгж, байгууллагууд, Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол гадаадын зээл түслэмжаар хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрийн нэгж, гадаад орны дипломат төлөөлөгчийн газар, олон улсын байгууллагад ажиллагчид (Монгол улсын иргэд, гадаадын иргэд, харьяалалгүй хүмүүс) (4.2.2 дахь заалт); хуульд өөрөөр заагаагүй бол төрийн албан хаагчид (4.2.3 дахь заалт); Хөдөлмөрийн гэрээгээр гадаадад ажиллаж буй Монгол улсын иргэд (4.2.4 дэх заалт); Хуулийн 4.2-т зааснаас бусад (албан салбарт ажилладаггүй болон тодорхой ажил хөдөлмөр эрхлээгүй) хүмүүс.

**Даатгуулах хэлбэр** Албан журмын ба сайн дурын

**Санхүүжилт** ҮОМШӨ-ний даатгалын санд ажил олгогчдоос төлсөн шимтгэл болон сайн дураар даатгуулагчдын төлсөн шимтгэл:

**Албан журмын даатгал:** ажил олгогч дангаараа 1.0 хувь, 2.0 хувь, 3.0 хувиар (хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны шаардлагаас хамаарна) хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоосоо шимтгэл төлнө.

**Сайн дурын даатгал:** зөвхөн даатгуулагч хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос 1.0 хувийн шимтгэл төлнө. Хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогыг даатгуулагч өөрөө тодорхойлох ба шимтгэл төлөх орлого нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ (2013 онд 192,000 төгрөгөөр тогтоосон)-ба уг доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээгээр хязгаарлагдана.

**Тэтгэвэр, тэтгэмж** Тахир дутуугийн болон тэжээгчээ алдсаны тэтгэвэр; хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж; үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас рашаан сувилалд эмчлүүлэх, протез, ортопедийн хэрэгсэл хийлгэх зэрэг нөхөн сэргээлттэй холбоотой зардлын нөхөн олговор; тэтгэврийн даатгалын шимтгэлийн төлбөр, ҮОМШӨ-нөөс урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгааны зардал

**Хамралт** 2013 оны байдлаар албан журмын даатгалд 766,815 хүн, сайн дурын даатгалд 147,100 хүн даатгуулсан байна.  
2013 онд 5.800 хүн тахир дутуугийн тэтгэвэр, 600 хүн тэжээгчээ алдсаны тэтгэвэр, 1000 хүн ХЧТА-ны тэтгэмж авчээ.

### Жирэмсний ба амаржсаны, ХЧТА-ны болон оршуулгын тэтгэмж

Хөдөлмөрийн болон иргэний гэрээгээр ажиллагчид, төрийн албан хаагчид (албан журмын үндсэн дээр), хувиараа хөдөлмөр эрхлэгчид, малчид, ажилгүй иргэд (сайн дурын үндсэн дээр) нийгмийн даатгалын нэг төрөл болох тэтгэмжийн даатгалд хамрагдаж, жирэмсний ба амаржсаны, ХЧТА-ны, оршуулгын тэтгэмж авна. Энэ даатгалын үйл ажиллагаа болон тэтгэмжүүдийг нийгмийн даатгалын байгууллага хариуцан зохион байгуулж олгож байна.

|                            |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                      |
|----------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| <b>Хууль эрхзүйн орчин</b> | 1994 оны Нийгмийн даатгалын тухай хуулийн 4.2 ба 4.3 дах хэсэг<br>1994 оны 6 дугаар сарын 7-ны өдөр батлагдсан Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                     |
| <b>Зорилтот бүлэг</b>      | Хөдөлмөрийн болон иргэний гэрээгээр ажиллагчид, төрийн албан хаагчид, албан бус салбарт ажиллагчид, малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, тодорхой хөдөлмөр эрхлээгүй хүн                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                             |
| <b>Даатгуулах хэлбэр</b>   | Албан журмын болон сайн дурын                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                        |
| <b>Санхүүжилт</b>          | Нийгмийн даатгалын Тэтгэмжийн даатгалын санд ажил олгогчид, ажилтны төлсөн шимтгэл:<br><b>Албан журмын даатгал:</b> хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын 1.6 хувьтай тэнцэх шимтгэлийг ажил олгогч, ажилтан хоёр адилхан хувааж төлнө.<br><b>Сайн дурын даатгал:</b> хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлого (хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлого нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс бага байж болохгүй)-ын 1.0 хувиар шимтгэл төлнө.                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                              |
| <b>Тэтгэмж авах эрх</b>    | <b>Жирэмсний ба амаржсаны тэтгэмж:</b> Жирэмсний чөлөө авахаас өмнө 12 сараас доошгүй хугацаанд, үүнээс сүүлийн 6 сард нь шимтгэлийг тасралтгүй төлсөн байх ёстой.<br><b>ХЧТА-ны болон оршуулгын тэтгэмж:</b> Ердийн өвчин, ахуйн ослын улмаас хөдөлмөрийн чадвараа түр хугацаагаар алдахаас өмнө 3, түүнээс дээш сарын хугацаагаар тэтгэмжийн даатгалын шимтгэл төлж ажилласан даатгуулагч ХЧТА-ны тэтгэмж авах эрхтэй. Оршуулгын тэтгэмжийн хувьд даатгуулагч 36 сараас доошгүй хугацаагаар Тэтгэмжийн даатгалын санд шимтгэл төлсөн байх ёстой.                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                   |
| <b>Тэтгэмж</b>             | <b>Жирэмсний ба амаржсаны тэтгэмж:</b> Албан журмын даатгалд даатгуулсан эхчүүдэд тэтгэмжийн даатгалын шимтгэл төлсөн сүүлийн 12 сарын хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын дунджаас 100 хувиар тооцож 4 сарын хугацаанд нийгмийн даатгалын сангаас олгоно (4.2 дахь заалт); сайн дураар даатгуулсан эхчүүдэд тэтгэмжийн даатгалын шимтгэл төлсөн сүүлийн 12 сарын хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын дунджаас 70 хувиар тооцож 4 сарын хугацаанд нийгмийн даатгалын сангаас олгоно (4.3 дахь заалт).<br><b>ХЧТА-ны тэтгэмж:</b> Даатгуулагчийн шимтгэл төлж ажилласан хугацааг харгалзан түүний сүүлийн бүтэн ажилласан гурван сарын хөдөлмөрийн хөлснөөс дор дурдсан хувь хэмжээгээр бодож олгоно: <ul style="list-style-type: none"> <li>• 5 жил хүртэл: 50 хувь,</li> <li>• 5-14 жил: 55 хувь,</li> <li>• 15 ба түүнээс дээш жил: 75 хувь.</li> </ul> ХЧХА-ны тэтгэмж олгох хугацааны нэг удаагийн дээд хязгаар нь ердийн өвчний үед нэг жилд ажлын 66 өдрөөс хэтрэхгүй байна. Харин хорт хавдар болон сүрьеэгээр анх өвчлөхөд нэг жилд ажлын 132 өдөр хүртэл сунгаж болно. (4.2 ба 4.3 дахь заалт).<br>Жишээ нь, хэрэв даатгуулагч хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнд үндэслэн таван жилийн турш шимтгэл төлсөн бол өвчтэй байсан 66 хоногийн хугацаанд авах тэтгэмж нь 314,160 төгрөг (185 ам.доллар) болно.<br><b>Оршуулгын тэтгэмж:</b> 620,000 төгрөг (4.2 ба 4.3 дахь заалт). |

**Хамралт** 2013 онд албан журмын даатгалд 766,815 хүн, сайн дурын даатгалд 147,100 хүн хамрагджээ. 2013 онд нийт 45,700 эх жирэмсний ба амаржсаны тэтгэмж, 104,400 ажилтан ХЧТА-ны тэтгэмж авсан байна. 2013 онд 12,400 хүн оршуулгын тэтгэмж авчээ.

### **Ажилгүйдлийн даатгал**

Албан журмын нийгмийн даатгал нь хувийн болон төрийн хэвшлийн албан салбарт ажиллаж буй даатгуулагчид ажилгүй болсон тохиолдолд дэмжлэг үзүүлдэг. Харин малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, албан бүс эдийн засагт ажиллагчид сайн дураар хамрагддаг нийгмийн даатгалын багцад ажилгүйдлийн тэтгэмж ордоггүй. Ажилгүйдлийн тэтгэмжийн хэмжээг тогтоож, баталгаажуулах ажлыг нийгмийн даатгалын байгууллага хариуцан гүйцэтгэдэг.<sup>26</sup>

**Хууль эрх зүйн орчин** Нийгмийн даатгалын тухай хуулийн 4.2 дахь заалт (1994 оны 5 дугаар сарын 31) Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хууль (1994 оны 7 дугаар сарын 05)

**Зорилтот бүлэг** Хөдөлмөрийн болон иргэний гэрээгээр ажиллагсад, төрийн албан хаагчид

**Даатгуулах хэлбэр** Албан журмын

**Санхүүжилт** Нийгмийн даатгалын Ажилгүйдлийн даатгалын санд ажил олгогч ба ажилтны төлсөн шимтгэл: Хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын 0.4 хувьтай тэнцэх шимтгэлийг ажил олгогч, ажилтан хоёр адилхан хувааж төлнө.

**Тэтгэмж авах эрх** Даатгуулагч ажилгүй болохоосоо өмнө 24 сараас доошгүй хугацаанд, үүнээс сүүлийн 9 сард нь тасралтгүй даатгалын шимтгэл төлсөн нөхцөлд ажилгүйдлийн тэтгэмж авах эрх үүснэ. 2015 оны 7 дугаар сараас эхлээд дахин тэтгэмж авах тохиолдолд эрх үүсэх хугацаа нь 6-аас 12 сар болж нэмэгдсэн, бусад шалгуур нь хуучнаараа адилхан байгаа (Хуулинд 2015 оны 1 дүгээр сарын 30-нд нэмэлт, өөрчлөлт оруулжээ).

**Тэтгэмж** Ажилгүйдлийн даатгалын шимтгэл төлсөн хугацаанаас үл хамааран тэтгэмжийг ажлын 76 хүртэл өдрийн хугацаанд олгоно. Ажилгүйдлийн тэтгэмжийн хэмжээг даатгуулагчийн шимтгэл төлж ажилласан хугацааг харгалзан сүүлийн 3 сарын хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын дунджаас дор дурдсан хувь хэмжээгээр тооцож тогтооно:

- шимтгэл төлж ажилласан хугацаа нь 5 хүртэлх жил бол 45 хувь,
- 5 - 10 жил бол 50 хувь,
- 10 - 15 жил бол 60 хувь,
- 15 ба түүнээс дээш жил бол 70 хувь.

Ажилгүйдлийн тэтгэмжийн доод хэмжээ нь Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт Үндэсний хорооноос тогтоосон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 75 хувиас багагүй байна. Одоо мөрдөж буй сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2013 оны 4 дүгээр сард 192,000 төгрөгөөр тогтоосон байна.

Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хуулийн дагуу хэрэв ажилтан сайн дурын үндсэн дээр хөдөлмөрийн гэрээг дуусгавар болгох, эсвэл Хөдөлмөрийн тухай хуульд заасан ноцтой зөрчлийг давтан гаргасны улмаас ажил олгогчийн санаачилгаар хөдөлмөр эрхлэх харилцааг дуусгавар болгож байгаа тохиолдолд тэтгэмж олгох хугацаанаас 36 хоногийг хасна. Гэхдээ 2015 оны 1 дүгээр сарын 30-нд батлагдсан хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр ирэх 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн энэ заалтыг хүчингүй болгосон юм.

**Хамралт** 2013 оны байдлаар 766,815 хүн даатгуулсан байна. 2013 онд 15,800 хүн ажилгүйдлийн тэтгэмж авчээ.

<sup>26</sup> Дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл: Ж. Картер, М. Бедард, С.Р.Биста: Ази тив болон дэлхийн улс орнуудын ажилгүйдлийн болон хөдөлмөр эрхлэлтийн даатгалын тогтолцооны харьцуулсан шинжилгээ, ОУХБ-ын Ази, Номхон далайн бүсийн товчоо, 2013.

## Тахир дутуугийн ба тэжээгчээ алдсаны тэтгэвэр

Нийгмийн даатгал, тэр дундаа Тэтгэврийн даатгалын сангаас өндөр насны тэтгэврээс гадна тахир дутуугийн болон тэжээгчээ алдсаны тэтгэвэр (нийтдээ гурван төрлийн тэтгэвэр) олгож байна. Орон нутгийн хувьд аймгийн нийгмийн даатгалын хэлтэс (сумын байцаагчаар дамжуулан) тэтгэврийн хэмжээг бодох, тогтоож олгох ажлыг хариуцан зохион байгуулдаг.

**Хууль эрх зүйн орчин** Нийгмийн даатгалын тухай хуулийн 4.2 ба 4.3 дахь хэсэг (1994 оны 5 дугаар сарын 31); Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль (1994 оны 6 дугаар сарын 7)

**Зорилтот бүлэг** Хөдөлмөрийн болон иргэний гэрээгээр ажиллагчид, төрийн албан хаагчид, албан бус салбарт ажиллагчид, малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, тодорхой хөдөлмөр эрхлээгүй хүн

**Даатгуулах хэлбэр** Албан журмын ба сайн дурын

**Санхүүжилт** Нийгмийн даатгалын тэтгэврийн санд ажил олгогч ба ажилтны төлөх шимтгэл:  
**Албан журмын даатгал:** хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос 14.0 хувийн шимтгэлийг ажил олгогч, ажилтан адил хуваан төлж, Тэтгэврийн сангаас олгох 3 тэтгэврийг санхүүжүүлнэ.

**Сайн дурын даатгал:** хувь хүн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогынхоо 10 хувьтай тэнцэх шимтгэл төлнө. Хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогыг даатгуулагч өөрөө тодорхойлох ба шимтгэл төлөх орлогын хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ ба хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлсэн хэмжээгээр хязгаарлагдана.

**Тэтгэвэр** **Тахир дутуугийн тэтгэвэр:** Даатгуулагч хөдөлмөрийн чадвараа 50-иас доошгүй хувиар алдсан бол түүний хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын 45.0 хувиар тэтгэврийг тогтооно. 20 –иос илүү ажилласан жил тутамд тэтгэвэр нь 1.5 хувиар нэмэгдэнэ. Тахир дутуу болохын өмнөх 5 жилийн 3 жилд нь шимтгэл төлсөн бол шимтгэл төлсөн нийт хугацаандаа ногдох тахир дутуугийн тэтгэврийг хувь тэнцүүлэн тогтоолгож авна. Гэхдээ аль ч тохиолдолд, бүрэн ба хувь тэнцүүлсэн тэтгэвэр нь НДС-аас олгох өндөр насны тэтгэврийн доод хэмжээ (бүрэн тэтгэвэр 230,000 төгрөг, хувь тэнцүүлсэн тэтгэвэр 195,000 төгрөг)-нээс бага байх ёсгүй.

**Тэжээгчээ алдсаны тэтгэвэр:** Даатгуулагчийн асрамжид байсан гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүдийн тоог харгалзан тэжээгчээ алдсаны тэтгэврийг тогтооно:

- Нэг тэжээлгэгч бол даатгуулагчийн тэтгэвэр авах орлого дээр үндэслэн тооцсон өндөр насны бүрэн тэтгэврийн хэмжээний 50 хувь,
- Хоёр тэжээлгэгчбол 75 хувь,
- Гурав ба түүнээс дээш тэжээлгэгч бол 100 хувь.

Гэхдээ тэтгэврийн доод хэмжээ нь тэжээлгэгчийн тооноос хамааран хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ(2013 онд 192,000 төгрөгөөр тогтоогдсон)- ний 50-100 хувьтай тэнцүү байна.

**Тэтгэвэр авах эрх** **Тахир дутуугийн тэтгэвэр:** Тэтгэврийн даатгалын шимтгэлийг нийтдээ 20-иос доошгүй жил, эсхүл тахир дутуу болохын өмнөх 5 жилийн 3 жилд нь төлсөн даатгуулагч ердийн өвчин, ахуйн ослын улмаас хөдөлмөрийн чадвараа байнга буюу удаан хугацаагаар алдаж тахир дутуу болсон бол тахир дутуугийн тэтгэвэр тогтоолгон авах эрхтэй.

**Тэжээгчээ алдсаны тэтгэвэр:** 20-иос доошгүй жил шимтгэл төлсөн, эсвэл нас барахын өмнөх 5 жилийн 3 жилд нь шимтгэл төлсөн тэжээгч ердийн өвчин, ахуйн ослын улмаас нас барвал түүний асрамжид байсан гэр бүлийн гишүүд (эхнэр, нөхөр, 16 нас хүрээгүй хүүхэд зэрэг).

|                         |                                                                                          |
|-------------------------|------------------------------------------------------------------------------------------|
| <b>Хамралт</b>          | 2013 онд албан журмын даатгалд 766,815 хүн; сайн дурын даатгалд 147,100 хүн даатгуулжээ. |
| <b>Тэтгэвэр авагчид</b> | 2013 онд 22,500 тэжээгчээ алдагч (насаар ангилаагүй) тэтгэвэр авсан байна.               |

### Цэргийн албан хаагчдын тэтгэвэр, тэтгэмжийн тогтолцоо

|                             |                                                                                                                                                                                                                                                         |
|-----------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| <b>Хууль эрх зүйн орчин</b> | Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 4.1 дэх заалт (1994 оны 6-р сарын 13)                                                                                                                                                         |
| <b>Зорилтот бүлэг</b>       | Зэвсэгт хүчин, хилийн цэрэг, тагнуул, цагдаа, шүүхийн шинжилгээний болон авлигатай тэмцэх, онцгой байдлын асуудал эрхэлсэн болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын генерал, офицер, ахлагч, түрүүч, байлдагч, цэрэг, цагдаагийн сургуулийн сонсогч |

|                          |                                                                                                                                                                                                                                                                                                                                          |
|--------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| <b>Тэтгэвэр, тэтгэмж</b> | Цэргийн тэтгэвэр, тэтгэмжийг нийгмийн даатгалын байгууллагаар дамжуулан олгодог бөгөөд дараах төрөлтэй байна: цэргийн алба хаасны тэтгэвэр (дэлгэрэнгүйг баталгаа 4-өөс харна уу), хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр, тэжээгчээ алдсаны тэтгэвэр, жирэмсний ба амаржсаны тэтгэмж, ХЧТА-ны тэтгэмж, нас барагчийн ар гэрт олгох тэтгэмж |
|--------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|

**Жирэмсний болон амаржсаны тэтгэмж:** Цэргийн албан хаагч эхэд сүүлийн 12 сард авсан цалин хөлсний дунджаас 100 хувиар тооцож 4 сарын хугацаанд олгоно.

**ХЧТА-ны тэтгэмж:** Тэтгэмжийг алба хаасан хугацаанаас хамааран дор дурдсан хувь хэмжээгээр бодож олгоно:

- 5 хүртэлх жил цэргийн алба хаасан бол хөдөлмөрийн хөлсний 50 хувь;
- 5 - 14 жил бол 60 хувь,
- 15 түүнээс дээш жил 80 хувь.

**Нас барагчийн ар гэрт олгох тэтгэмж:** 620,000 төгрөг (2014)

**Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр:** Тэтгэврийн хэмжээ нь хөдөлмөрийн чадвар алдалтын хувиас хамааран сүүлийн 20 жилийн доторх дараалсан 5 жилийн дундаж цалин хөлсний 10-60 хувийн хооронд байна.

**Тэжээгчээ алдсаны тэтгэвэр:** Тэжээгчээ алдсаны тэтгэврийн хэмжээг албан хаагчийн асрамжид байсан гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүдийн тоог харгалзан сүүлийн 20 жилийн доторх дараалсан 5 жилийн дундаж цалингийн хувиар бодож тооцно. Хөдөлмөрийн чадваргүй гишүүд нь эхнэр, нөхөр, эсвэл хүүхэд байж болно:

- 3 ба түүнээс дээш тэжээлгэгч бол 100 хувь,
- 2 тэжээлгэгч бол 75 хувь,
- 1 тэжээлгэгч бол 50 хувь, ажил үүргээ гүйцэтгэхтэй холбоотой шалтгаанаар нас барсан бол 10-15 хувиар нэмэгдүүлж олгоно.

|                          |                                                                                                    |
|--------------------------|----------------------------------------------------------------------------------------------------|
| <b>Тэтгэвэр авах эрх</b> | Цэргийн албан хаагч эрэгтэй 25-аас доошгүй жил, эмэгтэй 20-оос доошгүй жил алба хаасан байх ёстой. |
|--------------------------|----------------------------------------------------------------------------------------------------|

|                   |             |
|-------------------|-------------|
| <b>Санхүүжилт</b> | Улсын төсөв |
|-------------------|-------------|

1994, 1999 онд тус тус батлагдсан хуулиудын тахир дутуугийн болон тэжээгчээ алдсаны тэтгэвэртэй холбоотой зохицуулалтыг Хүснэгт 11-т харьцуулан үзүүлэв.

**Хүснэгт 11: 1994 ба 1999 онд батлагдсан хуулиудын тахир дутуугийн болон тэжээгчээ алдсаны тэтгэвэртэй холбоотой зохицуулалтыг харьцуулсан байдал**

|                                 | Цалинд суурилсан тэтгэврийн тогтолцоо (ЦСТТ)<br>(1960 оноос өмнө төрсөн иргэд)                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                  | Шимтгэлд суурилсан тэтгэврийн тогтолцоо буюу нэрийн дансны тогтолцоо (НДТ)<br>(1960 оноос хойш төрсөн иргэд)                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                 |
|---------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| <b>Тахир дутуугийн тэтгэвэр</b> |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                 |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                              |
| <b>Тэтгэврийн хэмжээ</b>        | <p>75, түүнээс дээш хувиар хөдөлмөрийн чадвараа алдаж тахир дутуу болсон бол тэтгэврийг хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын 45 хувиар бодож, 20-иос илүү шимтгэл төлсөн жил тутамд 1.5 хувиар нэмэгдүүлнэ.</p> <p>50 ба түүнээс доошгүй хувиар хөдөлмөрийн чадвараа алдаж тахир дутуу болсон бол тэтгэврийг хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын 45 хувиар бодож, 20-иос илүү шимтгэл төлсөн жил тутамд 1.5 хувиар нэмэгдүүлсэн дүнгээс хөдөлмөрийн чадвар алдалтын хувиар тооцож бодно.</p> <p>Бүрэн ба хувь тэнцүүлсэн тэтгэвэр нь өндөр насны тэтгэврийн доод хэмжээнээс багагүй байна.</p> <p>Өндөр насны тэтгэвэр нь тахир дутуугийн тэтгэврээс доогуур байх юм бол, тухайн хүн тэтгэвэрт гарах насандаа тахир дутуугийн тэтгэврээ үргэлжлүүлэн авах эрхтэй.</p> <p>ҮОМШӨ-ий улмаас тахир дутуу болоогүй, энд дурдсан болзол хангаагүй хүн нийгмийн халамжийн тэтгэвэр авах эрхтэй болно.</p> | <p>Хөдөлмөрийн чадвараа бүрэн алдаж тахир дутуу болсон бол тэтгэврийг сүүлийн гурван жилийн сарын дундаж хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын 60 хувиар, хөдөлмөрийн чадвараа хагас алдаж тахир дутуу болсон бол тэтгэврийг сүүлийн гурван жилийн сарын дундаж хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын 60 хувиар бодсон дүнгээс хөдөлмөрийн чадвар алдалтын хувиар тооцно.</p> <p>Тахир дутуугийн тэтгэврийн доод хэмжээ нь өндөр насны тэтгэврийн доод хэмжээтэй тэнцүү байна.</p> |
| <b>Шимтгэл төлөх хугацаа</b>    | 50-иас доошгүй хувиар хөдөлмөрийн чадвараа алдаж тахир дутуу болсон 20-иос доошгүй жил, эсхүл тахир дутуу болохын өмнөх 5 жилийн 3 жилд нь тэтгэврийн даатгалын шимтгэлийг төлсөн байна.                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                        |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                              |

| Тэжээгчээ алдсаны тэтгэвэр |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                       |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                  |
|----------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Тэтгэврийн хэмжээ          | 3 ба түүнээс дээш тэжээлгэгчид даатгуулагчийн тэтгэвэр бодох хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлого дээр үндэслэн өндөр насны бүрэн тэтгэврийн хэмжээний 100 хувь; 2 тэжээлгэгчид 75 хувь, 1 тэжээлгэгчид 50 хувьтай тэнцэх тэтгэвэр олгоно. Тэжээгчээ алдсаны тэтгэврийн доод хэмжээ нь тэжээлгэгчийн тооноос хамааран хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ (2013 онд 192,000 төгрөгөөр тогтоогдсон)- ний 50-100 хувьтай тэнцүү байна. | Хөдөлмөрийн чадваргүй 1 гишүүнд сүүлийн гурван жилийн сарын дундаж хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын 40 хувиар, хэрэв хөдөлмөрийн чадваргүй 2 ба 3-аас дээш гишүүнтэй бол гишүүн тус бүрт 10 хувиар нэмэгдүүлж тооцно. Тэтгэврийн хэмжээ нь сүүлийн 3 жилийн сарын дундаж хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын 60 хувиас хэтрэхгүй байна; Тэтгэврийн доод хэмжээ нь өндөр насны доод тэтгэвэртэй адил байх ёстой. |
| Шимтгэл төлөх хугацаа      | Ердийн өвчин, ахуйн ослын улмаас нас барсан даатгуулагч 20-иос доошгүй жил шимтгэл төлсөн, эсвэл нас барахын өмнөх 5 жилийн 3 жилд нь шимтгэл төлсөн байх                                                                                                                                                                                                                                                                             |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                  |

Эх үүсвэр: Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль, 1994; Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хууль, 1999.

### Одоогийн тогтолцоо: Хөдөлмөрийн насны хүмүүст зориулсан (шимтгэлгүй) нийгмийн хамгааллын хөтөлбөрүүд

Дараах тэтгэвэр, тэтгэмжийг нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллагуудаар дамжуулан олгодог.

#### Жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхийн тэтгэмж

|                      |                                                                                                                                                                                                                                                                 |
|----------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Хууль эрх зүйн орчин | Нийгмийн халамжийн тухай хуулийн 13.1.4, 13.7 ба 13.8 дахь хэсэг (2012 оны 1 дүгээр сарын 19); УИХ-ын 2012 оны 19 дүгээр тогтоол                                                                                                                                |
| Зорилтот бүлэг       | Бүх жирэмсэн эмэгтэйчүүд, нярай хүүхэдтэй эхчүүд                                                                                                                                                                                                                |
| Тэтгэмж авах эрх     | Нийгмийн даатгалд шимтгэл төлсөн эсэхээс үл хамааран Монгол улсын бүх эмэгтэйчүүд хамрагдах эрхтэй.                                                                                                                                                             |
| Тэтгэмж              | Жирэмсний тав дахь сараас эхлэн 12 сарын хугацаанд сар бүр 40,000 төгрөг (23.5 ам.доллар). Хэрэв эх хүүхдээ төрүүлсний дараа нас барсан бол уг хүүхдийн эцэг, эсхүл хууль ёсны асран хамгаалагч, үрчилж авсан эх /эцэг/ нь тэтгэмжийг үргэлжлүүлэн авах эрхтэй. |
| Санхүүжилт           | Улсын төсвөөс санхүүждэг нийгмийн халамжийн сан                                                                                                                                                                                                                 |
| Хамралт              | 2013 онд 94,882 хүн хамрагджээ.                                                                                                                                                                                                                                 |

#### Нийгмийн халамжийн сангаас олгох хөгжлийн бэрхшээлтэй иргэний тэтгэвэр

|                      |                                                                                                                                         |
|----------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Хууль эрх зүйн орчин | Нийгмийн халамжийн тухай хуулийн 12.1.3 ба 12.1.2 дахь заалтууд (2012 оны 1 дүгээр сарын 19); Засгийн газрын 2012 оны 81 дүгээр тогтоол |
| Зорилтот бүлэг       | Хөдөлмөрийн чадвараа 50 ба түүнээс дээш хувиар алдсан 16 насанд хүрсэн хөгжлийн бэрхшээлтэй иргэн; 16 насанд хүрсэн одой иргэн;         |

|                          |                                                                                                                                                                                                                                         |
|--------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| <b>Тэтгэвэр авах эрх</b> | Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авах эрх үүсээгүй (өөрөөр хэлбэл, нийгмийн даатгалын санд огт шимтгэл төлж байгаагүй, эсвэл гурваас доош жил шимтгэл төлсөн) иргэд авах боломжтой.                                                  |
| <b>Тэтгэвэр</b>          | Тэтгэврийн хэмжээг амьжиргааны өртгийн өсөлттэй уялдуулан индексжүүлдэггүй харин тухай бүр шинэчлэн тогтоодог. 2015 оны 2 дугаар сарын 1-ний өдрөөс тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлж, сард 115,000 төгрөг байсныг 126,500 төгрөг болгосон. |
| <b>Санхүүжилт</b>        | Улсын төсвөөс санхүүждэг нийгмийн халамжийн сан                                                                                                                                                                                         |
| <b>Хамралт</b>           | 2013 онд 44,209 хөгжлийн бэрхшээлтэй иргэн, 164 одой иргэн <sup>27</sup> уг тэтгэврийг авчээ.                                                                                                                                           |

#### Хүснэгт 12. Нийгмийн халамжийн бусад мөнгөн тусламж (2013)

| Төрөл                              | Хууль эрх зүйн орчин                                                                                                                                        | Зорилтот бүлэг/Эрх үүсэх нөхцөл                                                                                                                                       | Тэтгэмж, тусламж                                        | Хамралт                                                                                          |
|------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------|
| Ядуу өрхийн гишүүдэд олгох тэтгэмж | Нийгмийн халамжийн тухай хуулийн 13.3 дахь хэсэг (2012.01.19)                                                                                               | Өрхийн мэдээллийн нэгдсэн санд орсон, орлогыг орлуулан тооцох аргаар тодорхойлсон амьжиргааны түвшин нь босго онооноос доогуур өрхөөс сонгогдсон өрхийн гишүүн-иргэн  | Сард 48,000 төгрөг                                      | Орлогыг орлуулан тооцох аргаар өрхийн хэрэглээг тодорхойлдог хөтөлбөр. Хэрэгжиж эхлээгүй байгаа. |
| Онцгой тохиолдлын тэтгэмж          | Нийгмийн халамжийн тухай хуулийн 13.5.1 дэх заалт (2012.01.19)                                                                                              | Гэнэтийн аюул, осол, урьдчилан төсөөлөх боломжгүй бусад шалтгаанаар гэр оронгүй, гэр орон нь цаашид амьдрах боломжгүй болсон болон амьжиргааны эх үүсвэрээ алдсан өрх | Нэг удаа 1,200,000 төгрөг                               | 602 өрхийн 815 хүн                                                                               |
| Амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж   | Нийгмийн халамжийн тухай хуулийн 13.5.2 - 13.5.5 дахь заалтууд (2012.01.19)                                                                                 | 18 нас хүрээгүй байхдаа бүтэн өнчин болсон 18-24 насны иргэн; хорих ангиас суллагдсан өөрийн гэр оронгүй иргэн; гэр оронгүй тэнэмэл өрх, иргэн                        | Нэг удаа 1,200,000 төгрөг                               | 403 хүн                                                                                          |
| Тусламж, хөнгөлөлт                 | Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуулийн 5.1.2 ба 5.1.4 дэх заалтууд (2005.12.08); Засгийн газрын тогтоол 2012 оны 153 дугаар тогтоол | Хөгжлийн бэрхшээлтэй иргэд                                                                                                                                            | 15 төрлийн тусламж, хөнгөлөлт, нөхөн олговрын үйлчилгээ | 37,300 хүн <sup>1</sup>                                                                          |

<sup>27</sup> ХАХНХЯ-ны Тайлан сэтгүүл 2013

|                                                                                             |                                                                                                                                                             |                                                                                                                                       |                                                                                                                                                                                                                                                                     |                                                                           |
|---------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------|
| Байнгын асаргаа шаардлагатай иргэний асрагчид олгох тэтгэмж                                 | Нийгмийн халамжийн тухай хуулийн 13.2.4 дэх заалт (2012.01.19)                                                                                              | Эмнэлгийн хяналтад байдаг, байнгын асаргаа шаардлагатай ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд ба иргэнийг асарч байгаа иргэн | Сард 48,000 төгрөг (2015 оны 2 дугаар сарын 1-нээс тэтгэврийн хэмжээг 58000 төгрөг болгосон)                                                                                                                                                                        | Хөгжлийн бэрхшээлтэй 16,800 хүн (нэмээд 16,800 өндөр настан) <sup>2</sup> |
| Гэр бүлийн байнгын асаргааны тэтгэмж                                                        | Нийгмийн халамжийн тухай хуулийн 13.2.3 дахь заалт (2012.01.19)                                                                                             | Тэжээн тэтгэх хүүхэдгүй, ганц бие ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй ганц бие иргэнийг гэр бүлдээ авч асрамжилж байгаа иргэн     | Сард 48,000 төгрөг (2015 оны 2 дугаар сарын 1-нээс тэтгэврийн хэмжээг 58000 төгрөг болгосон)                                                                                                                                                                        | 239 хөгжлийн бэрхшээлтэй иргэд, 154 өндөр настан                          |
| Хүнс, тэжээлийн дэмжлэг                                                                     | Нийгмийн халамжийн тухай хуулийн 22-р зүйл (2012.01.19)                                                                                                     | хүнсний хангамж зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэн, гэр оронгүй, тэнэмэл амьдралтай иргэн                                      | Хүнсний талон – 2014 онд сар бүр том хүнд 10,000 төгрөг (2015 оны 1 дүгээр сарын 1-нээс 13,000 төгрөг)                                                                                                                                                              | 97,919 хүн хамрагдсан, үүнээс 47,548 том хүн байна.                       |
| Амьдралын нөхцөлийг сайжруулах мөнгөн тэтгэмж (2013 оны 6 дугаар сарын 1-ээс олгож эхэлсэн) | Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2013 оны 3 дугаар сарын 29-ний өдрийн 42 дугаар зарлиг; Засгийн газрын 2013 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн 168 дугаар тогтоол | Тайгад амьдардаг цаатан өрхийн гишүүд (үндэсний цөөнх)                                                                                | Насанд хүрсэн хүнд амьжиргааны доод түвшин(АДТ)-ий тэнцэх (100 хувь) хэмжээний тэтгэмжийг (2013 оны 6 дугаар сарын 1-нээс эхлэн) сар бүр олгож байна. АДТ-г ҮСХ-ноос 2013 онд бүсийн ялгавартайгаар сард 130,500 -149,900 төгрөгийн хооронд тогтоосон. <sup>3</sup> | 94 өрхийн 339 хүн                                                         |

<sup>1</sup> Монгол Улсын статистикийн эмхэтгэл 2013, ҮСХ

<sup>2</sup> ХАХНХЯ-ны Тайлан сэтгүүл 2013

<sup>3</sup> 2015 оны хүн амын амьжиргааны доод түвшин: Сард бүсээр 160,800-185,400 төгрөг байна. Хамгийн өндөр нь Улаанбаатар хотын бүс.

## Нийгмийн халамжийн бусад төрөл: Хөдөлмөрийн насны хүн амд зориулсан олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ

|                             |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                      |
|-----------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| <b>Зорилтот бүлэг</b>       | Хөгжлийн бэрхшээлтэй иргэн; хүчирхийлэлд өртсөн иргэн; хорих ангиас суллагдсан иргэн; согтууруулах, мансуурах донтох өвчтэй иргэн; эдгэшгүй хүнд өвчтэй хүн; гэр оронгүй тэнэмэл амьдралтай өрх, иргэн; шилжин суурьшсан өрхийн гишүүн-иргэн; өрх толгойлсон эх /эцэг/                                                                                                                                                                                                                               |
| <b>Үйлчилгээ</b>            | Гэр оронгүй иргэн, түүний гэр бүлийн гишүүдийн амьдрах итгэлийг нэмэгдүүлэх, нийгэмшүүлэх, бичиг баримтжуулах, түр хоноглох байранд байрлуулах; нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрх, иргэнийг нийгэмшүүлэх, хамт олны бүлэг бүрдүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох төсөл хэрэгжүүлэх, амьдрах ухаанд сургах, зөвлөгөө өгөх; сэргээн засах үйлчилгээнд хамруулах; түр байрлуулан асрамжлах; өдрийн үйлчилгээнд хамруулах; гэрийн асрамж, халамжийн үйлчилгээнд хамруулах; |
| <b>Санхүүжилт</b>           | Орон нутгийн төсөв (2013 оноос)                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                      |
| <b>Санхүүжүүлэх үйл явц</b> | Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд шаардагдах хөрөнгийг сум, хорооны Амьжиргааг дэмжих зөвлөлийн саналыг үндэслэн аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага тооцож, орон нутгийн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.                                                                                                                                                                                                                           |
| <b>Хамралт</b>              | 2014 онд 8,700 хүн хамрагдсан байна.                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                 |

## Хөдөлмөрийн зах зээлийн идэвхтэй хөтөлбөрүүд

Хөдөлмөрийн зах зээлийн идэвхтэй арга хэмжээ нь дараах хоёр зорилгод чиглэсэн хөтөлбөрүүдээс бүрдэнэ: 1) хөдөлмөр эрхлэх үр чадварыг сайжруулах; 2) хөдөлмөр эрхлэлтийг дэмжих. Бүх хөтөлбөр, түүнчлэн хөдөлмөр эрхлэлтийн албадын хүргэх үйлчилгээ, чиг үүргийг Хөдөлмөрийн яамнаас боловсруулж, санхүүжүүлэх ба аймаг, сумын түвшинд орон нутгийн засаг захиргаа хэрэгжүүлнэ. 2012-2014 оны хооронд Хөдөлмөрийн яам эхний зорилгын хүрээнд 2, хоёр дахь зорилгын хүрээнд 8 хөтөлбөр хэрэгжүүлсэн бөгөөд хөтөлбөрүүдийг доор тайлбарлав.

2015 оны 2 дугаар сард Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл (гурван талт байгууллага) нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр(ХЭДХ)-үүдийг хянан үзэж, дараах таван хөтөлбөрийг баталжээ. Үүнд:

1. Хувиараа хөдөлмөр эрхлэгч, нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнийг дэмжих хөтөлбөр;
2. Хөдөлмөр эрхлэлтийн үр чадвар олгох, ажлын байр хадгалах хөтөлбөр;
3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр;
4. Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр;
5. Залуучууд, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын төгсөгчдийн дунд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр

2015 онд эдгээр хөтөлбөрийн санхүүжилтэд 80.3 тэрбум төгрөг хуваарилагджээ.

Энэ тайланд 2013 оны 12 дугаар сараас 2014 оны 9 дүгээр сарын хооронд үндэсний хэлэлцүүлгээр авч үзсэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих 10 хөтөлбөрийн талаарх мэдээллийг тусгалаа.

## Хөдөлмөр эрхлэх үр чадварыг сайжруулах

Төрийн хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ нь мэргэжлийн чиг баримжаа олгох, мэргэжлийн зөвлөгөө өгөх, ажлын байр, үр чадварын эрэлт, нийлүүлэлт зэрэг хөдөлмөрийн зах зээлийн талаарх мэдээлэл цуглуулж дүн шинжилгээ хийхэд дэмжлэг туслалцаа үзүүлдэг. Үүнээс гадна, хөдөлмөр эрхлэлтийн албад нь өөрсдөө мэргэжлийн сургалт явуулдаг.

## Үндэсний мэргэжилтэй ажилтан бэлтгэх хөтөлбөр<sup>28</sup>

|                                   |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                    |
|-----------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| <b>Гол үйл ажиллагаа</b>          | Суралцагчдын бүртгэл (4 талт гэрээ байгуулсан талууд нь ажилгүй иргэн, Засгийн газар, сургалтын үйлчилгээ үзүүлэгч болон ажил олгогч); мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвүүдэд явагдах мэргэжлийн сургалтын 20 хувь нь онол, 80 хувь нь онолын мэдлэгийг практикт хэрэгжүүлэх дадлага туршлага байх ёстой; төгсөгчдийг үнэлэх, ажлын байраар хангах                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                             |
| <b>Зардал</b>                     | Суралцагч нь дараах хангамжийг авна: <ul style="list-style-type: none"><li>• Сар бүрийн тэтгэлэг 190,000 төгрөг</li><li>• Сар бүрийн байрны зардалд 75,000 төгрөг</li><li>• Ажлын хувцасны зардалд 60,000 төгрөг</li></ul> Дадлагын ажлын үед нэмэлт зардалд нэг дадлагын багш(зөвлөх багш, суралцагчийн харьцаа 1:15)-д 312,000 төгрөгийг 3 сарын хугацаанд олгоно. Ажлын байраар хангасан ажил олгогчид суралцагч бүрийн тоогоор 65,000 төгрөг олгодог. 2014 онд нийт 7,215 тэрбум төгрөг зарцуулжээ.                                                                                                                                                                                                                                                                                                                            |
| <b>Хамралт</b>                    | 4,182 хүн суралцан төгсөж, 3,085 нь ажлын байр бий болсноос 2,695 нь байнгын, 390 нь түр ажлын байр байна.                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                         |
| <b>Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөр</b> |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                    |
| <b>Гол үйл ажиллагаа</b>          | <b>Зөвлөгөө өгөх, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох: ажил мэргэжлийн зөвлөгөө өгөх, ярилцлагад бэлтгэх</b>                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                        |
| <b>Зардал</b>                     | Шаардлагатай бичиг баримт болон эрүүл мэндийн үзлэг хийлгэхэд гарсан зардлын нөхөн төлбөр.<br>Нэг хүнд олгох зардлын нөхөн олговрын дээд хэмжээг Хөдөлмөрийн сайд тогтооно. 2014 онд нийт 144.2 сая төгрөг зарцуулжээ.                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                             |
| <b>Хамралт</b>                    | 5,695 хүн хамрагдсан байна.                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                        |
| <b>Гол үйл ажиллагаа</b>          | <b>Хөдөлмөр эрхлэлтийн сургалт</b>                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                 |
| <b>Зардал</b>                     | 2014 онд нийт 1,618.2 тэрбум төгрөг зарцуулжээ.                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                    |
| <b>Хамралт</b>                    | 6,399 хүн                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                          |
| <b>Гол үйл ажиллагаа</b>          | <b>Ажил олгогчдыг дэмжих арга хэмжээ; ажлын байран дээр нь сургаж дадлагуулж, 12 сараас дээш хугацаагаар ажилласан бүтэн цагийн ажилтны практик дадлагын гурав хүртэлх сарын зардлыг нөхөн олгох.</b>                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                              |
| <b>Зардал</b>                     | Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөрт хамрагдсан иргэнийг 12 сараас доошгүй хугацаагаар ажлын байраар хангасан ажил олгогчид хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 12 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний урамшууллыг нэг удаа олгох.<br>Цалингийн дэмжлэг: <ul style="list-style-type: none"><li>• Хэрэв хөдөлмөрийн насанд хүрээд асрамжийн газраас гарсан болон хорих ангиас суллагдсан иргэн бүтэн цагийн ажилд ажлын байран дээрх сургалтаар дамжуулан зуучлагдаад, уг ажлын байрандаа нэгээс дээш жил ажиллаж байгаа бол ажил олгогч болон ажилтанд нэг жилийн цалин олгоно.</li><li>• Хэрэв хөдөлмөрийн насанд хүрээд асрамжийн газраас гарсан болон хорих ангиас суллагдсан иргэн бүтэн цагийн ажилд зуучлагдаад, уг ажлын байрандаа 8-12 сарын хугацаанд ажиллаж байгаа бол ажилтанд нэг жилийн цалингийн 50 хувийг олгоно.</li></ul> |
| <b>Хамралт</b>                    | 487 ажил олгогч                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                    |

<sup>28</sup> Хөдөлмөрийн яамны мэдээлэл, 2014

## Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүд

2012 оны 1 дүгээр сараас хойш Хөдөлмөрийн яам i) хөгжлийн бэрхшээлтэй иргэд(ХБИ), хувиараа хөдөлмөр эрхлэгчид, малчид, нөхөрлөл болон хоршоо байгуулах иргэд; ii) ажил олгогчдод чиглэсэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилтот хэд хэдэн хөтөлбөр, түүнчлэн iii) Эзэнтэй Монгол хөтөлбөрийг хэрэгжүүлж байна.

2014 онд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих найман хөтөлбөр хэрэгжсэн байна. Үүнд:

40-өөс дээш насны иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр

|                          |                                                                                                                                                                                     |
|--------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| <b>Гол үйл ажиллагаа</b> | Төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ тариалах төсөл                                                                                                                                   |
| <b>Зардал</b>            | 2014 онд нийт 527.1 сая төгрөг                                                                                                                                                      |
| <b>Хамралт</b>           | 1,286 хүн                                                                                                                                                                           |
| <b>Гол үйл ажиллагаа</b> | Иргэдийн эргүүл, байгаль хамгаалах, нөхөн сэргээх, осол гэмтлээс сэргийлэхэд бүлгээр ажиллуулах төсөл                                                                               |
| <b>Зардал</b>            | 1-3 хүнтэй нэг бүлэг, нэг бүлэг 4 сарын хугацаатай, урамшуулал нэг сард нэг бүлэгт 200,000 төгрөг. 2014 онд нийт 539.6 сая төгрөг зарцуулжээ.                                       |
| <b>Хамралт</b>           | 2,097 хүн                                                                                                                                                                           |
| <b>Гол үйл ажиллагаа</b> | Ерөнхий боловсролын сургуулийн орчимд явган хүний гарц зохицуулах төсөл                                                                                                             |
| <b>Зардал</b>            | Зөвхөн нийслэл Улаанбаатар хотод, 1-3 хүнтэй нэг бүлэг, найман сараас доошгүй хугацаанд, урамшуулал нэг сард нэг бүлэгт 200,000 төгрөг<br>2014 онд нийт 84.3 сая төгрөг зарцуулжээ. |
| <b>Хамралт</b>           | 458 хүн                                                                                                                                                                             |

## Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр

|                          |                                                                                                                                                                                                                                                                                                                                          |
|--------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| <b>Гол үйл ажиллагаа</b> | <b>Залуу малчдыг малжуулах</b>                                                                                                                                                                                                                                                                                                           |
| <b>Зардал</b>            | Гурван жилийн хугацаанд зээлийн 50.0 хувийг эргэн төлөх нөхцөлтэйгөөр нэг өрхөд нэг удаа 5,000,000 хүртэлх төгрөг<br>2014 онд нийт 2,906 сая төгрөг зарцуулжээ.                                                                                                                                                                          |
| <b>Хамралт</b>           | 1,492 залуу малчин                                                                                                                                                                                                                                                                                                                       |
| <b>Гол үйл ажиллагаа</b> | <b>Малчин -ажил олгогчид санхүүгийн дэмжлэг үзүүлэх:</b><br>Малчин ажил олгогч нь малгүй болон цөөн малтай иргэнийг туслах малчнаар ажиллуулж, 12 сараас доошгүй хугацаанд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс багагүй цалин хөлс олгож, мал маллагааны арга туршлагаа зааж сургах ёстой. Ажил олгогч нь жилд 10 хүртэлх тооны мал авна. |
| <b>Зардал</b>            | Нэг удаа 1,000,000 хүртэлх төгрөгийн тэтгэлэг<br>2014 онд нийт 40 сая төгрөг зарцуулжээ.                                                                                                                                                                                                                                                 |
| <b>Хамралт</b>           | 40 малчин-ажил олгогч                                                                                                                                                                                                                                                                                                                    |
| <b>Гол үйл ажиллагаа</b> | <b>Сургалт, танилцах аялал, үүлзалт, үзэсгэлэн яармаг зохион байгуулах,</b>                                                                                                                                                                                                                                                              |
| <b>Зардал</b>            | 2014 онд нийт 442.4 сая төгрөг зарцуулжээ.                                                                                                                                                                                                                                                                                               |
| <b>Хамралт</b>           | 1,101 малчин                                                                                                                                                                                                                                                                                                                             |

### Аж ахуй эрхлэлтийг хөгжүүлэх хөтөлбөр

|                          |                                                                                                                                                                                                                                                                                |
|--------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| <b>Гол үйл ажиллагаа</b> | <b>Дараах иргэдийн төсөлд санхүүгийн дэмжлэг үзүүлнэ:</b> <ul style="list-style-type: none"><li>• 40-өөс дээш насны иргэд</li><li>• Ажил олоход хүндрэлтэй иргэд</li><li>• Бизнес эхлүүлж буй, албан бус салбараас албан салбарт шилжсэн хувиараа хөдөлмөр эрхлэгчид</li></ul> |
| <b>Зардал</b>            | Нэг хүнд 1,000,000 төгрөг<br>2014 онд нийт 1,564.9 тэрбум төгрөг зарцуулжээ.                                                                                                                                                                                                   |
| <b>Хамралт</b>           | 1,417 хүн                                                                                                                                                                                                                                                                      |
| <b>Гол үйл ажиллагаа</b> | <b>Бизнес инкубацийн үйлчилгээ үзүүлэх</b>                                                                                                                                                                                                                                     |
| <b>Зардал</b>            | 2014 онд нийт 1,052.6 тэрбум төгрөг                                                                                                                                                                                                                                            |
| <b>Хамралт</b>           | 8,658 хүн                                                                                                                                                                                                                                                                      |

### Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр

|                          |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                           |
|--------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| <b>Гол үйл ажиллагаа</b> | <b>Ур чадварын сургалт</b>                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                |
| <b>Зардал</b>            | 2014 онд 83.3 сая төгрөг                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                  |
| <b>Хамралт</b>           | 1,022 хүн                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                 |
| <b>Гол үйл ажиллагаа</b> | <b>ХБИ-д аж ахуй эрхлэхэд нь санхүүгийн дэмжлэг үзүүлэх</b>                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                               |
| <b>Зардал</b>            | Урамшуулал: ХБИ-ийг ажлын байраар хангаж, 12 сараас дээш хугацаанд ажиллуулсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 12 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний урамшууллыг нэг удаа олгоно.<br>Санхүүгийн дэмжлэг: ХБИ-ний онцлог, мэргэжлийн ур чадварт нийцсэн 8 буюу түүнээс дээш байнгын тусгайлсан шинэ ажлын байр бий болгохоор боловсруулсан төслийн шалгаруулалт дээр үндэслэн, нэг ажлын байранд 5 сая төгрөг (нийт 50 хүртэл сая төгрөг)<br>2014 онд 97.8 сая төгрөг зарцуулжээ. |
| <b>Хамралт</b>           | Хөгжлийн бэрхшээлтэй 129 иргэнд 45 ажил олгогч ажил олгосон байна.                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                        |
| <b>Гол үйл ажиллагаа</b> | <b>ХБИ-дийг ажлын байраар хангаж буй ажил олгогчдод дэмжлэг үзүүлэх (1)</b>                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                               |
| <b>Зардал</b>            | Нэг ажлын байранд 1 сая хүртэлх төгрөг; ХБИ-ийн бизнесийн төслийг шалгаруулж, нийтдээ 5 сая төгрөгийг нэг удаа олгоно.<br>2014 онд 1,244.3 тэрбум төгрөг зарцуулжээ.                                                                                                                                                                                                                                                                                                                      |
| <b>Хамралт</b>           | 1,455 хүн                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                 |
| <b>Гол үйл ажиллагаа</b> | <b>ХБИ-дийг ажлын байраар хангаж буй ажил олгогчдод дэмжлэг үзүүлэх (2)</b>                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                               |
| <b>Зардал</b>            | Санхүүгийн дэмжлэг: ХБИ-ний онцлог, мэргэжлийн ур чадварт нийцсэн 8 буюу түүнээс дээш байнгын тусгайлсан шинэ ажлын байр бий болгохоор боловсруулсан төслийн шалгаруулалт дээр үндэслэн, нэг ажлын байранд 5 сая төгрөг (нийт 50 хүртэл сая төгрөг) 2014 онд нийт 300 сая төгрөг зарцуулжээ.                                                                                                                                                                                              |
| <b>Хамралт</b>           | 100 ажил олгогч                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                           |

### Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр

|                          |                                                                                                                                                              |
|--------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| <b>Гол үйл ажиллагаа</b> | <b>“Сумын залуус” төсөл:</b> сум, алслагдсан суурин газрын иргэдэд төрийн үйлчилгээ үзүүлэх, тухайн орон нутгийн хөгжлийн үйл ажиллагаанд хувь нэмэр оруулах |
| <b>Зардал</b>            | Төсөлд хамрагдаж, ажлын 21 өдөр ажилласан оролцогч тус бүрт 200,000 төгрөгийн урамшууллыг нэг удаа олгоно. 2014 онд нийт 403.6 сая төгрөг зарцуулжээ.        |
| <b>Хамралт</b>           | 1,978 хүн                                                                                                                                                    |

**Гол үйл ажиллагаа** “Ажлын гараа” төсөл: орон нутгийн засаг захиргаа, иргэний хөрөнгөөр өвөлжилтийн бэлтгэл, жишиг өвөлжөө барих, мал төллөлт, хадлан тэжээл бэлтгэх, ургац хураалтын ажилд залуучуудыг оролцуулах

**Зардал** Төсөлд хамрагдаж, ажлын 21 өдөр ажилласан оролцогч тус бүрт 200,000 төгрөгийн урамшууллыг нэг удаа олгоно.  
2014 онд нийт 1,485.7 тэрбум төгрөг зарцуулжээ.

**Хамралт** 7,311 хүн

**Гол үйл ажиллагаа** Уул уурхай, зам, барилга болон бусад салбарт **оюутан залуусыг** зуны амралтаар нь ажиллуулж, **орлого олоход нь дэмжлэг үзүүлэх**

**Зардал** 10-15 оюутан, залуучуудын багийн гишүүн бүрт дээр дурдсан эдийн засгийн салбаруудад ажлын 21 өдрөөс доошгүй хугацаанд ажилласан бол 200,000 төгрөгийг урамшууллыг нэг удаа олгоно.  
2014 онд нийт 198.8 сая төгрөг зарцуулжээ.

**Хамралт** 914 хүн

### “Эзэнтэй Монгол” хөтөлбөр

**Гол үйл ажиллагаа** **Орон нутгийн нийтийг хамарсан ажилд 10 –аас доошгүй ажлын өдөр цалинтай ажиллуулах**

**Зардал** Нэг хүнд нэг өдрийн цалинд 14,000 төгрөг, дээрээс нь нэг хүнд ажлын багаж хэрэгсэлд нэг удаагийн төлбөр 10,000 төгрөг. 2014 онд нийт 2,251.6 тэрбум төгрөг зарцуулжээ.

**Хамралт** 17,299 хүн

**Гол үйл ажиллагаа** **Орон нутгийн засаг захиргаанаас зохион байгуулж буй ногоон ажилд 10 –аас доошгүй ажлын өдөр цалинтай ажиллуулах**

**Зардал** Нэг хүнд нэг өдрийн цалинд 14,000 төгрөг, дээрээс нь нэг хүнд ажлын багаж хэрэгсэлд нэг удаагийн төлбөр 10,000 төгрөг. 2014 онд нийт 2,080.3 тэрбум төгрөг зарцуулжээ.

**Хамралт** 8,030 хүн

### Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ төсөл

**Гол үйл ажиллагаа** **Аймаг, сум, дүүрэг, хорооны хэрэгцээт онцлогийг тусгасан ажилд зөвлөгөө мэдээлэл өгч ажиллах ахмад мэргэжилтний баг** (3-аас доошгүй гишүүнтэй, дор хаяж 3 сарын хугацаанд, нэг сард 56 ажлын цаг ажиллах)

**Зардал** Нэг багт 1,000,000 төгрөг  
2014 онд нийт 984.7 сая төгрөг зарцуулжээ.

**Хамралт** 3,030 хүн

**Гол үйл ажиллагаа** **Ахмадын төрийн бус байгууллагаар зөвлөх үйлчилгээг гэрээний үндсэн дээр зохион байгуулах** (зөвхөн УБ хотод хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний төв нь төслийн шалгаруулалт дээр үндэслэн ажлыг эхлэхэд санхүүжилтийн 70 хувийг, ажлаа гүйцэтгэсэн нөхцөлд үлдэгдэл 30 хувийг санхүүжүүлнэ)

**Зардал** Мэдээлэл байхгүй

**Хамралт** 272 хүн

### Жижиг дунд үйлдвэр(ЖДҮ)-ийг хөгжүүлэх сан, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан (ХЭДС), Сум хөгжүүлэх сангийн зээл

**Гол үйл ажиллагаа** **Жижиг дунд үйлдвэрийн зээл; Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зээл; Сум хөгжүүлэх сангийн зээл**

**Зардал** Тендерийн журмын дагуу

**Хамралт** 440 хүн жижиг, дунд үйлдвэрийг дэмжих зээлд хамрагдсан бол 5,729 хүн ХЭДС-аас 17.4 тэрбум төгрөгийн зээл авсан байна. ХЭДС-ийн зээлийн үр дүнд 12,915 ажлын байр бий болсон, үүнээс 10193 нь байнгын, 2722 түр ажлын байр байна. Харин 3,386 хүн сум хөгжүүлэх сангийн зээл авч, 5.8 тэрбум төгрөг зарцуулагджээ

Хөдөлмөрийн насны хүн амд зориулсан нийгмийн хамгааллын хөтөлбөрүүдийн мэдээллийг Хүснэгт 13-т нэгтгэн оруулав.

**Хүснэгт 13. Хөдөлмөрийн насны хүн амд зориулсан нийгмийн хамгааллын хөтөлбөрүүдийн хураангуй**

| Хөтөлбөрийн төрөл                                         | Тусламж, дэмжлэг                                                                                                                                                                                                                                                          | Хамралт (2014 оны эцсийн байдлаар)                                                                      |
|-----------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------|
| <b>Нийгмийн даатгалын хөтөлбөрүүд</b>                     |                                                                                                                                                                                                                                                                           |                                                                                                         |
| Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгал | Тахир дутуугийн болон тэжээгчээ алдсаны тэтгэвэр; хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж; үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас рашаан сувилалд эмчлүүлэх, протез, ортопедийн хэрэгсэл хийлгэх зэрэг нөхөн сэргээлттэй холбоотой зардлын нөхөн олговор | ажиллах хүчний 71.7 хувь                                                                                |
| Тэтгэмжийн даатгал                                        | Жирэмсний ба амаржсаны тэтгэмж, ХЧТА-ны тэтгэмж, оршуулгын тэтгэмж                                                                                                                                                                                                        | ажиллах хүчний 71.6 хувь                                                                                |
| Ажилгүйдлийн даатгал                                      | Ажилгүйдлийн тэтгэмж                                                                                                                                                                                                                                                      | 766,815 хүн буюу нийт ажиллах хүчний 60.1 хувь                                                          |
| Тэтгэврийн даатгал                                        | Тахир дутуугийн тэтгэвэр, тэжээгчээ алдсаны тэтгэвэр                                                                                                                                                                                                                      | ажиллах хүчний 71.6 хувь                                                                                |
| Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмж                  | Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр, тэжээгчээ алдсаны тэтгэвэр, жирэмсний ба амаржсаны тэтгэмж, ХЧТА-ны тэтгэмж, нас барагчийн ар гэрт олгох тэтгэмж                                                                                                                     | Мэдээлэл байхгүй.                                                                                       |
| <b>Нийгмийн халамжийн хөтөлбөрүүд</b>                     |                                                                                                                                                                                                                                                                           |                                                                                                         |
| Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж                      | ХБИ-ний тэтгэвэр                                                                                                                                                                                                                                                          | 44,373 хүн сар бүр 115,000 төгрөг (2015 оны 2 дугаар сарын 1-нээс 126,500 төгрөг болж нэмэгдсэн) авчээ. |
| Жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхийн тэтгэмж      | Жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхийн тэтгэмж                                                                                                                                                                                                                      | 94,882 хүн 12 сарын хугацаанд сар бүр 40,000 төгрөг авчээ.                                              |
| Мөнгөн тэтгэмж                                            | Ядуу (нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай) өрхийн гишүүнд олгох тэтгэмж                                                                                                                                                                            | Мэдээлэл байхгүй.                                                                                       |
| Мөнгөн тэтгэмж                                            | Онцгой тохиолдлын тэтгэмж                                                                                                                                                                                                                                                 | 815 хүн нэг удаад 1,200,000 төгрөг авчээ.                                                               |
| Мөнгөн дэмжлэг                                            | 18-24 насны өнчин, гэр оронгүй иргэдэд үзүүлэх амьжиргааны дэмжлэг                                                                                                                                                                                                        | 403 хүн нэг удаад 1,200,000 төгрөг авчээ.                                                               |

|                                                    |                                                                                           |                                                                                                                                    |
|----------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Мөнгөн тусламж, хөнгөлөлт                          | ХБИ-нд үзүүлэх тусламж, хөнгөлөлт                                                         | 37,300 хүн                                                                                                                         |
| Мөнгөн тэтгэмж                                     | Байнгын асаргаатай иргэний асрагчид олгох тэтгэмж                                         | 33,600 хүн нэг сард 48,000 төгрөг (2015 оны 2 дугаар сарын 1-нээс 58,000 төгрөг болж нэмэгдсэн) авчээ.                             |
| Мөнгөн тэтгэмж                                     | Ганц бие ахмад настан, ХБИ-ийг гэр бүлдээ авч асарсны тэтгэмж                             | 393 хүн нэг сард 48,000 төгрөг (2015 оны 2 дугаар сарын 1-нээс 58,000 төгрөг болж нэмэгдсэн) авчээ.                                |
| Хүнс тэжээлийн дэмжлэг                             | Хүнсний талон                                                                             | 47,548 насанд хүрэгч нэг сарын 10,000 төгрөгийн хүнсний талон (2015 оны 2 дугаар сарын 1-нээс 13,000 төгрөг болж нэмэгдсэн) авчээ. |
| Нийгмийн халамжийн үйлчилгээ                       | Хөдөлмөрийн насны хүн амд зориулсан олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ | 8,700 хүн                                                                                                                          |
| Хөдөлмөр эрхлэх үр чадварыг сайжруулах хөтөлбөрүүд |                                                                                           |                                                                                                                                    |
|                                                    | Үндэсний мэргэжилтэй ажилтан бэлтгэх хөтөлбөр                                             | 4,182 хүн                                                                                                                          |
|                                                    | Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөр                                                                | 12,581 хүн                                                                                                                         |
| Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүд             |                                                                                           |                                                                                                                                    |
|                                                    | 40-өөс дээш насны иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр                            | 3,841 хүн                                                                                                                          |
|                                                    | Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр                                               | 2,633 хүн                                                                                                                          |
|                                                    | Аж ахуй эрхлэлтийг хөгжүүлэх хөтөлбөр                                                     | 10,075 хүн                                                                                                                         |
|                                                    | ХБИ-ний ажлын байрыг дэмжих хөтөлбөр                                                      | 2,622 хүн                                                                                                                          |
|                                                    | Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр                                           | 10,203 хүн                                                                                                                         |
|                                                    | “Эзэнтэй Монгол” хөтөлбөр                                                                 | 25,329 хүн                                                                                                                         |
|                                                    | Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ төсөл                                                 | 3,302 хүн                                                                                                                          |
|                                                    | Тусгай сангуудаар дамжуулан авсан зээл                                                    | 9,555 хүн                                                                                                                          |

Эх үүсвэр: НДЕГ, НХҮЕГ, Хөдөлмөрийн яам

## Бодлогын болон хэрэгжүүлэлтийн түвшинд тулгарч буй асуудлууд

### Бодлогын хийдэл

#### Даатгалын бодлого

Малчдын орлого олох үе нь улирлын чанартай байдгаас даатгалын шимтгэлийг сар бүр төлөхөд тохиромжгүй. (Энэ асуудал ҮСҮХ-ийн явцад буюу 2014 оны 1 дүгээр сард шийдвэрлэгдэж, одоо шимтгэлийг улирал, хагас болон бүтэн жилээр урьдчилан төлөх боломжтой болсон).

#### Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж

Бүх төрлийн тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ харьцангуй бага, ялангуяа хугацааны хувьд богино. Тэтгэвэр, тэтгэмж авахад тавигдах шаардлагыг хангахад хүндрэлтэй. Эдгээр хүчин зүйлүүд нь нийгмийн даатгалд хамрагдах эрмэлзлийг бууруулдаг.

#### ҮОМШӨ-ний даатгал

Өвчлөл нь эрхэлж буй ажилтай нь холбоотой эсэхийг шалгаж тогтоох механизм сул, үнэлэх шалгуур байхгүй, түүнчлэн ажилдаа ирэх, ажлаас явах замд гарсан ослын талаарх тодорхойгүй зохицуулалт нь уг даатгалын үр ашигт нөлөөлж байна.

Ажлын байранд гарсан осол нь ажилчны өөрийн буруугаас болсон үед олгох тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг бууруулах зэргээр хариуцлага хүлээлгэх зохицуулалт байхгүй гэдгийг ажил олгогчдын төлөөлөл тэмдэглэж байсан.

ХЧТА-ны тэтгэмж хэтэрхий бага байна. Өөрөөр хэлбэл, ОУХБ-ын 121 дүгээр конвенцийн II жагсаалтад заасан стандарт(эхнэр, хоёр хүүхэдтэй эрэгтэй хүний авч байсан цалингийн 60 хувь)-аас бараг гурав дахин бага байна. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний сангаас тэтгэвэр, тэтгэмж, түслэмж авахаар хандаж буй тохиолдлын тоог илүү үр дүнтэй урьдчилан сэргийлэх бодлого боловсруулан хэрэгжүүлэх замаар бууруулж болно.

#### Жирэмсний болон амаржсаны тэтгэмж

Хэдийгээр төлөх шимтгэлийн хувь хэмжээ нь адилхан ч албан журмаар даатгуулагчид олгодог жирэмсний болон амаржсаны тэтгэмж(өмнөх цалин хөлсний 100 хувь)-ээс сайн дураар даатгуулагчийн тэтгэмжийн хэмжээ (өмнөх цалин хөлсний 70 хувь) бага байна.

#### Ажилгүйдлийн тэтгэмж авах эрх

Ажилгүйдлийн тэтгэмж авахад даатгуулагчийг наад зах нь хоёр жилийн хугацаанд, ялангуяа ажилгүй болохоосоо өмнө есөн сарын турш тасралтгүй нийгмийн даатгалын шимтгэл төлсөн байхыг шаардаж байгаа нь хэтэрхий хатуу нөхцөл бөгөөд ажилгүй болсон олон хүн энэ шалгуурыг хангаж чадахгүй байгаагаас тэтгэмж авч чадахгүй үлдэхэд хүргэж байна.

Ажилгүйдлийн тэтгэмж авах эрх нь даатгуулагчийг эргэж ажилтай болгох, хөдөлмөр эрхлэлтийг нь дэмжихэд чиглэсэн хөтөлбөрүүдтэй үялдаагүй байна.

#### Нийгмийн даатгалын сангаас олгох тахир дутуугийн тэтгэвэр

Тэтгэврийн хэмжээ бага, тохиолдлын чанартай нэмэгдүүлдэг учраас амьжиргааны өртөгийн өсөлттэй уялдуулан автоматаар индексжүүлдэггүй.

Мөнгөн тэтгэмж олгоход л анхаараад ХБИ-ийн хөдөлмөр эрхлэх чадамжийг нь дэмжихэд тус дөхөм болох хөдөлмөр эрхлэлтийн болон нөхөн сэргээх зарим хөтөлбөрүүдтэй уялдуулж чадаагүй.

#### ХЭДХ: Хөдөлмөрт бэлтгэх

Хөтөлбөрт хамрагдахыг хүссэн иргэнд тавигддаг шалгуурын нэг болох ажил хайж эхэлсэн хугацаа(6 сараас дээш)-г 2-3 сараар багасгах шаардлагатай.

|                                                                        |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                      |
|------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| <b>Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих</b>                              | Хөдөө орон нутагт энэ хөтөлбөрийн шаардлага, эрэлт хэрэгцээ их байна. Гэсэн хэдий ч, санхүүжилт хязгаарлагдмал, тавигдах шалгуур хатуу байгаагаас хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэхэд сөргөөр нөлөөлж байж болзошгүй. Малчдын дунд нийгмийн даатгалын тогтолцооны талаарх мэдээлэл дутмаг байна. Жишээ нь, ХЭДХ-т хамруулахдаа нийгмийн даатгалд даатгуулахыг дэмжих зохицуулалт байхгүй байна. Малчид ихэнх татвараас чөлөөлөгддөг учраас нийгмийн даатгалын талаар ойлголт дутмаг, шимтгэл төлөх хүсэл сонирхолгүй байж болох юм. Залуу малчдад онцгой анхаарал хандуулах нь зүйтэй.                                               |
| <b>40-өөс дээш настай иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр</b> | Хөдөлмөрийн яам энэ хөтөлбөрийн дизайныг боловсронгуй болгох, ялангуяа энэ насны хүмүүсийг ажлын арга барилтайгаа дасан зохицоход нь туслах мэргэжлийн сургалтыг сайжруулах хэрэгтэй.                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                |
| <b>Ажил олгогчдыг дэмжих хөтөлбөр</b>                                  | Уг хөтөлбөрийн тавигдах шалгуур нөхцөл хатуу учраас боломжтой ажил олгогчид санхүүгийн дэмжлэг авч чадахгүй байна. Тухайлбал, шинээр ажилд орсон ажилтан тухайн байгууллагад 12 сараас доошгүй хугацаагаар ажилласан байх шалгуур тавьдаг. Үүнийг 6 сараас доошгүй хугацаанд ажиллуулахаар багасгаж болох юм.                                                                                                                                                                                                                                                                                                                        |
| <b>Санхүүгийн дэмжлэг үзүүлэх хөтөлбөрүүд</b>                          | Аж ахуй эрхлэхэд зориулж зээл олгох замаар санхүүгийн дэмжлэг үзүүлэх хөтөлбөрүүдийн зүгээс тэдгээрт хамрагдаж буй ХБИ, малчдын бизнес эрхлэх үр чадварыг хөгжүүлэхэд чиглэсэн дэмжлэг үзүүлдэггүй.                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                  |
| <b>Хэрэгжүүлэлтийн түвшинд гарч буй асуудлууд</b>                      |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                      |
| <b>Хамралт</b>                                                         | Хэдийгээр малчдын хувьд шимтгэлийн хэмжээ нь төлөхөд боломжийн (зах зээл дээрх малын үнийг авч үзвэл нэг хонины үнэ хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцэж байна) боловч малчид нийгмийн даатгалд сайн дураар хамрагдах нь бага байна. Ялангуяа залуучууд, малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн дунд хамрагдалт тааруу байгаа нь тэд нийгмийн даатгалын ач холбогдлыг мэдэхгүй, сонирхол багатай байгаагийн илэрхийлэл байж болох юм.                                                                                                                                                                                            |
| <b>Шимтгэл төлөхөөс зайлсхийх</b>                                      | ҮСХ-оос зарласан улсын хэмжээний дундаж цалин нийгмийн даатгалын шимтгэл төлсөн дундаж цалингаас хамаагүй өндөр байгаагаас үзэхэд ажил олгогчид, болон ажилтнууд шимтгэл төлөхөөс зайлсхийдэг байж болзошгүй.                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                        |
| <b>Хүртээмж</b>                                                        | Малчид алсмагдал байдал, малаа маллуулах өөр хүнгүй зэрэг нөхцөл байдлаас шалтгаалаад сумын төв рүү ховорхон (магадгүй сард нэг удаа) орж ирдэг.                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                     |
| <b>Шимтгэл төлөх хугацаа</b>                                           | Шимтгэл төлөх хугацаа нь хөдөөгийн хүн амын орлогын болон амьдралын мөчлөгтэй нь зохицохгүй, оновчтой бус байна. Малчдын орлого ноос ноолуур, сүү цагаан идээ, мал мах зарах зэрэг улирлын чанартай ажлуудаас ихээхэн хамааралтай байдаг. Малчид жилд бараг хоёрхон удаа, хавар ноолуураа зарах, 12 дугаар сарын эхээр мах бэлтгэх үед л бэлэн мөнгөтэй болдог. (Энэ асуудал ҮСҮХ-ийн явцад буюу 2014 оны 1 дүгээр сард шийдвэрлэгдэж, одоо шимтгэлийг нийгмийн даатгалын байгууллага болон даатгуулагчийн хооронд байгуулсан гэрээнд тохиролцсоны дагуу сар, улирал, хагас болон бүтэн жилээр урьдчилан төлөх боломжтой болсон юм). |
| <b>Ойлголт мэдлэг</b>                                                  | Нийгмийн даатгалд хамрагдаж, шимтгэл төлөх журам, түүнээс хүртэх үр ашгийн талаарх мэдлэг мэдээлэл ялангуяа залуучуудын дунд ихээхэн дутмаг байна.                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                   |
| <b>Зорилтот бүлгийн тодорхойлолт</b>                                   | Орон гэргүй тэнэмэл хүн гэдгийг ойлгомжтой сайн тодорхойлоогүй, тэднийг орон гэрээр хангах журам нь ч тодорхой бус байна.                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                            |

#### **Үйлчилгээний хүртээмж**

Протез, ортопедийн хэрэгсэлтэй хүмүүст орж гарах барилга байгууламжийн боломж нөхцөл нь бүрдээгүй, хөдөө орон нутагт үйлчилгээ үзүүлэх байгууллага байхгүй зэргээс ХБИ-дэд үйлчилгээнд хамрагдаж чадахгүй байна.

#### **ХЭДХ-үүдтэй хамааралтай нийтлэг шүүмж**

Хүн амын дунд эдгээр хөтөлбөрийн талаарх мэдлэг мэдээлэл тааруу байна. Хөдөлмөрийн яамны 2014 оны жилийн үнэлгээгээр малчид, аж ахуй эрхлэх, ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, мэргэжилтэй ажилчид бэлтгэх зээг 4 хөтөлбөрийг илүү амжилттай хэрэгжсэн гэж дүгнэжээ<sup>29</sup>. Бүх хөтөлбөрийн дизайныг цаашид боловсронгуй болгох шаардлагатай байна. Тайланд хөтөлбөрүүдийн зохицуулалт сул, давхардаж, зөрчилдсөн зүйлс байгааг тэмдэглэсэн байна. Хөтөлбөрүүдийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд хөрөнгө санхүүжилт, чадавхи дутагдаж байна. Ялангуяа ажилгүйдэл, ядуурлын түвшин үндэсний дундажаас дээгүүр байгаа хөдөө орон нутагт ХЭДХ-үүдийг хэрэгжүүлэх санхүүжилт дутмаг, хөдөлмөр эрхлэлтийн ажилтнуудын чадавх хангалтгүй байна.

#### **Мэргэжлийн сургалтыг дэмжихэд чиглэсэн ХЭДХ-үүд**

Мэргэжил олгох сургалтын хугацаа хэтэрхий богино байгаа нь хөдөлмөрийн зах зээл дээр өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд шаардлагатай мэргэжлийн үр чадваруудыг зохих ёсоор нь эзэмшүүлэхэд саад болж байна. Сургалтын байгууллага ажиллуулах зөвшөөрлийг олгохдоо Улаанбаатар хотын сургалтын байгууллагуудад илүү боломж олгож, харин хөдөө орон нутгийн хоршоод, улирлын чанартай ажлын байраар хангадаг газруудыг дэмжихэд чиглэсэн сургалтын байгууллага, төсөл хөтөлбөрүүдийг орхигдуулах хандлагатай байна.

#### **Дүгнэлт, зөвлөмжүүд**

Нийгмийн даатгалд сайн дураар хамрагдалт бага, орлогын дэмжлэг үзүүлэх хөтөлбөрүүд болон хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээ (тухайлбал, нийгмийн халамжийн хөтөлбөрүүд, ажилгүйдлийн тэтгэмж) хоорондын уялдаа холбоо сул байна. Хөдөлмөрийн насны хүн амын НХСТ-г хангахын тулд малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн нийгмийн даатгалд хамрагдалтыг нэмэгдүүлэх урамшууллын механизмыг нэвтрүүлэх (тухайлбал, шимтгэлд татаас олгох), нийгмийн даатгалд сайн дураар хамрагдсан эмэгтэйчүүдийн жирэмсний болон амаржсаны тэтгэмж бодох хувь хэмжээг нэмэгдүүлэх, нийгмийн даатгалыг хөдөлмөрийн зах зээлийн идэвхтэй арга хэмжээний хөтөлбөрүүдтэй үр дүнтэй, системтэй уялдуулах зэрэг гол зөвлөмжүүдийг өгсөн юм.

Хүснэгт 14-т ҮСҮХ-ийн явцад гарсан зөвлөмжүүдийг нэгтгэн харуулав. Нийгмийн хамгааллын шинэ зохицуулалт бий болгох, эсвэл одоогийн зохицуулалтынх нь хамрах хүрээг өргөжүүлэх шаардлагатайг илэрхийлсэн зөвлөмжийг (\*)-оор тэмдэглэв. Эдгээр нэмэлт зохицуулалтыг нэвтрүүлэх, хамрах хүрээг өргөжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог ОУХБ-ын РАП загвараар тооцоолсон болно. Зарим зөвлөмжийг хэрэгжүүлэхэд хэрэгцээтэй хөрөнгийн хэмжээг тооцохын тулд техник эдийн засгийн илүү нарийвчилсан үнэлгээ, актуар судалгаа хийх шаардлагатай юм. Эдгээр зөвлөмжийг хүснэгтэд (Δ)-аар тэмдэглэсэн болно.

<sup>29</sup> ХЭДХ-үүдийн хэрэгжилтийн тухай 2014 оны тайлан, Хөдөлмөрийн яам

**Хүснэгт 14. ҮСҮХ-ээс хөдөлмөрийн насны хүн хүн амын орлогын баталгааг хангах чиглэлд гаргасан зөвлөмжүүд**

|   | Гол зөвлөмжүүд                                                                                                                                                                                                                                                                                                                                                                      |
|---|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| * | ХЭ1. Нийгмийн даатгалд сайн дураар даатгуулсан иргэдийн жирэмсний болон амаржсаны тэтгэмж бодох хувь хэмжээг албан журмын нийгмийн даатгалд даатгуулагчдынхтай ижил 100 хувь болгож нэмэгдүүлэх.                                                                                                                                                                                    |
| △ | ХЭ2. Хугацаатай гэрээгээр ажиллаж буй иргэдийн хамгааллыг сайжруулахын тулд ажилгүйдлийн тэтгэмж олгоход тавьж буй нөхцөл болзлыг илүү уян хатан болгох, тухайлбал, ажилгүй болохоосоо өмнө 24 сарын хугацаанд, үүнээс сүүлийн 9 сард нь тасралтгүй шимтгэл төлсөн байхыг шаардаж байгааг өөрчлөх. Тэтгэмж бодох доод хувь хэмжээг хамгийн наад зах нь 50 хувьд хүргэж нэмэгдүүлэх. |
| * | ХЭ3. Нийгмийн даатгалд сайн дураар хамрагдах иргэдийн төлөх шимтгэлд төрөөс татаас олгох замаар даатгуулах урамшууллыг бий болгох.                                                                                                                                                                                                                                                  |
|   | ХЭ4. Нийгмийн даатгалд (тэтгэврийн даатгалын санд ч бас адил) сайн дураар шимтгэл төлөх илүү уян хатан нөхцөл бий болгох, ялангуяа малчдын шимтгэл төлөх хугацааг өөрчилж (жилд 2 удаа төлөх боломж бүрдүүлэх), төлөгдөөгүй шимтгэлийг тодорхой хугацааны дотор нөхөн төлөх боломж олгох(2014 оны 1 дүгээр сард шимтгэл төлөх хугацаанд өөрчлөлт оруулсан)                          |
| * | ХЭ5. Нийгмийн даатгалд даатгуулахыг ХЭДХ-т хамрагдах нэг нөхцөл болгон оруулж, нийгмийн даатгал болон ХЭДХ-үүдийг уялдуулах.                                                                                                                                                                                                                                                        |
| * | ХЭ6. Мэргэжлийн сургалт, нийгмийн даатгалтай уялдуулсан, залуу малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилготой хөтөлбөрүүдийг боловсруулах (Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих 8 хөтөлбөрт хамрагдсан иргэдийн олонх нь хот суурин газрын хүмүүс байна).                                                                                                                                      |
| * | ХЭ7. Ажилгүйдлийн тэтгэмжийг хөдөлмөрийн зах зээлийн идэвхтэй бодлого (ХЗЗИБ)-той илүү уялдуулах, тухайлбал ажилгүйдлийн тэтгэмж авагчдын эрэлт хэрэгцээнд нийцсэн сургалтын хөтөлбөр боловсруулах (үр чадвараа сайжруулах шаардлагатай эмзэг бүлгийн хүмүүст чиглэсэн ХЭДХ гаргах).                                                                                                |
| △ | ХЭ8. Төрийн хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг зөвхөн зээл олгох хөтөлбөрүүдээр хязгаарлахгүйгээр ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт, сургалтын асуудлаар зөвлөгөө өгөх, мэргэжлийн сургалт зохион байгуулах, аж ахуй эрхлэлтийн асуудлаар зөвлөх, ялангуяа залуу хүмүүст тохирсон үйлчилгээг үзүүлэх чиглэлд чадавхжуулан бэхжүүлэх.                                                      |
| * | ХЭ9. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөгжлийн бэрхшээлтэй болсон иргэдийн дахин ажил хөдөлмөр эрхлэхийг дэмжих (сургалт, давтан сургалт, аж ахуй эрхлэлтийн зөвлөгөө, ажил мэргэжлийн чиг баримжаа зэргийг багтаасан) цогц хөтөлбөр боловсруулах.<br><br>ХЭ10. Хөдөө орон нутагт ХЭДХ-үүдийн талаар мэдлэг мэдээлэл олгох кампанит ажлыг зохион байгуулах. |
|   | Нэмэлт зөвлөмжүүд                                                                                                                                                                                                                                                                                                                                                                   |
| △ | ХЭ11: Аймаг, сумын нийгмийн даатгалын байгууллагууд хоорондоо мэдээллийн технологи, цахим сүлжээгээр холбогдох, утсаар шимтгэлийн төлбөр тооцоо хийх зэрэг харилцаа холбооны шинэ техник технологи, уян хатан системийг ашиглах, явуулын үйлчилгээ, малчдын улирлын чанартай бэлэн мөнгөний үрсгалтай нийцсэн даатгалын бүтээгдэхүүн нэвтрүүлэх.                                    |
| △ | ХН12: Ажиллагчид, ажил олгогчдод мэдлэг мэдээлэл олгох, зөвлөгөө өгөх, сайн туршлага түгээн дэлгэрүүлэх зэргээр ажлын байрны нөхцөлийг сайжруулж, осол эндэгдлээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх.                                                                                                                                                                   |

Эх үүсвэр: НҮБ /ЗГ-ын хамтарсан Нийгмийн хамгааллын ажлын хэсэг, 2015



#### 4.4. Ахмад настан

*“Ахмад настан бүрийг наад зах нь үндэснийхээ хэмжээнд тодорхойлсон доод түвшнийг хангахуйц хэмжээний орлогын суурь баталгаагаар хангах.”*

Монгол Улсын тэтгэврийн тогтолцоо нь нийгмийн даатгалын болон нийгмийн халамжийн тэтгэврийн хөтөлбөрүүдээс тогтдог. Энэ хоёр төрлийн хөтөлбөрийн аль аль нь ажил хөдөлмөр эрхлэх боломжгүй болсон болон тэжээгчээ алдсан хүмүүст орлогын дэмжлэг үзүүлдэг. Ажил хөдөлмөр эрхлэх боломжгүй болсон шалтгаан нь өндөр наслах, хүүхэд асрах, хөдөлмөрийн чадвараа алдах зэрэг байж болно. Хэдийгээр хууль тогтоомж болон практикт өндөр наслах, хөдөлмөрийн чадвараа болон тэжээгчээ алдах гурван тохиолдлыг хамтад нь нийгмийн даатгалын болон халамжийн тэтгэвэр гэж ерөнхийд нь бүлэглэн хамруулдаг ч энэ тайланд бид эдгээр тэтгэврийг тус тусад нь (тахир дутуугийн тэтгэврийг хөдөлмөрийн насны хүн амын баталгаанд, тэжээгчээ алдсаны тэтгэврийг дөрвөн баталгаа тус бүр дээр оруулсан байгаа) авч үзлээ.

#### Одоогийн зохицуулалт: Тахир дутуугийн, өндөр насны болон тэжээгчээ алдсаны тэтгэвэр

Монгол Улс нь бүх нийтийг хамарсан, харьцангуй өндөр тэтгэвэр олгодог, эв санааны нэгдлийн зарчмаар санхүүждэг (PAYG) цалинд суурилсан тэтгэврийн тогтолцоо(ЦСТТ)-г уламжлан авсан билээ. Тэтгэврийг дахин хуваарилалтын зарим механизмаар дамжуулан улсын төсвөөс бүрэн санхүүжүүлдэг байв. 1995 онд Засгийн газар тэтгэврийн тогтолцоогоо шинэчилж, шимтгэл төлдөг тэтгэврийн даатгалын тогтолцоог нийгмийн даатгалын бусад төрлүүдийн хамт нэвтрүүлсэн юм. Гэхдээ одоо ч энэ тогтолцоо улсын төсвөөс ихээхэн хамааралтай хэвээр байна. Энэ шинэчлэл нь өнөөгийн тогтолцоог тодорхой хэмжээгээр сайжруулсан боловч санхүүгийн тогтвортой байдлыг хангаж, тогтолцооны үндсэн бүтцийн нэлээд олон асуудлыг шийдвэрлэж чадаагүй юм. Үүний улмаас нийгмийн даатгалд, ялангуяа сайн дурын даатгалд хамрагдаж, шимтгэл төлөх эрмэлзэл суларч, ажиллагчид, даатгуулагчдын янз бүрийн бүлгүүдийн дунд тэтгэврийн тэгш бус байдлыг бий болгожээ.

1999 онд шимтгэлд суурилсан тэтгэврийн буюу нэрийн дансны тогтолцоо(НДТ)-г 1960 оноос хойш төрсөн даатгуулагчдад зориулан бий болгож, нэрийн данснаас аажмаар хагас хуримтлалын тогтолцоонд шилжүүлэх зорилт тавьсан байна. НДТ-г нэвтрүүлэхдээ 1960 оноос өмнө төрсөн хүмүүст хамаарч буй ЦСТТ-ны параметр үзүүлэлтүүдийг өөрчлөөгүйгээс гадна 1960 оноос хойш төрсөн хүмүүсийн авах тэтгэврийн хэмжээ өмнөх бүлгийнхэнтэй харьцуулахад огцом буурахаар байгаа юм. Мөн НДТ нь даатгуулагчдын тэтгэвэр тогтоолгох нас зэрэг гол шалгууруудыг шинэчлээгүй орхисон мөртлөө тэтгэврийн доод хэмжээний зохицуулалтыг хэрэглэсээр байгаагаас төсвөөс авч буй нилээд их хэмжээний татаасыг үрт хугацаанд үргэлжлүүлэх шаардлагатай болж байна. Сайн дурын даатгалын хөтөлбөр амжилт олоогүй учир НДТ-ны шинэчлэл нь нийгмийн даатгалд бүх нийтийг хамруулах асуудлыг ч шийдэж чадаагүй юм.

Нийгмийн даатгалд (албан журмаар болон сайн дураар) хамрагдаж, Тэтгэврийн даатгалын санд төлсөн шимтгэлийн орлогоор санхүүжих өндөр насны, тахир дутуугийн болон тэжээгчээ алдсаны тэтгэврээс гадна ХАХНХЯ эмзэг бүлгийнхэнд чиглэсэн нийгмийн халамжийн хэд хэдэн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байна.

Монгол Улсын тэтгэврийн даатгалын одоогийн тогтолцооны хүрээнд хоёр багц хөтөлбөр хэрэгжиж байна. Нэг нь хуваарилалтын зарчимд үндэслэсэн, 1960 оноос өмнө төрсөн хүмүүст хамаарах ЦСТТ, нөгөө нь 1960 оноос хойш төрсөн хүмүүст зориулсан НДТ юм.

2013 оны байдлаар 56,500 хүн буюу нийт даатгуулагчдын 5.8 хувь нь “1960 оноос өмнөх” хөтөлбөрт хамрагдаж хараахан өндөр насны тэтгэвэрт гараагүй, шимтгэл төлсөн хэвээр байгаа бол 913,900 хүн буюу ЭЗИХА-ын 71.6 хувь нь НДТ-нд шимтгэл төлж байна.

2013 оны эцсийн байдлаар тус улсын тэтгэврийн наснаас дээш насны нийт хүн амын тоотой тэнцүү буюу 232,100 тэтгэвэр авагч<sup>30</sup> НДС-аас тэтгэвэр авчээ. 2015 оны нэгдүгээр сараас эхлэн эхний даатгуулагчид нэрийн данснаас тэтгэвэр тогтоолгож эхэлнэ (7,000 хүн тэтгэвэр авах эрх үүснэ).

Тэтгэврийн даатгалаас гадна Монгол Улс цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн, нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн хэд хэдэн хөтөлбөр хэрэгжүүлдэг.

### Нийгмийн даатгалын сангаас олгох өндөр насны цалинд суурилсан тэтгэвэр

**Хууль эрх зүйн орчин** Нийгмийн даатгалын тухай хуулийн 4.2 ба 4.3 дахь хэсэг (1994 оны 5 дугаар сарын 31); Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 4 дүгээр зүйл (1994 оны 6 дугаар 7)

**Зорилтот бүлэг** 1960 оны 1 дүгээр сарын 1-нээс өмнө төрсөн, хөдөлмөрийн болон иргэний гэрээгээр ажиллагчид, төрийн албан хаагчид (4.2 дахь хэсэг), албан бүс салбарт ажиллагчид, малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, тодорхой ажил хөдөлмөр эрхлээгүй иргэд (4.3 дахь хэсэг)  
Цаа буга маллан тайгад амьдарч байгаа цаатан иргэнийг тэтгэврийн болон тэтгэмжийн даатгалд төрөөс даатгуулна (4.7 дахь хэсэг). Эдгээр даатгуулагчийн хувьд шимтгэлийг сайн дурын даатгалын хувь хэмжээгээр төрөөс бүрэн хариуцна (2015 оны 1 дүгээр сарын 30-ны өдрийн хуулиар нэмсэн).

**Даатгуулах Хэлбэр** Албан журмын ба сайн дурын

**Санхүүжилт** Нийгмийн даатгалын Тэтгэврийн санд төлсөн шимтгэлээр өндөр насны, тахир дутуугийн болон тэжээгчээ алдсаны тэтгэврийг санхүүжүүлдэг. Тэтгэврийн даатгалын сан нь хуваарилалтын буюу эв санааны нэгдлийн зарчмаар санхүүждэг болно.

<sup>30</sup> НДЕГ-аас 2014 оны 4-р сард өгсөн мэдээлэл.

|                                  |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                   |
|----------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| <b>Санхүүжилт</b>                | <p><b>Албан журмын:</b> Хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлого (хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний хооронд хэлбэлзэнэ)-оос ажил олгогч, ажилтан хоёулаа 14 хувийн шимтгэлийг адил хэмжээгээр хувааж төлнө.</p> <p><b>Сайн дурын:</b> Хувь хүн өөрийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоосоо 10 хувиар шимтгэл төлнө. Хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогыг даатгуулагч өөрөө тодорхойлох ба шимтгэл төлөх орлогын хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ болон түүнийг 10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээгээр хязгаарлагдана.</p> <p>Үүнээс гадна, сангийн тэнцлийг хангахын тулд алдагдлыг нь Засгийн газар улсын төсвөөс санхүүжүүлж байна.</p>                               |
| <b>Тэтгэвэр авах эрх</b>         | <p><b>Шимтгэл төлсөн жил:</b> Нийтдээ 20-иос доошгүй жил тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн бол өндөр насны бүрэн тэтгэвэр авах эрхтэй; харин албан журмын болон сайн дурын даатгалд наад зах нь 10-аас 19 жилийн хугацаанд шимтгэл төлсөн бол хувь тэнцүүлсэн тэтгэвэр авна.</p> <p><b>Тэтгэврийн нас:</b> 1960 оны 1 дүгээр сарын 1-нээс өмнө төрсөн эмэгтэй (хэрэв өөрөө хүсвэл) 55 нас хүрээд; төрүүлсэн болон 3 хүртэл настайд нь үрчлэн авсан дөрөв, түүнээс дээш хүүхдээ 6 настай болтол өсгөсөн эх 50 нас хүрсэн бол; мөн 1960 оны 1 дүгээр сарын 1-нээс өмнө төрсөн эрэгтэй 60 нас хүрсэн бол тэтгэвэр тогтоолгох эрхтэй. Хэрэв даатгуулагч хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд ажиллаж байгаа бол ажлын нөхцөлөөс хамааран 45-аас 55 насандаа эрт тэтгэвэрт гарч болно.</p> |
| <b>Тэтгэвэр</b>                  | <p>Өндөр насны тэтгэврийн хэмжээг хуваарилалтын зарчмаар цалинд суурилсан томъёогоор тооцдог.</p> <p>2013 оны эцсийн байдлаар сарын дундаж тэтгэвэр 225,600 төгрөг байв. 2015 оны 2 дугаар сарын 1-нээс НДС-аас олгох өндөр насны хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээ 195,000 төгрөг, бүрэн тэтгэврийн доод хэмжээ 230,000 төгрөг болсон байна.</p>                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                            |
| <b>Тэтгэвэр бодох хувь</b>       | <p>Сарын тэтгэврийн хэмжээг хамгийн өндөр цалинтай дараалсан 5 жилийн сарын дундаж цалингийн 45 хувиар тогтоох ба 20 жилээс илүү шимтгэл төлсөн жил тутамд 1,5 хувиар, сар тутамд 0.125 хувиар нэмэгдүүлж тооцно. (сараар нэмэгдүүлж тооцохыг 2015 оны 1 дүгээр сарын 30-ны өдрийн хуулийн нэмэлтээр оруулсан бөгөөд 2015 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс мөрдөж эхэлнэ). Жишээ нь, 30 жил шимтгэл төлсөн бол тэтгэвэр бодох хувь хэмжээ 60 хувь болно. 20-иос доошгүй жил шимтгэл төлсөн даатгуулагчийн хувьд тэтгэврийн баталгаат доод хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 75 хувьтай тэнцүү байна.</p>                                                                                                                                                                |
| <b>Шимтгэл идэвхтэй төлөгчид</b> | <p>2013 онд 52,100 хүн албан журмын, 6,400 хүн сайн дурын тэтгэврийн даатгалд хамрагдсан байв.</p>                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                |
| <b>Тэтгэвэр авагчид</b>          | <p>2013 онд 232,100 хүн буюу хамрагдвал зохих бүх хүн тэтгэвэр авсан байна.</p>                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                   |

### Нэрийн данснаас олгох өндөр насны тэтгэвэр

НДТ-оос авах тэтгэврийн хэмжээ эрс буурч байгаа учраас 2015 онд Засгийн газар Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулжээ. Уг хуулийн төслөөр 1960-аас 1979 оны хооронд төрсөн, нэрийн данснаас өндөр насны тэтгэвэр тогтоолгох эрх үүсч буй даатгуулагчийн тухайд ЦСТТ болон НДТ хоёроос аль өндөр тэтгэвэр тогтоогдохыг нь сонгох боломж олгож байгаа юм. Хуулийн төслийг УИХ-ын 2015 оны намрын чуулганаар хэлэлцэнэ.

|                                  |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                              |
|----------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| <b>Хууль эрх зүйн орчин</b>      | Нийгмийн даатгалын тухай хуулийн 4.2 ба 4.3 дахь хэсэг (1994 оны 5 дугаар сарын 31); Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хууль (1999 оны 7 дугаар сарын 1)                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                   |
| <b>Зорилтот бүлэг</b>            | 1960 оны 1 дүгээр сарын 1-нээс хойш төрсөн, хөдөлмөрийн болон иргэний гэрээгээр ажиллагчид, төрийн албан хаагчид (4.2 дахь хэсэг), албан бус салбарт ажиллагчид, малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, тодорхой ажил хөдөлмөр эрхлээгүй иргэд (4.3 дахь хэсэг)                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                |
| <b>Даатгуулах хэлбэр</b>         | Албан журмын ба сайн дурын                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                   |
| <b>Санхүүжилт</b>                | <p>Нийгмийн даатгалын Тэтгэврийн санд төлсөн шимтгэлээр өндөр насны, тахир дутуугийн болон тэжээгчээ алдсаны тэтгэврийг санхүүжүүлдэг. Тэтгэврийн даатгалын сан нь хуваарилалтын буюу эв санааны нэгдлийн зарчмаар санхүүждэг болно.</p> <p><b>Албан журмын:</b> Хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлого (хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний хооронд хэлбэлзэнэ)-оос ажил олгогч, ажилтан хоёулаа 14 хувийн шимтгэлийг адил хэмжээгээр хувааж төлнө.</p> <p><b>Сайн дурын:</b> Хувь хүн өөрийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоосоо 10 хувиар шимтгэл төлнө. Хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогыг даатгуулагч өөрөө тодорхойлох ба шимтгэл төлөх орлогын хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ болон түүнийг 10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээгээр хязгаарлагдана.</p> |
| <b>Тэтгэвэр</b>                  | <p>Өндөр насны тэтгэврийн хэмжээг тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны томъёогоор тооцож гаргана.</p> <p>Тэтгэврийн доод хэмжээ: Улсын дундаж цалингийн 20 хувь, үүн дээр 15 жилээс илүү шимтгэл төлсөн жил тутам дундаж цалингийн 0.5 хувиар нэмэгдүүлж тооцно.</p>                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                |
| <b>Тэтгэвэр авах эрх</b>         | <p>Шимтгэл төлсөн жил: 15 жил шимтгэл төлж ажилласан байх</p> <p>Тэтгэврийн нас: 1960 оны 1 дүгээр сарын 1-нээс хойш төрсөн эмэгтэй (хэрэв өөрөө хүсвэл) 55 нас хүрээд; төрүүлсэн болон 3 хүртэл настайд нь үрчлэн авсан дөрөв, түүнээс дээш хүүхдээ 6 настай болтол өсгөсөн эх 50 нас хүрсэн бол; мөн 1960 оны 1 дүгээр сарын 1-нээс өмнө төрсөн эрэгтэй 60 нас хүрсэн бол тэтгэвэр тогтоолгох эрхтэй. Хэрэв даатгуулагч хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд ажиллаж байгаа бол ажлын нөхцөлөөс хамааран 45-аас 55 насандаа эрт тэтгэвэрт гарч болно.</p>                                                                                                                                                                                                                                                                                                                        |
| <b>Тэтгэвэр бодох хувь</b>       | Нэрийн дансанд төлсөн шимтгэлийн нийт орлого, жил бүрийн хийсвэр тооцсон хүү (нийгмийн даатгалын шимтгэл төлсөн дундаж хөдөлмөрийн хөлсний сүүлийн 3 жилийн дундаж өсөлт), тэтгэвэр авах дундаж хугацаан дээр үндэслэн тэтгэврийн хэмжээг тогтооно.                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                          |
| <b>Шимтгэл идэвхтэй төлөгчид</b> | 2013 онд 714,700 хүн албан журмын даатгалд, 140,700 хүн сайн дурын даатгалд даатгуулснаар нийт ажиллах хүчний 75.5 хувь нь хамрагджээ.                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                       |
| <b>Тэтгэвэр авагчид</b>          | 2015 оны 1 дүгээр сараас эхлэн эхний тэтгэвэр авагчид тэтгэврээ тогтоолгоно (ойролцоогоор 7,000 гаруй хүн байна гэж тооцсон).                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                |

Нийт 766,815 хүн албан журмаар, 147,100 хүн сайн дураар тэтгэврийн (ЦСТТ ба НДТ) даатгалд хамрагдсан нь ЭЗИХА-ын 71.6 хувийг эзэлж байна. Малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, албан бус эдийн засагт ажиллагчдын ердөө 23.4 хувь нь л сайн дурын даатгалд хамрагдаж байгаа боловч энэ үзүүлэлт 2010 оны (9.3 хувь) түвшинтэй харьцуулахад өссөн байна. Харин 2013 онд малчдын зөвхөн 8.4 хувь нь л сайн дурын нийгмийн даатгалд даатгуулсан байна<sup>31</sup>.

<sup>31</sup> Ажиллах хүчний судалгаа болон 2014 оны 4 дүгээр сард НДЕГ-аас авсан мэдээлэл.

## Хүснэгт 15. Монгол Улсын тэтгэврийн зэрэгцээ хоёр хөтөлбөр

| Өндөр насны тэтгэвэр   | ЦАЛИНД СУУРИЛСАН ТЭТГЭВРИЙН ХӨТӨЛБӨР<br>(1960 оноос өмнө төрсөн хүмүүс)                                                                                                                                                                                                                                                                                                                                                   | НЭРИЙН ДАНСНЫ ХӨТӨЛБӨР<br>(1960 оноос хойш төрсөн хүмүүс)                                                                                                                                                                                                                                                                                                                                                                 |
|------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Хууль                  | Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль (1995)                                                                                                                                                                                                                                                                                                                                                  | Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хууль (1999)                                                                                                                                                                                                                                                                                                                                                          |
| Шимтгэл төлсөн жил     | Бүрэн тэтгэвэр тогтоолгоход 20 -иос доошгүй жил, хувь тэнцүүлсэн тэтгэвэр тогтоолгоход 10-19 жил                                                                                                                                                                                                                                                                                                                          | 15-аас доошгүй жил                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                        |
| Тэтгэврийн нас         | Эрэгтэй 60, эмэгтэй 55                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                    | Эрэгтэй 60, эмэгтэй 55                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                    |
| Шимтгэлийн хувь хэмжээ | Албан журмын даатгал: Ажилтан, ажил олгогч хоёр тус бүр хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос 7.0 хувиар төлнө.<br>Сайн дурын даатгал: Хувиараа хөдөлмөр эрхлэгчид, малчид, тодорхой ажил хөдөлмөр эрхлээгүй иргэд хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогынхоо 10 хувиар төлнө.<br>Шимтгэл ногдуулах орлогын доод, дээд хязгаар: хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ, уг доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү | Албан журмын даатгал: Ажилтан, ажил олгогч хоёр тус бүр хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос 7.0 хувиар төлнө.<br>Сайн дурын даатгал: Хувиараа хөдөлмөр эрхлэгчид, малчид, тодорхой ажил хөдөлмөр эрхлээгүй иргэд хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогынхоо 10 хувиар төлнө.<br>Шимтгэл ногдуулах орлогын доод, дээд хязгаар: хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ, уг доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү |
| Тэтгэвэр бодох хувь    | Хамгийн өндөр дараалсан 5 жилийн сарын дундаж хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын 45 хувь + 20 –иос илүү шимтгэл төлсөн жил тутамд 1.5 хувиар нэмэгдүүлж бодно.                                                                                                                                                                                                                                                    | Нэрийн дансны тэтгэвэр нь дараах томъёонд үндэслэнэ:<br>(өндөр насны тэтгэвэрт зориулж төлсөн шимтгэл + сүүлийн 3 жилийн цалингийн дундаж өсөлтөөр хийсвэр тооцсон хүү) / (тэтгэвэр авах дундаж хугацаа)                                                                                                                                                                                                                  |

Эх үүсвэр: Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль, 1994; Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хууль, 1999.

### Тэжээгчээ алдсаны тэтгэвэр

|                      |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                           |
|----------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Хууль эрх зүйн орчин | Нийгмийн даатгалын тухай хуулийн 4.2 ба 4.3 дахь хэсэг (1994 оны 05 дугаар сарын 31); Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль (1994 оны 6 дугаар сарын 7)                                                                                                                                                                                       |
| Зорилтот бүлэг       | Хөдөлмөрийн болон иргэний гэрээгээр ажиллагчид, төрийн албан хаагчид (4.2 дахь хэсэг), албан бус салбарт ажиллагчид, малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, тодорхой ажил хөдөлмөр эрхлээгүй иргэд (4.3 дахь хэсэг)                                                                                                                                                         |
| Даатгуулах хэлбэр    | Албан журмын ба сайн дурын                                                                                                                                                                                                                                                                                                                                                |
| Санхүүжилт           | Нийгмийн даатгалын Тэтгэврийн санд ажил олгогчийн болон ажилтны төлсөн шимтгэл:<br><b>Албан журмын:</b> Хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлого (хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний хооронд хэлбэлзэнэ)-оос ажил олгогч, ажилтан хоёулаа 14 хувийн шимтгэлийг адил хэмжээгээр хувааж төлнө. |

|                          |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                            |
|--------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| <b>Санхүүжилт</b>        | <u>Сайн дурын</u> : Хувь хүн өөрийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоосоо 10 хувиар шимтгэл төлнө. Хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогыг даатгуулагч өөрөө тодорхойлох ба шимтгэл төлөх орлогын хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ болон түүнийг 10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээгээр хязгаарлагдана.                                                                                                                                                                                                                                                                                                            |
| <b>Тэтгэвэр</b>          | <p>Даатгуулагчийн асрамжид байсан гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүдийн тоог харгалзан дор дурдсанаар тэжээгчээ алдсаны тэтгэврийг тогтооно:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Нэг тэжээлгэгч бол даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлого дээр үндэслэн тооцсон өндөр насны бүрэн тэтгэврийн 50,</li> <li>• Хоёр тэжээлгэгч бол 75 хувь,</li> <li>• Гурав ба түүнээс дээш тэжээлгэгч бол 100 хувь.</li> </ul> <p>Тэжээгчээ алдсаны тэтгэврийн доод хэмжээ нь тэжээлгэгчийн тооноос хамааран хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ (2013 онд 192,000 төгрөгөөр тогтоогдсон)-ний 50-100 хувьтай тэнцүү байна.</p> |
| <b>Тэтгэвэр авах эрх</b> | 20-иос доошгүй жил шимтгэл төлсөн, эсвэл нас барахын өмнөх 5 жилийн 3 жилд нь шимтгэл төлсөн тэжээгч ердийн өвчин, ахуйн ослын улмаас нас барвал түүний асрамжид байсан гэр бүлийн гишүүд (эхнэр, нөхөр ба 16 нас хүрээгүй хүүхэд зэрэг).                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                  |
| <b>Хамралт</b>           | 2013 онд 714,700 хүн албан журмын даатгалд, 140,700 хүн сайн дурын даатгалд даатгуулжээ.                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                   |
| <b>Тэтгэвэр авагчид</b>  | 2013 онд 22,500 тэжээгчээ алдагч (насаар ангилаагүй тоо баримт) тэтгэвэр авсан байна.                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                      |

### **Цэргийн албан хаагчийн өндөр насны тэтгэвэр (цэргийн алба хаасны тэтгэвэр)**

|                            |                                                                                                                                                                                                                                                                           |
|----------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| <b>Хууль эрхзүйн орчин</b> | Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 4.1 дэх хэсэг (1994 оны 6 дугаар сарын 13)                                                                                                                                                                      |
| <b>Зорилтот бүлэг</b>      | Зэвсэгт хүчин, хилийн цэрэг, тагнуул, цагдаа, шүүхийн шинжилгээний болон авлигатай тэмцэх, онцгой байдлын асуудал эрхэлсэн болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын албан хаагчид                                                                                     |
| <b>Тэтгэвэр авах эрх</b>   | Эрэгтэй 25-аас доошгүй жил, эмэгтэй 20-иос доошгүй жил цэргийн алба хаасан байх ёстой. Тэтгэвэрт гарах насыг хуулиар тогтоогоогүй.                                                                                                                                        |
| <b>Тэтгэвэр бодох хувь</b> | Тэтгэврийн хэмжээг цэргийн албан хаагчийн сарын дундаж цалин хөлсний 80 хувиар тогтоох ба 20 ба 25 жилээс илүү алба хаасан жил тутамд тэтгэвэр тогтоолгосон дундаж цалин хөлснөөс 1.5 хувиар бодож нэмэгдүүлнэ.                                                           |
| <b>Тэтгэвэр</b>            | Тэтгэврийн доод хэмжээ нь нийгмийн даатгалын сангаас олгох өндөр насны тэтгэврийн доод хэмжээтэй адил байна. 2015 оны 2 дугаар сарын 1-нээс нийгмийн даатгалын хувь тэнцүүлсэн доод тэтгэврийн хэмжээ 195,000 төгрөг, бүрэн тэтгэврийн доод хэмжээ 230,000 төгрөг болсон. |
| <b>Санхүүжилт</b>          | Цэргийн тэтгэврийн зардлыг улсын төсвөөс санхүүжүүлдэг.                                                                                                                                                                                                                   |
| <b>Тэтгэвэр авагчид</b>    | 2013 онд 15,600 хүн                                                                                                                                                                                                                                                       |

### **Нийгмийн халамжийн сангаас олгох өндөр насны тэтгэвэр**

ХАХНХЯ-ны Нийгмийн хамгааллын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар болон тус газрын Нийгмийн халамжийн үйлчилгээний алба нь нийгмийн халамжийн тэтгэвэртэй холбоотой бодлого, шийдвэрийн төслийг боловсруулж, төлөвлөх асуудлыг хариуцдаг. Нийгмийн халамж, үйлчилгээний хэлтсүүд нь тэтгэвэр авах хүсэлт гаргагчдын уг тэтгэвэр авах эрхийг баталгаажуулж, олгох асуудлыг шийдвэрлэдэг.

## Нийгмийн халамжийн тэтгэвэр

**Хууль эрх зүйн орчин** Нийгмийн халамжийн тухай хуулийн 12.1.1 дэх заалт (2012)

**Зорилтот бүлэг** 60 ба түүнээс дээш настай эрэгтэй, 55 ба түүнээс дээш настай эмэгтэй; 18 хүртэлх насны дөрөв ба түүнээс дээш хүүхэдтэй, өрх толгойлсон 45 насанд хүрсэн эх, 50 насанд хүрсэн эцэг.

**Тэтгэвэр** 2015 оны 2 дугаар сарын 1-нээс тэтгэврийн хэмжээ нь 115,000 төгрөгөөс 126,500 төгрөг болж нэмэгдсэн.

**Тэтгэвэр авах эрх** Ажил хийж байгаагүй, эсвэл албан журмаар болон сайн дураар нийгмийн даатгалд 10-аас доош жил шимтгэл төлсөн учраас нийгмийн даатгалын тэтгэврийн сангаас тэтгэвэр авах эрх үүсээгүй иргэн

**Санхүүжилт** Улсын төсвөөс санхүүждэг нийгмийн халамжийн сан

**Тэтгэвэр авагчид** 2013 онд 1,693 өндөр настан<sup>32</sup>

Ахмад настан, олон хүүхэдтэй эхчүүдэд олгож буй мөнгөн тусламжийн талаарх мэдээллийг Хүснэгт 16-д оруулав.

### Хүснэгт 16. Нийгмийн халамжийн бусад мөнгөн тусламж, дэмжлэг

| Тусламж, дэмжлэг                         | Хууль эрх зүйн хүрээ                                                                                                                                                   | Зорилтот бүлэг /Эрх үүсэх нөхцөл                                                                                | Тусламж, дэмжлэгийн хэмжээ                                                                                  | Хамралт                                                           |
|------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------|
| Ахмад настанд зориулсан нэмэлт тэтгэмж   | Монгол улсын баатар, хөдөлмөрийн баатар, ардын болон гавьяат цолтон ахмад настанд төрөөс олгох нэмэгдлийн тухай хууль, 2008; Засгийн газрын 2012 оны 70 дугаар тогтоол | Монгол Улсын болон Хөдөлмөрийн баатар, ардын болон гавьяат цолтон зэрэг одон медалиар шагнуулсан ахмад настнууд | Сард 150,000-200,000 төгрөг                                                                                 | 2013 онд 4,800 хүн хамрагдаж, 4.9 тэрбум төгрөг зарцуулсан байна. |
| Олон хүүхэдтэй эхчүүдэд олгох тэтгэмж    | Нийгмийн халамжийн тухай хуулийн 13.5.9 дэх заалт (2012)                                                                                                               | “Эхийн алдар” нэг ба хоёрдугаар зэргийн одонтой эхчүүд                                                          | 1 дүгээр зэргийн одонтой эхэд 200,000 төгрөг, 2 дугаар зэргийн одонтой эхэд 100,000 төгрөгийг жилд нэг удаа | 2013 онд 202,500 хүн хамрагдаж, 29 тэрбум төгрөг зарцуулсан.      |
| Ахмад настанд үзүүлэх тусламж, хөнгөлөлт | Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуулийн 5.1.1-5.1.11 дэх заалтууд                                                                                               | Эмэгтэй 55-аас дээш, эрэгтэй 60-аас дээш насны ахмадууд                                                         | 11 төрлийн хөнгөлөлт, тусламжийн үйлчилгээ                                                                  | 2013 онд 126,000 хүн хамрагдаж, 14.3 тэрбум төгрөг зарцуулсан.    |

Эх үүсвэр: НХҮЕГ

<sup>32</sup> ХАХНХЯ-ны 2013 оны Тайлан сэтгүүл

## Ахмад настанд үзүүлэх асрамж, халамжийн үйлчилгээ

### Ахмад настанд зориулсан олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ

Энэ үйлчилгээнд зөвлөгөө өгөх, сэргээн засах үйлчилгээнд хамруулах, түр байрлуулан асрамжлах, өдрийн үйлчилгээнд хамруулах, гэрийн асрамж, халамжийн үйлчилгээнд хамруулах зэрэг үйлчилгээ орно. Эдгээрийг Нийгмийн халамжийн тухай хуулийн 17.1.1, 18.1, 18.2.12 дахь заалтуудаар зохицуулж байна.

2013 оноос хойш энэхүү халамжийн үйлчилгээг орон нутгийн төсвөөс санхүүжүүлж байна. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд шаардагдах хөрөнгийг сум, хорооны Амьжиргааг дэмжих зөвлөлийн саналыг үндэслэн аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага тооцож төсөвлөнө. Сонгогдсон саналыг орон нутгийн Засаг даргын Тамгын газраас батална.

2014 онд нийт 28,300 ахмад настан энэ хөтөлбөрөөс тусламж, үйлчилгээ авсан байна.

### Ахмадуудад зориулсан төрөлжсөн асрамжийн үйлчилгээ

Энэ үйлчилгээ нь тэжээн тэтгэх хүүхэдгүй, бие даан амьдрах чадваргүй ганц бие, эсхүл тэжээн тэтгэх хүүхэд нь ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй улмаас дэмжлэг, туслалцаа үзүүлэх чадваргүй болох нь тогтоогдсон ганц бие ахмад настануудад туслах зорилготой. Мөн энэ үйлчилгээг олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ авч буй ахмад настанууд ч авах боломжтой. Энэхүү асрамжийн үйлчилгээг Нийгмийн халамжийн тухай хуулийн 17.1.2 дахь заалтаар зохицуулдаг.

2013 оноос хойш энэхүү халамжийн үйлчилгээг орон нутгийн төсвөөс санхүүжүүлж байна. Төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хамруулах тухай ахмад настны өргөдлийг аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга батална. 2013 онд 320 ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн төрөлжсөн асрамжийн 9 төвд асруулж байжээ<sup>33</sup>.

Ахмад настанд зориулсан нийгмийн хамгааллын хөтөлбөрүүдийн хураангуйг Хүснэгт 17-д нэгтгэн оруулав.

#### Хүснэгт 17. Ахмад настанд зориулсан нийгмийн хамгааллын хөтөлбөрүүдийн хураангуй

| Хөтөлбөр                                                               | Үр шим хүртэгсдийн тоо                                                                                                                                                                               |
|------------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Нийгмийн даатгалын сангаас олгох өндөр насны цалинд суурилсан тэтгэвэр | 2013 онд 232,147 хүн энэ тэтгэвэрт хамрагдсан нь 60-аас дээш насны эрэгтэй, 55-аас дээш насны эмэгтэй нийт хүн амын тооноос давж байна (хөнгөлөлттэй нөхцөлөөр эрт тэтгэвэрт гарсан хүний тоо орсон) |
| Нэрийн данснаас олгох өндөр насны тэтгэвэр                             | Эхний даатгуулагчийн тэтгэвэр авах эрх 2015 онд үүснэ.                                                                                                                                               |
| Цэргийн албан хаагчдын тэтгэвэр                                        | 2013 онд 15,600 хүн                                                                                                                                                                                  |
| Нийгмийн халамжийн сангаас олгох өндөр насны тэтгэвэр                  | 2013 онд 1,693 өндөр настан                                                                                                                                                                          |
| Ахмад настанд зориулсан нийгмийн халамжийн мөнгөн дэмжлэг, тусламж     | 2013 онд 333,300 хүн (давхардсан тоогоор)                                                                                                                                                            |
| Эх үүсвэр: НДЕГ, НХҮЕГ, 2015                                           |                                                                                                                                                                                                      |

<sup>33</sup> ХАХНХЯ-ны 2013 оны Тайлан сэтгүүл

## Бодлогын болон хэрэгжүүлэлтийн түвшинд тулгарч буй асуудлууд

### Бодлогын хийдэл

#### Хамралт

Сайн дураар нийгмийн даатгалд хамрагдах хувь ялангуяа залуучууд, малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн дунд маш доогуур байна. Үүнийг өндөр насны тэтгэврийн санд шимтгэл төлөх талаарх тэдний мэдлэг мэдээлэл дутмаг, сонирхолгүй байгаатай холбон тайлбарлаж болох юм.

#### Санхүүжилт

Нийгмийн даатгалын сангаас олгох цалинд суурилсан тэтгэврийн хөтөлбөр нь одоогоор эв санааны нэгдлийн зарчмаар ажиллаж байна. Гэхдээ уг тэтгэврийн сан нь ихээхэн алдагдалтай байгаа бөгөөд хэдийгээр 1999 онд нэвтрүүлсэн Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны хөтөлбөрийн үр нөлөөг тооцсон ч цаашид энэ алдагдал өсөхөөр байгааг хэтийн тооцоо харуулж байна.

#### Тэтгэвэр

Нийгмийн даатгалын сангаас олгох өндөр насны, тэжээгчээ алдсаны тэтгэвэр, түүнчлэн нийгмийн халамжийн тэтгэврийн хэмжээг амьжиргааны өртгийн өсөлттэй уялдуулан индексжүүлдэггүй, тэтгэврийн хэмжээг тухайн үеийн шийдвэрээр шинэчлэн тогтоодог.

#### ЦСТТ ба

#### НДТ-ны

#### зөрчил

Одоогийн тэтгэврийн тогтолцоогоор 1960 оноос хойш төрсөн ажиллагчдын авах тэтгэвэр 1960 оноос өмнө төрсөн хүмүүсийнхээс бага тогтоогдохоор байна. НДТ-ноос олгох тэтгэврийн хэмжээ нь мөн ОУХБ-ын 102 дугаар конвенцид заасан стандартаас доогуур байхаар байна.

#### Тэтгэврийн

#### нас

Тэтгэвэрт гарах нас, ялангуяа эмэгтэйчүүдийн хувьд хангалттай хэмжээний тэтгэвэр тогтооход төдийгүй сангийн тогтвортой байдлыг хангахад хэтэрхий доогуур байна.

#### Тэгш хандах

Эмэгтэйчүүдийн тэтгэврийн нас эрэгтэйчүүдийнхээс бага байгаа бөгөөд ингэснээр тэдний шимтгэл төлөх жил нь ч багасах учраас бага тэтгэвэр авахад хүргэж байна. Үүнээс гадна ижил төстэй ажлын байран дээр, мэргэжлийн үр чадварын түвшин нь ч адилхан байхад эмэгтэйчүүд гол төлөв бага цалин авах хандлагатай байдаг.

## Хэрэгжүүлэлтийн түвшинд гарч буй асуудлууд

#### Цэргийн алба

#### хаасны тэтгэвэр

Цэргийн албан хаагчийн тэтгэвэр хэт өгөөмөр байгаа нь бусад тэтгэврийн санд даатгуулсан даатгуулагчдын дунд эргэлзээ төрүүлж байна.

#### Засаглал

Тогтмол актуар шинжилгээ хийгддэггүй, байгууллагын чадавхи, дэд бүтэц хангалтгүй байгаа зэрэг нь сангийн үр ашигтай, тогтвортой байдалд эрсдэл учруулж болзошгүй юм.

## Дүгнэлт, зөвлөмжүүд

Хувийн хэвшилд ажиллагчид болон төрийн албан хаагчдын өндөр насны тэтгэврийн даатгалд хамрагдалт өндөр байна. Харин уг даатгалд малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, албан бүс эдийн засагт ажиллагчдын хамрагдалтыг нэмэгдүүлэх зорилгоор удаа дараа хүчин чармайлт гаргаж байгаа боловч тэдний ердөө 23.4 хувь нь нийгмийн даатгалд сайн дураар шимтгэл төлж байна. Тиймээс ҮСҮХ-ээс малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, албан бүс эдийн засагт ажиллагчдыг тэтгэврийн даатгалд заавал хамруулах, төрөөс шимтгэлийн татаас (50 хувийг нь хариуцахыг санал болгосон) олгохыг зөвлөсөн юм. Ийнхүү бүхэлдээ албан журмын тогтолцоонд шилжихэд хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах механизмыг сайжруулах шаардлагатай болно. Мөн үрт хугацааны асрамжийн үйлчилгээг илүү цогц байдлаар үзүүлэх арга замыг боловсруулах талаар анхаарах нь зүйтэй.

Хүснэгт 18-д ҮСҮХ-ийн явцад гарсан зөвлөмжүүдийг нэгтгэн харуулав. Нийгмийн хамгааллын шинэ зохицуулалт бий болгох, эсвэл одоогийн зохицуулалтынх нь хамрах хүрээг өргөжүүлэх шаардлагатайг илэрхийлсэн зөвлөмжийг (\*)-оор тэмдэглэв. Эдгээр нэмэлт зохицуулалтыг нэвтрүүлэх, хамрах хүрээг өргөжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог ОУХБ-ын РАП загвараар тооцоолсон болно. Зарим зөвлөмжийг хэрэгжүүлэхэд хэрэгцээтэй хөрөнгийн хэмжээг тооцохын тулд техник эдийн засгийн илүү нарийвчилсан үнэлгээ, актуар судалгаа хийх шаардлагатай юм. Эдгээр зөвлөмжийг хүснэгтэд (Δ)-аар тэмдэглэсэн болно.

**Хүснэгт 18. ҮСҮХ-ээс ахмад настны нийгмийн хамгааллыг баталгаажуулах чиглэлд гаргасан зөвлөмжүүд**

|   | Гол зөвлөмжүүд                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                           |
|---|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| △ | ӨН1. Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн тэтгэвэрт гарах насыг ижил болгох.<br>ӨН2. Өндөр насны тэтгэврийн гурван давхаргат тогтолцоог нэвтрүүлэх: Давхарга 0: бүх нийтийн суурь тэтгэвэр; Давхарга 1: Нийгмийн даатгалын тэтгэвэр; Давхарга 2: Нэмэлт хувийн хуримтлалын данс.                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                   |
| * | ӨН3: Нийгмийн даатгалд хамрагдалтыг урамшуулах замаар малчид, бусад хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн өндөр насны орлогын баталгааг сайжруулах. Зорилтот бүлгийн хүн амын даатгалд хамрагдалтыг нэмэгдүүлэх зорилгоор урамшуулал болгож шимтгэлд төрөөс татаас олгох. Бүх ажиллагчдыг заавал хамруулахад чиглэсэн шинэчлэл хийх.                                                                                                                                                                                                                                                                                                                                             |
| △ | ӨН4. Өндөр настнуудад үрт хугацаанд асаргаа сүвилгаа, орлогын дэмжлэг үзүүлэх тогтолцоог хөгжүүлэх: асрамжийн газрууд байгуулах, нийгмийн ажилд ахмад хүмүүсийн оролцоог дэмжсэн хөтөлбөрүүд(жишээ нь хүүхэд харах)-д хамруулах, богино хугацааны ажил олгох (жишээ нь зөвлөх эмч).                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                      |
| * | ӨН5: Нийгмийн халамжийн тэтгэврийн хэмжээг ХҮИ-тэй уялдуулан индексжүүлж байх.                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                           |
|   | ӨН6. Нийгмийн даатгалд (тэтгэврийн даатгалын санд ч бас адил) сайн дураар шимтгэл төлөх илүү уян хатан нөхцөл бий болгох, ялангуяа малчдын шимтгэл төлөх хугацааг өөрчилж (жилд 2 удаа төлөх боломж бүрдүүлэх), Малчдын орлого олох улирлын онцлогтой уялдуулан сайн дурын нийгмийн даатгалын шимтгэлээ жилд хоёр удаа төлөх боломжийг бий болгох (эсвэл илүү уян хатан болгож, жилд нэг удаа төлүүлэх), төлөгдөөгүй шимтгэлийг тодорхой хугацааны дотор нөхөн төлөх боломж олгох (2014 оны 1 дүгээр сард шимтгэл төлөх хугацаанд өөрчлөлт оруулсан); (Энэ зөвлөмж нь ХН4 ба ЭМ2 зөвлөмжүүдтэй уялдсан ба тэтгэврийн даатгал болон ЭМД-ын шимтгэл төлөхөд мөн хамаарна). |
|   | Нэмэлт зөвлөмжүүд                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                        |
| △ | ӨН7: Тэтгэвэр тогтоох параметр үзүүлэлтүүдийг өөрчлөх ( мөн тэтгэврийн хэмжээг ХҮИ-тэй уялдуулан индексжүүлж байх) замаар НДТ-оос олгох тэтгэврийн түвшин доогуур тогтоогдохоор байгааг шийдвэрлэх.                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                      |
| △ | ӨН8: 1960 оноос хойш төрсөн даатгуулагчид эрт тэтгэвэрт гарах тохиолдолд тэдэнд зориулсан нэмэлт тэтгэвэр олгох шинэ тогтолцоог нэвтрүүлэх.                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                              |
| △ | ӨН9. Ядуу амьдралтай ахмад настнуудад мөнгөн ба түүнтэй адилтгах тусламж дэмжлэг үзүүлж буй одоогийн нийгмийн халамжийн хөтөлбөрүүд дээр тулгуурлан илүү уялдаа холбоо бүхий нэгдсэн тусламжийн багц бий болгох, ингэхдээ одоогийн хөтөлбөрт тавигдаж буй шалгуурыг хэвээр үлдээх.                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                       |
|   | ӨН10: Тэтгэврийг индексжүүлэхээс гадна нийгмийн даатгалд хамрагдаж, шимтгэл төлөх хүсэл эрмэлзлэлийг бууруулахгүйгээр тэтгэврийн доод хэмжээг боломжийн түвшинд нэмэгдүүлэх.                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                             |
| △ | ӨН11: Ядуу амьдралтай ахмад настнуудад зориулан (нас ба орлогын шалгуураар олгодог) нийгмийн халамжийн тусламж үйлчилгээний нэгдсэн багцыг бий болгох. Үүнд орон сууц, түлшний үнийн хөнгөлөлт, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний өргөжүүлсэн багц, өндөр насны тэтгэврийн шинэ тогтолцооны хүрээнд олгох суурь тэтгэвэр зэргийг хамруулах.                                                                                                                                                                                                                                                                                                                            |
| △ | ӨН12: Нийгмийн даатгалд хамрагдах журмыг хялбаршуулж, сумын түвшинд цахим файл, шимтгэлээ гар утсаараа дамжуулан төлөх мэдээллийн технологийн систем зэргийг нэвтрүүлэх.                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                 |



## 5. Хоёрдугаар үе шат: Зардал тооцох аргачлал, нийгмийн хамгааллын суурь түвшинг хангах бодлогын саналууд(“хувилбарууд”)-ын тайлбар, зардлын тооцоолол

### РАП загварыг ашиглан өртөг зардал тооцох аргачлал

НҮБХС/ОУХБ-ын зардал тооцох өмнөх арга дээр үндэслэн ОУХБ-аас шинэчлэн боловсруулсан Түргэвчилсэн үнэлгээний протокол буюу РАП загварыг энэхүү тооцоололд ашиглав.

Зардлын тооцооллоор дараах үр дүн гарна. Үүнд:

- ҮСҮХ-ээс гаргасан зөвлөмжүүдийн дагуу Монгол улсад нийгмийн хамгааллын суурь түвшинг хангахын тулд хэрэгжүүлж болох бодлогын хувилбарууд (нийгмийн хамгааллын нэмэлт зохицуулалтууд)
- Санал болгож буй нийгмийн хамгааллын зохицуулалтууд хэрэгжих боломжтой эсэхийг урьдчилан таамаглахын тулд эдгээр бодлогын хувилбаруудын зардлыг төгрөгөөр тооцож, үр дүнг ДНБ, улсын төсвийн орлого, зарлагатай харьцуулсан байдал, мөн улсын төсвийн төсөөлөлд тооцооны үр дүнг тусган харуулах боломжтой.

Энэхүү зардал тооцох ажлаас гарсан үр дүнг нийгмийн хамгааллын бодлогын тэргүүлэх чиглэлүүд, төсвийн боломж болон улсын төсвийн дахин хуваарилалтын талаар төрийн бусад яам, агентлагуудтай яриа хэлэлцүүлэг хийхэд ашиглаж болно.

РАП загвар нь насаар гаргасан хүн амын хэтийн тооцоо, ажиллах хүчний оролцооны түвшний тооцоон дээр үндэслэсэн энгийн аргачлал хэрэглэдэг. РАП загвар нь өөрийн хэтийн тооцооллыг гаргахыг зорьдоггүй учраас тухайн улс орны хүн ам зүйн хэтийн тооцоо, хөдөлмөрийн зах зээлийн

болон эдийн засгийн үзүүлэлтүүдийн бэлэн тоо мэдээлэлд үндэслэн зардлын төсөөллийг тооцож гаргадаг юм. Тиймээс нийгмийн хамгааллын суурь түвшинг хангахад шаардагдах зардлыг 2020 он хүртэл хугацаагаар тооцож гаргалаа. Тоо мэдээллийн эх үүсвэр, гол таамаглал болон суурь тооцооллыг доор оруулав.

#### Нутаг дэвсгэрийн ба засаг захиргааны нэгжүүд

Монгол Улс нь нутаг дэвсгэрийн хэмжээгээр дэлхийд 18 дугаарт ордог бөгөөд ОХУ, БНХАУ-тай хиллэдэг. Монгол Улс 21 аймагтай, нийслэл нь Улаанбаатар хот. 2006 оноос хойш Монгол Улс 331 сумтай байна.

#### Хүн амын тоо мэдээлэл ба хэтийн тооцоо

РАП загвар нь Үндэсний статистикийн хорооноос гаргасан хүн ам зүйн бодит болон хэтийн тооцооллын тоон мэдээллийг ашигласан. РАП загварын тооцоололд Монгол Улсын суурин хүн ам өөрөөр хэлбэл, тухайн жилд 6 сар буюу 183 хоногоос доошгүй хугацаанд оршин суусан бөгөөд Монгол Улсын засаг захиргааны нэгжид бүртгэлтэй хүн амыг авч үзсэн. Харин хүн амын энэ тооцоонд тухайн жилд 6 сараас дээш хугацаагаар гадаадад байсан Монгол Улсын иргэдийг оруулаагүй болно. ҮСХ-ны энэхүү тоо мэдээлэл нь 2010 оны хүн амын тооллого дээр суурилсан бөгөөд ҮСХ-ны тогтмол давтамжтай явуулдаг түүвэр судалгаануудын дүнгээр шинэчлэгдсэн байна.

Зардлын тооцоололд ҮСХ-ны 2011-2020 оны хүн амын хэтийн тооцоог ашигласан. Хэтийн тооцоо нь тус улсын нас баралт болон төрөлтийн дундаж хувилбарын таамаглалд үндэслэсэн байна. Үүнээс гадна шилжилт хөдөлгөөнийг тэгтэй тэнцүү гэж тооцжээ.


2013 онд Монгол Улсын эрэгтэйчүүдийн дундаж наслалт 65.42, эмэгтэйчүүдийнх 75.01 байв (Хүснэгт 19).


#### Хүснэгт 19. Монгол Улсын хүн амын дундаж наслалт 2007-2013

| Дундаж наслалт | 2007  | 2009  | 2011  | 2013  |
|----------------|-------|-------|-------|-------|
| Бүгд           | 66.54 | 67.96 | 68.32 | 69.11 |
| Эрэгтэй        | 63.13 | 64.33 | 64.68 | 65.42 |
| Эмэгтэй        | 70.23 | 71.79 | 73.76 | 75.01 |

Эх үүсвэр: ҮСХ, Монгол Улсын Статистикийн эмхэтгэл, 2013.

#### Зураг 11. 15-аас дээш насны нийт хүн амын тоо, засварласан тооцоо (2012), (а) эрэгтэй (б) эрэгтэй





Эх үүсвэр: ҮСХ

### Ажиллах хүчний оролцооны түвшин

15, түүнээс дээш насны хүн амын ажиллах хүчний оролцооны түвшний мэдээллийг ҮСХ-ны 2006-2012 онуудын Ажиллах хүчний түүвэр судалгаанаас авсан бөгөөд энэ үзүүлэлт нь ОУХБ-ын гаргадаг статистик мэдээллийн багцад (ILO STAT) ордог юм. ҮСХ нь ажиллах хүчний оролцооны түвшний хэтийн тооцоог хийдэггүй. ҮСХ-ны ажиллах хүчний оролцооны түвшний талаарх тоо мэдээлэл дээр үндэслэн ОУХБ-ын "ILO-LAB" загвараар<sup>34</sup> тооцсон 2013-2020 оны ажиллах хүчний оролцооны түвшингийн таамаглалыг РАП загварын тооцоололд ашиглав. ILO-LAB загварын тооцоонд ирэх таван жилд бүх насны бүлгийн хувьд ажиллах хүчний оролцооны түвшин харьцангуй тогтвортой байна гэж таамагласан.

Ажиллах хүчний оролцооны бодит болон таамаглаж буй өгөгдлүүдийн хувьд ҮСХ-ны ашигласан 15-аас дээш насны хүн амын тоо нь хүн амын энэ бүлгийн бодит тооноос зөрүүтэй байна. Энэ зөрүү нь Зураг 11-т үзүүлсэнчлэн нас залуу бүлгүүд дээр ажиглагдаж байна. ҮСХ энэ зөрүүний талаар тайлбар өгч чадаагүй юм. Иймд РАП загварын тооцоололд нийт хүн ам, ялангуяа залуу хүн амыг илүү төлөөлөх чадварыг нь харгалзан 15-аас дээш насны хүн амын бодит тоог энэхүү ажиллах хүчний оролцооны тооцоонд ашигласан болно.

### Хөдөлмөрийн хөлсний доод болон дундаж хэмжээ

Монгол Улсад хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2010 онд баталсан Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай хуулийн дагуу Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт үндэсний хорооны шийдвэрээр тогтоодог. 2014 оны хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ 2013 оныхтой ижил буюу сарын 192,000 төгрөг байв. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2005 оноос инфляци болон хөдөлмөрийн бүтээмжтэй уялдуулан индексжүүлж байсан гэж төсөөлөн 2014 оноос хойш уг доод хэмжээг инфляцийн түвшин, хөдөлмөрийн бүтээмжтэй уялдуулан өсгөнө гэж РАП таамагласан.

Хөдөлмөрийн хөлсний дундаж хэмжээ(өмнөх тоо мэдээ болон таамаглал)-г 2005-2012 оны Ажиллах хүчний судалгаанаас авсан. 2013 оноос хойшхи цалингийн дундажийг хөдөлмөрийн бүтээмж болон инфляцийн түвшний өсөлт дээр үндэслэн засварлаж тооцсон.

<sup>34</sup> 2014 онд ХАХНХЯ-ны захиалгаар тэтгэврийн даатгалын хамрах хүрээг өргөжүүлж малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, албан бүс эдийн засагт ажиллагчдыг хамруулах хөтөлбөрийн дизайныг боловсруулахын тулд зэрэгцээ актуар судалгаа хийх зорилгоор ILO-LAB загварыг боловсруулсан.

**Хүснэгт 20. Өрхийн сарын дундаж орлогын эх үүсвэрүүд (2012 оны 4-р улирлын байдлаар, төгрөгөөр)**

|                                                                                                                                         | Үндэсний<br>дундаж | Нийслэл<br>хот | Аймгийн<br>төвүүд | Сумын<br>төвүүд | Хөдөө          |
|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------|----------------|-------------------|-----------------|----------------|
| <b>Нийт орлого</b>                                                                                                                      | 852,267            | 1,021,938      | 828,034           | 719,301         | 651,785        |
| <b>1. Мөнгөн орлого</b>                                                                                                                 | <b>780,769</b>     | <b>988,080</b> | <b>780,932</b>    | <b>654,014</b>  | <b>490,012</b> |
| Цалин, хөлс                                                                                                                             | 391,244            | 560,887        | 401,311           | 355,994         | 109,161        |
| Тэтгэвэр, тэтгэмж, бусад шилжүүлэг                                                                                                      | 163,052            | 183,343        | 172,053           | 146,049         | 128,623        |
| Мал аж ахуйн орлого                                                                                                                     | 58,377             | 3,725          | 20,133            | 37,386          | 198,177        |
| Хөдөө аж ахуйн орлого (ургац,<br>хадлан гэх мэт)                                                                                        | 2,192              | 574            | 4,754             | 3,956           | 2,579          |
| Хөдөө аж ахуйн бус аж ахуйн үйл<br>ажиллагааны орлого                                                                                   | 100,189            | 165,773        | 97,096            | 46,996          | 17,805         |
| Бусад орлого                                                                                                                            | 65,714             | 74,297         | 85,586            | 63,633          | 33,667         |
| <b>2. Үнэ төлбөргүй авсан хүнсний болон<br/>хүнсний бүс зүйлсийн үнэ цэнэ</b>                                                           | <b>28,004</b>      | <b>29,487</b>  | <b>26,399</b>     | <b>17,392</b>   | <b>32,365</b>  |
| <b>3. Өөрийн эдийн засгийн үйл<br/>ажиллагаанаас хэрэглэсэн хүнсний<br/>бүтээгдэхүүний үнэ цэнэ (мал аж<br/>ахуй болон ногоо тарих)</b> | <b>43,495</b>      | <b>4,371</b>   | <b>20,702</b>     | <b>47,894</b>   | <b>129,408</b> |

Эх үүсвэр: ҮСХ, 2014, Өрхийн нийгэм-эдийн засгийн судалгаа

ҮСХ нь 1966 оноос эхлэн “Өрхийн орлого, зарлагын судалгаа (ӨОЗС)”-г, 2007 оноос ӨОЗС болон “Амьжиргааны түвшний түүвэр судалгаа”-г нэгтгэн “Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа”-г хийж ирсэн байна. Жил бүр энэхүү судалгаагаар 11,232 өрхийг түүвэрлэн нас, хүйс, ажил эрхлэлт, өрхийн орлого, зарлага болон хэрэглээний талаар мэдээлэл цуглуулдаг. Жишээлбэл, судалгааны үр дүнд өрхийн орлогын мэдээллийг оршин суугаа газар, ажил мэргэжлийн бүлгээр ангилж гаргадаг. “Хөдөө” гэдэг ангилалд малчдын орлогыг оруулж тооцдог (Хүснэгт 20). ҮСХ нь Улаанбаатар хот, аймгийн төвүүд болон бусад хотод оршин сууж буй хүн амыг хотын хүн ам гэж тодорхойлдог. Сумын төв болон хөдөө орон нутагт оршин сууж буй хүн амыг хөдөөний хүн амд оруулж байна

### **Ядуурлын үзүүлэлтүүд**

ҮСХ нь 1998 оноос эхлэн бүсийн ялгаатайгаар “амьжиргааны доод түвшин” буюу үндэсний ядуурлын шугамыг тодорхойлж ирсэн. Амьжиргааны доод түвшин гэж мөнгөн дүнгээр илэрхийлсэн хэрэглээний доод түвшинг хэлнэ. Хэрэглээний доод түвшин гэдэг нь хүнсний болон хүнсний бүс хэрэглээний сагсаар шинжлэх ухааны үндэслэлтэй тогтоосон хүний наад захын хэрэглээний тоо хэмжээ юм. 2013 онд хүн амын амьжиргааны доод түвшин сард 130,500-149,900 төгрөг байв.

Ядуурлын хамрах хүрээний индекс гэж хэрэглээ нь ядуурлын шугам буюу амьжиргааны доод түвшнээс доогуур байгаа хүн амын хувь хэмжээ юм. Хамгийн сүүлийн мэдээгээр 2012 онд ядуурлын хамралтын хүрээний индекс буюу ядуурлын түвшин 27.5 хувь байв. Ядуурлын түвшин 2013 онд 25.0 хувь байна гэж ҮСХ төсөөлж байна. Харин РАП загварт ирэх таван жилийн хугацаанд ядуурлыг буурах бөгөөд 2020 он гэхэд ядуурлын хамралтын хүрээний индекс 20.0 болно гэж таамаглаж байна.

### **Нэрлэсэн ба бодит ДНБ, ДНБ-ий дефлятор**

ДНБ-ий 2005-2012 оны мэдээллийг ҮСХ-ноос гаргадаг Монгол Улсын Статистикийн эмхэтгэлээс авсан. Сангийн яамны Төсвийн хүрээний дунд хугацааны мэдэгдэл(ТХДХМ)-д макро эдийн засгийн хэд хэдэн үзүүлэлтүүд, таван жилийн төсөөлөл тусгагдсан байна. РАП загварын тооцоонд 2014 оны 9 дүгээр сард батлагдсан ТХДХМ-д тусгагдсан гүйцэтгэлийн мэдээ болон төсөөллийг ашиглав.

2017 оноос хойш (олдсон мэдээлэлдээ тулгуурлан) ДНБ-ий өсөлт болон ДНБ-ий дефлятор тогтмол буюу жилийн 5.9 хувийн өсөлттэй, тогтмол 3.6 хувийн дефлятортой байхаар таамаглаж байна.

РАП загвар нь шинээр нэвтрүүлэх нийгмийн хамгааллын арга хэмжээнүүдийн зардлыг оны үнээр тооцсон ДНБ-нд эзлэх хувиар тооцож гаргадаг.

### **Инфляци**

Инфляцийн хувьд РАП нь инфляцийн жилийн дундаж түвшинг ашигласан. Энэ үзүүлэлтийг ХҮИ-ийг ашиглан жилийн эцэст тооцдог жилийн инфляцийн түвшинд харьцуулсан (Суурь он: 2010) 2005-2013 оны тоо мэдээллийг ҮСХ-оос авсан. 2013-2017 оны төсөөллийн хувьд, Сангийн яамнаас 2014 оны 9 дүгээр сард гаргасан ТХДХМ-ийн мэдээллийг ашигласан болно. РАП загварын тооцоонд 2017 оноос хойш инфляци тогтмол 6.0 хувьтай байна гэж таамаглаж байна.

### **Хөдөлмөр эрхлэлт ба ажилгүйдлийн түвшин**

РАП загвараар 15, түүнээс дээш насны нийт хүн амд үндэслэн хөдөлмөр эрхэлж буй болон ажилгүй байгаа хүмүүсийн тоо, ажилгүйдлийн түвшинг дахин тооцсон. Ингэхдээ 2014 оны 9 дүгээр сард Сангийн яамнаас гаргасан ТХДХМ-д тусгасан ажилгүйдлийн түвшинг ашиглав. 2017 оноос хойшхи хугацаанд ажилгүйдлийн түвшин тогтмол 5.9 хувь байна гэж таамагласан. Бүх насныхны ажилгүйдлийн түвшний чиг хандлага 2013 оноос хойшхи 15-29 насны бүлгийн ажилгүйдлийн түвшний төсөөлөлд мөн хамаарна гэж үзсэн. Харин хөдөлмөр эрхлэлт болон ажилгүйдлийн түвшний төсөөллийг хүйсээр ангилсан ямар ч мэдээлэл байхгүй байна.

### **Эрүүл мэндийн зарлага**

Эрүүл мэндийн яамны харьяа Эрүүл мэндийн хөгжлийн төв эрүүл мэндийн статистик мэдээллийг цуглуулж, ҮСХ-нд эрүүл мэндийн статистикийн сарын тайлан мэдээг сар тутам, жилийн тайланг дараа оны гуравдугаар сард ирүүлдэг.

Инфляци, хүн амын өсөлтөөс шалтгаалан эрүүл мэндийн зарлага өснө гэж РАП таамаглаж байна. Гэхдээ энэ зарлагын дийлэнх хэсэг нь Улаанбаатар хотын хүн амын эрүүл мэндийн үйлчилгээнд хамаардаг учраас дээрх төсөөлөл нь эрүүл мэндийн зарлагын бодит өсөлтийг дутуу тооцоолж байж болох юм.

### **Улсын төсвийн нийт орлого, буцалтгүй тусламж ба зарлага**

Өртөг зардал тооцох энэхүү ажилд ашигласан улсын төсвийн нийт орлого, буцалтгүй тусламж, зарлагын талаарх тоо баримт нь Сангийн яамнаас гаргасан ТХДХМ-д тусгагдсан түүхэн мэдээлэл болон төсөөлөлд үндэслэсэн болно. Засгийн газрын дээрх зарлага, орлого нь бодлого тогтвортой өөрөөр хэлбэл, одоогийн бодлогод ямар нэг өөрчлөлт ороогүй нөхцөлд хамаарна. РАП нь нийгмийн хамгааллын шинээр нэвтрүүлж буй арга хэмжээний зардлыг улсын төсвийн орлого, буцалтгүй тусламжийн төсөөлөл болон зарлагад эзлэх хувиар тооцож гаргасан. Үүнд улсын нэгдсэн төсвийн орлого, зарлага болон ХХСийн орлого, зарлагыг авч үзсэн болно. Иймээс орон нутгийн төсөв, НДС-ийн орлого, зарлагыг оруулаагүй учраас улсын төсвийн орлого, зарлага дутуу тооцогдсон байж болох талтай.



### 5.1. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ

“Эхэд үзүүлэх тусламж, үйлчилгээг оруулан үндэснийхээ түвшинд тодорхойлсон (олдоц, хүртээмж, хэрэгцээ, чанарын шалгуурт нийцсэн) эрүүл мэндийн нэн шаардлагатай тусламж, үйлчилгээний багц”

Эрүүл мэндийн даатгал (ЭМД)-д бүх хүн ам хамрагдсан ч эрүүл мэндийн чанартай үйлчилгээг хүртэх явдал хөдөө орон нутгийн олон хүнд хүндрэлтэй хэвээр байна. Тухайлбал, сүүлийн жилүүдэд ЭМД-ын хамрах хүрээ 6 хувиар буурсан явдал нь хэрэглэгчид үйлчилгээнд сэтгэл дундуур байгаагийн илрэл байж болох юм. Даатгуулагчид шимтгэл төлж байгаа мөртлөө янз бүрийн оношлогоо, үйлчилгээ хийлгэх, эмнэлгийн багаж төхөөрөмж ашигласны төлөө хувиасаа зардал төлөх болдог зэргээс тэдний ЭМД-д итгэх итгэлийг алдагдуулж байгаа нь олон судалгаанаас харагдаж байна. Нийгмийн даатгалд нийт хүн ам бүрэн, тогтвортой хамрагдсан байхын зэрэгцээ нийгмийн даатгалын сангийн тогтвортой байдлыг хангахын тулд одоо мөрдөгдөж буй бодлогод өөрчлөлт оруулаагүй буюу тогтвортой байх нөхцөлийг хэд хэдэн хувилбартай харьцуулж үзэв. Хамгийн сүүлийн хувилбарт I ба II ангиллын даатгуулагчдад шимтгэлийн татаасыг олгох болон орлогын шалгуураар зорилтот бүлэгт олгох хувилбаруудыг харьцуулан гаргасан болно.

#### Хүснэгт 21. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хамралттай холбоотой хувилбарууд

|                 |                                                                                                                                                                                                             |
|-----------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Хувилбар ЭМ1-0: | Одоогийн буюу бодлого тогтвортой байх нөхцөлд: II ангилал(малчид, ажилгүйчүүд болон мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвд суралцагсад)-ын даатгуулагчдын ЭМД-ын сарын шимтгэлийг 670 төгрөг хэвээр байлгах |
| Хувилбар ЭМ1-1: | II ангиллын даатгуулагчдын ЭМД-ын шимтгэлийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 1 хувь хүртэл өсгөх                                                                                                         |
| Хувилбар ЭМ1-2  | IIр ангиллын даатгуулагчдын ЭМД-ын шимтгэлийг төрөөс бүрэн хариуцах                                                                                                                                         |
| Хувилбар ЭМ1-3: | Орлогыг орлуулан тооцох тогтолцоог нэвтрүүлэх: II ангиллын ядуу иргэдийн ЭМД-ыг төрөөс бүрэн хариуцаж, харин ядуу бус иргэд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 1 хувьтай тэнцэх хэмжээний шимтгэл төлөх     |

Эх үүсвэр: НҮБ/ЗГ-ын хамтарсан Нийгмийн хамгааллын ажлын хэсэг, 2014

## Хувилбар ЭМ1-1: II ангиллын даатгуулагчдын ЭМД-ын шимтгэлийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 1 хувьд хүргэж өсгөх

### Таамаглал

- ЭМД-ын тогтолцооны II ангиллын даатгуулагчдад малчид, ажилгүйчүүд болон мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд суралцагсад багтдаг. Энэ бүлгийн 324,500 иргэний ЭМД-ын шимтгэлийг 2011 онд төрөөс хариуцаж даатгуулснаар ЭМД-д хүн ам бүрэн хамрагдсан байна. Бүх ажилгүй иргэд II ангилалд хамрагдаж, ЭМДС-д шимтгэл төлдөггүй, зарим нь хувиараа хөдөлмөр эрхлэгчид гэсэн IY ангилалд хамаарч даатгуулсан гэж үзэж байна.
- 2011 онд Засгийн газар ХХС-аар дамжуулан ЭМД-ын шимтгэлд татаас олгоход даатгуулсан хүн амын тоо нь нийт оршин суугаа хүн амаас 3 хувиар давсан байна. Тиймээс энэ зөрүү мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд суралцагсдыг II ба III ангилалд хоёуланд нь давхардуулан хамруулснаас үүссэн гэж үзсэн.
- ХХС-аас шимтгэлийг нь хариуцсан тул 2011 онд ЭМД-д хүн ам бүрэн хамрагдсан гэж үзэж, уг оныг суурь он болгосон. Харин 2011 оны даатгуулагчдын ангилал тус бүрээр нийт хүн амд эзлэх хувийг ЭМД-ын бүх нийтийн хамралтыг тооцоход ашиглав.
- Хүн амын өсөлт нь хүн амын бүх ангилалд, түүний дотор малчид, ажилгүйчүүд болон мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд суралцагсдад ч адилхан хамаарна гэж үзсэн болно.
- Хот ба хөдөөгийн хүн амын эрүүл мэндийн зарлагын ялгааг тооцохдоо хот, хөдөөгийн бүсийн 10,000 хүн тутамд ногдох эмчийн тооны зөрүүгээр тооцоолсон бөгөөд энэ тоо нь хөдөөд 18.8, Улаанбаатар хотод 43.4 байна. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний үйлчилгээний зарлагыг ийнхүү орлуулан тооцсоноор 2008 оны хувьд ойролцоогоор 2.3 гэсэн харьцаа гарч байна. (Эх үүсвэр: ДЭМБ, Монгол улсын хамтын ажиллагааны стратеги, 2010-2015). Энэ 2.3 гэсэн харьцаа нь ирэх 12 жилийн хугацаанд тогтмол байна гэж таамагласан.
- Оюутнуудын эрүүл мэндийн зардал хязгаарлагдмал байдаг учраас хөдөөгийн хүн амын эрүүл мэндийн зарлагыг II ангиллын даатгуулагчдын зарлага гэж үзэв. Ажил хөдөлмөр эрхлээгүй хүмүүсийн эрүүл мэндийн зарлагыг мөн хязгаарлагдмал гэж үзсэн (энэ бүлэгт ажилгүй иргэд цөөхөн бөгөөд ажил хөдөлмөр эрхлээгүй хүмүүсийн олонх нь бүртгэлгүй, албан бус эдийн засагт ажиллагчдын хамт хувиараа хөдөлмөр эрхлэгчид гэсэн ангилалд тоологдсон). Хөдөө орон нутагт эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, үйлчилгээний дэд бүтэц хангалтгүй, харин Улаанбаатар хотод илүү байдаг тул малчин өрхүүдийн эрүүл мэндийн үйлчилгээний хэрэглээ бага байх хандлагатай байна. Инфляци, хөдөлмөрийн бүтээмж (цалингийн өсөлт) болон хүн амын өсөлтөөс шалтгаалан эрүүл мэндийн зарлага нэмэгдэнэ гэж таамагласан. Гэхдээ эдгээр зарлагын ихэнх нь Улаанбаатар хотын хүн амд хамаарах учраас энэ таамаглалд эрүүл мэндийн зарлагын бодит өсөлтийг дутуу тооцож байж болох юм.
- Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тогтоохдоо инфляци, хөдөлмөрийн бүтээмжтэй холбож индексжүүлээгүй, харин бодлогын чанартай шийдвэрээр шинэчлэн тогтоодог. РАП-ын тооцоонд 2016 оноос хойш энэ хэмжээг хөдөлмөрийн бүтээмж болон инфляцитай уялдуулан нэмэгдүүлнэ гэж үзлээ.

### Үр дүн

II ангилалд хамаарах даатгуулагчид (малчид, ажилгүйчүүд, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн суралцагчид)-ын шимтгэлд олгосон татаасыг багасгавал гарах хөрөнгийн хэмнэлтийг энэ хувилбараар харьцуулахыг зорьсон юм. Дээрх таамаглалуудыг харгалзан үзвэл бодлого тогтвортой байх нөхцөлд уг хэмнэлт нь 2014 онд ДНБ-ий 0.02 хувь, 2020 онд ДНБ-ий 0.05 хүртэлх хувь болно.

## Хувилбар ЭМ1-2: II ангиллын даатгуулагчдын ЭМД-ын шимтгэлд бүрэн татаас олгох

### Таамаглал

- ЭМ1-1 хувилбарт хамаарах дээрх бүх таамаглал хэвээр байна.
- 2011 оныхтой адил, энэ хувилбар дээр засгийн газар Хүний хөгжил сангийн хөрөнгийг ашиглана гэж үзсэн.

### Үр дүн

Энэхүү хоёр дахь хувилбараар ЭМД-д бүх нийтийг хамруулахын тулд II ангиллын даатгуулагчид (малчид, ажилгүйчүүд, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн оюутнууд)-ын шимтгэлд бүрэн татаас олгоход гарах зардлыг бодлого хэвээр байх (сарын шимтгэлийг 670 төгрөгөөр тогтоосон) болон бага татаас (шимтгэлийн хэмжээг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 1 хувиар тогтоосон)-тай хувилбартай харьцуулан үзэхийг зорьж байна. Дээрх таамаглалуудыг харгалзан үзвэл, II ангиллын даатгуулагчдын шимтгэлд бүрэн татаас олгосноор ЭМДС-ийн зардал нь бодлого хэвээр байх одоогийн хувилбарын зардлаас гадна 2014 онд ДНБ-ий ердөө 0.06 хувь, харин 2017 оноос хойш 0.01 хувиар өснө.

## Хувилбар ЭМ1-3: Орлогыг орлуулан тооцох аргыг нэвтрүүлэх: II ангиллын даатгуулагчдад хамаарах ядуу иргэдийн төлөх шимтгэлд бүрэн татаас олгож, ядуу бус даатгуулагчид хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 1 хувьтай тэнцэх хэмжээний шимтгэл төлөх

### Таамаглал

- ЭМ1-1 хувилбарт хамаарах дээрх бүх таамаглал хэвээр байна.
- Харьцуулах зорилгоор, үндэсний хэлэлцүүлгээс II ангилалд хамаарах ядуу иргэдийн төлөх шимтгэлд бүрэн татаас олгож, уг ангиллын ядуу бус даатгуулагчид хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 1 хувьтай тэнцэх хэмжээний шимтгэл төлдөг байх хувилбарын зардлыг тооцож үзэхээр шийдсэн болно.
- Ядуу иргэдийг тодорхойлохын тулд РАП нь ядуурлын хамралтын хүрээний индексийг ашигласан. Ядуурлын хамралтын хүрээний индекс гэдэг нь ядуурлын шугамаас буюу амьжиргааны доод түвшингээс доогуур хэрэглээтэй хүн амын эзлэх хувь хэмжээ юм.
- Орлогыг орлуулан тооцох аргыг хэрэгжүүлэхэд гарах зардал нь тухайн хөтөлбөрийн зардлын 15 хувьтай тэнцэнэ гэж үзсэн.

### Үр дүн

Энэ гурав дахь хувилбарын зардлыг тооцож үзэхэд орлогыг орлуулан тооцох аргыг хэрэглэснээр гарч болох боломжит хэмнэлтийн талаар дорвитой дүгнэлт гараагүй. Учир нь энэ хувилбараар ядуу гэж тодорхойлогдсон иргэдийн 25 хувийнх нь шимтгэлд бүрэн татаас олгосноор 2016 он хүртэл огт хэмнэлт гарахгүй бөгөөд 2020 онд ч ач холбогдол багатай буюу зөвхөн 0.04 хувь байхаар байна. Энэхүү арга хэмжээнд багтах ядуу бус хүн амын тоо хэтэрхий хязгаарлагдмал (2014 онд хүн амын 6.0 хувь), мөн орлогыг орлуулан тооцох арга нь өөрөө удирдлагын/захиргааны зардал ихтэй байх тул ийм үр дүн гарна гэж үзсэн.

Хувилбаруудын нөхцөл болон тооцооны үр дүнг Хүснэгт 22-т нэгтгэн харуулав.

## Хүснэгт 22. ЭМД-тай холбоотой хувилбаруудын зардлын тооцооллын үр дүн

|                                                                                                                                                                                                   | 2014          | 2016          | 2018          | 2020          |
|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------------|---------------|---------------|---------------|
| Хувилбар ЭМ1-0: Одоогийн буюу бодлого тогтвортой байх нөхцөлд (II ангилалд сарын 670 төгрөгийн шимтгэлтэй)                                                                                        |               |               |               |               |
| Зорилтот бүлэг = ЭМД-ын II ангиллын хүн ам (мян.хүн)                                                                                                                                              | 352           | 364           | 375           | 386           |
| Хамрагдах хувь (%)                                                                                                                                                                                | 67%           | 83%           | 100%          | 100%          |
| Энэ хувилбарт хамрагдсан бүлэг (мян. хүн)                                                                                                                                                         | 235           | 303           | 375           | 386           |
| <b>Хувилбарын зардал (сая төгрөгөөр)</b>                                                                                                                                                          | <b>20,952</b> | <b>34,657</b> | <b>54,740</b> | <b>72,542</b> |
| <b>Зардлын ДНБ-нд эзлэх хувь (өнөөгийн)</b>                                                                                                                                                       | <b>0.10%</b>  | <b>0.13%</b>  | <b>0.17%</b>  | <b>0.20%</b>  |
| <b>Зардлын улсын төсвийн орлого, буцалтгүй тусламжид эзлэх хувь</b>                                                                                                                               | <b>0.34%</b>  | <b>0.47%</b>  | <b>0.54%</b>  | <b>0.57%</b>  |
| Хувилбар ЭМ1-1: II ангиллын шимтгэлийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 1 хувь болгож өсгөх                                                                                                     |               |               |               |               |
| Зорилтот бүлэг = ЭМД-ын II ангиллын хүн ам(мян.хүн)                                                                                                                                               | 352           | 364           | 375           | 386           |
| Хамрагдах хувь (%)                                                                                                                                                                                | 67%           | 83%           | 100%          | 100%          |
| Энэ хувилбарт хамрагдсан бүлэг (мян.хүн)                                                                                                                                                          | 235           | 303           | 375           | 386           |
| <b>Хувилбарын зардал (сая төгрөгөөр)</b>                                                                                                                                                          | <b>17,255</b> | <b>27,872</b> | <b>43,168</b> | <b>56,246</b> |
| <b>Зардлын ДНБ-нд эзлэх хувь (өнөөгийн)</b>                                                                                                                                                       | <b>0.08%</b>  | <b>0.10%</b>  | <b>0.13%</b>  | <b>0.15%</b>  |
| <b>Зардлын улсын төсвийн орлого, буцалтгүй тусламжид эзлэх хувь</b>                                                                                                                               | <b>0.28%</b>  | <b>0.38%</b>  | <b>0.43%</b>  | <b>0.44%</b>  |
| Хувилбар ЭМ1-2: II ангиллын шимтгэлд төрөөс бүрэн татаас олгох                                                                                                                                    |               |               |               |               |
| Зорилтот бүлэг =ЭМД-ын II ангиллын хүн ам (мян.хүн)                                                                                                                                               | 352           | 364           | 375           | 386           |
| Хамрагдах хувь (%)                                                                                                                                                                                | 100%          | 100%          | 100%          | 100%          |
| Энэ хувилбарт хамрагдсан бүлэг (мян.хүн)                                                                                                                                                          | 352           | 364           | 375           | 386           |
| <b>Хувилбарын зардал (сая төгрөгөөр)</b>                                                                                                                                                          | <b>34,402</b> | <b>44,659</b> | <b>57,907</b> | <b>75,800</b> |
| <b>Зардлын ДНБ-нд эзлэх хувь (өнөөгийн)</b>                                                                                                                                                       | <b>0.16%</b>  | <b>0.16%</b>  | <b>0.18%</b>  | <b>0.21%</b>  |
| <b>Зардлын улсын төсвийн орлого, буцалтгүй тусламжид эзлэх хувь</b>                                                                                                                               | <b>0.55%</b>  | <b>0.61%</b>  | <b>0.57%</b>  | <b>0.60%</b>  |
| Хувилбар ЭМ1-3: Орлогыг орлуулан тооцох арга нэвтрүүлэх: II ангиллын ядуусын шимтгэлд төрөөс бүрэн татаас олгож, ядуу бус иргэд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 1 хувьтай тэнцэх шимтгэл төлөх |               |               |               |               |
| Зорилтот бүлэг= ЭМД-ын II ангиллын ядуу хүн ам (мян.хүн)                                                                                                                                          | 88            | 84            | 75            | 77            |
| Хамрагдах хувь (%)                                                                                                                                                                                | 100%          | 100%          | 100%          | 100%          |
| Энэ хувилбарт хамрагдсан бүлэг (мян.хүн)                                                                                                                                                          | 88            | 84            | 75            | 77            |
| Зорилтот бүлэг= ЭМД-ын IIангиллын ядуу бус хүн ам (мян. хүн)                                                                                                                                      | 264           | 280           | 300           | 309           |
| <b>Хувилбарын зардал (сая төгрөгөөр)</b>                                                                                                                                                          | <b>21,744</b> | <b>31,689</b> | <b>45,574</b> | <b>59,458</b> |
| <b>Зардлын ДНБ-нд эзлэх хувь (өнөөгийн)</b>                                                                                                                                                       | <b>0.10%</b>  | <b>0.11%</b>  | <b>0.14%</b>  | <b>0.16%</b>  |
| <b>Зардлын улсын төсвийн орлого, буцалтгүй тусламжид эзлэх хувь</b>                                                                                                                               | <b>0.35%</b>  | <b>0.43%</b>  | <b>0.45%</b>  | <b>0.47%</b>  |
| Эх үүсвэр: ОУХБ РАП загварын тооцооллын дүн, 2015                                                                                                                                                 |               |               |               |               |

### Дүгнэлт

ЭМД-ын II ангиллын даатгуулагчдад 1 хувийн шимтгэл буюу орлогыг орлуулан тооцох аргыг нэвтрүүлэх зардлын тооцооноос үзвэл II ангиллын шимтгэлд өгөх татаасыг өөрчлөх үндэслэл болж чадахгүй бөгөөд энэ нь ЭМД-ын хамрагдалтыг бууруулах эрсдэл өндөртэй байна гэж үндэсний хэлэлцүүлэгт оролцогчид дүгнэлээ. Тиймээс НХСТ-г хангахад бодлого тогтвортой байх хувилбарыг зардал багатай багцын нэг бүрэлдэхүүн хэсэг болгож, харин II ангиллын даатгуулагчдын шимтгэлийг бүрэн татаастай болгох хувилбарыг зардал өндөртэй багцын нэг бүрэлдэхүүн хэсэг болгож үлдээвэл 2020 он гэхэд ДНБ-ий 0.01 хувьтай тэнцэх зардал нэмж шаардагдахаар байна.



## 5.2. Хүүхэд

*“Хүүхэд хоол тэжээл, боловсрол, асаргаа, бусад шаардлагатай бараа, үйлчилгээг авах боломжийг нь баталгаажуулахын тулд наад зах нь үндэснийхээ хэмжээнд тодорхойлсон доод түвшнийг хангахуйц хэмжээний орлогын суурь баталгаагаар хангах”*

Хүүхдүүдийн тухайд нийгмийн хамгааллын суурь түвшинг хангахын тулд ХМХ-ийг инфляцитай уялдуулан индексжүүлж, цэцэрлэгийн хүүхдүүдийн хоолны мөнгийг нэмэгдүүлэх гол зөвлөмжүүд гарсан юм. НҮБ/ Засгийн газрын хамтарсан Нийгмийн хамгааллын ажлын хэсэг энэхүү хоёр зөвлөмжийг одоогийн тусламж дэмжлэгийг бэхжүүлэхэд чиглэсэн дараах хувилбаруудад шилжүүлэн тооцлоо. Харин Х1-2 болон Х3-3 хувилбаруудыг бүх хүүхдийг хамруулж буй одоогийн тогтолцоог орлогыг орлуулан тооцох аргаар тодорхойлсон зорилтот бүлэгт чиглэсэн хөтөлбөртэй харьцуулах зорилгоор нэмж тооцсон болно (Хүснэгт 23).

### Хүснэгт 23. Хүүхдийн нийгмийн хамгаалалтай холбоотой хувилбарууд

|               |                                                                                                                                                                           |
|---------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Хувилбар Х1-0 | Одоогийн буюу бодлого тогтвортой байх нөхцөлд: ХМХ-ийн параметр үзүүлэлтүүд хэвээр, олгох мөнгийг индексжүүлээгүй                                                         |
| Хувилбар Х1-1 | Хүүхдийн мөнгийг инфляцитай уялдуулан индексжүүлэх                                                                                                                        |
| Хувилбар Х1-2 | Хүүхдийн мөнгийг орлогыг орлуулан тооцох аргаар сонгосон зорилтот бүлэгт олгох, тэтгэмжийг инфляцитай уялдуулан индексжүүлэх                                              |
| Хувилбар Х3-0 | Одоогийн буюу бодлого тогтвортой байх нөхцөлд: Цэцэрлэгийн хүүхдүүдийн хоолны хөтөлбөрийн параметр үзүүлэлтүүд хэвээр, хоолны зардлыг инфляцитай уялдуулж индексжүүлээгүй |
| Хувилбар Х3-1 | Цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлыг одоогийн түвшинд нь хадгалж (өдрийн ангид өдөрт 1650 төгрөг, 24 цагийн ангид өдөрт 2400 төгрөг), инфляцитай уялдуулан индексжүүлэх    |

|                      |                                                                                                                                                                                                                                                                                                            |
|----------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| <b>Хувилбар ХЗ-2</b> | Хоолны зардлыг нэмэгдүүлэх: Өдрийн анги өдөрт 2000 төгрөг, 24 цагийн анги өдөрт 4000 төгрөг (инфляцитай уялдуулан индексжүүлэх)                                                                                                                                                                            |
| <b>Хувилбар ХЗ-3</b> | Дараах параметр үзүүлэлт бүхий зорилтот хөтөлбөрийг нэвтрүүлэх: Өдрийн ангийн ядуу өрхийн хүүхдүүдэд өдөрт 2000 төгрөг, 24 цагийн ангийн ядуу өрхийн хүүхдүүдэд өдөрт 4000 төгрөг (инфляцитай уялдуулан индексжүүлсэн); хөтөлбөрт хамрагдах шалгуур хангахгүй хүүхдүүдийн хувьд 50 хувийн хөнгөлөлт олгох. |

Эх үүсвэр: НҮБ/ЗГ-ын хамтарсан Нийгмийн хамгааллын ажлын хэсэг, 2014

ОУХБ-аас гаргасан Нийгмийн хамгааллын суурь түвшний тухай 2012 оны зөвлөмж(No.202)-д тэтгэмж, тусламжийг инфляцитай болон цалингийн өсөлттэй уялдуулан индексжүүлэхийг зөвлөсөн байдаг. Иймд энэ хувилбарыг нийгмийн хамгааллын суурь баталгааны багцад оруулна. ҮСҮХ-ийн эхний хэлэлцүүлгүүд болсны дараа Засгийн газар хүүхдийн мөнгийг ХҮИ-тэй уялдуулан индексжүүлдэг болох талаар ярилцаж эхэлсэн юм.

#### Хувилбар Х1-1: ХМХ-ийн тэтгэмжийг инфляцитай уялдуулан индексжүүлэх

ХМХ-ийн хүрээнд хүүхдэд сар бүр 20,000 төгрөг олгож байгааг хэвээр үлдээх, гэхдээ ОУХБ-ын Нийгмийн хамгааллын суурь түвшний тухай 2012 оны (No.202) зөвлөмжийн дагуу ХҮИ-ээр индексжүүлдэг болохыг үндэсний хэлэлцүүлгээс зөвлөсөн юм.

#### Таамаглал

- РАП-ын тооцоонд 2014 оноос хойш (хамгийн сүүлийн мэдээлэл олдсон он) жилийн эцэст тооцсон инфляцийн түвшин нь инфляцийн жилийн дундаж түвшинтэй ойролцоо байна гэж ТҮП таамаглаж байна. Хүүхдийн мөнгийг инфляцитай уялдуулан индексжүүлэхэд шаардагдах зардлыг тооцоолохын тулд бид инфляцийн жилийн дундаж түвшинг ашигласан.
- Нэмэлт зардлыг Хүний хөгжил сангаас санхүүжүүлнэ.
- ХАХНХЯ-ны орлогын шалгуур тавилгүй бүх хүүхдийг хамруулах ХМХ-ийн удирдлагын/захиргааны зардал нь 2 хувиас хэтрэхгүй.
- ХМХ-ийн бусад бүх параметр, ялангуяа бүх хүүхдийг хамрах зорилго нь өөрчлөгдөхгүй.

#### Үр дүн

Хүүхдийн мөнгийг индексжүүлдэг болсноор олон улсын хөдөлмөрийн стандартыг хангах бөгөөд үүнд 2014 онд ДНБ-ий 0.16 хувьтай, 2020 онд 0.46 хувьтай тэнцэх зардал нэмж шаардагдана.

#### Хувилбар Х1-2: Хүүхдийн мөнгийг орлогыг орлуулан тооцох аргаар зорилтот бүлэгт олгох, инфляцитай уялдуулан индексжүүлэх

#### Таамаглал

- Дээрх хувилбар Х1-1-д дэвшүүлсэн таамаглалууд хэвээр
- Харьцуулалт хийх зорилгоор үндэсний хэлэлцүүлгээс хүүхдийн мөнгийг орлогыг орлуулан тооцох аргаар тодорхойлсон ядуу хүүхдүүдэд л олгох, ингэхдээ хэмжээг инфляцитай уялдуулан индексжүүлэх хөтөлбөрийн зардлыг тооцоолохоор шийдсэн. Ядуусыг тодорхойлохын тулд энэ хувилбарт ядуурлын хамралтын хүрээний индексийг ашигласан. Ядуурлын хамралтын хүрээний индекс нь ядуурлын шугам буюу амьжиргааны доод түвшнээс доогуур хэрэглээ бүхий хүн амын хувь хэмжээ юм.
- Улсын хэмжээний ядуурлын түвшнийг 15 хувиар нэмэгдүүлж, ядуу гэж тооцогдох 0-18 насны хүүхдийн тооны харьцаанд ашигласан.
- Орлогыг орлуулан тооцох аргыг нэвтрүүлэхэд гарах удирдлагын зардал нь тухайн хөтөлбөрийн зардлын 15 хувь байна гэж таамагласан.

## Үр дүн

Орлогыг орлуулан тооцох аргаар тодорхойлсон зорилтот бүлэгт хүүхдийн мөнгийг олгосноор Засгийн газар хүүхдийн мөнгийг индексжүүлсэн хөтөлбөртэй харьцуулахад 2014 онд ДНБ-ий 1.02 хувьтай тэнцэх хэмнэлт хийх боломжтой боловч энэ хэмнэлтийн хэмжээ аажмаар буурч, 2020 он гэхэд хэмжээ нь ДНБ-ий 0.92 хувьтай тэнцэнэ. Гэхдээ энэ нь 4 хүүхэд тутмын 3-ыг нь орлогын дэмжлэггүй үлдэхэд хүргэнэ. Харин бүх хүүхдэд амьжиргааны өртөгийн өөрчлөлттэй уялдуулан нэмэгдүүлсэн хүүхдийн мөнгийг олгоход ДНБ-ий ердөө 1.19 хувьтай тэнцэх зардал нэмж шаардагдах юм.

### Хувилбар ХЗ-1: Цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлыг одоогийн түвшинд нь хадгалж (өдрийн ангид өдөрт 1650 төгрөг, 24 цагийн ангид өдөрт 2400 төгрөг), инфляцитай уялдуулан индексжүүлэх

Хүүхдийн бага насны өсөлт хөгжил нь хүүхэд насанд нь төдийгүй насанд хүрсэн хойно нь ч урт удаан хугацаанд сайн сайхан амьдрахад нь маш чухал гэдгийг НҮБХС-ийн нотолгоонд суурилсан олон судалгаа харуулж байна. Хүүхдэд эрүүл мэнд, хоол тэжээл, ус болон ариун цэвэр, боловсролын үйлчилгээ, түүнчлэн тэднийг бүрэн дүүрэн хөгжүүлэхэд дэмжсэн арга хэмжээнүүдийг цогц байдлаар хүргэх нь манай улсын ирээдүйн баталгаа болох юм. Монгол улс хүүхдэд эрүүл мэнд, боловсролын үйлчилгээг үнэ төлбөргүй хртээмжтэй хүргэж байгаа боловч хүүхдийн хоол тэжээлийн асуудал тулгамдаж буй хэвээр байна. Цэцэрлэгт явдаг бага насны хүүхдийн (2-оос 6 хүртэл) насны хүүхдийн хоол, тэжээлийн чанарыг сайжруулахад хүчин чармайлт гаргах хэрэгтэй гэж үндэсний хэлэлцүүлгээс үзсэн болно. Энэ чиглэлд хэрэгжүүлж болох хамгийн хялбар арга хэмжээ бол цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлыг ХҮИ-тэй уялдуулан нэмэгдүүлдэг болох явдал юм. НҮБ/ЗГ-ын хамтарсан Нийгмийн хамгааллын ажлын хэсэг хоолны зардлыг арай илүү хүрэлцээтэй гэж үзсэн түвшинд хүргэж нэмэгдүүлэхэд шаардагдах нийт зардлыг тооцож үзсэн болно.

## Таамаглал

- Хувилбар Х1-1-ийн хувьд дэвшүүлсэн таамаглалууд хэвээр
- Монгол Улсад 24 цагийн зургаан цэцэрлэг ажиллаж байгаа бөгөөд тус бүрд нь дунджаар 150 хүүхэд хүмүүжиж байна. РАП-ын тооцоонд 24 цагийн цэцэрлэгт хүмүүжих хүүхдийн тоо жил бүр 10 хувиар нэмэгдэнэ гэж таамагласан.
- 2-оос 6 хүртэлх насны хүүхдийн цэцэрлэгт хамрагдалт эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцоотой хамааралтай гэж үзэж байна.
- Хүүхдүүд (9 дүгээр сараас эхлэн 6 дугаар сар хүртэл) жилд 45 долоо хоног цэцэрлэгт явна гэж тооцсон.
- Улсын хэмжээний ядуурлын түвшин нь Монгол улсад ядуу гэж тооцогдох 2-оос 6 хүртэлх насны хүүхдийн харьцаа ч хамаарна гэж үзсэн.
- 24 цагийн цэцэрлэгт явдаг хүүхдүүд ихэвчлэн эмзэг гэр бүлийнх буюу хөгжлийн бэрхшээлтэй эцэг эх, эсхүл ганц бие эх, эцгийн хүүхэд байдаг (НҮБХС).
- Цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлын татаасыг тавин хувь бууруулахад цэцэрлэгт элсэх хүүхдийн тоонд нөлөөлөхгүй.
- Эцэг эх нь хоёулаа ажил хийдэг өрхүүд хүүхдүүдээ цэцэрлэгт явуулах шаардлагатай байдаг гэж үзсэн. Ийм учраас энэ дэмжлэгт хамрагдах хүүхдийн хувь нь эмэгтэй ажиллах хүчний оролцооны таамаглаж буй хувьтай шууд хамааралтай.

## Үр дүн

ОУХБ-ын Нийгмийн хамгааллын суурь түвшний тухай 2012 оны (No.202) зөвлөмжийн дагуу цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлыг инфляцитай уялдуулан индексжүүлбэл хөтөлбөрийн өртөг 2014 онд ДНБ-ий 0.04 хувьтай, 2020 он гэхэд 0.12 хувьтай тэнцэх хэмжээгээр нэмэгдэнэ. Гэхдээ зардлын хэмжээ нь хүүхдийн хоол тэжээлийг сайжруулах зорилтыг хангах хэмжээнд хоолны чанарыг сайжруулж чадахгүй юм.

### Хувилбар ХЗ-2: Цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлыг өдрийн ангийн бүх хүүхдэд өдөрт 2,000 төгрөг, 24 цагийн ангийн хүүхдэд өдөрт 4,000 төгрөг болгож өсгөх (инфляцитай уялдуулан индексжүүлэх)

Одоогийн цэцэрлэгт олгож буй хоолны зардлын хэмжээ нь хангалттай шим тэжээлтэй хоол өгөхөд хүрэлцэхгүй байж болзошгүй гэдэгт үндэсний хэлэлцүүлэгт оролцогчид санал нэгдсэн. Иймд хоолны зардлыг өдрийн ангийн хүүхдэд өдөрт 2,000 төгрөг, 24 цагийн ангийн хүүхдэд өдөрт 4,000 төгрөг болгож өсгөхөд гарах зардлыг тооцохыг санал болгосон юм. Аль ч тохиолдолд, ОУХБ-ын Нийгмийн хамгааллын суурь түвшний тухай 2012 оны (No.202) зөвлөмжийн дагуу цэцэрлэгийн хоолны зардлын хэмжээг инфляцитай уялдуулан индексжүүлэх ёстой.

#### Таамаглал

- Хувилбар ХЗ-1-ийн хувьд дэвшүүлсэн дээрх бүх таамаглал хувилбар ХЗ-2-ын хувьд хамаарна.

#### Үр дүн

Бага насны хүүхдийн хоол, тэжээлийн чанарыг сайжруулах нь нэн тэргүүний ач холбогдолтой гэж тодорхойлсны дагуу цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлыг нэмэгдүүлэх хувилбараар тооцоход уг зардлыг инфляцитай уялдуулан индексжүүлсэн хувилбартай харьцуулахад хөтөлбөрийн нийт зардлыг ДНБ-ий 0.03 хувьтай тэнцэх хэмжээгээр тогтмол өсгөнө. Үр шим хүртэгч хүүхдийн тоо багасах үед (2020 он гэхэд 180,000 хүүхэд) энэхүү зардал тогтворжино.

Хувилбар ХЗ-3: Цэцэрлэгийн хүүхдийн хоолны хувьд дараах параметр үзүүлэлт бүхий зорилтот хөтөлбөр нэвтрүүлэх: орлогыг орлуулан тооцох аргыг нэвтрүүлэх: Өдрийн ангийн ядуу хүүхдүүдэд өдөрт 2000 төгрөг, 24 цагийн ангийн ядуу өрхийн хүүхдүүдэд өдөрт 4000 төгрөг (инфляцитай уялдуулан индексжүүлсэн); хөтөлбөрт хамрагдах шалгуур хангахгүй хүүхдүүдийн хувьд 50 хувийн хөнгөлөлт олгох.

#### Таамаглал

- Хувилбар ХЗ-1-ийн хувьд дэвшүүлсэн дээрх таамаглалууд хэвээр
- Харьцуулалт хийх зорилгоор үндэсний хэлэлцүүлгээс хүүхдийн мөнгийг орлогыг орлуулан тооцох аргаар тодорхойлсон ядуу хүүхдүүдэд л олгох, ингэхдээ хэмжээг инфляцитай уялдуулан индексжүүлэх хөтөлбөрийн зардлыг тооцоолохоор шийдсэн. Ядуусыг тодорхойлохын тулд энэ хувилбарт ядуурлын хамралтын хүрээний индексийг ашигласан. Ядуурлын хамралтын хүрээний индекс нь ядуурлын шугам буюу амьжиргааны доод түвшнээс доогуур хэрэглээ бүхий хүн амын хувь хэмжээ юм.
- Улсын хэмжээний ядуурлын түвшнийг 15 хувиар нэмэгдүүлж, ядуу гэж тооцогдох хүүхдийн тооны харьцаанд ашигласан, тиймээс 2-оос 6 хүртэлх насны хүүхдүүдийн 28.7 хувиар авч үзсэн.
- 2012 оны Өрхийн нийгэм-эдийн засгийн судалгааны дагуу үндэсний дунджаар тооцоолоход 17-40 насны өрхийн тэргүүнтэй өрхүүд (0-18 насны) 1.2 хүүхэдтэй байсан болно. Ядуурлын шугамаас доогуур хэрэглээтэй өрхүүдийн хувьд энэ тоо адилхан гэж таамагласан. Ядуу өрхүүдийн бүрэлдэхүүн болон ядуу өрхөд буй бага насны (0-6 насны) хүүхдийн тооны талаар тодорхой тоо баримт байхгүй тул ядуу өрх бүр 0-6 насны 1.0 хүүхэдтэй байна гэж энэ тооцоонд авч үзсэн.
- Орлогыг орлуулан тооцох аргыг нэвтрүүлэхэд гарах удирдлагын зардал нь тухайн хөтөлбөрийн зардлын 15 хувь байна гэж таамагласан.

#### Үр дүн

Зөвхөн ядуу хүүхдүүд хамрагдах энэ гуравдугаар хувилбарын зардлын тооцооноос боломжит хэмнэлтийн талаар дорвитой дүгнэлт гараагүй. Орлогыг орлуулан тооцох аргын удирдлагын зардал өндөр тул хязгаарлагдмал тооны зорилтот хүн ам (2-6 насны хүүхдүүд) бүхий энэ тогтолцоог

нэвтрүүлэхэд багахан хэмжээний хэмнэлт (ДНБ-ий 0.12 хувь) гаргах боломжтой юм. Хүснэгт 24-т хүүхдийн орлогын баталгаа, хоол тэжээлийг сайжруулахтай холбоотой хувилбаруудын үр дүнгийн үзүүлэлтүүдийг хураангуйлан харуулав.

**Хүснэгт 24. Хүүхдийн орлогын баталгаа, хоол тэжээлийг сайжруулахтай холбоотой зардлын тооцооллын дүн**

|                                                                                                                                                               | 2014           | 2016           | 2018           | 2020           |
|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------|----------------|----------------|----------------|
| Хувилбар Х1-0: Одоогийн буюу бодлого тогтвортой байх нөхцөлд: Хүүхдийн мөнгийг индексжүүлээгүй                                                                |                |                |                |                |
| Зорилтот бүлэг 0 - 18 насны хүүхэд (мян.хүн)                                                                                                                  | 1,001          | 1,028          | 1,059          | 1,093          |
| Хамрагдах хувь (%)                                                                                                                                            | 100%           | 100%           | 100%           | 100%           |
| Энэ хувилбарт хамрагдсан бүлэг (мян. хүн)                                                                                                                     | 1,001          | 1,028          | 1,059          | 1,093          |
| <b>Хувилбарын зардал (сая төгрөгөөр)</b>                                                                                                                      | <b>244,976</b> | <b>251,766</b> | <b>259,135</b> | <b>267,466</b> |
| <b>Зардлын ДНБ-нд эзлэх хувь</b>                                                                                                                              | <b>1.15%</b>   | <b>0.91%</b>   | <b>0.80%</b>   | <b>0.73%</b>   |
| <b>Зардлын улсын төсвийн орлого, буцалтгүй тусламжид эзлэх хувь</b>                                                                                           | <b>3.94%</b>   | <b>3.44%</b>   | <b>2.55%</b>   | <b>2.12%</b>   |
| Хувилбар Х1-1: Хүүхдийн мөнгийг инфляцитай уялдуулан индексжүүлсэн                                                                                            |                |                |                |                |
| Зорилтот бүлэг 0 - 18 насны (мян.хүн)                                                                                                                         | 1,001          | 1,028          | 1,059          | 1,093          |
| Хамрагдах хувь (%)                                                                                                                                            | 100%           | 100%           | 100%           | 100%           |
| Энэ хувилбарт хамрагдсан бүлэг (мян.хүн)                                                                                                                      | 1,001          | 1,028          | 1,059          | 1,093          |
| <b>Хувилбарын зардал (сая төгрөгөөр)</b>                                                                                                                      | <b>277,313</b> | <b>323,246</b> | <b>373,830</b> | <b>433,539</b> |
| <b>Зардлын ДНБ-нд эзлэх хувь</b>                                                                                                                              | <b>1.31%</b>   | <b>1.17%</b>   | <b>1.15%</b>   | <b>1.19%</b>   |
| <b>Зардлын улсын төсвийн орлого, буцалтгүй тусламжид эзлэх хувь</b>                                                                                           | <b>4.46%</b>   | <b>4.41%</b>   | <b>3.68%</b>   | <b>3.43%</b>   |
| Хувилбар Х1-2: Орлогыг орлуулан тооцох аргаар сонгосон зорилтот хөтөлбөр, хүүхдийн мөнгийг инфляцитай уялдуулан индексжүүлсэн                                 |                |                |                |                |
| Зорилтот бүлэг 0 - 18 насны (ядуурлын түвшнээс доогуур) (мян. хүн)                                                                                            | 250            | 237            | 212            | 219            |
| Хамрагдах хувь (%)                                                                                                                                            | 80%            | 100%           | 100%           | 100%           |
| Энэ хувилбарт хамрагдсан бүлэг (мян.хүн)                                                                                                                      | 200            | 237            | 212            | 219            |
| <b>Хувилбарын зардал (сая төгрөгөөр)</b>                                                                                                                      | <b>62,531</b>  | <b>83,822</b>  | <b>84,295</b>  | <b>97,759</b>  |
| <b>Зардлын ДНБ-нд эзлэх хувь</b>                                                                                                                              | <b>0.29%</b>   | <b>0.30%</b>   | <b>0.26%</b>   | <b>0.27%</b>   |
| <b>Зардлын улсын төсвийн орлого, буцалтгүй тусламжид эзлэх хувь</b>                                                                                           | <b>1.00%</b>   | <b>1.14%</b>   | <b>0.83%</b>   | <b>0.77%</b>   |
| Хувилбар Х3-0: Одоогийн буюу бодлого тогтвортой байх нөхцөлд: Өдрийн ангийн хоол өдөрт 1650 төгрөг, 24 цагийн ангийн хоол өдөрт 2400 төгрөг (индексжүүлээгүй) |                |                |                |                |
| 2-оос 6 насны нийт хүн ам (мян.хүн)                                                                                                                           | 311            | 316            | 318            | 316            |
| Хамрагдах хувь (%)                                                                                                                                            | 56%            | 56%            | 57%            | 57%            |
| Энэ хувилбарт хамрагдсан бүлэг (мян.хүн)                                                                                                                      | 173            | 178            | 181            | 180            |
| <b>Хувилбарын зардал (сая төгрөгөөр)</b>                                                                                                                      | <b>67,613</b>  | <b>69,724</b>  | <b>70,777</b>  | <b>70,477</b>  |
| <b>Зардлын ДНБ-нд эзлэх хувь</b>                                                                                                                              | <b>0.32%</b>   | <b>0.25%</b>   | <b>0.22%</b>   | <b>0.19%</b>   |
| <b>Зардлын улсын төсвийн орлого, буцалтгүй тусламжид эзлэх хувь</b>                                                                                           | <b>1.09%</b>   | <b>0.95%</b>   | <b>0.70%</b>   | <b>0.56%</b>   |
| Хувилбар Х3-1: Өдрийн ангийн хоол өдөрт 1650 төгрөг, 24 цагийн ангийн хоол өдөрт 2400 төгрөг (инфляцитай уялдуулан индексжүүлсэн)                             |                |                |                |                |
| 2-оос 6 насны нийт хүн ам (мян.хүн)                                                                                                                           | 311            | 316            | 318            | 316            |
| Хамрагдах хувь (%)                                                                                                                                            | 56%            | 56%            | 57%            | 57%            |
| Энэ хувилбарт хамрагдсан бүлэг (мян.хүн)                                                                                                                      | 173            | 178            | 181            | 180            |
| <b>Хувилбарын зардал (сая төгрөгөөр)</b>                                                                                                                      | <b>76,538</b>  | <b>89,519</b>  | <b>102,104</b> | <b>114,236</b> |
| <b>Зардлын ДНБ-нд эзлэх хувь</b>                                                                                                                              | <b>0.36%</b>   | <b>0.32%</b>   | <b>0.31%</b>   | <b>0.31%</b>   |
| <b>Зардлын улсын төсвийн орлого, буцалтгүй тусламжид эзлэх хувь</b>                                                                                           | <b>1.23%</b>   | <b>1.22%</b>   | <b>1.01%</b>   | <b>0.90%</b>   |

Хувилбар ХЗ-2: өдрийн ангийн хоол өдөрт 2000 төгрөг, 24 цагийн ангийн хоол өдөрт 4000 төгрөг (инфляцитай уялдуулан индексжүүлсэн)

|                                                                     |               |               |                |                |
|---------------------------------------------------------------------|---------------|---------------|----------------|----------------|
| 2-оос 6 насны нийт хүн ам (мян.хүн)                                 | 311           | 316           | 318            | 316            |
| Хамрагдах хувь (%)                                                  | 56%           | 56%           | 57%            | 57%            |
| Энэ хувилбарт хамрагдсан бүлэг (мян.хүн)                            | 173           | 178           | 181            | 180            |
| <b>Хувилбарын зардал (сая төгрөгөөр)</b>                            | <b>82,264</b> | <b>96,279</b> | <b>109,906</b> | <b>123,105</b> |
| <b>Зардлын ДНБ-нд эзлэх хувь</b>                                    | <b>0.39%</b>  | <b>0.35%</b>  | <b>0.34%</b>   | <b>0.34%</b>   |
| <b>Зардлын улсын төсвийн орлого, буцалтгүй тусламжид эзлэх хувь</b> | <b>1.32%</b>  | <b>1.31%</b>  | <b>1.08%</b>   | <b>0.97%</b>   |

Хувилбар ХЗ-3: Зорилтот хөтөлбөр болгох: Өдрийн ангийн ядуу хүүхдүүдэд өдөрт 2000 төгрөг, 24 цагийн ангийн ядуу өрхийн хүүхдүүдэд өдөрт 4000 төгрөг (инфляцитай уялдуулан индексжүүлсэн); хөтөлбөрт хамрагдах шалгуур хангахгүй хүүхдүүдийн хувьд 50 хувийн хөнгөлөлт олгох.

|                                                                     |               |               |               |               |
|---------------------------------------------------------------------|---------------|---------------|---------------|---------------|
| 2-оос 6 насны нийт хүн ам (мян.хүн)                                 | 311           | 316           | 318           | 316           |
| Хамрагдах хувь (%)                                                  | 56%           | 56%           | 57%           | 57%           |
| Энэ хувилбарт хамрагдсан бүрэн татаастай бүлэг (мян.хүн)            | 43            | 41            | 36            | 36            |
| Энэ хувилбарт хамрагдсан бүрэн бус татаастай бүлэг (мян.хүн)        | 130           | 137           | 145           | 144           |
| <b>Хувилбарын зардал (сая төгрөгөөр)</b>                            | <b>57,164</b> | <b>66,029</b> | <b>73,844</b> | <b>83,099</b> |
| <b>Зардлын ДНБ-нд эзлэх хувь</b>                                    | <b>0.27%</b>  | <b>0.24%</b>  | <b>0.23%</b>  | <b>0.23%</b>  |
| <b>Зардлын улсын төсвийн орлого, буцалтгүй тусламжид эзлэх хувь</b> | <b>0.92%</b>  | <b>0.90%</b>  | <b>0.73%</b>  | <b>0.66%</b>  |

Эх үүсвэр: ОУХБ РАП загварын тооцооллын дүн, 2015

## Дүгнэлт

Хүүхдийн мөнгийг индексжүүлэх болон бүх хүүхдийн цэцэрлэгийн хоолны зардлыг нэмэгдүүлэх нь хүүхдүүдийн орлогын баталгаа, тэдний хөгжилд чухал хоол тэжээлийн чанарыг сайжруулахад нэн чухал гэж үзэж байна. Энэ хоёр арга хэмжээг хэрэгжүүлэхэд 2020 онд ДНБ-ий 0.72 хувьтай тэнцэх нэмэлт зардал шаардагдах бөгөөд ингэснээр хоёр хөтөлбөрийн зардал нийлээд 2020 онд ДНБ-ий 1.53 хувьтай тэнцэнэ. Хүүхдийн мөнгө хөтөлбөр болон цэцэрлэгийн хүүхдийн хоолны мөнгөнд ядуу хүүхдүүдэд чиглэсэн орлогыг орлуулан тооцох аргыг нэвтрүүлснээр гойд хэмнэлт гарахгүй гэж энэхүү зардлын тооцооноос дүгнэж байна. Харин ч эсрэгээр, цэцэрлэгт хамрагдалт, хоол тэжээлийн хүртээмжид үзүүлэх нөлөөлөл болон үндсэн хэрэгцээний хангалт буурах нь хүүхдийн өсөлт хөгжилд сөрөг нөлөөтэй байх болно. Хүүхдийн хоол тэжээл, боловсрол болон амин чухал хэрэгцээний хүртээмжид хөрөнгө оруулах нь улс орны ирээдүйд хөрөнгө оруулж буй хэрэг юм.



### 5.3. Хөдөлмөрийн насны хүн ам

“Өвчлөх, ажилгүй болох, жирэмслэх болон хүүхэд төрүүлэх, хөдөлмөрийн чадвараа алдах зэрэг шалтгаанаар хангалттай орлого олох боломжгүй байгаа хөдөлмөрийн насны хүмүүсийг наад зах нь үндэснийхээ хэмжээнд тодорхойлсон доод түвшнийг хангахуйц хэмжээний орлогын суурь баталгаагаар хангах”

Хөдөлмөрийн насны хүн амын НХСТ-г хангахын тулд албан болон албан бус эдийн засагт ажиллагчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, малчин эмэгтэйчүүдэд олгох жирэмсний болон амаржсаны тэтгэмжийг бодох хувь хэмжээг адил болгох, мөн малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид болон албан бус эдийн засагт ажиллагсад, ялангуяа Хөдөлмөрийн яамны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арван хөтөлбөрөөс үр шим хүртэж буй хүн амын дунд нийгмийн даатгалд хамрагдах хүрээг өргөжүүлэх нь зүйтэй гэсэн гол зөвлөмжүүд гарсан юм. Зөвлөмжүүдийн өртөг зардлыг Хүснэгт 25-д харуулсан хувилбаруудаар тооцсон болно.

#### Хүснэгт 25. Хөдөлмөрийн насны хүн амын нийгмийн даатгалтай холбоотой хувилбарууд

|                |                                                                                                                                                                              |
|----------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Хувилбар ХН1-0 | Одоогийн буюу бодлого тогтвортой байх нөхцөлд: сайн дураар даатгуулагчдад олгох жирэмсний болон амаржсаны тэтгэмжийг бодох хувь хэмжээ 70 хувь (одоогийн хуулиар)            |
| Хувилбар ХН1-1 | Сайн дураар даатгуулагчдад олгох жирэмсний болон амаржсаны тэтгэмжийг бодох хувь хэмжээг 100 хувь болгож өсгөх                                                               |
| Хувилбар ХН2-1 | Жирэмсний болон амаржсаны, ердийн өвчний улмаас ХЧТА-ны болон ҮОМШӨ-ний даатгалын шимтгэлийн 50 хувиар татаас олгох                                                          |
| Хувилбар ХН2-2 | Жирэмсний болон амаржсаны, ердийн өвчний улмаас ХЧТА-ны болон ҮОМШӨ-ний даатгалын шимтгэлийн 70 хувиар татаас олгох                                                          |
| Хувилбар ХН3-1 | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт хамрагдагчдын сайн дурын нийгмийн даатгалын шимтгэлд 100 хувийн татаас олгох (тэтгэвэр болон богино хугацаат тэтгэмжүүд).               |
| Хувилбар ХН3-2 | “Эмзэг бүлэг”-ийн сайн дурын нийгмийн даатгалын шимтгэлд 100 хувь татаас, “эмзэг бус бүлэг”-ийн шимтгэлд 70 хувийн татаас олгох (тэтгэвэр болон богино хугацаат тэтгэмжүүд). |
| Хувилбар ХН3-3 | “Эмзэг бүлэг”-ийн сайн дурын нийгмийн даатгалын шимтгэлд 100 хувь татаас, “эмзэг бус бүлэг”-ийн шимтгэлд 50 хувийн татаас олгох (тэтгэвэр болон богино хугацаат тэтгэмжүүд). |

Эх үүсвэр: НҮБ/ЗГ-ын хамтарсан Нийгмийн хамгааллын ажлын хэсэг, 2014

Мөн хөдөө орон нутгийн залуучуудын дунд нийгмийн даатгалд хамрагдалт, хөдөлмөр эрхлэлтийг нь дэмжих, үүний дотор үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас ажилгүй бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй болсон даатгуулагчдыг ажилдаа буцан орохыг дэмжих зорилготой нэмэлт зөвлөмжүүд гарсан юм. Эдгээр зөвлөмжийг дараах хувилбаруудаар авч үзэв (Хүснэгт 26).

#### Хүснэгт 26. Хөдөлмөрийн насны хүн амын ХЗЗИБ-той холбоотой хувилбарууд

|                |                                                                                                                                                                                           |
|----------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Хувилбар ХН4-1 | Аж ахуй эрхлэх талаар зөвлөгөө өгөх, нийгмийн даатгалын шимтгэлийг нь нэг жилийн турш хариуцах (татаас олгох) хосолсон дэмжлэг бүхий залуу малчдад зориулсан ХЭДХ-ийг шинээр нэвтрүүлэх   |
| Хувилбар ХН4-2 | Аж ахуй эрхлэх талаар зөвлөгөө өгөх, нийгмийн даатгалын шимтгэлийг нь нэг жилийн турш хариуцах (татаас олгох) хосолсон дэмжлэг бүхий залуу малчдад зориулсан ХЭДХ-ийг шинээр нэвтрүүлэх   |
| Хувилбар ХН4-3 | Мэргэжлийн болон дагалдан сургалт, тэтгэлэг болон нийгмийн даатгалын шимтгэлийн (6 сарын) төлбөр зэргийг багтаасан ХЭДХ-ийг шинээр нэвтрүүлэх                                             |
| Хувилбар ХН4-4 | Мэргэжлийн болон дагалдан сургалт, тэтгэлэг болон нийгмийн даатгалын шимтгэлийн (3 сарын) төлбөр зэргийг багтаасан ХЭДХ-ийг шинээр нэвтрүүлэх                                             |
| Хувилбар ХН5   | Албан салбарт ажиллаж байгаад ажилгүй болсон мэргэжилтэй ажилчдын (НДС-аас ажилгүйдлийн тэтгэмж авч буй иргэд) мэргэжил, үр чадварыг нь дээшлүүлэх 2 сарын сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх |
| Хувилбар ХН6   | ҮОМШӨ-ий улмаас хөгжлийн бэрхшээлтэй болсон (НДС-аас ҮОМШӨ-ний сангаас тахир дутуугийн тэтгэвэр авдаг) хүмүүст дахин мэргэжил, үр чадвар олгох сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх             |

Эх үүсвэр: НҮБ/ЗГ-ын хамтарсан Нийгмийн хамгааллын ажлын хэсэг, 2014

#### Н1-1: Сайн дураар даатгуулагчдад олгох жирэмсний болон амаржсаны тэтгэмжийг бодох хувь хэмжээг 100 хувьд хүргэж нэмэгдүүлэх

Жирэмсний болон амаржсаны тэтгэмж нь ажил эрхэлдэг бүх эмэгтэйчүүдэд төрөхийн өмнө болон төрсний дараа, мөн нярай хүүхдээ асарч байх үед орлогыг нь нөхөх зорилготой. Иймд энэ нь жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхчүүдэд олгодог нийгмийн халамжийн тэтгэмжтэй давхцахгүй. Нийгмийн даатгалд албан журмаар даатгуулсан эхэд жирэмсний болон амаржсаны тэтгэмжийг сүүлийн 12 сарын цалингийн дундажаас 100 хувиар бодож олгодог бол, харин сайн дураар даатгалд хамрагдсан эхчүүдийн хувьд энэ хэмжээ сүүлийн 12 сарын шимтгэл төлсөн дундаж орлогын ердөө л 70 хувь байдаг. Энэ хувилбар дээр бид албан салбарт ажиллагч эмэгтэйчүүд болон малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, албан бүс эдийн засагт ажиллагчдад жирэмсний болон амаржсаны тэтгэмж бодох хувийг адилхан 100 хувь болгож нэмэгдүүлэхэд шаардагдах зардлыг тооцоолсон юм.

#### Таамаглал

- Зорилтот хүн ам (малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид)-ын төрөлтийн түвшин улсын түвшинтэй улсын түвшинтэй адил байна.
- Төрөлтийн тоог тооцохдоо нэг эхэд ногдох төрөлтийн тоо болон нялхсын эндэгдлийг тусгаагүй.
- 2011 онд II ангилалд хамаарах даатгуулагчид (малчид, мэргэжлийн сургалтын төвд суралцагсад, ажилгүйчүүд) болон IV ангилалд хамаарах даатгуулагчид(хувиараа хөдөлмөр эрхлэгчид)-ын тоо сайн дураар нийгмийн даатгалд хамрагдах зорилтот хүн амын тоотой тэнцүү (100 хувь) байв. РАП загварт мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвд суралцагсад нь сайн дурын тогтолцооны зорилтот хүн амын тоонд орохгүй харин Нийгмийн даатгалын тухай хуулийн 4.2 дахь хэсэгт зааснаар албан журмын нийгмийн даатгалд, эсвэл идэвхигүйд тооцогдоно гэж үзсэн.
- Бүх сайн дураар даатгуулагчид хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс шимтгэл төлнө.
- 2020 он гэхэд сайн дураар даатгуулагчдын хамрагдалт 100 хувьд хүрнэ.

## Үр дүн

Албан журмаар болон сайн дураар нийгмийн даатгалд хамрагдсан эхчүүдийн жирэмсний болон амаржсаны тэтгэмжийг адилхан хувь хэмжээгээр бодож олгосноор 2020 онд сайн дурын даатгалд хамрагдвал зохих бүх хүн хамрагдсан ч шаардагдах нэмэлт зардал нь ДНБ-ий 0.1 хувиас хэтрэхгүй байна. Энэ зардал нь аль ч тохиолдолд даатгуулах хүн ам нэмэгдэхийн хэрээр өссөн шимтгэлийн орлогод шингээгдэх учраас ийм арга хэмжээ нь НДС-ын тэнцэлд маш бага нөлөө үзүүлнэ.

### **Хувилбар ХН-2: Малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, албан бүс эдийн засагт ажиллагчдын жирэмсний болон амаржсаны, ердийн өвчний улмаас ХЧТА-ны, УОМШӨ-ний даатгалд төлөх шимтгэлийн 50 болон 70 хувиар татаас олгох**

Энэ хувилбараар нийгмийн даатгалд хамралтыг нэмэгдүүлэх хөшүүрэг болгож малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид болон албан бүс эдийн засагт ажиллагчдын төлөх шимтгэлд татаас олгохыг саналыг тооцож байгаа юм. Үүнд 50 болон 70 хувийн татаас олгоход гарах зардлуудыг харьцуулав.

Энэ хувилбар нь өндөр насны тэтгэврийн тогтолцоог шинэчилж, сайн дураар даатгалд хамрагдаж байгаа малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, албан бүс эдийн засагт ажиллагчдыг шимтгэлд нь татаас өгөх замаар албан журмын нийгмийн даатгалд хамруулах талаар одоо ид явагдаж хэлэлцүүлгийн агуулгад нийцэж байгаа юм. Ийм шинэчлэлийг богино хугацааны тэтгэмжийн даатгалд мөн нэвтрүүлж болно. РАП загварчлалаар хэрэв бүх зорилтот хүн ам 2020 он гэхэд нийгмийн даатгалд хамрагдвал, өөрөөр хэлбэр зорилтот хүн ам 100 хувь хамрагдах хувилбарын зардал ямар байхыг симуляци хийж тооцсон. Гэхдээ ийм тооцоог илүү үнэн зөв тооцохын тулд илүү нарийвчилсан актуар судалгаа хийх шаардлагатай.

## Таамаглал

- Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвд суралцагсад нь сайн дурын тогтолцооны зорилтот хүн амын тоонд орохгүй, харин Нийгмийн даатгалын тухай хуулийн 4.2 дахь хэсэгт зааснаар албан журмын нийгмийн даатгалд, эсвэл идэвхигүйд тооцогдоно гэж үзсэн.
- 2011 онд II ангилалд хамаарах даатгуулагчид (малчид, мэргэжлийн сургалтын төвд суралцагсад, ажилгүйчүүд) болон IY ангилалд хамаарах даатгуулагчид (хувиараа хөдөлмөр эрхлэгчид)-ын тоо сайн дураар нийгмийн даатгалд хамрагдах зорилтот хүн амын тоотой тэнцүү (100 хувь) байв. Малчид болон хувиараа хөдөлмөр эрхлэгч хүн амыг тооцоолоход дээрх тоог суурь болгон авсан.
- Бүх сайн дураар даатгуулагчид хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс шимтгэл төлнө.
- 2020 он гэхэд сайн дураар даатгуулагчдын хамрагдалт 100 хувьд хүрнэ.

## Үр дүн

Сайн дурын нийгмийн даатгалын шимтгэлд татаас олгоход шаардагдах нэмэлт зардал нь 2014 онд ДНБ-ний 0.02 хувь (татаасын хоёр түвшинд хоёуланд нь)-иар хязгаарлагдах бөгөөд 2020 он гэхэд бүрэн хамралттай болох тохиолдолд 50 хувийн татаас олгоход ДНБ-ний 0.1 хувьтай, 70 хувийн татаас олгоход ДНБ-ний 0.14 хувьтай тэнцэх зардал шаардагдах болно.

### **Хувилбар ХН3: Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт хамрагдагчдын сайн дурын нийгмийн даатгалын шимтгэлд татаас олгох (тэтгэвэр болон богино хугацаат тэтгэмжүүд): (1) Бүх хамрагдагчийн шимтгэлийг бүрэн хариуцах; (2) “эмзэг бүс” бүлэгт хэсэгчилсэн татаас олгох (50 хувь, эсвэл 70 хувь)**

Хувилбар 3 нь нийгмийн даатгалд хамралтыг нэмэгдүүлэх, ялангуяа Хөдөлмөрийн яамнаас хэрэгжүүлж буй Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арван хөтөлбөрт хамрагдаж, үр шим хүртэгсдийг нийгмийн даатгалд даатгуулах хөшүүрэг бий болгох зорилготой. 2012 онд 8 ХЭДХ хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд 2014 онд хоёр хөтөлбөр нэмэгдсэнээр нийтдээ арван хөтөлбөр болсон юм.

Эдгээр арван хөтөлбөрт хамрагдаж буй бүх хүнд нийгмийн даатгалын шимтгэлийн татаас олгохыг санал болгож байгаа бөгөөд үүнд шаардагдах зардлыг Хөдөлмөрийн яамны төсөвт тусгана. Зардлыг дараах хувилбаруудаар харьцуулж тооцов: (1) Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих 10 хөтөлбөрт хамрагдаж буй иргэд хөтөлбөрийн түршид нийгмийн даатгалын шимтгэлийн татаас авна; (2) зөвхөн “эмзэг” бүлэг бүрэн татаас авч, “эмзэг бүс” бүлэг 50, эсвэл 70 хувийн татаас авна. Нийгмийн даатгалын шимтгэлд татаас өгснөөр ХЭДХ-үүдэд хамрагдаж дууссанаас хойшхи хугацаанд ч нийгмийн даатгалд үргэлжлүүлэн хамрагдах хөшүүрэг болно гэж үзсэн.

#### Таамаглал

- ХЭДХ-үүдэд хамрагдаж үр шим хүртэгчдийн тоо жил бүр 10 хувиар өснө.
- Дунджаар нэг ХЭДХ 6.6 сарын хугацаанд үргэлжилнэ (“ХЭДХ-ийн үр шимийг хүртэгчид”-ийг үзнэ үү)
- ХЭДХ-ийн бүтэц, зохион байгуулалт дараагийн зургаан жилийн хугацаанд өөрчлөгдөхгүй.

#### Үр дүн

Хамгийн зардал ихтэй хувилбарт буюу тухайн хөтөлбөрийн үргэлжлэх хугацаанд ХЭДХ-ийн үр шимийг хүртэгсдэд бүгдэд нь бүрэн татаас олговол 2014 онд ДНБ-ий 0.05 хувь, 2020 онд 0.1 хувьтай тэнцэх хэмжээний нэмэлт зардал шаардагдана. Бүрэн болон хэсэгчилсэн татаастай ХЭДХ-үүдийн зардлын зөрүү нь бага (2020 онд ДНБ-ий 0.01 хувь) байхаар байна.

**Хувилбар ХН4: Залуу малчдад зориулсан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хоёр шинэ хөтөлбөр хэрэгжүүлэх: (1) аж ахуй эрхлэх талаар зөвлөгөө өгөх, нийгмийн даатгалын шимтгэлийг нь нэг жилийн түрш хариуцах (татаас олгох) хосолсон дэмжлэг бүхий хөтөлбөр; (2) мэргэжлийн болон дагалдан сургалт, тэтгэлэг, нийгмийн даатгалын шимтгэлийн төлбөр зэргийг багтаасан хөтөлбөр: 3 сарын хугацаатай, эсвэл 6 сарын дагалдан сургалттай.**

Хэдийгээр Хөдөлмөрийн яам зорилтот бүлэгт чиглэсэн ХЭДХ-үүдийг хэрэгжүүлж эхэлсэн ч, эдгээр хөтөлбөрийн аль нь ч залуу малчдын хэрэгцээг бүрэн хангаж чадахгүй байна гэж үндэсний хэлэлцүүлгээс үзсэн. Тиймээс дараах хоёр хөтөлбөрийг санал болгож байна: (1) аж ахуй эрхлэлтийн талаар ганцаарчилсан зөвлөн туслах нэг жилийн (зардал багатай хувилбар), эсвэл гурван жилийн (зардал ихтэй хувилбар) хөтөлбөр; (2) мал аж ахуйн үйл ажиллагааны талаар гурван сарын хугацаатай зорилтот сургалт (зардал багатай хувилбар), эсвэл гурван сарын дагалдан сургалт бүхий нийтдээ зургаан сарын сургалт (зардал ихтэй хувилбар) явуулах. Сургалтын үеэр залуу малчид өөрсдийн болон гэр бүлийнхээ амьжиргааны зардлыг хариуцах шаардлагатай тул сургалтын хөтөлбөрөөс сар бүр тэтгэлэг олгоно. Дээрх хувилбаруудтай адилаар хөтөлбөр хэрэгжих бүхий л хугацаанд залуу малчдын дунд нийгмийн даатгалд хамрагдах хөшүүрэг болгож шимтгэлийн татаас олгоно. Энэхүү татаас нь сургалтын хөтөлбөрт оролцогчдод бүрэн, харин аж ахуй эрхлэлтийн талаар зөвлөгөө авч буй хүмүүст хэсэгчилсэн (90 хувь) байдлаар олгогдоно. Энэ хувилбарын зорилтот хүн ам нь нэг бол мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгч, эсвэл мал аж ахуйгаа сайжруулах, эсвэл орон нутагтаа эдийн засгийн шинэ боломжийг эрэлхийлж, жижиг дунд үйлдвэр байгуулж буй 15-аас 29 насны залуучууд юм.

#### Таамаглал

- Нийт хүн амын дунд хөдөө, хотын хүн амын харьцаа нь 15-29 насны бүлэгт мөн хамаарна.
- Улсын хэмжээний залуучууд(15-29 нас)-ын ажилгүйдлийн түвшин нь мөн хөдөөгийн залуучуудад хэрэглэгдэнэ.
- Аж ахуй эрхлэх талаар ганцаарчилсан болон хамтаар нь зөвлөгөө өгөх үйлчилгээний зардал нь дунджаар нэг удаад 15,000 төгрөг байна. Энэхүү зардлын дүнг хөгжиж буй орнуудын хөдөө орон нутагт ийм зорилтот хөтөлбөрүүд хэрэгжүүлсэн удаан хугацааны туршлага бүхий ОУХБ-ын Олон нийтэд түшиглэсэн аж ахуйн хөгжлийн хөтөлбөртэй зөвлөлдсөний үндсэн дээр тодорхойлсон болно.

- Хөдөөгийн таван залуу бүрийн нэг нь өөрийн хувийн бизнесийг эхлүүлэх, бэхжүүлэх, мэргэжлийн үр чадвараа сайжруулах хүсэл эрмэлзэлтэй.
- Хөдөөгийн таван залуу бүрийн нэг нь үр чадвараа сайжруулах хүсэлтэй.
- Эхний 3 сард нэг ногдох сургалтын сарын дундаж зардал 200,000 төгрөг, дараагийн 3 сард 100,000 төгрөг байхаар тооцсон. Залуу малчдын хөтөлбөр нь одоо байгаа сургалтыг ашиглаж байгаа тул сургалтын шинэ хөтөлбөр зохиох шаардлагагүй. Зардал багатай хувилбарын хувьд сургалтын үргэлжлэх дундаж хугацаа нь гурван сар, зардал ихтэй хувилбарын хувьд (гурван сарын дагалдан сургалттай) 6 сар байна.
- Сарын тэтгэлэг нь мэргэжилтэй ажилтан бэлтгэх одоогийн хөтөлбөрийнхтэй жишиж 190,000 төгрөг байхаар тогтсон.
- Дагалдан сургалтын үеэр ажил олгогч нь хөтөлбөрт хамрагдагчдад олгох ХХДХ-ний хагастай тэнцэх цалингийн болон нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг төлөх дэмжлэгийг Хөдөлмөрийн яамнаас авна.

### Үр дүн

Залуу малчдад зориулсан ХЭДХ-ийг нэмж шинээр нэвтрүүлэхэд зардал ихтэй хувилбарын хувьд аж ахуй эрхлэх талаарх гурван жилийн ганцаарчилсан зөвлөн туслах үйлчилгээнд 2020 онд ДНБ-ий 0.13 хувь, дагалдан сургалт бүхий зорилтот сургалтад ДНБ-ий 0.13 хувьтай тэнцэх нэмэлт хөрөнгө шаардагдана. Зардал багатай хувилбарын хувьд дээрх хоёр хөтөлбөрт 2020 он гэхэд ДНБ-ий 0.04 хувь, 0.03 хувьтай тэнцэх санхүүжилт тус тус шаардагдана. Энэ зардалд нийгмийн даатгалын шимтгэлд татаас олгоход шаардагдах хөрөнгийг мөн багтаасан. Иймд залуу малчдын хэрэгцээ шаардлагад илүү нийцүүлэхийн тулд зардал ихтэй хоёр хөтөлбөрийг хоёуланг нь хэрэгжүүлэхийг санал болгож байна.

### Хувилбар ХН5: Албан салбарт ажиллаж байгаад ажилгүй болсон мэргэжилтэй ажилчдын (НДС-аас ажилгүйдлийн тэтгэмж авч буй иргэд) мэргэжил, үр чадварыг нь дээшлүүлэх 2 сарын сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх

Энэ тогтолцоо нь одоогийн ажилгүйдлийн даатгалын тогтолцоог ХЗЗИБ-той илүү сайн уялдуулах замаар сайжруулах бөгөөд ажилгүйдлийн тэтгэмж авч буй хүмүүсийг ажилд эргэн ороход нь тусална. Ажилгүйдлийн даатгалын тэтгэмж авч буй иргэдийн мэргэжил, үр чадварыг нь дээшлүүлэх сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэхийг үндэсний хэлэлцүүлгийн оролцогчид дэмжсэн юм. Үр чадвар дээшлүүлэх ийм хөтөлбөр нь эдийн засгийн бүтцийн өөрчлөлтөнд хамгийн их өртсөн хүмүүсийг эрэлт хэрэгцээтэй шинэ мэргэжил, үр чадвар эзэмших боломжоор хангаснаар эдийн засгийн өөрчлөлтийг зохистой хэрэгжүүлэхэд хувь нэмэр оруулна.

### Таамаглал

- Ажилгүйдлийн тэтгэмж авагчдын тоо нь ирэх жилүүдэд ажилгүйдлийн түвшний хандлагыг дагана.
- 2017 оноос хойш ажилгүйдлийн түвшин тогтмол 5.9 хувь байна.
- Ажилгүйдлийн даатгалын тэтгэмж авагчдад зориулсан давтан сургалтын зардал нь “Хөдөлмөр эрхлэлтэд бэлтгэх хөтөлбөр”-ийн нэг хүнд ногдох зардалтай ойролцоо буюу 131,000 төгрөг орчим байна. Бид ажилчдад шинэ үр чадвар эзэмшүүлэх бус харин тэдний үр чадварыг дээшлүүлэхийг авч үзэж буй тул энэ зардал нь дээрх хувилбарт ашигласан зардлаас бага байна. Энэ зардлыг ажиллах хүчний зардалтай уялдуулан индексжүүлсэн.
- Сургалтын үргэлжлэх хугацаа хоёр сар байна.
- Ажилгүйдлийн даатгалын тэтгэмж авагчид нь жилд зөвхөн нэг удаа л үр чадвар дээшлүүлэх сургалтанд хамрагдаж болно.
- 2014 онд ажилгүйдлийн даатгалын тэтгэмж авагчдын тэн хагас нь үр чадвар дээшлүүлэх хөтөлбөрт хамрагдсан бөгөөд энэ харьцаа ирэх жилүүдэд хэвээр байна.

## Үр дүн

Ажилгүйдлийн даатгалын тогтолцоог бэхжүүлэхэд 2020 онд улсын төсвийн орлого болон буцалтгүй тусламжийн дүнгийн 0.03 хувьтай тэнцэх зардал шаардагдана. Үнэлгээнд суурилсан үндэсний хэлэлцүүлгийн үеэр ажилгүйдлийн даатгалын тэтгэмж болон ХЗЗИБ-ыг хэрхэн үчлдуулах талаар судлах хүсэлт гарсан юм. Ийм хүсэлтийг өөр олон хувилбаруудын санхүү, эрх зүйн болон зохион байгуулалтын хувьд хэрэгжих боломжийг үнэлэн, нарийвчилсан судалгаа хийх замаар шийдвэрлэж болох юм.

## Хувилбар ХН6: ҮОМШӨ-ий улмаас хөгжлийн бэрхшээлтэй болсон (НДС-аас ҮОМШӨ-ний даатгалын сангаас тахир дутуугийн тэтгэвэр авдаг) хүмүүст дахин мэргэжил, үр чадвар олгох сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх

Энэ нь НДС-аас олгодог одоогийн тахир дутуугийн тэтгэвэр болон ХБИ-дэд зориулсан ХЭДХ-ийн нэмэлт болж хэрэгжих бөгөөд ҮОМШӨ-ний даатгалын сангаас тахир дутуугийн тэтгэвэр авч буй хүмүүст чиглэх юм. Шинээр санал болгож буй мэргэжил, үр чадвар шинээр эзэмшүүлэх хөтөлбөр нь тахир дутуугийн тэтгэвэр ямар нэг ажил хөдөлмөр эрхлүүлэх боломжийг нь хангахын тулд тэдний хэрэгцээнд нийцүүлэн өөрчилсөн сургалт, давтан сургалтыг санал болгох юм.

## Таамаглал

- Тахир дутуугийн тэтгэвэр авагчдын тоо 2013-2020 оны хугацаанд тогтвортой буюу 2005-2012 оны үеийн тэтгэвэр авагчдын тооны дундаж түвшинд байхаар байна.
- Тахир дутуугийн тэтгэвэр авч буй бүх хүн шинэ ажил эрхлэхэд бэлтгэгдэх сургалтад хамрагдсанаар ямар нэг ашиг тус хүртэнэ гэж үзсэний үндсэн дээр нийт тэтгэвэр авагчдад энэ хөтөлбөрийг чиглүүлэхээр тогтсон.
- Нэг хүний сургалтын сарын дундаж зардал 400,000 төгрөг байна гэж тооцсон (ажиллах хүчний зардалтай уялдуулан индексжүүлсэн). Сургалтын хөтөлбөрийг зорилтот бүлэгт нийцүүлэн өөрчлөх хэрэгтэй учраас шинэлэг заах арга зүй, шинэ технологи нэвтрүүлэх, илүү туршлагатай багш нар шаардлагатай болж магадгүй юм.
- Сургалтын үргэлжлэх дундаж хугацаа зургаан сар.

## Үр дүн

Тахир дутуугийн тэтгэвэр авагчдад зориулсан сургалтын хөтөлбөр хэрэгжүүлснээр 2014 онд ДНБ-ий 0.08 хувь, 2020 онд 0.09 хувьтай тэнцэх хэмжээний зардал гарна. Энэ зардал нь 2014 онд улсын төсвийн орлого, буцалтгүй тусламжийн дүнгийн 0.24, 2020 онд 0.27 хувьтай тэнцэнэ. Энд дахин тэмдэглэхэд ХБИ-ийн хэрэгцээг үр дүнтэй хангахын тулд илүү нарийвчилсан судалгаа шаардлагатай болно. Гэвч энэ хувилбарыг ҮСҮХ-ийн үеэр оруулсан нь ХБИ-ийг хөдөлмөрийн зах зээлд болон нийгэмд илүү идэвхитэй оролцуулах талаар бүх оролцогч талууд санал нэгтэй байгааг харуулсан юм.

Хувилбар бүрийн зардлын тооцооллыг Хүснэгт 27-д нэгтгэн харуулав.

**Хүснэгт 27. Хөдөлмөрийн насны хүн амын нийгмийн даатгалд хамрагдалтыг нэмэгдүүлж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжихтэй холбоотой хувилбаруудын зардлын тооцооллын дүн**

|                                                                                                                                                                                           | 2014         | 2016          | 2018          | 2020          |
|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------|---------------|---------------|---------------|
| <b>Хувилбар ХН1-0: Одоогийн буюу бодлого тогтвортой байх нөхцөлд: Сайн дураар даатгуулагчдад олгох жирэмсний болон амаржсаны тэтгэмжийг бодох хувь хэмжээ 70 хувь</b>                     |              |               |               |               |
| Зорилтот бүлэг (Нийгмийн даатгалын тухай хуулийн 4.3-т хамаарах эмэгтэй ажилтнуудын төрөлтийн тоо: малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид болон албан бус эдийн засагт ажиллагчид) (мян.хүн) | 32           | 32            | 31            | 31            |
| Хамрагдах хувь (%) (Зорилтот бүлгийн ажилчдын тоонд сайн дурын нийгмийн даатгалд даатгуулагчын эзлэх хувиар)                                                                              | 19           | 25            | 33            | 44            |
| Энэ хувилбарт хамрагдсан бүлэг (мян.хүн)                                                                                                                                                  | 6            | 8             | 10            | 14            |
| <b>Хувилбарын зардал (сая төгрөгөөр)</b>                                                                                                                                                  | <b>3,462</b> | <b>5,761</b>  | <b>9,589</b>  | <b>16,089</b> |
| <b>Зардлын (одоогийн) ДНБ-д эзлэх хувь</b>                                                                                                                                                | <b>0.02</b>  | <b>0.02</b>   | <b>0.03</b>   | <b>0.04</b>   |
| <b>Зардлын улсын төсвийн орлого, буцалтгүй тусламжид эзлэх хувь</b>                                                                                                                       | <b>0.06</b>  | <b>0.08</b>   | <b>0.09</b>   | <b>0.13</b>   |
| <b>Хувилбар ХН1-1: Сайн дураар даатгуулагчдад олгох жирэмсний болон амаржсаны тэтгэмжийг бодох хувь хэмжээг 100 хувь болгож өсгөх</b>                                                     |              |               |               |               |
| Зорилтот бүлэг (Нийгмийн даатгалын тухай хуулийн 4.3-т хамаарах эмэгтэй ажилтнуудын төрөлтийн тоо: малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид болон албан бус эдийн засагт ажиллагчид) (мян.хүн) | 32           | 32            | 31            | 31            |
| Хамрагдах хувь (%)                                                                                                                                                                        | 20           | 60            | 100           | 100           |
| Энэ хувилбарт хамрагдсан бүлэг (мян.хүн)                                                                                                                                                  | 6            | 19            | 31            | 31            |
| <b>Хувилбарын зардал (сая төгрөгөөр)</b>                                                                                                                                                  | <b>5,186</b> | <b>19,575</b> | <b>40,983</b> | <b>51,789</b> |
| <b>Зардлын ДНБ-д эзлэх хувь</b>                                                                                                                                                           | <b>0.02</b>  | <b>0.07</b>   | <b>0.13</b>   | <b>0.14</b>   |
| <b>Зардлын улсын төсвийн орлого, буцалтгүй тусламжид эзлэх хувь</b>                                                                                                                       | <b>0.08</b>  | <b>0.27</b>   | <b>0.40</b>   | <b>0.41</b>   |
| <b>Хувилбар ХН2-1: Жирэмсний болон амаржсаны, ердийн өвчний улмаас ХЧТА-ны болон ҮОМШӨ-ний даатгалын санд сайн дураар төлөх шимтгэл 2 хувь, шимтгэлийн 50 хувийг төрөөс хариуцах</b>      |              |               |               |               |
| Зорилтот бүлэг (Малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид) (мян.хүн)                                                                                                                            | 675          | 697           | 719           | 740           |
| хамрагдах хувь (%)                                                                                                                                                                        | 20%          | 60%           | 100%          | 100%          |
| Энэ хувилбарт хамрагдсан зорилтот бүлэг (мян.хүн)                                                                                                                                         | 135          | 418           | 719           | 740           |
| <b>Хувилбарын зардал (сая төгрөгөөр)</b>                                                                                                                                                  | <b>3,266</b> | <b>12,895</b> | <b>28,249</b> | <b>37,478</b> |
| <b>Зардлын ДНБ-нд эзлэх хувь</b>                                                                                                                                                          | <b>0.02%</b> | <b>0.05%</b>  | <b>0.09%</b>  | <b>0.10%</b>  |
| <b>Зардлын улсын төсвийн орлого, буцалтгүй тусламжид эзлэх хувь</b>                                                                                                                       | <b>0.05%</b> | <b>0.18%</b>  | <b>0.28%</b>  | <b>0.30%</b>  |
| <b>Хувилбар ХН2-2: Жирэмсний болон амаржсаны, ердийн өвчний улмаас ХЧТА-ны болон ҮОМШӨ-ний даатгалын санд сайн дураар төлөх шимтгэл 2 хувь, шимтгэлийн 70 хувийг төрөөс хариуцах</b>      |              |               |               |               |
| Зорилтот бүлэг (Малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид) (мян.хүн)                                                                                                                            | 675          | 698           | 719           | 740           |
| Хамрагдах хувь (%)                                                                                                                                                                        | 20%          | 60%           | 100%          | 100%          |
| Энэ хувилбарт хамрагдсан бүлэг (мян.хүн)                                                                                                                                                  | 135          | 419           | 719           | 740           |
| <b>Хувилбарын зардал (сая төгрөгөөр)</b>                                                                                                                                                  | <b>4,574</b> | <b>18,061</b> | <b>39,549</b> | <b>52,469</b> |
| <b>Зардлын ДНБ-нд эзлэх хувь</b>                                                                                                                                                          | <b>0.02%</b> | <b>0.07%</b>  | <b>0.12%</b>  | <b>0.14%</b>  |

|                                                                                                                                                                                                         |              |               |               |               |
|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------|---------------|---------------|---------------|
| <b>Зардлын улсын төсвийн орлого, буцалтгүй тусламжид эзлэх хувь</b>                                                                                                                                     | <b>0.07%</b> | <b>0.25%</b>  | <b>0.39%</b>  | <b>0.42%</b>  |
| Хувилбар ХНЗ-1: ХЭДХ-т хамрагдагчдын сайн дурын нийгмийн даатгал(тэтгэвэр болон богино хугацаат тэтгэмжүүд)-ын шимтгэлийг төрөөс бүрэн буюу 100 хувь хариуцах                                           |              |               |               |               |
| “Эмзэг бүлэг”-т чиглэсэн 4 ХЭДХ-т хамрагдсан хүмүүс (мян.хүн)                                                                                                                                           | 38           | 46            | 56            | 68            |
| “Эмзэг бүс бүлэг”-т чиглэсэн 2 ХЭДХ-т хамрагдсан хүмүүс (мян.хүн)                                                                                                                                       | 30           | 36            | 44            | 53            |
| <b>Хувилбарын зардал (сая төгрөгөөр)</b>                                                                                                                                                                | <b>9,993</b> | <b>15,406</b> | <b>23,762</b> | <b>37,073</b> |
| <b>Зардлын ДНБ-д эзлэх хувь</b>                                                                                                                                                                         | <b>0.05%</b> | <b>0.06%</b>  | <b>0.07%</b>  | <b>0.10%</b>  |
| <b>Зардлын улсын төсвийн орлого, буцалтгүй тусламжид эзлэх хувь</b>                                                                                                                                     | <b>0.16%</b> | <b>0.21%</b>  | <b>0.23%</b>  | <b>0.29%</b>  |
| Хувилбар ХНЗ-2: Сайн дурын нийгмийн даатгал(тэтгэвэр болон богино хугацаат тэтгэмжүүд)-д төлөх “эмзэг бүлгийн” шимтгэлийг төрөөс бүрэн буюу 100 хувь, “эмзэг бүс бүлгийн” шимтгэлийн 70 хувийг хариуцах |              |               |               |               |
| “Эмзэг бүлэг”-т чиглэсэн 4 ХЭДХ-т хамрагдсан хүмүүс (мян.хүн)                                                                                                                                           | 38           | 46            | 56            | 68            |
| “Эмзэг бүс бүлэг”-т чиглэсэн 2 ХЭДХ-т хамрагдсан хүмүүс (мян.хүн)                                                                                                                                       | 30           | 36            | 44            | 53            |
| <b>Хувилбарын зардал (сая төгрөгөөр)</b>                                                                                                                                                                | <b>8,640</b> | <b>13,319</b> | <b>20,543</b> | <b>32,052</b> |
| <b>Зардлын ДНБ-д эзлэх хувь</b>                                                                                                                                                                         | <b>0.04%</b> | <b>0.05%</b>  | <b>0.06%</b>  | <b>0.09%</b>  |
| <b>Зардлын улсын төсвийн орлого, буцалтгүй тусламжид эзлэх хувь</b>                                                                                                                                     | <b>0.14%</b> | <b>0.18%</b>  | <b>0.20%</b>  | <b>0.25%</b>  |
| Хувилбар ХНЗ-3: Сайн дурын нийгмийн даатгал(тэтгэвэр болон богино хугацаат тэтгэмжүүд)-д төлөх “эмзэг бүлгийн” шимтгэлийг төрөөс бүрэн буюу 100 хувь, “эмзэг бүс бүлгийн” шимтгэлийн 50 хувийг хариуцах |              |               |               |               |
| “Эмзэг бүлэг”-т чиглэсэн 4 ХЭДХ-т хамрагдсан хүмүүс (мян.хүн)                                                                                                                                           | 38           | 46            | 56            | 68            |
| “Эмзэг бүс бүлэг”-т чиглэсэн 2 ХЭДХ-т хамрагдсан хүмүүс (мян.хүн)                                                                                                                                       | 30           | 36            | 44            | 53            |
| <b>Хувилбарын зардал (сая төгрөгөөр)</b>                                                                                                                                                                | <b>7,737</b> | <b>11,928</b> | <b>18,398</b> | <b>28,704</b> |
| <b>Зардлын ДНБ-д эзлэх хувь</b>                                                                                                                                                                         | <b>0.04%</b> | <b>0.04%</b>  | <b>0.06%</b>  | <b>0.08%</b>  |
| <b>Зардлын улсын төсвийн орлого, буцалтгүй тусламжид эзлэх хувь</b>                                                                                                                                     | <b>0.12%</b> | <b>0.16%</b>  | <b>0.18%</b>  | <b>0.23%</b>  |
| Хувилбар ХН4-1: Зардал бага хувилбар: Нийгмийн даатгалтай холбосон залуу малчдын ХЭДХ: аж ахуй эрхлэх зөвлөгөө + 1 жилийн хугацаанд нийгмийн даатгалын шимтгэлийг нь хариуцах                           |              |               |               |               |
| Зорилтот хүн ам 1 (15-29 насны, хөдөөгийн ажилгүй залуучууд) (мян.хүн)                                                                                                                                  | 7            | 6             | 5             | 4             |
| Зорилтот хүн ам 2 (бизнесээ хөгжүүлэх хүсэлтэй 15-29 насны, хөдөөгийн залуучууд)                                                                                                                        | 15           | 14            | 12            | 11            |
| Хамрах хувь                                                                                                                                                                                             | 50%          | 70%           | 100%          | 100%          |
| Үр шим хүртэгчдийн тоо (мян.хүн)                                                                                                                                                                        | 11           | 14            | 17            | 15            |
| <b>Хувилбарын зардал (сая төгрөгөөр)</b>                                                                                                                                                                | <b>5,048</b> | <b>7,890</b>  | <b>12,495</b> | <b>14,085</b> |
| <b>Зардлын ДНБ-д эзлэх хувь</b>                                                                                                                                                                         | <b>0.02%</b> | <b>0.03%</b>  | <b>0.04%</b>  | <b>0.04%</b>  |
| <b>Зардлын улсын төсвийн орлого, буцалтгүй тусламжид эзлэх хувь</b>                                                                                                                                     | <b>0.07%</b> | <b>0.11%</b>  | <b>0.12%</b>  | <b>0.11%</b>  |
| Хувилбар ХН4-2: Зардал ихтэй хувилбар: Нийгмийн даатгалтай холбосон залуу малчдын ХЭДХ: аж ахуй эрхлэх зөвлөгөө + 3 жилийн хугацаанд нийгмийн даатгалын шимтгэлийг нь хариуцах                          |              |               |               |               |
| Зорилтот хүн ам 1 (15-29 насны, хөдөөгийн ажилгүй залуучууд) (мян.хүн)                                                                                                                                  | 7            | 6             | 5             | 4             |

|                                                                                                                                                                                                                                                      |               |               |               |               |
|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------------|---------------|---------------|---------------|
| Зорилтот хүн ам 2 (бизнесээ хөгжүүлэх хүсэлтэй 15-29 насны, хөдөөгийн залуучууд)                                                                                                                                                                     | 15            | 14            | 12            | 11            |
| Хамрах хувь                                                                                                                                                                                                                                          | 50%           | 70%           | 100%          | 100%          |
| Үр шим хүртэгчдийн тоо (мян.хүн)                                                                                                                                                                                                                     | 11            | 14            | 17            | 15            |
| <b>Хувилбарын зардал (сая төгрөгөөр)</b>                                                                                                                                                                                                             | <b>15,143</b> | <b>23,671</b> | <b>37,485</b> | <b>42,255</b> |
| <b>Зардлан ДНБ-д эзлэх хувь</b>                                                                                                                                                                                                                      | <b>0.07%</b>  | <b>0.09%</b>  | <b>0.12%</b>  | <b>0.12%</b>  |
| <b>Зардлын улсын төсвийн орлого, буцалтгүй тусламжид эзлэх хувь</b>                                                                                                                                                                                  | <b>0.24%</b>  | <b>0.32%</b>  | <b>0.37%</b>  | <b>0.33%</b>  |
| Хувилбар ХН4-3: Зардал ихтэй хувилбар: Нийгмийн даатгалтай холбосон залуу малчдын ХЭДХ: мэргэжлийн сургалт+ тэтгэлэг+ сургалтын 6 сарын хугацаанд нийгмийн даатгалын шимтгэлийг нь хариуцах (3 сарын бүтэн цагийн сургалт, 3 сарын дагалдан сургалт) |               |               |               |               |
| Зорилтот хүн ам 1 (15-29 насны, хөдөөгийн ажилгүй залуучууд) (мян.хүн)                                                                                                                                                                               | 7             | 6             | 5             | 4             |
| Зорилтот хүн ам 2 (бизнесээ хөгжүүлэх хүсэлтэй 15-29 насны, хөдөөгийн залуучууд)                                                                                                                                                                     | 15            | 14            | 12            | 11            |
| Хамрах хувь                                                                                                                                                                                                                                          | 50%           | 70%           | 100%          | 100%          |
| Үр шим хүртэгчдийн тоо (мян.хүн)                                                                                                                                                                                                                     | 11            | 14            | 17            | 15            |
| <b>Хувилбарын зардал (сая төгрөгөөр)</b>                                                                                                                                                                                                             | <b>18,930</b> | <b>28,439</b> | <b>43,284</b> | <b>46,902</b> |
| <b>Зардлын ДНБ-д эзлэх хувь</b>                                                                                                                                                                                                                      | <b>0.09%</b>  | <b>0.10%</b>  | <b>0.13%</b>  | <b>0.13%</b>  |
| <b>Зардлын улсын төсвийн орлого, буцалтгүй тусламжид эзлэх хувь</b>                                                                                                                                                                                  | <b>0.30%</b>  | <b>0.39%</b>  | <b>0.43%</b>  | <b>0.37%</b>  |
| Хувилбар ХН4-4: Зардал бага хувилбар: Нийгмийн даатгалтай холбосон залуу малчдын ХЭДХ: мэргэжлийн сургалт+ тэтгэлэг+ сургалтын 3 сарын хугацаанд нийгмийн даатгалын шимтгэлийг нь хариуцах                                                           |               |               |               |               |
| Зорилтот хүн ам 1 (15-29 насны, хөдөөгийн ажилгүй залуучууд) (мян.хүн)                                                                                                                                                                               | 7             | 6             | 5             | 4             |
| Зорилтот хүн ам 2 (бизнесээ хөгжүүлэх хүсэлтэй 15-29 насны, хөдөөгийн залуучууд)                                                                                                                                                                     | 15            | 14            | 12            | 11            |
| Хамрах хувь                                                                                                                                                                                                                                          | 50%           | 70%           | 100%          | 100%          |
| Үр шим хүртэгчдийн тоо (мян.хүн)                                                                                                                                                                                                                     | 4             | 4             | 5             | 4             |
| <b>Хувилбарын зардал (сая төгрөгөөр)</b>                                                                                                                                                                                                             | <b>4,573</b>  | <b>6,172</b>  | <b>8,948</b>  | <b>9,567</b>  |
| <b>Зардлын ДНБ-д эзлэх хувь</b>                                                                                                                                                                                                                      | <b>0.02%</b>  | <b>0.02%</b>  | <b>0.03%</b>  | <b>0.03%</b>  |
| <b>Улсын төсвийн орлого, буцалтгүй тусламжид эзлэх хувь</b>                                                                                                                                                                                          | <b>0.07%</b>  | <b>0.08%</b>  | <b>0.09%</b>  | <b>0.08%</b>  |
| Хувилбар ХН5: Албан салбарт ажиллаж байгаад ажилгүй болсон мэргэжилтэй ажилчдын (НДС-аас ажилгүйдлийн тэтгэмж авч буй иргэд) мэргэжил, үр чадварыг нь дээшлүүлэх 2 сарын сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх                                              |               |               |               |               |
| НДС-аас ажилгүйдлийн тэтгэмж авч буй иргэд (мян.хүн)                                                                                                                                                                                                 | 9             | 5             | 5             | 5             |
| Хамрах хувь                                                                                                                                                                                                                                          | 80%           | 100%          | 100%          | 100%          |
| Сургалтын хамрагдсан тэтгэмж авагчид (мян.хүн)                                                                                                                                                                                                       | 7             | 5             | 5             | 5             |
| <b>Хувилбарын зардал (сая төгрөгөөр)</b>                                                                                                                                                                                                             | <b>2,459</b>  | <b>2,198</b>  | <b>2,866</b>  | <b>3,261</b>  |
| <b>Зардлын ДНБ-д эзлэх хувь</b>                                                                                                                                                                                                                      | <b>0.01%</b>  | <b>0.01%</b>  | <b>0.01%</b>  | <b>0.01%</b>  |
| <b>Зардлын улсын төсвийн орлого, буцалтгүй тусламжид эзлэх хувь</b>                                                                                                                                                                                  | <b>0.04%</b>  | <b>0.03%</b>  | <b>0.03%</b>  | <b>0.03%</b>  |
| Хувилбар ХН6: ҮОМШӨ-ий үлмаас хөгжлийн бэрхшээлтэй болсон (НДС-аас ҮОМШӨ-ний даатгалын сангаас тахир дутуугийн тэтгэвэр авдаг) хүмүүст дахин мэргэжил, үр чадвар олгох сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх                                                |               |               |               |               |
| ҮОМШӨ-ий даатгалын сангаас тахир дутуугийн тэтгэвэр авагчид (мян.хүн)                                                                                                                                                                                | 6             | 6             | 6             | 6             |

|                                                                     |               |               |               |               |
|---------------------------------------------------------------------|---------------|---------------|---------------|---------------|
| <b>Хувилбарын зардал (сая төгрөгөөр)</b>                            | <b>15,344</b> | <b>20,675</b> | <b>26,355</b> | <b>33,982</b> |
| <b>Зардлын ДНБ-д эзлэх хувь</b>                                     | <b>0.08%</b>  | <b>0.08%</b>  | <b>0.08%</b>  | <b>0.09%</b>  |
| <b>Зардлын улсын төсвийн орлого, буцалтгүй түслэмжид эзлэх хувь</b> | <b>0.24%</b>  | <b>0.28%</b>  | <b>0.26%</b>  | <b>0.27%</b>  |

Эх үүсвэр: ОУХБ РАП загварын тооцооллын дүн, 2015

### Дүгнэлт

Малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, албан бус эдийн засагт ажиллагчдад зориулсан нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүлэх нь хоёр тогтолцооны хооронд ижил тэгш байдлыг хангах бодлогын нэг гэдгийг харуулж байна. Нийгмийн даатгалд нийт хүн ам бүрэн хамрагдсан тохиолдолд ч үүнд шаардагдах зардал нь ДНБ-ний 0.1 хувиас хэтрэхгүй юм. Үндэсний хэлэлцүүлэгт оролцогчид богино хугацааны тэтгэмжийн даатгалын шимтгэлд 50 хувиар татаас олгох хувилбарыг сонгосон бөгөөд эн хүрээнд зардлаас илүү албан ба албан бус салбарын даатгуулагчдын хооронд тэгш шударга хандах явдлыг чухалчилсан болно. Богино хугацааны тэтгэмжийн даатгалын шимтгэлд татаас олгох, энэ арга хэмжээний санхүүгийн үр дагавар, тогтвортой байдал зэргийг цаашид нарийвчилсан актуар судалгаагаар тооцох шаардлагатай.

Үндэсний хэлэлцүүлгээс санал болгосны дагуу залуу малчид, ажилгүй болон ХБИ зэрэг эмзэг бүлгийнхэнд чиглэсэн ХЗЗИБ-ын сайжруулсан багцыг нэвтрүүлэхэд ДНБ-ий 1 хувьд хүрэхгүй зардал гарахаар байна. Эдгээр хөтөлбөрийн параметр үзүүлэлтүүдийг сайжруулахад цаашид дизайн болон хэрэгжих боломж талаас нь судлах шаардлагатай юм.



#### 5.4. Ахмад настан

**“Ахмад настныг наад зах нь үндэснийхээ хэмжээнд тодорхойлсон доод түвшнийг хангахуйц хэмжээний орлогын суурь баталгаагаар хангах”**

Ахмад настны НХСТ-г хангахын тулд юуны өмнө малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид болон албан бүс эдийн засагт ажиллагчдын дунд өндөр насны тэтгэврийн даатгалд хамрагдалтыг нэмэгдүүлэхийн тулд урамшууллын механизм нэвтрүүлэх, орлогын баталгааны тодорхой түвшинг хангахын тулд нийгмийн халамжийн сангаас олгож буй өндөр насны тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх (тухайлбал, инфляцитай уялдуулан индексжүүлдэг болох) гэсэн гол зөвлөмжүүд гарсан юм. Одоо баримталж буй бодлогын дагуу зорилтот бүлэгт 55-аас дээш насны бүх эмэгтэй, 60-аас дээш насны бүх эрэгтэйчүүд багтаж байна.

Түүнчлэн үндэсний хэлэлцүүлэгт оролцогчид малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн дунд өндөр насны тэтгэврийн даатгалд хамрагдах сонирхлыг нэмэгдүүлэхийн тулд сайн дураар нийгмийн даатгалд хамрагдвал шимтгэлийн татаас олгох асуудал дээр санал нэгдсэн юм. НҮБ/ЗГ-ын хамтарсан Нийгмийн хамгааллын ажлын хэсэг дээрх зөвлөмжүүдийг Хүснэгт 28-д тусгагдсан хувилбаруудаар авч үзлээ.

#### **Хүснэгт 28. Ахмад настны нийгмийн хамгаалалтай холбоотой хувилбарууд**

|                       |                                                                                                                                                                               |
|-----------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| <b>Хувилбар ӨН1-0</b> | <b>Одоогийн буюу бодлого тогтвортой байх нөхцөлд: Нийгмийн халамжийн тэтгэврийг одоогийн түвшин (115,000 төгрөг)-д нь хэвээр үлдээж, инфляцитай уялдуулан индексжүүлэхгүй</b> |
| <b>Хувилбар ӨН1-1</b> | Нийгмийн халамжийн тэтгэвэр (115,000 төгрөг)-ийг инфляцитай уялдуулан индексжүүлэх                                                                                            |
| <b>Хувилбар ӨН2-1</b> | Малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, албан бүс эдийн засагт ажиллагчдын өндөр насны тэтгэврийн даатгалд төлөх шимтгэлд 50 хувийн татаас олгох.                                |
| <b>Хувилбар ӨН2-2</b> | Малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, албан бүс эдийн засагт ажиллагчдын өндөр насны тэтгэврийн даатгалд төлөх шимтгэлд 70 хувийн татаас олгох.                                |

Эх үүсвэр: НҮБ/ЗГ-ын хамтарсан Нийгмийн хамгааллын ажлын хэсэг, 2014

### **Хувилбар ӨН1-1: Нийгмийн халамжийн тэтгэвэр (115,000 төгрөг)-ийг инфляцитай уялдуулан индексжүүлэх**

Нийгмийн халамжийн энэхүү тэтгэвэр нь огт ажил хийж байгаагүй, эсвэл НДС-д 10-аас бага жил шимтгэл төлсөн 55-аас дээш насны бүх эмэгтэй, 60-аас дээш насны бүх эрэгтэйчүүдийг орлогын суурь баталгаагаар хангадаг. Нийгмийн халамжийн өндөр насны тэтгэврийг инфляцийн өсөлттэй уялдуулан индексжүүлдэггүй. Сүүлийн хэдэн жилд инфляци үлэмж нэмэгдэж байгаа тул ийнхүү индексжүүлэхгүй байгаа нь бодлогын нэг хийдэл юм гэж үндэсний хэлэлцүүлэгт оролцогчид дүгнэсэн.

#### **Таамаглал**

- Нийгмийн халамжийн тэтгэвэр авагчдыг хүйсээр ангилсан мэдээлэл байхгүй байна. РАП загварын тооцоонд зорилтот хүн ам(60-аас дээш насны эрэгтэй, 55-аас дээш насны эмэгтэй)-ын өсөлтийн дундаж түвшинг энэ бүлгийн эрэгтэй, эмэгтэйчүүдийн аль алиных нь өсөлтөд хэрэглэсэн.
- Нийгмийн халамжийн сангаас өндөр насны тэтгэвэр авагчдын тоо энэ насны бүлгийн хүн ам зүйн өсөлтийг дагаж өснө.
- Одоогийн буюу бодлого тогтвортой байх хувилбарт ХАХНХЯ ирэх зургаан жилд тэтгэврийн хэмжээг өсгөхгүй гэж таамагласан.

#### **Үр дүн**

Үр шим хүртэгчдийн тоо нь хэт хязгаарлагдмал (3,000-4,000 орчим) тул нийгмийн халамжийн өндөр насны тэтгэврийг инфляцитай уялдуулан индексжүүлснээр нэмж шаардагдах зардлын хэмжээ төдийлөн их гарахгүй. Нэмэлт зардал нь 2020 онд ДНБ-ий ердөө 0.01 хувь, улсын төсвийн орлого, буцалтгүй тусламжийн дүнгийн 0.03 хувьтай тэнцэхээр байна.

### **Хувилбар ӨН2: Малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, албан бүс эдийн засагт ажиллагчдын өндөр насны тэтгэврийн даатгалд төлөх шимтгэлд 50 болон 70 хувийн татаас олгох.**

Ахмад настны нийгмийн хамгааллын хоёр дахь хувилбар нь нийгмийн даатгалд хамрагдах хөшүүрэг урамшуулал болгож нийгмийн даатгалын тэтгэврийн санд төлөх шимтгэлд татаас олгоход шаардагдах хөрөнгийг тооцов. Энэ нь малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг өндөр насны тэтгэврийн даатгал төдийгүй бусад таван өөр эрсдэлээс хамгаалах даатгалын хүрээг өргөжүүлэх юм. Учир нь нийгмийн даатгалд хамрагдсанаар ХЧТА, жирэмслэх, хүүхэд төрүүлэх, ҮОМШӨ-нд өртөх, өндөр наслах, хөдөлмөрийн чадвараа болон тэжээгчээ алдах тохиолдолд зургаан төрлийн тэтгэмжийн багцыг авах боломжтой. Тэтгэврийн сан (урт хугацаанд олгох тэтгэврийг санхүүжүүлдэг)-д сард төлөх шимтгэл нь хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын 10 хувь, тэтгэмжийн сан(богино хугацаат тэтгэмжүүдийг санхүүжүүлдэг)-д төлөх шимтгэл нь 2 хувьтай тэнцэнэ.

Энэ хувилбарт малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, албан бүс эдийн засагт ажиллагчдын төлөх шимтгэлд 50 болон 70 хувийн татаас олгох арга хэмжээний зардлыг тооцож харьцуулалт хийсэн.

Энэ хувилбар нь одоо ид хэлэлцэж байгаа өндөр насны тэтгэврийн тогтолцооны шинэчлэлийн хүрээнд сайн дураар даатгалд хамрагдаж буй малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, албан бүс эдийн засагт ажиллагчдыг шимтгэлд нь татаас өгөх замаар нийгмийн даатгалд албан журмаар хамруулах асуудалтай нийцэж байгаа юм. РАП-ын тооцооллоор хэрэв бүх зорилтот хүн ам 2020 он гэхэд нийгмийн даатгалд бүрэн хамрагдвал шаардагдах зардал ямар байхыг симуляци хийж тооцсон болно. Гэхдээ ийм зардлыг илүү үнэн зөв тооцохын тулд илүү нарийвчилсан актуар судалгаа хийх шаардлагатай.

#### **Таамаглал**

- Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвд суралцагсад нь сайн дурын тогтолцооны зорилтот хүн амын тоонд орохгүй, харин Нийгмийн даатгалын тухай хуулийн 4.2 дахь хэсэгт зааснаар албан журмын нийгмийн даатгалд, эсвэл идэвхигүйд тооцогдоно гэж үзсэн.

- 2011 онд II ангилалд хамаарах даатгуулагчид (малчид, мэргэжлийн сургалтын төвд суралцагсад, ажилгүйчүүд) болон IV ангилалд хамаарах даатгуулагчид(хувиараа хөдөлмөр эрхлэгчид)-ын тоо сайн дураар нийгмийн даатгалд хамрагдах зорилтот хүн амын тоотой тэнцүү (100 хувь) байв. Малчид болон хувиараа хөдөлмөр эрхлэгч хүн амыг тооцоолоход дээрх тоог суурь болгон авсан.
- Бүх сайн дураар даатгуулагчид хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс шимтгэл төлнө.
- 2020 он гэхэд сайн дураар даатгуулагчдын хамрагалд 100 хувьд хүрнэ. Тэтгэвэр авагчдын хувь нь хувилбар ХН2-т ашигласантай адил байна.

## Үр дүн

Нийгмийн даатгалд сайн дураар малчид болон хувиараа хөдөлмөр эрхлэгч хүн ам бүрэн хамрагдсан тохиолдолд хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоосоо төлөх шимтгэлийн 50 хувьтай тэнцэх татаас нь 2020 онд ДНБ-ий 0.51 хувь, харин 70 хувийн татаас нь 0.72 хувьтай тэнцэх нэмэлт санхүүжилт шаардана. Зорилтот хүн ам бүрэн хамрагдсан тохиолдолд ч гэсэн энэ зардал улсын төсвийн орлого, буцалтгүй тусламжийн дүнгийн 1.48 болон 2.08 хувьтай тус тус тэнцүү байна.

Малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг өндөр насны тэтгэврийн даатгалд хамруулахтай холбоотой хувилбарууд, тэдгээрийн зардлын тооцооллын үр дүнг Хүснэгт 29-т хураангуйлан танилцуулав.

### Хүснэгт 29. Малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн өндөр насны тэтгэврийн даатгалын хамрагалдыг өргөжүүлэхтэй холбоотой зардлын тооцооллын дүн

|                                                                                                                               | 2014          | 2016          | 2018           | 2020           |
|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------------|---------------|----------------|----------------|
| Хувилбар ӨН1-0: Одоогийн буюу бодлого тогтвортой байх нөхцөлд: Нийгмийн халамжийн тэтгэврийг индексжүүлэхгүй                  |               |               |                |                |
| Зорилтот хүн ам (60-аас дээш насны эрэгтэй, 55-аас дээш насны эмэгтэй) (мян.хүн)                                              | 231           | 259           | 292            | 328            |
| <b>Хувилбарын зардал (сая төгрөгөөр)</b>                                                                                      | <b>2,793</b>  | <b>3,135</b>  | <b>3,536</b>   | <b>3,974</b>   |
| <b>Зардлын ДНБ-д эзлэх хувь</b>                                                                                               | <b>0.01%</b>  | <b>0.01%</b>  | <b>0.01%</b>   | <b>0.01%</b>   |
| <b>Зардлын улсын төсвийн орлого, буцалтгүй тусламжид эзлэх хувь</b>                                                           | <b>0.04%</b>  | <b>0.04%</b>  | <b>0.03%</b>   | <b>0.03%</b>   |
| Хувилбар ӨН1-1: Инфляцитай уялдуулан индексжүүлсэн нийгмийн халамжийн тэтгэвэр                                                |               |               |                |                |
| Зорилтот хүн ам (60-аас дээш насны эрэгтэй, 55-аас дээш насны эмэгтэй) (мян.хүн)                                              | 231           | 259           | 292            | 328            |
| <b>Хувилбарын зардал (сая төгрөгөөр)</b>                                                                                      | <b>3,162</b>  | <b>4,025</b>  | <b>5,100</b>   | <b>6,442</b>   |
| <b>Зардлын ДНБ-д эзлэх хувь</b>                                                                                               | <b>0.01%</b>  | <b>0.01%</b>  | <b>0.02%</b>   | <b>0.02%</b>   |
| <b>Зарлын улсын төсвийн орлого, буцалтгүй тусламжид эзлэх хувь</b>                                                            | <b>0.05%</b>  | <b>0.05%</b>  | <b>0.05%</b>   | <b>0.05%</b>   |
| Хувилбар ӨН2-1: Малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, албан бус эдийн засагт ажиллагчдын төлөх шимтгэлд 50 хувийн татаас олгох |               |               |                |                |
| Зорилтот хүн ам (малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид) (мян. хүн)                                                              | 675           | 697           | 719            | 740            |
| Хамрах хувь (%)                                                                                                               | 20%           | 60%           | 100%           | 100%           |
| Энэ хувилбарт хамрагдсан зорилтот бүлэг (мян. хүн)                                                                            | 135           | 418           | 719            | 740            |
| <b>Хувилбарын зардал (сая төгрөгөөр)</b>                                                                                      | <b>16,329</b> | <b>64,477</b> | <b>141,246</b> | <b>187,388</b> |
| <b>Зардлын ДНБ-д эзлэх хувь</b>                                                                                               | <b>0.08%</b>  | <b>0.23%</b>  | <b>0.43%</b>   | <b>0.51%</b>   |
| <b>Зардлын улсын төсвийн орлого, буцалтгүй тусламжид эзлэх хувь</b>                                                           | <b>0.24%</b>  | <b>0.88%</b>  | <b>1.39 %</b>  | <b>1.48%</b>   |
| Хувилбар ӨН2-2: Малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, албан бус эдийн засагт ажиллагчдын төлөх шимтгэлд 70 хувийн татаас олгох |               |               |                |                |

|                                                                     |               |               |                |                |
|---------------------------------------------------------------------|---------------|---------------|----------------|----------------|
| Зорилтот хүн ам (малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид) (мянгаар)     | 675           | 697           | 719            | 740            |
| Хамрах хувь (%)                                                     | 20%           | 60%           | 100%           | 100%           |
| Энэ хувилбарт хамрагдсан зорилтот бүлэг (мян.хүн)                   | 135           | 418           | 719            | 740            |
| <b>Хувилбарын зардал(сая төгрөгөөр)</b>                             | <b>22,861</b> | <b>90,268</b> | <b>197,745</b> | <b>262,344</b> |
| <b>Зардлын ДНБ-д эзлэх хувь</b>                                     | <b>0.11%</b>  | <b>0.33%</b>  | <b>0.61%</b>   | <b>0.72%</b>   |
| <b>Зардлын улсын төсвийн орлого, буцалтгүй тусламжид эзлэх хувь</b> | <b>0.33%</b>  | <b>1.23%</b>  | <b>1.95%</b>   | <b>2.08%</b>   |

Эх үүсвэр: ОУХБ РАП загварын тооцооллын дүн, 2015

### Дүгнэлт

Үндэсний хэлэлцүүлэгт оролцогчид өндөр насны тэтгэврийн даатгалд төлөх шимтгэлийн 50 хувиар татаас олгох хувилбарыг сонгосон. Богино хугацааны тэтгэмжийн даатгалын шимтгэлд татаас нэвтрүүлэхэд гарах зардал, үүний эдийн засгийн үндэслэл, тогтвортой байдал зэргийг ямар ч тохиолдолд цаашид нарийвчилсан актуар судалгаагаар үнэлж тооцох шаардлагатай.





## 6. Монгол Улсын нийгмийн хамгааллын суурь түвшин

### 6.1. Монгол Улсын НХСТ-г хангахад тулгамдаж буй бодлогын асуудлуудыг шийдвэрлэхэд чиглэсэн нэгдсэн зөвлөмж

Монгол Улсын НХСТ-ийг хангах хүрээнд тулгамдаж буй бодлогын асуудлуудыг шийдвэрлэхийн тулд НҮБ/ЗГ-ын хамтарсан Нийгмийн хамгааллын ажлын хэсэг Хүснэгт 30-д харуулсан “зардал багатай”, “зардал ихтэй” хоёр хувилбарыг санал болгосон юм.


#### Хүснэгт 30. Санал болгож буй зардал их, бага хувилбаруудын нэгтгэл

|                                                                                                                                                                                                        | Зардал багатай хувилбар | Зардал ихтэй хувилбар |
|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------|-----------------------|
| <b>Эрүүл мэнд</b>                                                                                                                                                                                      |                         |                       |
| Хувилбар ЭМ1-1: II ангиллын даатгуулагчдын ЭМД-ын шимтгэлийг төрөөс бүрэн буюу хэсэгчлэн хариуцаж байгааг хэвээр үлдээх (одоогийн буюу бодлого тогтвортой байх нөхцөл)                                 | ✓                       |                       |
| Хувилбар ЭМ1-2: II ангиллын даатгуулагчдын ЭМД-ын шимтгэлийг төрөөс бүрэн хариуцах                                                                                                                     |                         | ✓                     |
| <b>Хүүхдүүд</b>                                                                                                                                                                                        |                         |                       |
| Хувилбар Х1-1: Хүүхдийн мөнгийг инфляцитай уялдуулан индексжүүлэх                                                                                                                                      | ✓                       | ✓                     |
| Хувилбар Х3-1: Цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлыг өнөөгийн түвшин(өдрийн ангийн хүүхдэд өдөрт 1,650 төгрөг, 24 цагийн ангийн хүүхдэд өдөрт 2,400 төгрөг)-д хадгалж, инфляцитай уялдуулан индексжүүлэх | ✓                       |                       |
| Хувилбар Х3-2: Хоолны зардлыг нэмэгдүүлэх: өдрийн ангийн хүүхдэд өдөрт 2,000 төгрөг, 24 цагийн ангийн хүүхдэд өдөрт 4,000 төгрөг (инфляцитай уялдуулан индексжүүлэх)                                   |                         | ✓                     |

| Хөдөлмөрийн насны хүн ам                                                                                                                                                                                         |   |   |
|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---|---|
| Хувилбар ХН1-1: Сайн дураар даатгуулсан эхчүүдийн жирэмсний болон амаржсаны тэтгэмжийг бодох хувь хэмжээг 100 хувьд хүргэж нэмэгдүүлэх                                                                           | ✓ | ✓ |
| Хувилбар ХН2-1: Малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, албан бус эдийн засагт ажиллагчдын жирэмсний болон амаржсаны, ердийн өвчний улмаас ХЧТА-ны болон ҮОМШӨ-ний даатгалд төлөх шимтгэлийн 50 хувиар татаас олгох | ✓ |   |
| Хувилбар ХН2-2: Малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, албан бус эдийн засагт ажиллагчдын жирэмсний болон амаржсаны, ердийн өвчний улмаас ХЧТА-ны болон ҮОМШӨ-ний даатгалд төлөх шимтгэлийн 70 хувиар татаас олгох |   | ✓ |
| Хувилбар ХН3-1: Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт хамрагдагчдын сайн дурын нийгмийн даатгалын шимтгэлд 100 хувийн татаас олгох (тэтгэвэр болон богино хугацаат тэтгэмжүүд).                                   |   | ✓ |
| Хувилбар ХН3-3: “Эмзэг бүлэг”-ийн сайн дурын нийгмийн даатгалын шимтгэлд 100 хувь татаас, “эмзэг бус бүлэг”-ийн шимтгэлд 50 хувийн татаас олгох (тэтгэвэр болон богино хугацаат тэтгэмжүүд).                     | ✓ |   |
| Хувилбар ХН4-1: Аж ахуй эрхлэх талаар зөвлөгөө өгөх, нийгмийн даатгалын шимтгэлийг нь нэг жилийн турш хариуцах (татаас олгох) хосолсон дэмжлэг бүхий залуу малчдад зориулсан ХЭДХ-ийг шинээр нэвтрүүлэх          | ✓ |   |
| Хувилбар ХН4-2: Аж ахуй эрхлэх талаар зөвлөгөө өгөх, нийгмийн даатгалын шимтгэлийг нь нэг жилийн турш хариуцах (татаас олгох) хосолсон дэмжлэг бүхий залуу малчдад зориулсан ХЭДХ-ийг шинээр нэвтрүүлэх          |   | ✓ |
| Хувилбар ХН4-3: Мэргэжлийн болон дагалдан сургалт, тэтгэлэг болон нийгмийн даатгалын шимтгэлийн (6 сарын) төлбөр зэргийг багтаасан ХЭДХ-ийг шинээр нэвтрүүлэх                                                    |   | ✓ |
| Хувилбар ХН4-4: Мэргэжлийн болон дагалдан сургалт, тэтгэлэг болон нийгмийн даатгалын шимтгэлийн (3 сарын) төлбөр зэргийг багтаасан ХЭДХ-ийг шинээр нэвтрүүлэх                                                    | ✓ |   |
| Хувилбар ХН5: Албан салбарт ажиллаж байгаад ажилгүй болсон мэргэжилтэй ажилчдын (НДС-аас ажилгүйдлийн тэтгэмж авч буй иргэд) мэргэжил, ур чадварыг нь дээшлүүлэх 2 сарын сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх          | ✓ | ✓ |
| Хувилбар ХН6: ҮОМШӨ-ий улмаас хөгжлийн бэрхшээлтэй болсон (НДС-аас ҮОМШӨ-ний сангаас тахир дутуугийн тэтгэвэр авдаг) хүмүүст дахин мэргэжил, ур чадвар олгох сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх                      | ✓ | ✓ |
| Ахмад настан                                                                                                                                                                                                     |   |   |
| Хувилбар ӨН1-1: Нийгмийн халамжийн тэтгэвэр(115,000 төгрөг)-ийг инфляцитай уялдуулан индексжүүлэх                                                                                                                | ✓ | ✓ |
| Хувилбар ӨН2-1: Малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, албан бус эдийн засагт ажиллагчдын өндөр насны тэтгэврийн даатгалд төлөх шимтгэлд 50 хувийн татаас олгох                                                    | ✓ |   |
| Хувилбар ӨН2-2: Малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, албан бус эдийн засагт ажиллагчдын өндөр насны тэтгэврийн даатгалд төлөх шимтгэлд 70 хувийн татаас олгох.                                                   |   | ✓ |

Эх үүсвэр: НҮБ/ЗГ-ын хамтарсан Нийгмийн хамгааллын ажлын хэсэг, 2014


## 6.2. Монгол Улсад нийгмийн хамгааллын суурь түвшин тогтоох хувилбаруудын зардлын харьцуулалт



Эх үүсвэр: ОУХБ РАП загварын тооцооллын дүн, 2015

Монгол Улсын НХСТ-ий зардал ихтэй хувилбарыг хэрэгжүүлэхэд 2020 он хүртэл тооцсон нийгмийн хамгааллын зардлын төсөөлөл дээр нэмж ДНБ-ий 1.91 хувьтай тэнцэх, зардал багатай хувилбарыг хэрэгжүүлэхэд ДНБ-ий 1.42 хувьтай тэнцэх хэмжээний зардал шаардагдахаар байна (Хүснэгт 12-13). Эрүүл мэндийн даатгалд бүх нийтээр хамрагдсан тул ийнхүү гарах зардал нь ихэвчлэн хүүхдүүдийн нийгмийн хамгаалал, хоол тэжээлийг сайжруулах, хөдөлмөрийн насны хүн амын орлогын баталгаа, хөдөлмөр эрхлэх чадварыг дээшлүүлэх, түүнчлэн ахмад настны хамгаалалд голчлон зориулагдана. НХСТ-ий зардал ихтэй хувилбарыг хэрэгжүүлбэл 2020 он хүртэл төсөвлөсөн нэмэлт зардал дараах байдлаар хуваарилагдана: хүүхдийн баталгааг хангахад ДНБ-ий 0.60 хувь, хөдөлмөрийн насны иргэдийн баталгаанд 0.63 хувь, харин ахмад настны баталгааг хангахад 0.66 хувь.

**Зураг 13. Зардлын хувьд их, бага хувилбараар тооцсон НХСТ-ийг хангахад нэмж шаардагдах зардлыг баталгаа тус бүрээр харьцуулан тооцсон үр дүн, ДНБ-д эзлэх хувиар (2014-2020)**




Эх үүсвэр: ОУХБ РАП загварын тооцооллын дүн, 2015

Монгол Улсын НХСТ-г хангахад нийгмийн хамгааллын зардал 2015 онд ДНБ-ний 4.23-аас 4.56 хувьд хэлбэлзэхээр байна (Зураг 14). Хэрэв зургаан жилээр тооцоолж үзвэл, Монгол Улсад НХСТ-г хангахад шаардагдах нийгмийн хамгааллын нийт зардал нь жил бүр өсч 2020 он гэхэд **ДНБ-ий 4.46-аас 4.95 хувьд** хэлбэлзэхээр байна. Энэ нь нийгмийн хамгааллын зарлага хамгийн их тэлсэн тохиолдолд ДНБ-ий 0.91 хувьтай тэнцэх нэмэлт зардал шаардагдана гэсэн үг юм.

Үүнийг Засгийн газар 2010-2012 онд иргэн бүрт бэлэн мөнгө олгож байсан үеийнхтэй харьцуулахад нийгмийн хамгааллын зардал хавьгүй бага байгаа болно. 2011 онд нийгмийн хамгааллын зардал хамгийн өндөр хэмжээнд буюу ДНБ-ий 9.5 хувьд хүрч байсан бөгөөд дараа нь эргээд бүүрч 2007 оноос өмнөх түвшинд очсон байна.

**Зураг 14. Нийгмийн хамгааллын зардлыг ДНБ-д эзлэх хувиар тооцож, НХСТ-ий зардал бага, их хувилбаруудтай харьцуулсан байдал**



Эх үүсвэр: ОУХБ РАП загварын тооцооллын дүн, 2015

**Хүснэгт 31. Нийгмийн хамгааллын зардлын ДНБ-д эзлэх бүсийн дундаж хувь (нийт хүн амын жигнэсэн дундажаар), баталгаа тус бүрээр**

| Нутаг дэвсгэр, бүс, улс      | Нийгмийн хамгааллын нийт зардал | Төрөөс санхүүжих эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардал | Төрөөс санхүүжих ахмад настны нийгмийн хамгааллын зардал | Төрөөс санхүүжих хөдөлмөрийн насны хүн амын нийгмийн хамгааллын зардал <sup>1</sup> | Нийгмийн нийтлэг тусламж | Төрөөс санхүүжих хүүхдийн нийгмийн хамгааллын зардал |
|------------------------------|---------------------------------|-------------------------------------------------------------|----------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------|--------------------------|------------------------------------------------------|
| Африк                        | 4.3                             | 2.6                                                         | 1.3                                                      | 0.4                                                                                 | 0.2                      | 0.2                                                  |
| Хойд Африк                   | 10.0                            | 3.2                                                         | 5.0                                                      | 1.1                                                                                 | 0.3                      | 0.4                                                  |
| Саб Сахарын Африк            | 4.3                             | 2.6                                                         | 1.1                                                      | 0.3                                                                                 | 0.2                      | 0.1                                                  |
| Ази-Номхон далайн бүс        | 4.6                             | 1.5                                                         | 2.0                                                      | 0.4                                                                                 | 0.4                      | 0.2                                                  |
| Баруун Европ                 | 27.1                            | 7.9                                                         | 11.1                                                     | 5.0                                                                                 | 0.9                      | 2.2                                                  |
| Төв ба Зүүн Европ            | 17.8                            | 4.4                                                         | 8.3                                                      | 3.0                                                                                 | 1.3                      | 0.8                                                  |
| Латин Америк, Карибын орнууд | 13.9                            | 4.0                                                         | 4.6                                                      | 2.0                                                                                 | 2.6                      | 0.7                                                  |
| Хойд Америк                  | 17.0                            | 8.5                                                         | 6.6                                                      | 2.8                                                                                 | 1.1                      | 0.7                                                  |
| Ойрх Дорнод                  | 11.0                            | 2.0                                                         | 3.3                                                      | 1.5                                                                                 | 3.4                      | 0.8                                                  |
| Дэлхий                       | 8.8                             | 2.8                                                         | 3.3                                                      | 1.5                                                                                 | 0.7                      | 0.4                                                  |

<sup>1</sup> Хөдөлмөрийн насны хүн амд зориулсан нийгмийн тэтгэмж, тусламж (нийгмийн нийтлэг тусламжийг оруулахгүйгээр). Эх үүсвэр: ОУХБ, Дэлхийн нийгмийн хамгааллын илтгэл 2014–2015 (ОУХБ, 2015).

Хүснэгт 31-т үзүүлсэнчлэн НХСТ-ий зардал ихтэй хувилбарыг хэрэгжүүлсэн тохиолдолд Монгол Улсын төсвөөс зарцуулах нийгмийн хамгааллын зардлын ДНБ-д эзлэх хувь (улсын төсвөөс хариуцдаг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зарлагыг оруулахгүйгээр) дэлхийн дундаж(6 хувь)-аас доогуур, гэхдээ Ази-Номхон далайн бүсийн дундаж(3.1 хувь)-аас өндөр байх юм.

### 6.3. Монгол Улсын нийгмийн хамгааллын суурь түвшний тодорхойлолт, зардал

Монгол Улсын бүх хүн амын нийгмийн хамгааллын хамгийн наад захын баталгааг хангахад чиглэсэн бодлогын янз бүрийн хувилбаруудаар зардлын тооцооллыг хянаж үзсэний эцэст үндэсний хэлэлцүүлэгт оролцогчид НХСТ-г хамтран тодорхойлсон юм. Хүснэгт 32-т хэлэлцүүлгээр санал нэгдэж тогтсон уг тодорхойлолтыг оруулав.


**Хүснэгт 32. Монгол Улсын нийгмийн хамгааллын суурь түвшний тодорхойлолт**

| Баталгаа                  | Нийгмийн хамгааллын суурь түвшний бүрэлдэхүүн хэсгүүд                                                                                                                                                                                                                     | Одоо байгаа, сайжруулах шаардлагатай | Шинээр бий болгох |
|---------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------|-------------------|
| Эрүүл мэнд                | Эмзэг бүлгийн иргэд болон малчдын төлөх шимтгэлийг төрөөс бүрэн хариуцах замаар бүх нийтийг эрүүл мэндийн даатгалд хамруулах                                                                                                                                              | ✓                                    |                   |
|                           | Бүх хүнд чанартай, олдоцтой, боломжийн үнэ өртөг бүхий эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг улс орон даяар хүргэх, хөдөө орон нутагт тусламж үйлчилгээ, нийлүүлэлтийг сайжруулах                                                                                             | ✓                                    |                   |
| Хүүхэд                    | Ерөнхий боловсролыг бүх хүүхдэд үнэ төлбөргүй эзэмшүүлэх, сургуулийн дотуур байраар үнэ төлбөргүй хангах                                                                                                                                                                  | ✓                                    |                   |
|                           | Бүх хүүхэд хүүхдийн мөнгөнд хамрагдаж байгааг хуулиар баталгаажуулж, амьжиргааны өртөгийн өсөлттэй уялдуулан автоматаар индексжүүлж байх                                                                                                                                  | ✓                                    |                   |
|                           | Цэцэрлэгт хамрагдаж буй (2-5 насны) бүх хүүхдийн хоолны зардлыг амьжиргааны өртгийн өсөлттэй уялдуулж индексжүүлэн нэмэгдүүлэх замаар бага насны хүүхдийн хоол тэжээлийн чанарыг сайжруулах                                                                               | ✓                                    |                   |
|                           | Малчин өрхийн хүүхдийн үндсэн эрх, хөгжлийг хангахуйцаар орчин нөхцөлийг сайжруулах                                                                                                                                                                                       |                                      | ✓                 |
| Хөдөл-мөрийн насны хүн ам | Малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, албан бүс эдийн засагт ажиллагчдын төлөх шимтгэлд (улсын төсвөөс 50 хувийн) татаас өгөх замаар хөдөлмөрийн чадвар түр алдсаны, жирэмсний болон амаржсаны, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалд бүрэн хамруулах |                                      | ✓                 |
|                           | Хөдөлмөр эрхэлж буй бүх хүнд, түүний дотор малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, албан бүс эдийн засагт ажиллагчдад жирэмсний болон амаржсаны тэтгэмжийг өмнөх орлогыг нь 100 хувь нөхөх хэмжээнд олгох                                                                    | ✓                                    |                   |
|                           | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүд (ХЭДХ)-ийг бэхжүүлж, залуу малчдад зориулсан тусгай хөтөлбөрийг нэвтрүүлэх                                                                                                                                                         | ✓                                    |                   |
|                           | Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хохирсон иргэд болон ажилгүйдлийн даатгалын сангаас тэтгэмж авч буй иргэдийг ажил хөдөлмөр эрхлэх, давтан сургах хөтөлбөрүүдэд хамруулах                                                                         |                                      | ✓                 |
| Ахмад настан              | Тэтгэврийн гурван давхаргат тогтолцоо нь дараах бүтэцтэй байна:                                                                                                                                                                                                           |                                      | ✓                 |
|                           | - Бүх нийтийг хамарсан суурь тэтгэвэр: тэтгэврийн хэмжээг амьжиргааны өртгийн өсөлттэй уялдуулан индексжүүлж байх                                                                                                                                                         |                                      |                   |
|                           | - Өндөр насны тэтгэврийн албан журмын даатгал: Малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, албан бүс эдийн засагт ажиллагчдын төлөх шимтгэлд (улсын төсвөөс 50 хувийн) татаас олгох замаар заавал даатгуулдаг болох -Тэтгэврийн нэмэлт хөтөлбөрүүд                               |                                      |                   |

Ядуу амьдралтай ахмад настнуудад мөнгөн ба түүнтэй адилтгах тусламж үзүүлж буй одоогийн нийгмийн халамжийн хөтөлбөрүүд дээр үндэслэн ахмадуудад зориулсан тусламж, үйлчилгээний нэгдсэн багц бий болгох. Үүнд урт хугацааны асрамжийн тогтолцоог хамруулах.

Эх үүсвэр: НҮБ/ЗГ-ын хамтарсан Нийгмийн хамгааллын ажлын хэсэг, 2014

**Зураг 15. Нийгмийн зардлын ДНБ-д эзлэх хувь, одоогийн нийгмийн хамгааллын зардлыг НХСТ-ий зардалтай харьцуулсан байдал (2014-2020)**



Эх үүсвэр: ОУХБ РАП загварын тооцооллын дүн, 2015

2020 онд Монгол Улсын НХСТ-г хангахад шаардагдах зардал **ДНБ-ий 4.7 орчим хувьтай тэнцэх** бөгөөд хэрэв хөдөлмөр эрхлэлтийг дэмжих шинэ хөтөлбөрүүдийг одоогийн жишгээр нийгмийн хамгааллын зардалд оруулалгүй улсын төсвийн бусад зүйлд тусгавал энэ хувь 4.4 болж буурахаар байна. Энэ нь 2020 онд НХСТ-г хангахад нийгмийн хамгааллын зардалд зориулан хуваарилж байгаа одоогийн төсөв дээр ДНБ-ий 1.7 хувьтай тэнцэх нэмэлт зардал шаардах юм. Өөрөөр хэлбэл, 2020 онд НХСТ-д сард нэг хүнд 44,650 төгрөг буюу 22.5<sup>35</sup> ам.доллар зарцуулагдах юм. Энэ нь НХСТ-г 2020 он гэхэд бүрэн хангахын тулд нэг хүнд сард 8 ам.доллар нэмж шаардагдана гэсэн үг болно. Уг зардалд өмнө нь тогтсон нийгмийн хамгааллын бүх зардал, нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийг амьжиргааны өртгийн өсөлттэй уялдуулан индексжүүлэх, нийгмийн даатгалын шимтгэлд олгох татаас, НХСТ-ийг бүрдүүлэх зорилгоор шинээр нэвтрүүлэх зарим нэмэлт арга хэмжээний зардал бүгд орсон болно.

Монгол Улсад хүн бүрийн орлогын баталгаа, нийгмийн суурь үйлчилгээнд хамрагдах боломжийг хангахын тулд 2020 онд нэмж шаардагдах хөрөнгө нь ердөө ДНБ-ий 1.7 хувьтай тэнцэж байна. Ингэснээр ДНБ-д нийгмийн зардлын эзлэх хувь 4.7 хувьд хүрэх юм. НХСТ нь эмзэг бүлгийн бүх иргэд


<sup>35</sup> 2015 оны 3 дугаар сарын 16-ны өдрийн валютын ханш: 1 ам.доллар=1985.6 төгрөг

болон малчдын төлөх шимтгэлийг төрөөс хариуцах замаар бүх нийтийг эрүүл мэндийн даатгалд хамруулж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах боломжоор хангах; одоогийн үнэ төлбөргүй ерөнхий (бүрэн дунд буюу 12 жилийн) боловсролоос гадна бүх хүүхдэд хүүхдийн мөнгө олгож байгааг үргэлжлүүлэн олгох, хэмжээг нь индексжүүлэх; малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, албан бус эдийн засагт ажиллагчдад шимтгэлийн татаас олгох замаар бүх нийтийг нийгмийн, тэр дундаа өндөр насны тэтгэврийн даатгалд хамруулах; зорилтот бүлэгт, ялангуяа залуу малчдад чиглэсэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үр дүнтэй хөтөлбөрүүдийг бий болгож хэрэгжүүлэх баталгаа болно.



төлбөр, орон сууц худалдаж авсны төлбөр, эрүүл мэндийн үйлчилгээний төлбөр, нийгмийн даатгалын шимтгэлийн төлбөр, ялангуяа эмзэг бүлгийн иргэдийн эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн татаас зэргийг төлдөг. Гуравдугаарт, улсын төсвөөс тэтгэврийн даатгалын алдагдлыг санхүүжүүлдэг.


**Зураг 17. Нийгмийн хамгааллын нийт зарлага, эх үүсвэрээр (тэрбум төгрөг)**



Эх үүсвэр: ҮСХ, ЭЗХЯ, Сангийн яам, ТХДХМ, төсвийн хэрэгцээний дагуу тооцсон төсөөлөл


2011-2012 онд буюу эдийн засаг таатай байх үед нийгмийн хамгааллын тогтолцооны зардал ХХС-аас олгосон бэлэн мөнгөнөөс болж огцом нэмэгдсэн юм. Харин ХХС-д энэхүү өргөн цар хүрээ бүхий хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх хангалттай нөөц бүрдээгүйн улмаас 2013 оноос эхлэн энэ бэлэн мөнгөн тэтгэмжийн ихэнхийг, ялангуяа иргэн бүрт бэлэн мөнгө олгож байсныг зогсоосон билээ. Үүний үр дүнд нийгмийн хамгааллын зардлын ДНБ-д эзлэх хувь 8.6 хувь байсан бол 2014 онд 3.8 хувь болж буурсан байна. Хэрэв нийгмийн хамгааллын бодлого тогтвортой, өөрчлөлтгүй байвал энэ хувь хэмжээ 2020 он гэхэд ДНБ-ий 3.0 хувь хүртэл буурахаар байна.

**Зураг 18. Нийгмийн зардлын ДНБ-нд болон улсын төсвийн орлого, тусламжийн дүнд эзлэх хувь, 2005-2020**



Эх үүсвэр: ҮСХ, ЭЗХЯ, Сангийн яам, ТХДХМ, төсвийн хэрэгцээний дагуу тооцсон төсөөлөл, ОУХБ РАП загварын тооцооллын дүн, 2015

Зураг 19. Нийгмийн хамгааллын зарлага болон НХСТ-ий зардлын улсын төсвийн орлого, тусламжийн дүнд эзлэх хувь (гүйцэтгэл ба төсөөлөл)




Эх үүсвэр: ҮСХ, ЭЗХЯ, Сангийн яам, ТХДХМ, төсвийн хэрэгцээний дагуу тооцсон төсөөлөл, ОУХБ РАП загварын тооцооллын дүн, 2015

РАП загвараар хийсэн тооцоололд ХЭДХ-үүдийн зардлыг шинэчлэн тооцоолсон нийгмийн хамгааллын зарлагын төсөөлөлд оруулж тооцсон гэдгийг тэмдэглэх нь зүйтэй. Хэрвээ бид хөдөлмөр эрхлэлтийг дэмжих нэмэлт арга хэмжээнүүдийн зардлыг хасвал НХСТ-г хангахад шаардлагатай нийгмийн хамгааллын зардлын улсын төсвийн орлого, буцалтгүй тусламжид эзлэх хувь 2020 онд 13.6 бус, харин 12.7 хувь байхаар байна.

Монгол Улсад НХСТ-г хангахын тулд нийгмийн хамгааллын зардлыг нэмэгдүүлж нэгэнт бий болсон төсвийн алдагдлыг нэмэх нь зайлшгүй болж байна. Сангийн яамны боловсруулсан төсөөллөөр 2020 он гэхэд төсвийн алдагдлыг ДНБ-ий 3.0 хувиас хэтрүүлэхгүй гэж тооцсон байна. Монгол Улс НХСТ-г нэвтрүүлэхэд төсвийн алдагдал 2020 он гэхэд (оны үнээр тооцсон) ДНБ-ий 4.2 хувьд хүрч болзошгүй байна.

Энэ алдагдлыг, тухайлбал төсвийн дахин хуваарилалт хийх, татварын бүтцийг өөрчлөх, татвар хураалтыг сайжруулах, нийгмийн даатгалын тогтолцооны параметр үзүүлэлтүүдийг өөрчлөх болон бусад арга хэмжээнүүдтэй хамтад нь авч хэрэгжүүлснээр шийдвэрлэх боломжтой. Үүний зэрэгцээ малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, албан бус эдийн засагт ажиллагчдыг нийгмийн даатгалд хамруулснаар нэмэгдэх шимтгэлийн орлого нь одоо төсвийн татаасаар санхүүжиж буй нийгмийн даатгалын сангийн алдагдлыг шингээх боломж бүрдэнэ.


**Зураг 20. Төсвийн алдагдлын ДНБ-д эзлэх хувь (оны үнээр), одоогийн нийгмийн зардлыг НХСТ-ний зардалтай харьцуулсан байдал**



Эх үүсвэр: ҮСХ, ЭЗХЯ, Сангийн яам, ТХДХМ, төсвийн хэрэгцээний дагуу тооцсон төсөөлөл, ОУХБ РАП загварын тооцооллын дүн, 2015

Зураг 21-т үзүүлсний дагуу НХСТ-ий зардал нь улсын төсвийн нийт зарлагатай харьцуулахад харьцангуй бага хувь эзэлсэн хэвээр байхыг харуулж байна.

**Зураг 21. НХСТ-ий зардлыг улсын төсвийн нийт зарлага, нийт орлого, тусламжийн дүнд харьцуулсан байдал**



Эх үүсвэр: ҮСХ, ЭЗХЯ, Сангийн яам, ТХДХМ, төсвийн хэрэгцээний дагуу тооцсон төсөөлөл, ОУХБ РАП загварын тооцооллын дүн, 2015

Гэхдээ Засгийн газар нийгмийн түншүүд болон гол оролцогч талууд, ялангуяа нийгмийн хамгааллын хөтөлбөрүүдийн үр шимийг хүртэгчдийн төлөөлөлтэй хамтран ямар хөтөлбөрүүдийг цомхотгож болохыг авч үзэж болох юм. Тухайлбал, ахмад настны орлогын баталгааг хангах зорилгоор өндөр насны бүх нийтийн тэтгэвэр нэвтрүүлэхэд нийгмийн халамжийн зарим тэтгэвэр, тэтгэмжтэй давхцаж болзошгүй. Нийгмийн тодорхой тэтгэвэр тэтгэмж, үйлчилгээ, тусламж дэмжлэгийг зогсоох иймэрхүү шийдэл тэдгээрийн үр шимийг хүртэгчдийн төлөөллийг зохих мэдээ мэдээллээр хангаж, харилцан үр дүнтэй яриа хэлэлцээний дүнд л бий болно. Энэ нь эргээд зардал, үр ашиг, үр нөлөөний талаар нэмэлт дүн шинжилгээ хийхийг шаардана.

## 6.5. Салбар дундын зохицуулалт, тусламж үйлчилгээг үр ашигтай хүргэх хэрэгцээ шаардлага

Үр бүтээлтэй, цалин хөлстэй бөгөөд хамгаалалттай, тэр дундаа нийгмийн даатгалд хамрагддаг ажил хөдөлмөр эрхлэх нь орлогын баталгааг сайжруулах, нийгмийн үйлчилгээг хүртэх гол түлхүүр юм. Зохистой хөдөлмөрийн эдгээр чухал хэмжээсүүд хоорондын холбоос байхгүй бол иргэд үндэсний болон олон улсын гэрээ, хэлэлцээрээр баталгаажсан хөдөлмөр, нийгмийн хамгаалалд хамрагдаж чадахгүйд хүрнэ. Энэ нь зохистой хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгааллын эрхээ эдлэхийн тулд саад бэрхшээлтэй байнга тулгарч байдаг эмзэг бүлгийн иргэдэд ихээхэн хамааралтай.

Аливаа улс оронд НХСТ-г хангах нь ард иргэдийг ядуурлын эргүүлэгт татагдан орохоос сэргийлэх, нийгмийн хамгааллын хоосон орон зайг нөхөх, уялдаа холбоогүй байдлыг арилгахад маш чухал юм. 2012 онд Засгийн газрын бүтцийн өөрчлөлтөөр нийгмийн хамгаалал болон хөдөлмөрийн асуудлыг Хөдөлмөрийн яам ба ХАХНХЯ гэсэн хоёр яаманд хуваарилан хариуцуулсан байна. Энэхүү бүтцийн өөрчлөлт нь Засгийн газрын мөрийн хөтөлбөрийн нэн тэргүүний зорилтууд болох Монгол хүн бүрийг зохистой хөдөлмөр эрхлэх боломжоор хангах, хүн амын хөгжлийг дэмжихэд чиглэсэн бодлогын төлөвлөлт, хэрэгжилтийг сайжруулахад чиглэжээ. Түүнчлэн яам тус бүрийн харьяанд бодлогыг хэрэгжүүлж, үйлчилгээг хүргэх босоо тогтолцоо бүхий төрөлжсөн агентлаг, төвүүд байгуулагдсан байна. Босоо удирдлагатай олон байгууллагууд зэрэгцэн ажиллаж байгаа нь төрөөс авч хэрэгжүүлж буй нийгмийн хамгааллын арга хэмжээнүүд, ялангуяа нийгмийн халамжийн хөтөлбөрүүдийг хөдөлмөр эрхлэлтийн стратегитай илүү уялдуулах зохицуулалтын механизмыг зайлшгүй шаардаж байна. Түүнчлэн одоогийн зохицуулалтын механизмууд, ялангуяа салбарын яамд, агентлагуудын хоорондын харилцан уялдаа сүл хэвээр байгаагаас харилцан бие биеэ нөхөж байх ёстой, хөгжлийн өргөн далайцтай зорилтыг биелүүлэхэд шаардлагатай бодлого, стратегийн хэрэгжилт нь нэгдсэн зохицуулалтгүй явагдаж байна. Ийм байдал холбогдох яамдын шууд удирдлагад харьяалагддаг салбар, нэгжүүдийн үйл ажиллагааг орон нутгийнхаа түвшинд уялдуулан зохицуулж ажилладаг орон нутгийн засаг захиргааны доод түвшинд ч хүртэл ажиглагдаж байна.

Хөтөлбөр, арга хэмжээнүүдийн хоорондын уялдаа зохицуулалт дутмаг буюу үр дүн муутайн улмаас нийгмийн даатгалын болон халамжийн байгууллагууд зөвхөн тус тусын чиг үүрэгт л анхаарч, харин эдгээр салбарын тархай бутархай олон хөтөлбөрийн тэтгэмж, тусламж, үйлчилгээ нь өөр хоорондоо давхцах явдал байна. Тиймээс иргэдэд нийгмийн үйлчилгээ, туслалцаа дэмжлэгийг нэгдмэл, хүртээмжтэй аргаар хүргэхийн тулд нийгмийн хамгааллын салбар дотроо төдийгүй гадагшаа үр дүнтэй, системтэй харилцан уялдаатай хамтран ажиллах шаардлагатай байна.

Өргөн уудам газар нутагтай, хүн ам тархан суурьшсан Монгол орны өвөрмөц орчин нөхцөлд тусламж, үйлчилгээ хэрэгцээтэй байгаа олон хүнд нийгмийн үйлчилгээг үр дүнтэй хүргэхэд нэлээдгүй саад бэрхшээл байна. Төрийн байгууллагуудын одоогийн бүтэц, зохион байгуулалтаас гадна аймаг, зарим суманд нэг цонхны үйлчилгээг бий болгож, олон төрлийн үйлчилгээг нэг дор авчирсан нь үйлчилгээний хүртээмжийг, ялангуяа сумдын түвшинд ихээхэн сайжруулжээ<sup>36</sup>. Гэхдээ үйлчилгээ, шийдвэр гаргах эрх мэдэл, үүрэг хариуцлагын төвлөрлийг улам сааруулж, шийдвэр гаргах эрх мэдлийг аймгаас сумын түвшинд шилжүүлж чадаагүй байна. Үүнээс гадна, нэг цонхны үйлчилгээний төвүүдийг босоо ба хэвтээ бүтцийн аль алинд нь хэрэгжүүлэгч агентлагууд болон орон нутгийн засаг захиргааны байгууллагуудын дунд тодорхой бөгөөд үр дүнтэй уялдуулан зохицуулах арга зам, нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр хоорондоо уялдаа холбоо бүхий олон талт үйлчилгээг хүмүүст хүргэх нэг талбар гэж хүлээн зөвшөөрвөл зохино.<sup>37</sup>

Эцэст нь, цаашид хөгжүүлж сайжруулах шаардлагатай өөр нэг талбар бол хяналт-шинжилгээ, үнэлгээ, ялангуяа үр нөлөөний үнэлгээ юм. Нийгмийн хамгааллын төсөл хөтөлбөрүүд нь ядуурлыг бууруулахад хувь нэмрээ оруулж байхын тулд хөтөлбөр нэг бүр дээр нөлөөллийн үнэлгээг хийх шаардлагатай байна.

<sup>36</sup> ОУХБ, 2015: Нэг цэгийн үйлчилгээ-Нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг хүргэх Монгол улсын туршлага (Улаанбаатар, 2015) (видео)

<sup>37</sup> Тибо ван Ланенхов, 2015: Нэг цонхны үйлчилгээний талаарх орон нутгийн үнэлгээний тайлан, цаашид хөгжүүлэх зөвлөмжүүд, (ажлын төсөл, 2015 оны 2-р сар).

## Ашигласан материал

Азийн хөгжлийн банк (АХБ). 2006. Technical assistance for strengthening the pension system (Манила).

Картер.Ж; Бедард, М.; Биста, С.П. 2013. Ази тив болон дэлхийн улс орнуудын ажилгүйдлийн болон хөдөлмөр эрхлэлтийн даатгалын тогтолцооны харьцуулсан шинжилгээ ( ОУХБ-ын Ази, Номхон далайн бүсийн товчоо): [http://ilo.org/asia/whatwedo/publications/WCMS\\_229985/lang--en/index.htm](http://ilo.org/asia/whatwedo/publications/WCMS_229985/lang--en/index.htm) [2015 оны 4 дүгээр сарын 30].

Монгол Улсын Засгийн газар. 2012. Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, 2012-2016 (Улаанбаатар).

Оон улсын хөдөлмөрийн байгууллага (ОУХБ). 2010. /1999 оны тэтгэврийн шинэчлэлд хийсэн шинжилгээ (ILO/RP/Mongolia/R.1).

— . 2013. Өндөр насны тэтгэврийн хүрээг өргөжүүлж, малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, албан бус хэвшилд ажиллагчид болон ажиллах хүчний хамрагдаагүй бусад бүлгүүдийг хамруулах нь, Монгол Улсын Засгийн газрын тайлан (ILO/TF/Mongolia/R.3).

—; Япон Улсын Засгийн газар; Хүн амын хөгжил, нийгмийн хамгаалын яам (ХАХНХЯ); Нэгдсэн үндэстний байгууллагын Нийгмийн хамгааллын баг. 2014. Монгол Улсын нийгмийн хамгааллын үнэлгээнд суурилсан үндэсний хэлэлцүүлгийн үнэлгээний матриц, 2013-2014 (Улаанбаатар).

Эдийн засгийн хөгжлийн яам. 2013. Монгол Улсын макро эдийн засгийн төлөв байдал, 2013-2017 (Улаанбаатар).

Боловсрол, шинжлэх ухааны яам. 2014. 2013 оны жилийн тайлан: Шинэчлэл-шийдэл-амжилт (Улаанбаатар). Монгол хэлээр: <http://www.meds.gov.mn/data/02/REPORT2013> [2015 оны 4 дүгээр сарын 30].

— . 2015. Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2015 оны төсвийн төсөл (Улаанбаатар). Монгол хэлээр: <http://www.meds.gov.mn/data/1409/Tusul2015.pdf> [2015 оны 4 дүгээр сарын 30].

Сангийн яам. 2013. Монгол Улсын төсвийн статистик, 2005-2012 (Улаанбаатар).

— . 2014. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2015 оны төсөл, 2016-2017 оны төсвийн төсөөлөл (Улаанбаатар).

Хүн амын хөгжил, нийгмийн хамгаалын яам (ХАХНХЯ). 2014. Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлогын төсөл 2015-2030, 9 дүгээр сар. (Улаанбаатар).

— . 2014. Хүн амын хөгжил, нийгмийн хамгаалын яамны 2013 оны тайлан сэтгүүл (Улаанбаатар).

—; Эрүүл мэндийн яам (ЭМЯ). 2013. Эрүүл мэндийн даатгалын хөгжлийн урт хугацааны стратеги 2013-2022 (Улаанбаатар).

— болон Нийгмийн даатгалын ерөнхий газар (НДЕГ). 2013. Эрүүл мэндийн даатгалын хөгжлийн урт хугацааны стратеги 2013-2022 (Улаанбаатар).

Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам. 2003. Нийгмийн хамгааллын салбарын стратегийн баримт бичиг, 11 дүгээр сар (Улаанбаатар).

Хүүхдийн төлөө үндэсний газар. 2010. Хүүхэд хамгааллыг бэхжүүлэх үндэсний стратеги 2010-2015 (Улаанбаатар, Монгол Улсын Засгийн газар).

Насан туршийн боловсролын үндэсний төв. 2014. 2014 оны үйл ажиллагааны нэгдсэн тайлан. 2014. (Улаанбаатар, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам). Монгол хэлээр: <http://www.nfde.mn/images/Pdf/2014.pdf> [2015 оны 4 дүгээр сарын 30].

Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл. 2013. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүд (Улаанбаатар, Хөдөлмөрийн яам).

Эрүүл мэндийн хөгжлийн төв. 2010. Эрүүл мэндийн статистикийн эмхэтгэл, 2010-2012 (Улаанбаатар, ЭМЯ).

Монгол Улсын Үндэсний статистикийн хороо (ҮСХ). 2008. Статистикийн эмхэтгэл (Улаанбаатар).

— 2010. Статистикийн эмхэтгэл (Улаанбаатар).

— 2011. Статистикийн эмхэтгэл (Улаанбаатар).

— 2012. Статистикийн эмхэтгэл (Улаанбаатар).

— 2013. Статистикийн эмхэтгэл (Улаанбаатар).

— 2009. Статистикийн эмхэтгэл (Улаанбаатар).

Шмит, В.; Сатриана, С.; Мухамад, Т. 2012. Нийгмийн хамгааллын үнэлгээнд суурилсан үндэсний хэлэлцүүлэг: Индонези улсын нийгмийн хамгааллын суурь түвшнийг тодорхойлох нь (Жакарта, ОУХБ). [http://www.ilo.org/jakarta/whatwedo/publications/WCMS\\_195572/lang--en/index.htm](http://www.ilo.org/jakarta/whatwedo/publications/WCMS_195572/lang--en/index.htm) [2015 оны 4 дүгээр сарын 30].

Шмит, В.; Дэ, Л. 2013. Үнэлгээнд суурилсан үндэсний хэлэлцүүлэг: Сайн туршлагын гарын авлага (Бангкок, ОУХБ). <http://www.socialsecurityextension.org/gimi/gess//ShowRessource.action?ressource.ressourceId=44257> [2015 оны 4 дүгээр сарын 30].

Шмит, В.; Таворн, С.; Ораван, П. 2013. Үнэлгээнд суурилсан үндэсний хэлэлцүүлэг: Тайланд улсын нийгмийн хамгааллын суурь түвшнийг тодорхойлох нь (Бангкок, ОУХБ). [http://www.ilo.org/secsoc/information-resources/publications-and-tools/books-and-reports/WCMS\\_213264/lang--en/index.htm](http://www.ilo.org/secsoc/information-resources/publications-and-tools/books-and-reports/WCMS_213264/lang--en/index.htm) [2015 оны 4 дүгээр сарын 30].

Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэн. 2008. Үдийн цай хөтөлбөрийн хэрэгжилтэд хийсэн үнэлгээ (Улаанбаатар, ЭМЯ).

НДЕГ. 2013. Үйл ажиллагааны тайлан 2013 он (Улаанбаатар). Монгол хэлээр: <http://www.ndaatgal.mn/tailan/SIGO-REPORT-2013.pdf> [2015 оны 4 дүгээр сарын 30].

НДЕГ-ын Мэдээлэл, технологийн төв. 2014. Нийгмийн даатгалд даатгуулагчид, тэтгэвэр, тэтгэмж авагчдын статистик мэдээлэл 2009-2013 (Улаанбаатар).

Монгол Улсын Их Хурал (Парламент). 1999. Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар 2021 он хүртэл баримтлах үндсэн чиглэл (Улаанбаатар, Монгол Улсын Засгийн газар).

— 2010. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл 2010-2013 (Улаанбаатар, Монгол Улсын Засгийн газар).

— 2008. Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого (Улаанбаатар, Монгол Улсын Засгийн газар).

НҮБ-ын Хүүхдийн сан (НҮБХС). 2007. Хүүхдийн тэтгэмж ба ядуурал: Монгол Улсад хэрэгжсэн хүүхдийн мөнгө хөтөлбөрийн туршлага (Нью Йорк).

Монгол Улс дахь НҮБХС. 2014. Монгол Улс дахь Хүүхдийн аж байдлын үнэлгээ (Улаанбаатар).

Монгол Улс дахь НҮБ-ын Хүн амын сан (НҮБХАС). 2012. Монгол улсын нийгэм, эдийн засгийн хөгжил, нийгмийн бодлого дахь хүн ам зүйн өөрчлөлтийн нөлөөлөл (Улаанбаатар).

Ван Ланенхов, Т. 2015. Нэг цонхны үйлчилгээний талаарх орон нутгийн үнэлгээний тайлан, цаашид хөгжүүлэх зөвлөмжүүд, 2015 (ажлын төсөл).

Уайнд, Н.А. 2013. PROST загварын 2013-2085 оны хэтийн тооцоонд үндэслэн Монгол Улсын тэтгэврийн даатгалын санд хийсэн шинжилгээний тайлан, 12 дугаар сар. (Вашингтон, Дэлхийн банк).

Дэлхийн банк. 2006. Монгол: Хүүхдийн мөнгө, түүнд хамрагдагсдыг тодорхойлох аргачлал (Вашингтон).

— . 2011. Монгол - Тэтгэврийн бодлогын шинэчлэлийн хувилбарууд, Тайлан No. 68526-MN, 1 дүгээр сарын 20. (Вашингтон). <http://documents.worldbank.org/curated/en/2011/01/16662950/mongolia-policy-options-pension-reform> [2015 оны 4 дүгээр сарын 30].

Монгол Улс дахь Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (ДЭМБ). 2010. ДЭМБ, Монгол Улсын хамтын ажиллагааны стратеги, 2010-2015 (Улаанбаатар). [http://www.who.int/countryfocus/cooperation\\_strategy/ccs\\_mng\\_en.pdf](http://www.who.int/countryfocus/cooperation_strategy/ccs_mng_en.pdf) [2015 оны 4 дүгээр сарын 30].

Веб сайт

Монгол Улсын Их Хурал (Парламент).: <http://www.parliament.mn/laws/projects>

Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем (Legal info): <http://www.legalinfo.mn>



Хавсралт

**Хавсралт 1. Нийгмийн хамгааллын үнэлгээнд суурилсан үндэсний хэлэлцүүлгийн матриц**

<http://www.social-protection.org/gimi/gess/ShowProjectRessource.action?ressource.ressourceId=45199&pid=2287>

Олон орны Засгийн газар болон Нэгдсэн үндэстний байгууллага (НҮБ) нийгмийн хамгааллыг сайжруулах нь аливаа улс орны ядуурлыг бууруулах, нийгэм, эдийн засгийн хөгжлийг дэмжих үр дүнтэй арга болохыг хүлээн зөвшөөрч, дэлхийн улс орнуудыг хамгийн наад зах нь нийгмийн хамгааллын суурь түвшнийг бүрдүүлэхийг уриалж байна.

Нийгмийн хамгааллын суурь түвшин нь тухайн орны нийт иргэдийг нэн шаардлагатай эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хамруулах, хүүхдэд боловсрол, асрамж халамжийн болон хоол тэжээлийн дэмжлэг үзүүлэх, хөдөлмөрийн насныхан, ахмад настнуудын орлогын баталгааг хангах замаар хамгийн наад захын нийгмийн тусламж, үйлчилгээг хүртэх боломжийг нь баталгаажуулах зорилготой юм. Түүнчлэн нийгмийн хамгааллын суурь түвшний үзэл баримтлал нь НҮБ-ын төрөлжсөн байгууллагууд, хөгжлийн түншүүд, олон улсын санхүүгийн байгууллагуудад нийгмийн хамгааллыг өргөжүүлэх, нийгмийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг сайжруулахын төлөө хамтран ажиллах боломж олгож байна.

Афганистан, Камбож, Энэтхэг, Индонези, Мьянмар, Пакистан, Филиппин, Соломоны арлууд, Тайланд, Вануату, Вьетнам зэрэг Ази, Номхон далайн бүс нутгийн олон улс нийгмийн хамгааллын бодлого, стратегиа боловсруулахдаа нийгмийн хамгааллын суурь түвшний үзэл баримтлалыг дэмжин баталгаажуулаад байна.

Монгол Улс 2013 оны 6 дугаар сараас 2015 оны 1 дүгээр сар хүртэлх хугацаанд нийгмийн хамгааллын үнэлгээнд суурилсан үндэсний хэлэлцүүлгийг НҮБ-ын дэмжлэгтэйгээр зохион байгуулж, үндэснийхээ нийгмийн хамгааллын суурь түвшнийг тодорхойлон шаардагдах зардлыг тооцсон юм. Үнэлгээний үр дүнтэй энэхүү тайлангаас танилцаж болно.

### Холбоо барих хаяг:

НҮБ-ын Суурин зохицуулагчийн газар  
Нэгдсэн Үндэстний гудамж 14  
Сүхбаатар дүүрэг  
Улаанбаатар-14201, Монгол улс  
Утас: 976 11327585  
Факс: 976 11329996  
Website: [www.un-mongolia.org](http://www.un-mongolia.org)

ОУХБ-ын Үндэсний зохицуулагчийн газар  
Нэгдсэн Үндэстний гудамж 14  
Сүхбаатар дүүрэг  
Улаанбаатар-14201, Монгол улс  
Утас: 976 11320624  
Факс: 976 11320625  
Website: [www.ilo.org](http://www.ilo.org)



ОУХБ Япон улсын  
олон/хоёр талт хамтын  
ажиллагааны хөтөлбөр

**DECENT WORK**

A better world starts here.

ISBN: 9789228298352